




ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН

Улаанбаатар хот
2017 он

Хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn

Сэтгүүлд нийтэлсэн бүтээл нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Сэтгүүлийн зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн "Андерсон энд Андерсон" ХХН-д талархал илэрхийлье.

© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээлийн зохиогчийн эрх Сэтгүүлийн редакц болон зохиогчид хадгалагдана.

Хэвлэсэн газар: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэвлэх үйлдвэр

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ж.Амарсанаа	<i>Академич, гавьяат хуульч</i>
Ц.Сарантuya	<i>Хууль зүйн шинжслэх ухааны доктор, гавьяат хуульч</i>
Б.Баярсайхан	<i>Хууль зүйн доктор</i>
Д.Гангабаатар	<i>Хууль зүйн доктор</i>
Д.Зүмбэрэлхам	<i>Хууль зүйн доктор</i>
Ж.Оюунтунгалаг	<i>Хууль зүйн доктор</i>
Д.Сүнжид	<i>Хууль зүйн доктор</i>
З.Сүхбаатар	<i>Хууль зүйн доктор</i>
Ц.Цогт	<i>Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч</i>
Х.Эрдэм-Үндрах	<i>Хууль зүйн доктор</i>

Эрхлэгч

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал

С.Энхцэцэг

Нарийн бичгийн дарга

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Д.Нямбаяр

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эх бэлтгэгч, дизайнер

З.Эрдэнэтөгс

Улсын бүртгэлийн дугаар: 279
ISSN:2226-9185
Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргав. Жилд 5 дугаар гарна.

Хаяг: Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Бага тойруу /15160/,
Хуулийн гудамж I,
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн байр
Утас: +(976)-11-315735
Факс: 315735
Вэб хуудас: www.legalinstitute.mn
Цахим хаяг: lawjournal@legalinstitute.mn

EDITORIAL BOARD

J.Amarsanaa	<i>Academician, Merited Lawyer of Mongolia</i>
Ts.Sarantuya	<i>(Sc.D), Merited Lawyer of Mongolia</i>
B.Bayarsaikhan	<i>(Ph.D)</i>
D.Gangabaatar	<i>(LL.D)</i>
D.Zumberellkham	<i>(Ph.D)</i>
J.Oyuntungalag	<i>(LL.D)</i>
D.Sunjid	<i>(Dr.jur)</i>
Z.Sukhbaatar	<i>(Ph.D)</i>
Ts.Tsogt	<i>Judge of the Administrative Appellate Court</i>
Kh.Erdem-Undrakh	<i>(Dr.jur)</i>

Executive Editor-in-Chief
Director, National Legal Institute
S.Enkhtsetseg

Acting Assistant Editor
Research, National Legal Institute
D.Nyambayar

Designed by
Designer, National Legal Institute
Z.Erdenetugs

State Registration Number:279
ISSN: 2226-9185
The National Legal Institute
publishes this journal five times per
year.

Address: 4th Khoroo of Chingeltei District,
Lawyer's Street-1, Ulaanbaatar-15160, Mongolia
Phone:+(976)-11-315735
Fax: 315735
Website: www.legalinstitute.mn
E-mail: lawjournal@legalinstitute.mn

АГУУЛГА

ХУУЛЬ ТӨРӨХИЙН ӨМНӨ /ОНЦЛОХ ӨГҮҮЛЭЛ, ЯРИЛЦЛАГА/

Үндсэн хууль ба шүүх эрх мэдэл

Шүүхийн өрөнхий зөвлөлийн дарга, хууль зүйн шинжлэх ухааны
доктор Н.Лүндиндорж

Хуульчдын өөрийн удирдлагын байгууллагын тухай

БНЧУ-ын Өмгөөлөгчдийн Холбооны Ерөнхийлөгч асан нойн
Владимир Ийроусектэй хийсэн ярилцлага

Хууль зүйн фирм

Өмгөөлөгч, хууль зүйн доктор З.Сүхбаатар

Хууль бүтээх ажиллагааны зарим асуудал

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант П.Сэлэнгэ

ЭРХ ЗҮЙН СЭТГЭЛГЭЭ: ҮЗЭЛ БОДОЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

Тэмт хэргийн бүрэлдэхүүний 4 талт элемент бүхий онолыг
шүүмжлэх нь

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимиийн
эрхлэгч, хууль зүйн доктор Д.Баярсайхан

Үндэсний аюулгүй байдал ба хариуцлагын асуудал

Хуульч, дипломатч Ж.Шишишиг

CEDAW ба Сүүдэр илтгэл

Хууль зүйн магистр Т.Саруул

Диспозитив зарчмын мөн чанар

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант С.Номынбаясгалан

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ

Хөдөлмөрний харилцаанд ялгаралтан гадуурхах явдлыг хориглох зарчим
ба хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэж буй шүүхийн практик

Удирдлагын академийн багш, хууль зүйн доктор Б.Уранцэцэг

9

27

33

42

48

54

61

71

84

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд анхаарах зарим асуудал	92
УЕПГ-ын Сургалт, судалгааны төвийн сургагч багш, хяналтын прокурор Г.Оюунболд	
Захиргааны гэрээнд иргэний хуулийн зохицуулалтыг нөхөн тохируулж хэргэлэх асуудал	97
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимиийн дадлагажигч багш, хууль зүйн магистр Т.Мөнх-Эрдэнэ	
Хэрэг маргааныг анхан шатны журмаар шийдвэрлэхэд шүүх бүрэлдэхүүний оролцоог тодорхойлж болох асуудал	107
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магистр М.Цэдэвсүрэн	
ХУУЛИЙН ТАЙЛБАР	
Кабинетийн Засгийн газрын Үндсэн хуулийн үзэл баримтлал	113
“Оюуны инноваци” Эрх зүйн судалгааны төвийн Тэргүүн, өмгөөлөгч П.Баттулга	
ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА, ТОЙМ, ҮР ДҮН	
Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын кибер аюулгүй байдлыг хангах хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалт	117
Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаач Л.Галбаатар	
Оюутны илтгэх үр чадвар хөгжихэд семинарын нелөө	130
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимиийн дадлагажигч багш, хууль зүйн магистр Э.Мөнхдаваа	
ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА	
Хувийн эрх зүйн тодорхойгүй нэр томъёо ба шүүгчийн эрх хэмжээ	137
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимиийн багш, Б.Буянхишиг	
Компанийн эрх зүйн сонирхлын зөрчилтэй хэлцлийн зохицуулалт	144
Өмгөөлөгч, хууль зүйн магистр Б.Буянтогос	
ШИНЭ БҮТЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА	160

CONTENT

BEFORE CREATING A LAW (UNDERLINE ARTICLE AND INTERVIEW)

The Constitution and Judicial Power <i>Professor Lundendorj.N (Sc.D), Chair of the General Council of Courts</i>	9
Lawyers' Self-Governing Organization <i>Interview with Mr. Vladimir Jirousek, former Chairman of the Czech Bar Association</i>	27
Law Firm <i>Sukhbaatar.Z (Ph.D), Advocate</i>	33
Some Issue of Law Making Process <i>Selenge.P, Master's student at School of Law, National University of Mongolia</i>	42

LEGAL THINKING: VIEWS AND REFLECTIONS

To Criticize the Theory Concerning 4-sided Element of The Crime <i>Bayarsaikhan.D (Ph.D), Professor, Head of Public Law Department School of Law, National University of Mongolia</i>	48
National Security and Responsibility <i>Shishmishig.J, Lawyer, Diplomat</i>	54
CEDAW and Side Presentation <i>Saruul.T, LL.M</i>	61
Nature of Dispositive Principle <i>Nomiinbaysgalan.S, Master's student at School of Law, National University of Mongolia</i>	71

IMPLEMENTATION OF EFFICIENCY AND LAW

Principle of Prohibition Discrimination in Labor Relations and Judicial Practice of Labor Disputes <i>Urantsetseg.B, (Ph.D), Lecturer, National Academy of Governance</i>	84
Some Issue of The Enforcement of Family Violence Law <i>Oyumbold.G, Public prosecutor, trainer, Research and Training Center, the Office of Prosecutor General of Mongolia</i>	92

Issue of Replacement Configuration and Usage of The Civil Law Regulations in an Administrative Agreement	97
<i>Munkh-Erdene.T, (LL.M), Lecturer of the Public Law Department, School of law, National University of Mongolia</i>	
The Aspect of Possibility for Determining The Participation of Court Panel in Resolving Disputes by Way of First Instance	107
<i>Tsedevsuren.M, (LL.M) Research of National Legal Institute</i>	
LEGAL DESCRIPTIONS	
Constitutional Concepts of the Cabinet Government	113
<i>Battulga.P, Advocate, Head of the Legal research center "Intellectual innovation"</i>	
LEGAL RESEARCHES, SUMMARY, RESULTS	
Legal Regulation of The Cooperation Providing Cyber Security of Mongolia, Russia and China	117
<i>Galbaatar.L, Researcher of the Judicial Research, Information and Training Institute</i>	
Effect of Seminars on Developing Student's Presentation Skills	130
<i>Munkhdavaa.E, (LL.M), Lecturer of the Public Law Department, School of law, National University of Mongolia</i>	
FOREIGN COUNTRY PRACTICES	
Indefinite Terms of Private Law and Competence of Judge	137
<i>Buyankhishig.B, Lecturer of the Private Law Department, School of law, National University of Mongolia</i>	
Legal Regulation of Conflict of Interest Transaction in Company Law	144
<i>Buyantogos.B, (LL.M) Advocate</i>	
INTRODUCTION OF NEW PUBLICATIONS	
	160

ҮНДСЭН ХУУЛЬ БА ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ



Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга,
хууль зүйн шинжлэх ухааны
доктор Н.Лүнэндорж

ТҮЛХҮҮР ҮГ:

Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэц, Шүүх эрх мэдэл, Шүүхийн захиргаа, Шүүхийн томилогоо, Гүйцэтгэх эрх мэдэл, Парламент, Шүүхийн тогтолцоо, Шүүхийн тогтолцоо.

ТОВЧЛОЛ:

Үндсэн хуулийн эрх зүй нь аль нэг Үндсэн хуулиар хязгаарлагддаггүй, харин хүний ташин мэдэхүйн хүрсэн түвшингөөр хязгаарлагддаг улс тэр, эрх зүйн судлagmaahuун болжээ.

Үндсэн хууль - төрийн эрхийг хязгаарладаг, хүний эрхийг хамгаалдаг хамгийн хүчтэй хэрэгсэл. Энэ утгаараа манай улсын тухайд жинхэнэ Үндсэн хуультай болоод 25-хан жилийн нүүр үзэх байгаагийн улмаас болон пост социалист орны зовлон бэрхшээлээс үүдэн Үндсэн хуулийн төрийн эрхийг хязгаарлах, хүний эрхийг хамгаалах гэсэн хоёр том чиг үргийн суурь асуудал бүрэн шийдвэргээгүй байна.

Монгол улсад төрийн эрх мэдэл бүрэн хувсаарилагдаж, хяналт, тэнцвэр хамтадаагүй, түүнчлэн хүний үндсэн

эрхийг олон улсын түвшинд дөхүүлж хуульчилсан хэдий ч хамгаалах ёстой шүүхийн хамгаалалтад оруулаагүй байна. Иймд энэхүү өгүүллээр Үндсэн хууль ба шүүх эрх мэдлийн онолын үндэслэлийг үндэсний эрх зүйн болон харьцуулсан эрх зүйн үүднээс судалж, төвч дүн шинжилгээ хийнэ.

1. Үндсэн хууль орших нөхцөл

Үндсэн хуулийн эрх зүй нь аль нэг Үндсэн хуулиар хязгаарлагддаггүй, харин хүний танин мэдэхүйн хүрсэн түвшингөөр хязгаарлагддаг улс тэр, эрх зүйн судлagmaahuун болжээ.

Үндсэн хууль - төрийн эрхийг хязгаарладаг, хүний эрхийг хамгаалдаг хамгийн хүчтэй хэрэгсэл. Энэ хоёр чиг үүрэгт өдгөө отг эргээхээс болж, түүний институуцүүд институт болон тогтох, харин одоо улсын хөгжлийг хотөлдөг, шударга, зөв удирдах тоглоомын дүрмуудийг Үндсэн хуульд суулгах, түүний шийдлүүдийг олох явдал Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны шинэ чиг хандлага болж, зохицуулалт, судлagmaahuуны тэлэлт бий болж байна.


Манай улсын тухайд жинхэнэ Үндсэн хуультай болоод 25-хан жилийн нүүр үзэх байгаагийн улмаас болон пост социалист орны зовлон бэрхшээлээс үүдэн Үндсэн хуулийн төрийн эрхийг хязгаарлах, хүний эрхийг хамгаалах гэсэн хоёр том чиг үргийн суурь асуудал бас ч бүрэн шийдвэргээгүй байна.

Монгол Улсад төрийн эрх мэдэл бүрэн хувсаарилагдаж, хяналт, тэнцвэр хамгагдаагүй байна. Хүний үндсэн эрхийг олон улсын түвшинд дөхүүлж хуульчилсан хэдий ч хамгаалах ёстой шүүхийн хамгаалалтад оруулаагүй

байна. Шүүхээр хамгаалагдаагүй эрх ямар хэмжээний эрх гэдэг нь бидэнд өдгөө их тодорхой зүйл юм.

1789 оны Францын "Хүний болон иргэний эрхийн тунхаг"-ын 16 дугаар зүйлд "Хүний эрхийн баталгааг хангаагүй, төрийн эрх мэдлийг хуваарилаагүй улсад үндсэн хууль оршдоггүй¹ гэсэн нэг ноцтой уг бий. Эргэцүүлэн бодоход энэ уг мэргэжлийн болон угаа зохиолын халилт биш юм. Үнэхээр төрийн эрх мэдлийг хуваарилаагүй улс оронд Үндсэн хуулийн үндсэн чиг үүрэг хэрэгждэггүй бид холоос хайх хэрэггүй юм. Манай улсын 1924, 1940, 1960 оны Үндсэн хуультай гэх үеийн он жилүүд "үйл явдал" бэлхэнэ нотлох билээ.

Төрийн эрх мэдлийг Үндсэн хуулиар хуваарилсан эсэхийг шалгадаг шалгуурыг хүн төрөлхтөн аль хэдийн боловсруулсан учраас энэ талаар маргах шалтгаан өдгөө бараг угүй болжээ.



Монгол Улсын төрийн эрх мэдлийн хуваарилалтын шинжилгээ

Монгол Улсын гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн хоорондын хяналт, тэнцвэрийг дээрх нийтлэг стандартаар шинжилгээ: Гүйцэтгэх эрх мэдлээс хууль тогтоох эрх мэдэл дэх хяналт (хориг болон УИХ-ыг тараах эрх) Ерөнхийлэгчээр дамжин хэрэгжихээр хуулынчилсан. Гэтэл Монгол Улсын Ерөнхийлэгч Гүйцэтгэх эрх мэдэлд хамаарч буй эсэх нь эргэлзээтэй юм. Өдгөө Ерөнхийлэгчийг "парламентын улсын ерөнхийлэгч гүйцэтгэх эрх мэдэлд багтаж ёстой" гэдэг логикоор л энэ эрх мэдэлд "хүчээр" хамаатуулж байгаа болохос хэрэг дээрээ эрх зүйн хувьд тэрээр гүйцэтгэх эрх мэдлийн төдийгүй төрийн эрх мэдлийн тогтолцооны гадна байна.

Парламентын улсын Ерөнхийлэгч, ерөнхий сайд, засгийн газрын гишүүдийг парламент болон ерөнхий

¹ Declaration of the Rights of Man, 1789, st. XVI.

сайдын санал болгосноор томилдог бүрэн эрхтэй байдаг. Үүгээр Төрийн тэргүүн, Ерөнхий сайд хоёр эрх мэдлийн хувьд эрэмбэлэгдэж, нэг эрх мэдэлд багтаж нөхцөл болдог.

Гэтэл манай Үндсэн хуулийн 33.2 дахь заалтаар Ерөнхий сайдад нэр дэвшиүүлэх Ерөнхийлөгчийн бүрэн эрх формаль, зөвхөн дамжуулагчийн үүрэг гүйцэтгэх шинжтэй бөгөөд Үндсэн хуулийн 39.2 дахь заалтаар Засгийн газрыг байгуулахад Ерөнхий сайдад давуу эрх³ олгож, Ерөнхийлөгчид зөвхөн танилцах эрх хэмжээг хэрэг дээрээс олгосон байдал.

Мөн Үндсэн хуулийн 33.3 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхэд хамаараах асуудлаар Засгийн газарт чиглэл егөх эрхтэй боловч энэ талаар Ерөнхийлөгч зарлиг гаргавал түүнд Ерөнхий сайд гарын усг зурснаар хүчин төгөлдөр болохоор заасан, Үндсэн хуулийн 43.3 дахь хэсэгт Засгийн газрыг огцруулах санал гаргах бүрэн эрхийг Ерөнхийлөгчид олгосон зэрэг нь түүнийг энэ эрх мэдэлд хамааралгүй гэдгийн нотолж байгаа мэт харагддаг. Зүй нь парламентын засгилгээний улсын Ерөнхийлөгч гүйцэтгэх эрх мэдэлд багтдагийн хувьд парламентын улс төрийн хүсэл зоригоос Засгийн газраа хамгаалж байх үүрэг хүлээн, Засгийн газрыг үндэслэлгүйгээр “оролдсон” парламентыг тараах эрх эзэлж байдаг билээ.

Үнээс гадна парламентад цөөнх болж байгаа намаас нэр дэвшиж, нийт ард түмнээс мандат авч сонгогдсон Ерөнхийлөгч, Засгийн газар хоёрыг яягаад ч нэг эрх мэдэлд шингээх бололцоо өнөөгийн улс төрийн соёлын

³ “Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвлэлээс нэр дэвшүүлсан хүнийг; аль ч нам, эвсал олонхины суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам бусад нам, эзвэлтийн зөвшлийн нэр дэвшүүлсан хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсал бусад нам, эзвэлтийн зөвшлийг, Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсал зөвшлийн олонкоороо нэр дэвшүүлсан хүнийг Ерөнхий сайдад томилж саналын тас хоногийн дотор Улсын Их Хурал оруулах” Үндсэн хуулийн гучин гуравдугаар айлын 2 дахь хэсгийг узна уу.

⁴ “Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрдэлзүүн, түүнд өөрчлөлт оруулах саналыа Ерөнхийлөгчийг зөвшлийн Улсын Их Хуралд өргөн мэргүүлж Ерөнхий сайд уул асуудлыг Ерөнхийлөгчийтэй долоо хоногийн дотор зөвшлийцэх чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэргүүлж” Үндсэн хуулийн гучин төлбөртэй зүйлийн 2 дахь хэсгийг узна уу.

орчинд бараг л боломжгүй зүйл. Тэр ч бүү хэл парламентад олонх болсон улс төрийн намаас нэр дэвшиж сонгогдсон Ерөнхийлөгч нь Засгийн газар болон Ерөнхий сайдтайгаа улс төрийн байр суурь, үзэл бодлын ялгаатай бол нэг эрх мэдэлд багтах нь бүү хэл “нэг байшинд багтахад” хэцүү байсан үеийг монголчууд мэдэх билээ. Тийм учраас ерөнхийлөгчийг гүйцэтгэх эрх мэдлийн салаанд багтаж байгаа гэж үзэх эрх зүйн (де юре) болон бодит (де факто) үндэслэл харгадахгүй байгаа юм. Үүний улмаас хуульд тавих Ерөнхийлөгчийн хоригийг гүйцэтгэх эрх мэдлээс хууль тогтоох эрх мэдлийг хянаж, тэнцвэрэйг хянаж байгаа механизм гэж үзэх үндэслэл хомстож, улмаар гүйцэтгэх эрх мэдлээс хууль тогтоох эрх мэдлийг хянаж, тэнцвэржих гол механизмыг (засгийн газар хууль санаачилж байгааг эс тооцвол) Монгол Улсад сонгодог утгаараа байхгүй гэхэд хилсдэхгүй. Түүчлэн, Ерөнхийлөгчийн тавьсан хоригийн олонх нь Засгийн газраас санаачилсан хуульд хамааралтай байгааг нэмж тооцох хэрэгтэй. Хэрэв Ерөнхийлөгч гүйцэтгэх эрх мэдэлд багтаж байгаа бол Засгийн газрын санаачилсан хуульд урьдчилан санаалаа өгөх албан ёсны механизм ч байх ёстой билээ.

Тэгэхлээр, Гүйцэтгэх эрх мэдлээс хууль тогтоох эрх мэдлийг хянах гол механизмыг УИХ-ын хууль болон бусад шийдвэрт хориг тавих эрхийг Ерөнхийлөгчид олгосон нь гүйцэтгэх эрх мэдлийн хяналт мөн эсэх нь эргэлзээтэй, мөн УИХ-ыг тараах эрхийг ёөрт нь, Ерөнхийлөгчид олгосон нь нэхцэлт шинжтэй⁴ зэрэгээс үзэхэд Гүйцэтгэх эрх мэдлээс парламентыг хянах гол стандарт хангагдаагүй гэж дүгнэхээр байна.

⁴ “Тухайлбал, УИХ бүрэн эрхээс хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүдийн гуравны хөөрөс доошгүй нь узсан тохиолдолд Ерөнхийлөгч УИХ-ын дартагийт зөвшлийн санал болгох, мөн Ерөнхий сайдыг УИХ-д санал болгосноос хойж 45 хоногийн дотор хэлэлцэн шинжээрэлж чадаагүй бол УИХ тараахар нэхцэл зассан байдал” Үндсэн хуулийн хорин хөфргүүлэг зүйлийн 2 дахь хэсгийг узна уу.

Хууль тогтоох эрх мэдлээс гүйцэтгэх эрх мэдэлд хяналт тавих механизм бүрэн хэрэгжээд зогсохгүй зарим нь "хэт даван" биөлж буйгаас харахад хууль тогтоох эрх мэдэл илт давуу байдалтай байна.

Гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн хяналт, тэнцвэрийг шинжилбэл: Монгол Улсын Үндсэн хуулийн 51.2 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгч бүх шатны шүүгчийг томилж буйг гүйцэтгэх эрх мэдлийн хяналт гэж үзэх үү гэсэн асуулт дахин үүсдэг.

Үндсэн хуулийн Цэц Үндсэн хуулийн 66.2.1, 66.2.3 дахь хэсэгт зааснаар Ерөнхийлөгч, Засгийн газрын шийдвэр, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийн Үндсэн хууль зөрчсөн эсвэл хяналт буйг Үндсэн хуулийн Цэц шүүхийн үндсэн тогтолцооны гадна байгаа үндэслэлээр шүүх эрх мэдлийн хяналт гэж үзэх үү гэж асууж бас болно.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд шүүхийн тогтолцоо нэгдмэл байна гэсэн нэг гун утгатай үг бий. Гэтэл хэрэг дээрээ энэ заалт хэрэгжихгүй нэгдмэл бүс байна.

Үндсэн хуулийн шүүхнь парламент, засгийн газрын ўйл ажиллагаа, хууль, шийдвэрт төдийгүй бусад шүүхийн шийдвэрийт ч Үндсэн хуулийн эрх зүйн үүднээс хянах, төрийн эрх мэдлүүдийн хооронд зохицуулагчийн үүргэгтэй байхаар хуульчилсан улс орнууд ч үндсэн хуулийн шүүхээ шүүхийн үндсэн тогтолцоондо оруулдаг⁵. Тухайлбал, ХБНГУ-ын Үндсэн хуулийн 92 дугаар зүйлд "Шүүх эрх мэдлийг үндсэн хуулийн, холбооны, энхүү үндсэн хуульт заасан шүүхийн шүүгчид хэрэгжүүлнэ", ОХУ-ын Үндсэн хуулийн 118 дугаар зүйлд "Шүүх эрх мэдлийг үндсэн хуулийн, иргэний, захиргааны, эрүүгийн хэргийг шүүн таслах шүүхүүд хэрэгжүүлнэ". Болгар Улсын Үндсэн хуулийн 119 дүгээр зүйлд "Шүүх эрх мэдлийг хяналтын дээд, захиргааны дээд, давж заалдах, тойргийн, цэргийн,

⁵ ХБНГУ-ын Үндсэн хуулийн 92 дугаар зүйлийн 1 дахь хасгийг үзнэ үү.

дүүргийн шүүхүүд хэрэгжүүлнэ" гэж тодорхой заасан байдаг. Энэ жишгээр Монгол Улсын Үндсэн хуулийн аюуны төсөлд "Монгол Улсад шүүх эрх мэдлийг Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн болон бус нутгийн шүүх, мен Үндсэн хуулийн Цэц хэрэгжүүлнэ" гэж томьёолссан байсны "учрыг үл ухан, хий болгоюнажтон маргасаар тус хэсгээс хасаг, өөр бие даасан бүс дугаар булэг болгон "шилжүүлсэн" нь өдгөө асуудал ҮССэж байна гэж БЧимид агсан бичсэн нь бий.

Монгол Улсын Үндсэн хуулийн 48.1 дахь хэсэгт "Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дүйн, дүүргийн шүүхээс бурдэх..." гэж тодорхой зассан. Энд Үндсэн хуулийн Цэц байж үйлбайгааг бид харж байна. ХБНГУ-ын эрдэмтэн, профессор Хайнрих Шоппер "Үндсэн хуулийн шүүх нь шүүх эрх мэдлийн бүрэлдэхүүн хэсэг үү, албан ёснуулж хууль тогтоох эрх мэдлийг толгойлогч уу хэмээн зүйл гол асуудал болж байлаа. Үндсэн хуульд тусгагдсан гэдгээр нь л ердөө энэ шинэ байгууллагыг шүүх эрх мэдэлд багтаан оруулахад мэдээжийн хэрэг хангальгүй"⁶ гэжээ.

Үндсэн хуулийн Цэцийг шүүхийн үндсэн тогтолцооны гадна байгааг Үндсэн хуулийн веер бүлэгт эрх хэмжээг нь тусгайлан заасан дагнасан шүүх гэж хүчээр шүүх эрх мэдэлд багтаах оролдлого бас бий. Гэтэл Үндсэн хуулийн Цэцийг дагнасан шүүх гэж үзвэл Үндсэн хуулийн 48.1 дахь хэсэгт зааснаар шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтад байх болно. Тийм учраас Үндсэн хуулийн Цэц дагнасан шүүх биш юм. Дагнасан шүүх биш учраас Үндсэн хуулиар тодорхойлсон Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцооны гадна байгаа веер төрлийн шүүх болж таарна. Гэтэл шүүхийн

⁶ Чимид Б. Шүүх эрх мэдлийн талаарх үндсэн хуулийн үзэл баримтлалын тухайд: "Монгол Улсын үндсэн хуулийн цэц" өгүүлэл, илтгэлийн эмсэгтэл, УБ., 2007 он, 27 дахь тал.

⁷ Шолпер Х. Үндсэн хуулийн шүүх гурав дахь эрх мэдлийн бүрэлдэхүүн хэсэг болох нь "Монгол Улсын үндсэн хуулийн цэц" өгүүлэл, илтгэлийн эмсэгтэл, УБ., 2007 он, 405 дахь тал.

Үндсэн тогтолцоонд ердийн болон дагнасан шүүхээс өөр төрлийн шүүх байх Үндсэн хуулийн эрх зүйн болопцоо байхгүй байгаа учраас Үндсэн хуулийн Цэцийг Үндсэн хуульд заасан шүүхийн үндсэн тогтолцооны гадна байгаа, Үндсэн хуулиар эрх хэмжээг нь тусад нь тодорхойлсон “төрөлжсөн” эсвэл “бие даасан” шүүх гэж үзэхэд хүрээд байна.

Үндсэн хуулийн Цэцийг дагнасан шүүхийн шинжийг агуулаагүй, төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд Үндсэн хуульд заасан эрх хэмжээний хүрээнд эрх тэгш оролцог “үндсэн хуулийн байгууллага”⁸, “төрөлжсөн”⁹ шүүх гэж мэтээр янз бүрээр авч үзсэн нь бий. Ийнхүү Үндсэн хуулийн Цэцийг Үндсэн хуулийн 48.1 дэх хэсэгт тодорхойлсон Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцооны гадна байгаа, бие даасан төрөлжсөн, шүүх эрх мэдлийн бүрэлдэхүүнд хамаарах шүүх гэж “хүчээр” үзэхэд хүрч байгаа юм. Гэтэл дэлхийн улс орнууд нь Үндсэн хуулийн шүүхийг шүүх эрх мэдлийн бүрэлдэхүүнд Үндсэн хуулиараа багтаасан атлаа “шүүх эрх мэдлийн бүтцээс гарч дөрөв дэх эрх мэдэл болох гэсэн хандлагатай байdag нь маргаангүй”¹⁰ учраас шүүх эрх мэдлийн үндсэн тогтолцоондоо ороогүй байгаа манай Үндсэн хуулийн Цэц цааш нэг алхаад л дөрөв дэх эрх мэдэл болох болопцоо нээлттэй байна.

Үндсэн хууль тулгуур хууль учраас түүний зохицуулалт, хэм хэмжээ нь эрх зүйн гүнзгийг агуула, нарийн техниктэй байх ёстой. Энэ хуулийн зүйл, заалтыг хэн нэг нь тааварлан ойлгох, зоргоор нийлуулж, салгаж, тайлбарлах учиргүй. Гэтэл Үндсэн хуулийн Цэц болон Ерөнхийлөгчийн институтц өнөөдөр аль эрх мэдэлд багтаж байгаа тухайд

⁸ Мен тэнд. 73 дахь талаас үзнэ үү

⁹ Сөнөр Үндсэн хуулийн хяналтын тогтолцоонд үндсэн хуулийн цэцийн эзлэх байр, Ж.Амарсанаа. Үндсэн хуулийн цаа ба эзиргираваны харгимн шүүх. “Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц” өгүүлэл, илтгэглийн эмхэтгэл, УБ., 2007 он, 91, 318 дахь талаас үзнэ үү.

¹⁰ Шоллер Х. Үндсэн хуулийн шүүх гурав дахь эрх мэдлийн бүрэлдэхүүн хэсэг болох нь “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц” өгүүлэл, илтгэглийн эмхэтгэл, УБ., 2007 он, 411 дахь тал.

судлаачид маргаж, хүчээр аль нэг талд хамруулж байгаа нь асуудал бодитой оршиж байгаагийн илэрхийлэл болж байгаа юм. Үндсэн хуулийн байгууллын тогтолцооны хамаарал маргаан, эргэлзээс дуудсан байх нь бүү хэл, хэн ч салаа утгаар ойлгохооргүй, тодорхой байх эрх зүйт ёсны шаардлага мэн.

Эндээс үсэж байгаа гол асуудал бол шүүхийн үндсэн тогтолцооны гадна байгаа Үндсэн хуулийн Цэц. Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлж байгаа нь шүүх эрх мэдлийн нэгдмэл байх зарчим алдагдаж байна гэж үзэхэд хүрнэ. Хэрэв Үндсэн хуулийн Цэцийг шүүхийн үндсэн тогтолцоонд оруулбал шүүх эрх мэдлийн салгүй хэсэг болж, шүүх эрх мэдлийн нэгдмэл байдал хангагдан, төрийн эрх мэдлийн бусад салааны эсрэг шүүхийн хяналтын нэгдмэл хүчигт бэхжүүлэхэд чухал алхам болно.

Ерөнхийлөгчийн болон Үндсэн хуулийн Цэцийн эрх мэдлийн харьялал Үндсэн хуулиар нэг мөр, бүрэн тодорхойлогоогүй хэдий ч хэрэгжүүлж байгаа бүрэн эрхийн агуулгаар нь авч үзвэл гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн хоорондын хяналт хэрэгжиж байна.¹¹

Шүүх эрх мэдэл болон хууль тогтоох эрх мэдлийн хяналт, тэнцвэрэйг шинжилбэл: Шүүх эрх мэдлээс хууль тогтоох эрх мэдэлд тавих уламжлалт хяналтууд Монголд хэрэгжих байгаа бөгөөд эдгээр нь Үндсэн хуулийн Цэц (үүнийг шүүх эрх мэдлийн нэг хэсэг гэж үзвэл)-ийн түвшинд УИХ-аас баталсан хууль, бусад шийдвэрт Үндсэн хуулийн хяналт тавих, харин ердийн шүүхийн түвшинд Үндсэн хуульд нийцэгүй хуулийг хэрэглэхгүй байх, тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль нь Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж үзвэл тухайн хэрэг, маргааныг хянан

¹¹ Шүүх гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаанд хангалият хяналт тавьж чадлагад газгүй судалгаанд оролцсон эзргэлтийн 64 хувь нь “Огт санал нийлэхгүй! Санал нийлэхгүй!” гэж харилцээ. Уайт Б.Т. “Голдоо хүртэл ялзарсан уу? Монгол Улсын шүүхийн шинжлэлийн өнөөгийн байдалд хисэн судалгааны тайлтан”. Нээлттэй Нийгэм Форум УБ., 2008 он.

шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, саналаа Улсын дээд шүүхэд оруулах, Улсын дээд шүүх тухайн асуудлыг авч хэлэлцээд үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн Цэцэд хүснэгт гаргах¹² зэрэгээр хэрэгжих байна.

Хууль тогтоо эрх мэдлээс Үндсэн хуулийн Цэцэйн гишүүдийг томилох, эргүүлэн татах, Улсын дээд шүүхийн шүүгчийг томилогохын өмнө Ерөнхий зөвлөлийн санал болгосноор Улсын Их Хурал танилцах зэргээр шүүхийн томилгоонд их, бага хэмжээгээр оролцохын зэрэгцээ шүүх эрх мэдлийн бүхий л үйл ажиллагааг хууль тогтоо агаар хянах байна. Энэ бол хууль тогтоо болон шүүх эрх мэдлийн хооронд харилцан хяналтын зарчим хэрэгжих бүй илтгэнэ. Харин шүүх эрх мэдлийг хууль тогтоо эрх мэдлэлтэй тэнцвэржүүлэх үүрэгтэй шүүхийн хараат бус байдлын дархланы институуцд бүрэлдээгүй байгаа нь эрх мэдлийн тэнцвэржийг алдагдуулж байна.

Эцэст нь дүгнэхэд: Монгол Улсын төрийн тогтолцоонд үссэн бэрхшээлийг зөв оношилж, хүлээн зөвшөөрч, төрийн эрх мэдлийн салаа бүрүг төлөөлөх субъектиг олон улсын жишиг, Үндсэн хуулийн эрх зүйн үүднээс дахин тодорхойлж, эрх мэдлийг хяналт, тэнцвэрийн зарчмаар шинээр хуваарилж, төрийн тогтолцоог парламентын улсын жишигт нийцүүлэх шаардлага бодитой бий болсон байна.

2. Шүүх эрх мэдлийн Үндсэн хуулийн зохицуулалтын хөгжил

Одоо шүүх эрх мэдлийг Үндсэн хуулиар хэрхэн хамгаалж, бэхжүүлдэг, өдгөө энэ асуудал хэрхэн стандартчилагдсан талаарх ажиглалт, судалгаанд Та бүхний анхаарлыг хандуулъя.

XVIII, XIX зуунд батлагдсан түрүү үеийн зарим Үндсэн хууль (АНУ, Франц, Польш, Норвеги, Бельги, Люксенбург) дахь шүүх эрх мэдлийн зохицуулалтыг харьцуулан судалж үзвэл шүүх эрх

мэдлийг өөр эрх мэдлээс хэрэгжүүлж болохгүй гэдэг дээр гол анхаарлаа хандуулж байсан нь харгадана. Харин шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал, шүүгчийн хариуцлага болон шүүхийн эдийн засгийн талаар нарийвчлан зохицуулсан хэм хэмжээ ховор гэж хэлж болно. Харин эдгээр хуулиудад шүүгчийг хэн томилох, ямар ямар шүүх байх, түүний эрх хэмжээ, шүүх хэрэг маргаан шийдвэрдээ баримтлах процессын суурь зарчмуудыг тулхуу зохицуулсан байна. Бельги, Люксенбургийн Үндсэн хуулид "Шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байна" гэж заасан нь урт удаан түүхийг дамжин уламжлагдсаар байгаа сонирхол татахуйц, бидний тухайд шинэ гэмэр хэм хэмжээ юм.

ХХ зууны дунд үеэр батлагдсан зарим улсын (ХБНГУ, Франц, Итали, Испани, Япон) Үндсэн хууль дахь шүүх эрх мэдлийн зохицуулалтыг харьцуулан судлахад шүүх эрх мэдлийн тогтолцооны түрүү үеийн уламжлалт зохицуулалтаас гадна шүүхийн захирага, эрх хэмжээ, бурэлдэхүүн, чиг үүрэг¹³ гэсэн институт шинээр гол байр суурь эзэлж эхэлсан байна. Тухайлбал, Францын Үндсэн хуулийн шүүх эрх мэдлийн хэсэг бүхэлдээ шүүхийн захирагаанд зориулсан, Италийн Үндсэн хуульд мөн гол байр суурь эзэлснээс харгадана. Үүнээс гадна органик болон ердийн хуулиар зохицуулахад бэрхшээлтэй зарим зохицуулалт шинээр орсон байна. Жишээ нь, төрийн өндөр албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэх¹⁴, дээд шатны шүүх Үндсэн хууль зөрчвэл хүлээлгэх хариуцлага¹⁵ дээд шатны шүүгчдийг тодорхой хугацаанд санал хураалтад оруулах¹⁶ зэрэг уламжлалт бус асуудлуудыг зохицуулсан байна. Үүнээс гадна хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад шууд чиглэсэн процессын

¹² Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 7.4, 7.5 дахь хэсэг.

¹³ Франц-улсын Үндсэн хуулийн 64,65, Итали, Испани, Япон улсын Үндсэн хуулийн 104, 122 дугаар зүйлийн үзүү.

¹⁴ Мен куулийн Х хэсэг

¹⁵ ХБНГУ-ын Үндсэн хууль 98 дугаар зүйл

¹⁶ Япон улсын Үндсэн хууль 98 дугаар зүйл

шударга зарчмуудыг ч бас орхиогүй байна.

Харин ардчиллыг сэргээн тоогоосон, пост социалист зарим орны (ОХУ, Латвия, Литва, Эстон, Польш, Унгар) шүүх эрх мэдлийн Үндсэн хуулийн зохицуулалтыг судлахад ерөнхий, тунхаг шинжтэй, техник муттай¹⁷, зөвлөлт маягийн¹⁸ зохицуулалттай, эрх зүйн шударга процессын зарчмуудыг хуульчлаагүй, шүүгч нам бус байх, улс төрийн үйл ажиллагаанд оролцожгүй гэх мэт онцлогаар гарагдана. Харин Үндсэн хуулийн шүүх, шүүхийн захирага, дагнасан шүүх, шүүхийн эдийн засаг зэрэг шинэ зохицуулалтыг зарим улс хүлээн авсан байна. Зүй нь эдгээр улсууд Үндсэн хуультыг ёсны орчин үеийн ололтод тулгуурлан чамбай үндсэн хууль бүтээж бололцоо байсан ч тэжж чадаагүйг нь социалист сэтгэлгээний ул мөртэй холбон үзэхээс өөр арагтай.

Шүүх эрх мэдлийн Үндсэн хуулийн зохицуулалтын хамрах хүрээ, суурь стандартыг дээрх ажиглалт, судалгаанд тулгуурлан тоймловол: (1) Шүүхийн тогтолцоо, (2) Шүүхийн бие даасан байдал, (3) Шүүгчийн хараат бус байдал, (4) Шүүхийн захирага, (5) Шүүгчийн томилгоо, (6) Шүүхийн үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчмын зэрэг институт нийтлэг байна. Ялангуяа өдгөө Үндсэн хуулийн шүүх, шүүхийн захирага зэрэг институт Үндсэн хуулийн шүүх эрх мэдлийн тогтолцоонд онцгой байр эзлэх болсон байна.

Эдгээр нийтлэг стандартаар Монгол Улсын Үндсэн хуулийн шүүх эрх мэдлийн зохицуулалтыг шинжилж үзэвл дээрх институуцүүд бараг бүхэлдээ тусгагдсан хэдий ч агуулга, чамар, техникийн хувьд зарим ялгаа бүхий байгааг тодруулсан шинжилгээнд та бүхний анхаарлыг хандуулъя.

¹⁷ Кийзээ нь шүүхийн тогтолцоог байршилаар районы, мукуйийн, зогсмын шүүх гах матээр ярианы хэлээр нэрлэж, дараа ч тэр шүүхийн инхэн шатны гэж үзэн гах матээр бичсан байдал.

¹⁸ Үндэснэгийн прокурорын байгууллагыг Үндсэн хуулийн гуулжин түвшинд зохицуулсаны хэлж байна

3. Монгол Улсын Үндсэн хууль дахь Шүүх эрх мэдлийн зохицуулалтад хийсэн шинжилгээ

Дэлхийн улс орнуудын Үндсэн хуульд шүүхийн тогтолцоог нэгдмэл байдааар томьёолж, бусад эрх мэдэлтэй тэнцэвэржүүлэх чиг хандлага баримталж байна. Харин манай улсын тухайд Үндсэн хуулийн түвшинд шүүх эрх мэдэл нэгдмэл биш бөгөөд Үндсэн хуулийн шүүх бие даасан эрх мэдэл болох чиг хандлагатай байгааг өмнө нь тэмдэглэсэн билээ.

Үндсэн хуулийн 48.1 дэх хэсэгт шүүхийн тогтолцоог буруу техникиэр бичсэндийн улмаас "шүүхийн тогтолцоо" гэсэн нийтлэг ойлголтын утгыг гүйвуулан тайлбарлах янз бүрээр ойлгох нөхцлийг бурдуулсан. Давж заалдах шатны шүүхээс "аймгийн шүүх", "Нийслэлийн" гэж хуучны ярианы хэлээр Үндсэн хуульдаа бичсан нь хууль зүйн техникийн алдаа гэдэг нь бараг эргэлзээгүй юм. Харин энэ алдааг тайлбараар засаж чадахгүй байгаа нь социалист сэтгэлгээний өв, эмгэг үү эсвэл улс төрийн асуудал уу гэж бодоход хүргэдэг.

Шүүхийн тогтолцоогоо засаг захирагааны нэгжээр нэрлэдэг энэ буруу техникиэр зөвхөн манай оронд бус пост социалист орнуудад¹⁹ бас цөөнгүй байгаа нь эдгээр орнуудын социализмын үеийн засаг захирагааны нэгжээр намын үүр хороодыг байгуулж, түүгээр дамжуулж бүхнийг хянаж байсан тоталитар бодлоготой холбоотой бөгөөд тэрхүү тогтолцоо арга барил, сэтгэлгээний буруу өв хадгалагдсан гэж хэлж болмоор байна.

Шүүхийн тогтолцооны гол мөн чанар нь Хүний эрхийн түгээмэл Тунхаг, Иргэний болон улс төрийн эрхийн пактад заасны дагуу хүний гомдох, давж заалдах эрхийг хангах шатлал билээ. Үндсэн хуулийн 48.1 дэх хэсэгт "Шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын дүүргийн шүүхээс

¹⁹ Литва, Эстон зэрэг орны Үндсэн хуулийг үзэн үү.

бүрдэх..." гэж засаг захиргааны нэрээр шүүхээ нэрлэж, хэл зүйн буруу техник хэрэглэсний Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн Шүүхийн тогтолцоого гэсэн тусгай зүйлээр "Шүүхийн үндсан тогтолцоо нь Улсын дээд шүүх (хяналтын шатны шүүх), аймаг, нийслэлийн шүүх (давж заалдах шатны шүүх), сум буюу сум дундын, дүүргийн шүүх (анхан шатны шүүх)-ээс бүрдэнэ гэж органик хуулиар запруулан тайлбарласан ч тусыг эс олсоор байна. Тийм учраас дэлхийн улс орнуудын жишгээр шүүхээс хууль тайлбарлах стандартыг **Үндсэн хуулийн түвшинд хуульчлах шаардлага чухал байна.** Жишиг нь, АНУ-ын Үндсэн хуулийн 4 дүгээр зүйл III хэсэг (2)-д "Энэхүү үндсан хууль дахь нэг Ч заалтыг Нэгдсэн улсын, эсвэл гэль нэг тодорхой муж улсын эрх ашигт хохирол учруулахаар тайлбар хийж болохгүй". Мен тус хуулийн 9 дүгээр нэмэлтэд "Үндсэн хуульд заасан тодорхой эрхийг ард түмний бусад эрхийг угыйгэх буюу баагасгах байдлаар тайлбарлаж болохгүй", мөн Унгар улсын Үндсэн хуулийн 28 дугаар зүйлд шүүгч хууль тайлбарлахдаа эдийн засагт хохирол учруулахаар, ухаалаг бус байдлаар тайлбарлахгүй гэх мэтээр хуулычилсан байна. Шүүхийн тогтолцооны мен чанар, агуулга нь хүний давж заалдах эрхийг шүүхийн шатуудаар хангуулахад л оршдог учраас уг асуудлыг Үндсэн хуулиар зохицуулдаг. Зарим орны Үндсэн хууль шүүхийн шатлал буюу тогтолцоо хоёроос доош байж болохгүй гэж заасан улс ч бий. Хаана шүүх байхыг Үндсэн хуулиар зохицуулдаггүй. Зохицуулж болдоггүй. Хаана хэрэгцээ үүснэ тэнд шүүхийг байгуулж болно. Тэр бололцоо бүрийг урьдчилж Үндсэн хуульд бичих бололцоо байхгүй. Хаана байгуулах хэрэгцээ тэрнэ тэр үед нь парламент хууль гаргаж шийддэг ёстой. Хаана шүүх байж нь Үндсэн хуулийн зохицуулалт шаардсан асуудал биш юм. Тийм учраас Монгол Улсын Үндсэн хууль дахь шүүхийн тогтолцооны зохицуулалтад боловсронгуй болгох асуудал байна.

Шүүхийн бие даасан байдал - хамгийн өргөн угтгаараа шүүх эрх мэдэл автономи орших тухай юм. Хэнээс юунаас автономи байх вэ? Мэдээж шүүх бие даасан эрх мэдэл, институтийн хувьд бусад эрх мэдэлээс автономи байхаас гадна шүүгчийг хуулиас ёэр ю ч захирахгүй гэсэн утгыг бас агуулна. Мен үнээс гадна шүүх, шүүгч териийн хамгаалалтад байж ёстойг илрэхийлдэг.

Тэгэхлээр, шүүхийн бие даасан байдал нь *институтийн, бүтцийн, чиг үргийн, эрх хэмжээний, нөөцийн*²⁰

²⁰ Гаджиев Г.А. Конституционный принцип самостоятельности судебной власти в РФ // Журнал Российской права. 2003. №1. Абросимова Е. Б. Судебная, законодательная и исполнительная власть: проблемы взаимоотношений и пределы воздействия // Самостоятельность и независимость судебной власти Российской Федерации. М., 2006. Алексеев С. С. Общая теория социалистического права. Свердловск, 1983. Алексеев С. С. Право. Опыт комплексного исследования. М., 1999. Бозров В. Контрольная функция суда // Российская юстиция. 1996. N 11. Боников А. Д. Третья власть в России. Очерки о правосудии, законности, судебной реформе 1990 - 1996 гг. М., 1997. Будаев К. А. О конституционных основах судебной власти в России // Конституционные основы судебной власти. Материалы Всероссийской научной конференции. М., 2004. Гаджиев Г. А. Конституционный принцип самостоятельности судебной власти в РФ // Журнал российского права. 2003. N 1. Даль В. Толковый словарь. Т. 2. М., 1956. Ермошин Г. Т. Статус судьи Российской Федерации. М., 2004. Золотухин Б. Правда и милость да царствуют в судах. Три источника и три составные части Концепции судебной реформы 1991 года // Российская юстиция. 2001. N 12. Кадровый состав судебного корпуса // Российская юстиция. 1999. N 8. Кузнецова И. В. А судьи кто? // Государство и право. 1994. N 8 - 9. Лазарева В. А. Судебная власть. Судебная защита. Судебный контроль: понятие и соотношение. Самара, 1999. Лебедев В. М. Судейская мантня на каждом по плечу // Российская газета. 2000. 23 ноября. Маклаева Т. Н. Судебная власть в системе разделения властей. М., 2003. Палиев М. С., Пащен С. А., Савицкий В. М. Закон о статусе судей в Российской Федерации. Научно-практический комментарий. М., 1994. Радченко В. И. Судебная реформа в России // Журнал российского права. 1991. N 1. Савельева Т. А. Судебная власть в гражданском процессе. Саратов, 1997. Самостоятельность и независимость судебной власти в Российской Федерации. М., 2006. Стецовский Ю. И. Судебная власть. Учебное пособие. М., 1999. Судебная власть. М., 2003. Судья. Ноябрь 2004. Спецвыпуск. Тихомиров Ю. А. Конституционные основы судебной системы // Судебная власть в России: роль судебной практики. М., 2002. Топорин Б. Н. Гражданение судебной власти в России: общие подходы // Судебная реформа: проблемы и перспективы. М., 2001. Цихоцкий А. В. Теоретические проблемы эффективности правосудия по гражданским делам. Новосибирск, 1997. Чепурнова Н. М. Конституционные принципы судебной власти и проблемы формирования судебной системы в субъектах Российской Федерации. Ростов н/Д, 1999. С.1

хувьд нөгөө хоёр эрх мэдэлтэй эрх тэгш, тусгаар байх тухай юм.

Шүүх *институцийн* хувьд бие даасан гэдэг нь бусад эрх мэдэлтэй эрх тэгш оршдог, эрх мэдлүүдийг эрэмбэлдэггүй, тийм үнэлэмж, сэтглээс, соёл, хууль ёс бүрэлдэхийг, хараат бус байдлыг хангаж, хамгаалах захирагаатай болсон байхыг; шүүх *бүтцийн* хувьд бие даасан байна гэдэг нь шүүх эрх мэдлээс хэрэгжүүлэхдээс бусад эрх мэдлээс үл хамаарах өөрийн бие даасан байгууллагын тогтолцоо, бүтцээр дамжуулсан хэрэгжүүлж, өөр эрх мэдэлд бүтцийн хувьд хамаарах, захирагдахгүй байхыг; чиг *үүргийн* хувьд бие даасан байх гэдэг нь шүүн шийдэх ажлаа хэнтэй ч хуваалцахгүй, давхардахгүй, шилжүүлэхгүй, зэрэгцэн өөр субъект хэрэгжүүлэхгүй байхыг; шүүх эрх *хэмжээний* хувьд бие даасан байна гэдэг нь шийдвэрээ зөвхөн хуульд нийцүүлэн хэнээс ч хараат бусаар гаргадаг, тэр нь эсийнхийн байх чанарыг; шүүх *нөөцийн* хувьд бие даасан байна гэдэг нь хүний болон материаллаг нөөцтэй, бие даасан төсөвтэй, түүнийгээ захиран зарцуулсан эрхтэй, тэр нь хүрэлцээтэй, хамгаалалтай байхыг тус ойлгоно.

Шүүхийн бие даасан байдлын дээрх элементээр Монгол Улсын Үндсэн хуулийн зохицуулалтыг шинжилж үзвэл ихэнх элемент хэрэгжик байгаа гэж дүгнэж болно.

Харин шүүх эрх мэдэл нөөцийн хувьд бие даасан байх нь институцийн түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн хэдий ч тэр нь институт болж тогтоогүй байна. Ганцхан жишээ хэлэхэд Дархан хот дахь эрүү, иргэн, захирагааны хэргийн анхан шатны шүүх ОХУ-ын түрэсийн байранд олон жил болж байгааг дурдахад хангальттай.

Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэгт “Шүүх ўйл ажиллагаа явуулах здийн засгийн баталгааг тэр хангана” гэж заасан нь шүүхийн материаллаг нөөц хангалтай, хүрэлцэхүйц байх, эрэлт хэрэгцээг бие даан тодорхойлох бололцоог хангахуйц

зохицуулалт, хамгаалалт болж чадахгүй байна. Шүүхийн болон шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар арай дэлгэрүүлж зохицуулсан шүүхийн төсөв, шүүгчийн цалинтай холбоотой хамгаалалтыг өнгөрсөн парламент бүхэлд нь хүчингүй болгосон нь үүнийг нотолно. Ийм учраас шүүхийн нөөцийн бие даасан байдлыг хангахын тулд улс териин соёлыг хөгжлийг хүлээх бус Үндсэн хуулийн түвшинд хэрэгжихиں баталгааг процессжуулан зохицуулах шаардлага байсаар байна. Энэ асуудал дэлхийн бусад орнууд ч бас бэрхшээл дагуулсан хэвээр. Цөөнгүй улс шүүхийн материаллаг нөөцийн гол эх сурвалж болох шүүхийн төсвийг улсын төсөвт эзлэх хувь хэмжээг тодорхой хувь зааж тусгас болсон нь арга барсан хэрэг гэж үзэж болно. Одоогийн байдлаар Латин-Америкийн 10 орчим орны Үндсэн хуульд ийм зохицуулалт²¹ байна. Шүүхийн багц хуулийн төслийг боловсруулж байх үед ийм санал бас гарч байсан юм. Хэдийгээр энэ нь арга тасарсан, агуулга, мөн чанар, техникийн хувьд оновчтой биш боловч бидний хүрсэн түвшинд хэрэгтэй ч байж мэдэх зохицуулалт юм.

Шүүх эрх мэдлийн чиг үүргийг өөр субъект хэрэгжүүлэх явдал Монгол Улсад бас бүрэн шийдэгдээгүй байна. Зарим хууль сахиулагч²², мэргэжлийн хяналтын байцаагч²³, шүүх хуралдааны нэг оролцогч прокурор шүүх эрх мэдлийн чиг үүргийг хуульчилсны дагуу хэрэгжүүлсээр байна.

Дээрх үндэслэл, шалтгаанаар шүүх чиг үүргийн хувьд шүүх эрх мэдэл бүрэн бие даасан гэх стандартыг хангасан гэж үзэж хараахан болохгүй байна.

Шүүгчийн хараат бус байдлыг Монгол Улс “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” (49.1) гэсэн үндсэн хуулийн хэм хэмжээгээр

²¹ Ellyn Skaar. Judicial Independence and Human Rights in Latin America (2011)

²² ЗБШХ-ийн 28 2 дахь хэсгийг үзнэ үү.

²³ Жиншээблэл, Төрийн хянант шалгалтын тухай хуулийн 10.9.7 дахь залвтыг үзн үү.

олон улсын нийтлэг жишигийн түвшинд хамгаалсан.²⁴ Шүүгчийг хуулиас өөр юу ч захирагхуй гэсэн утгатай энэ хэм хэмжээш шүүгчийн албаны (Institutional Independence)²⁵ болон хувийн (Personal Independence)²⁶ гэсэн хоёр түвшинд хамгаалагдаж, хэрэгжих бөгөөд эхнийх нь төрөөс, хоёр дахь нь шүүгчээс өөрсдөөс нь голчлон хамаарна. Аль нь тэргүүлэх ач холбогдолтой тодорхойлох аргагийг бөгөөд аль нэг нь дутгахад шүүх эрх мэдэл хараат бус орших баталгаагаа алдаж байдаг. Гэвч зарим судлаач эрэмбэлэх оролдлого хийсн нь бий. Тухайлбал, Израилийн шүүгч, судлаач А.Берек шүүгчийн албаны хараат бус байдал бол шийдвэрлэх нөхцөл мөн гэж үзжээ. Энэ дүгнэлтээ тэрээр цааш нь дэлгэрүүлэн тайлбарлахдаа шүүгчийн хувийн хараат бус байдал бол шүүх эрх мэдлийн зайлшгүй нөхцөл мөн боловч хангалттай нөхцөл бас биш гээд, шүүгчийн хувийн хараат бус байдал бол шүүх эрх мэдлийн институтийн хараат бус байдалтай хавсралгүйгээр

²⁴ Шүүх эрх мэдэл харягдуулэх албан ажил, мэргэшлийн хувьд шүүгч нь парламент, засгийн газар, нутгийн эрх барих ба зэхиргээнь байгууллагын албан тушаалтан хийгээд дэд шатны шүүгч, түүхэнд тухайн шүүгчийн ерөнхий шүүгч, шүүгчийн орлогод гэжэлэн шатлан хэзиргэдэг байгүй. Хамгийн эзлэж жишиг гэвэл шүүхэд хэрэг, маргааны хэн, хэн авч шийдвэржийн ерөнхий шүүгч хувьцаарилж “ни шийд” гэж тушаах байгүй. “Тэгэх ингэж шийд” гэх нь бур ч цээртэй. Чимид Б. Үндэснэхийн хуулийн үзэл баримтлал. Хүний эрх, шүүх эрх мэдэл. УБ. 2004 он. Энэхүү бүтээлээс дэлгэрүүлэн үзүүлүү.

²⁵ Шүүгчийн албаны хараат бус байдал (Institutional Independence of Judges) -хууль тогтоог болон гүйцэтгэх эрх мэдэл, бусад эх сурвалжлаас хамааралгүйгээр ажиллас баталгаалуудын нийлбэр цогц юм. Хамгийн эзлэж жишиг гэвл шүүхэд хэрэг, маргааны хэн, хэн авч шийдвэржийн ерөнхий шүүгч хувьцаарилж “ни шийд” гэж тушаах байгүй. “Тэгэх ингэж шийд” гэх нь бур ч цээртэй. Шүүгчийн албаны хараат бус байдал Үндэснэхийн хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: “Ерөнхийлгэч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн болоч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй” гэж заасан. Гэхдээ шүүгч хараат бус байж нь түүнийн хуулиас хараат биш болж байгаа хэрэг биш юм. Харин шүүгч зөвхөн Үндэснэхийн хууль болон бусад хуулият зажирдахыг ойлгоно. Учир нь шүүгчийн албаны хараат бус байдал нь зөвхөн хуульд зажирдах зарчмын дээр үндэслэлээс байдаг.

²⁶ Шүүгчийн хувийн хараат бус байдал (Personal Independence)-ажил мэргэжлийдээ өөрийнөө багтгсан хувийн чанууруудын нийлбэр цогц мөн. Тухайлбал, нийз нөхцөл, харгийн оролцогчид, бусад шүүгч, шүүгчийн удирдлагасаа чөлөөтэй байх гээл.

дангаараа Үндэснэхийн хууль болон түүний үнэт зүйлийг хамгаалж чадахгүй²⁷ гэжээ. Мөн Үндэснэхийн хуулийн 49.2 дахь заалтаар “...шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй” гэж шүүгчийн хараат бус байдлыг хамгаалсан заалт Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22, 38 дугаар зүйлээр хэрэгжих механизмын нь 20 гаруй жилийн дараа хуульлагдан хэрэгжжээ эхлээд байна.

Шүүгчийн албаны хараат бус байдлын бүрдэл хэсэгт: (1) шүүгчийт бүх насаар нь томилох, (2) шүүгчийн цалинг буруулахгүй байх, (3) шүүхийн үйл ажиллагааны зохион байгуулалтын ажлыг шүүгч нар хянах, (4) шүүгчийн халдашгүй байдал, (5) шүүгчдийг огцруулах, чөлөөлөх нөхцөл, (6) шүүгчийг тэтгэвэрт гаргах нөхцөл, (7) шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, (8) шүүгчийн материалыг хангамж, нийгмийн хамгаалал зэрэг багтана.²⁸

Шүүгчийн хараат бус байдлын эдгэр бүрдэл хэсгийг Монгол Улсын Үндэснэхийн хуульд хэрхэн хамгаалалыг шинжилгэл²⁹ ихэнх нь Үндэснэхийн хуулиар болон органик хуулиар боломжийн түвшинд хамгаалагдан тогтвортой хэрэгжих байна.³⁰ Жишээ нь, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангаж хамгаалах, шүүгчийн хариуцлага, ёс зүйг хянах чиг үүрэгтэй байгууллагын бүрэлдэхүүнийг Ерөнхийлгэч томилдог чиг үүрэг улам бүр хэлбэрийн шинжтэй болж, тэднийг сонгох, бүрэн эрх олгох чиг үүрэг хэрэг дээрээс шүүгчдийн эрх мэдэлд бүрэн очсон байна.

Харин шүүгчийн цалинг буруулахгүй байх, нийгмийн хамгаалал зэрэг стандарт Үндэснэхийн хууль болон органик хуулиар бүрэн хамгаалагдаагүй

²⁷ Barak A. The Judge in a Democracy, Princeton University Press, Princeton and Oxford, 2006, p.80.

²⁸ Шүүгчийн эрх зүйн үндэснэхийн зарчмуудад сууринж эдгэр межийнзүүдэй тодорхойлжсан болно.

²⁹ Монгол Улсад шүүхийн хараат бус байдлыг бахжуулж нь. Бодлогын тойм судалгаа (Н.Лүнчэндэрж, Ч.Өнөрбаяр, М.Батсуур) УВ., 2010 он.

³⁰ Монгол Улсын Үндэснэхийн хуулийн Тавин ногдуулж зүйлийн 2 дахь хэсэг.

нь шүүгчийн хараат бус байдлын энэ стандарт манай улсад хангагдаагүй илэрхийлэхээс гадна хамгаалсан хэм хэмжээгээ хүчингүй болгосон нь Үндсэн хуулийн түвшинд зохицуулах шаардлагатайг нотолж байгаа юм. Гэтэл шүүгчийн албаны хараат бус байдлын энэ чухал стандартыг 1787 онд АНУ Үндсэн хуулийн З дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: шүүгч "...албан тушаалд байх хугацаанд нь түүний цалинг буруулж болохгүй" гэж хуульчилсан нь их сургамжтай юм. Мөн энэ зүйд шүүгчийн хувийн хараат бус байдлын стандартыг АНУ анх удаа "Дээд болон доод шатны шүүгчид зан төлөвийн хувьд үлгэр жишээч баймааж албан тушаалдаа байна" гэж 230 орчим жилийн тэртээ хуульчилсан нь гүн утгатай.

Шүүхийн захиргаа - орчин үеийн үндсэн хуульт ёсны нэг чухал институц, шүүх эрх мэдлийн талаарх үндсэн хуулийн гол зохицуулалт болсон байна. Дэлхийн зарим улс орны Үндсэн хуульд шүүх эрх мэдэл гэсэн хэсэгтээ зөвхөн шүүхийн захиргааны статусыг хуульчилсан нь ч байна. Үүний жишээнд Франц улс орно. Өдгөө шүүхийн захиргааг зохицуулаагүй Үндсэн хуулийг түрүү үеийн хэдэн Үндсэн хуулийг эс тооцвол дэлхийгээс олоход бэрх болсон. Монгол Улс шинэ Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3, 49.4, 49.5 дахь хэсэгт шүүхийн захиргааны чиг үүрэг, ажиллас гарчмыг тодорхойлж, энэ байгууллагын эрх хэмжээг хуулиар тусгайлан зохицуулахаар хуульчилсан, түүний 2012 оны Шүүхийн захиргааны тухай хуулиар задлан хуульчилсан нь олон улсын үндсэн хуульт ёсны нийтлэг жишигт нийцэж байна.

Харин шүүхийн захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэхэд түүний бүрэлдэхүүн их чухал үүрэгтэйг манай үндсэн хуулийг зохиогчид тэр үед төдийлен анхаараа үй байна. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангаж хамгаалах энэхүү хэцүү чиг үүргийг хэрэгжүүлэх бүрэлдэхүүнийг Үндсэн хуулийн түвшинд дэлхийн улс

орнууд хуульчилдаг нь нарийн угтатай аж. Манай улс Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд хэн орох, тэднийг сонгох, тодруулах, томилох арга ажиллагааг органик хуулиар зохицуулсан нь хэвэрг төдийгүй захын хүн гоочилдог нь шүүхийн хараат бус байдлыг хамгаалах субъект чадамжгүй болж, шүүх манаачгүй болоход хүрч болзошгүй тул дэлхийн улс орнуудын жишгээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөжүүлэн Үндсэн хуулиар тодорхойлох нь олон улсын чиг хандлагад нийцэ.

Шүүгчийн томилгооны зарчмыг Үндсэн хуулиар зохицуулдаг нь уламжлалт ёс болжээ. Монгол Улсын Үндсэн хуулийн 51.2 дахь хэсэгт заасны дагуу шүүгчийг хугацаагүй томилдог нь шүүх эрх мэдлийн Үндсэн хуулийн зохицуулалтын нийтлэг стандартад нийцэж байгаа. Харин шүүгчийн томилгооны процессыг Үндсэн хуулиар бүрэн зохицуулаагүйн улмаас асуудал үүсэх, шүүмжлэл дагуулах тохиолдол байсаар байна. Тухайлбал, Үндсэн хуулийн Цэцийн гишүүдийг УИХ томилж байгаа нь зөв эсэх, Ерөнхийлөгч ямар нөхцөлд шүүгчийг томилохоос татгалзах, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийг улираан томилох эсэхийг органик хуулиар янз бүрээр зохицуулж ирсний улмаас эзэстээ хувийн эрх зүйд хэрэглэдэг аналогийг нийтийн эрх зүйд хэрэглэх, эсвэл хязгаарлаагүй юм чинь хязгааргүй гэсэн эрх зүйн бус, парадокс тайлбар хийхэд хүрч байна.

Шүүгчийн томилгооны хүрээнд хэлэлцүүлэг дагуулсан өөр нэг асуудал бол Үндсэн хуулийн шүүхийн томилгоо хийж байгаа институтийн тухай асуудал юм. Олон улсын практикаас харахад төрийн тэргүүн, парламент гэсэн хоёр институт дангаар болон хамтарч томилж³¹ байна. Харин парламентаас томилж байгаа практикийг судлаачид болон Европын шүүгчийн зөвлөлдөх зөвлөл

"Дэлхийн 61 улсыг судалж үзвэл: Ерөнхийлөгч дангаар томилод 16, Парламент томилод 15, Ерөнхийлөгч, Парламент гах мат субъект хуваан томилод 26. Шүүхийн зөвлөл томилод 4 улс байна.

шүүгчийн томилгоонд улс төрийн нелөө оруулсан, шүүгчийн хараат бус байдлыг хөндсөн хэлбэр гэж үзэж байна. Тухайлбал, профессор Хайнрих Шоллер «Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг тохоон томилоход улс төрийн нелөөг хягаарлахгүй юм бол Үндсэн хуулийн шүүх маань парламентын байнгын хороо шиг юм болно. Ийм «шүүх» байгуулсаар улс төр, хууль зүйн хоорондын харилцааны зөрчлийг бүрэн шийдэх боловч шүүхийн хараат бус байх зарчим, шүүх эрх мэдлийн тухай ярих нь огт утгагүй болно»³², «... шүүгчид нэр дэвшиүүлэх эрхийг парламент болон хууль зүйн сайдад олгохгүй байх зэрэг парламентын зүгээс Үндсэн хуулийн шүүхэд үзүүлж болзошгүй нелөөг багасгах арга замыг зэрэлхийлэн бодох хэрэгтэй»³³ гээд одоогийн ХБНГУ-ын парламентаас томилдог тогтолцоог тэрэр «намууд наймаалцан томилдог»³⁴ гэж дүгнэсэн бол ХБНГУ-ын Бундестагийн гишүүн, доктор Дитрих Мало өөрийн орны үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг томилох журмыг «шүүгчийн хараат бус байдлын баталгаа болж чадахгүй байна»³⁵ гэжээ. Европын шүүгчийн зөвлөлдөх зөвлөлийн Зөвлөлмж № R (94) 12-ийн 19 дүгээр зүйлд «Зарим улсууд (ХБНГУ, Швейцар, Итали зэрэг орныг эхлэж байна-Н.Л) шүүгчийг томилох процессыг улс төрийн шүүд нөлөөтэй байхаар Үндсэн хуульдаа хуульчилсан байна» гэснээс харгадана³⁶.

Манай улсын тухайд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг

³² Х.Шоллер. Үндсэн хуулийн шүүх гурав дахь эрх мэдлийн бүрэлдэхүүн хэсэг болох тухай! Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц(егүүлэл, илтгэлийн эмхэтгэл) УБ., 2007 он. 410-411 дахь тал.

³³ Мен тэнд.

³⁴ Х.Шоллер. Үндсэн хуулийн шүүх гурав дахь эрх мэдлийн бүрэлдэхүүн хэсэг болох тухай! Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц(егүүлэл, илтгэлийн эмхэтгэл) УБ., 2007 он. 417 дахь тал.

³⁵ Дитрих Мало. Эрх зүй улс төрийн хоорондын харилцаанд үндсэн хуулийн шүүхийн Залж байр суурь! Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц(егүүлэл, илтгэлийн эмхэтгэл) УБ., 2007 он. 387 дахь тал.

³⁶ Н.Лундэнцдорж. Шүүх эрх мэдэл дахь төрийн тэрэгүүний бурган эрх ॥Үндсэн хууль ёс ба Ерөнхийлөгчийн бурган эрх. УБ., 2015 он. 67-80 талваас үзүүлүү.

парламентаас томилдог Үндсэн хуулийн зохицуулалттай. Энд бодох асуудал байгааг манай эрдэмтэд бас тэмдэглэжээ. «Үндсэн хуулийн Цэцийн гишүүдийг... Монгол Улсын парламентаас томилж байгаа практикаас хараад зарим тохиолдолд Ерөнхийлөгч болон Улсын дээд шүүхээс нэр дэвсэн хүнийг тодорхой шалтгаан заалгүй санал хураалтаар унагах тохиолдолд хэд хэдэн удаа гарсан юм. Харин парламент өөрөө нэр дэвшиүүлсэн хүний унагасан тохиолдол гараагүй байна. Үүнээс үзэхэд парламент Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг томилоодо хуулычийнх нь хувьд биш тухайн хүнийг улс төрийн нийдээр харж, цэгнэж байна гэсэн шүүмжлэл гардаг юм. Магадгүй ийм практик гүнзгийрвэл Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн хараат бус байдалд нелөөлөхийг угүйсгэхгүй»³⁷. Тийм учраас «Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг парламентаас томилж байгаа өнөөгийн тогтолцоо зөв эсэхэд цаащаа олон улсын практиктай харьцуулан жишиж, судалгаа хийж үзүүх нь зүйтэй юм» гэж Үндсэн хуулийн цэцийн гишүүн, доктор Н.Жанцан үзсэн байна. Үг асуудлыг шүүгчийн томилгоо улс төрийн нелөөнөөс ангид, хараат бус, бие даасан байдлыг хангах баталгаа бүхий этгээдээс томилогдож байх асуудлыг Монгол Улс судалж, шийдэх ёстой асуудал гэж үзэж болно. Үндсэн хуулийн шүүхийн хяналтын хамгийн гол объект парламентын баталсан хууль, шийдвэр байdag учраас томилгоо нь хөндлөнгийн байх шаардлага бас бий.

Эдгээрийг эс тооцвол шүүгчийн томилгооны үндсэн хуулийн эрх зүйн суурь стандарт манай улсад хангагдаж байгаа гэж үзэж болно.

Шүүхийн эрх ажиллагаанд баримтлах үндсэн зарчмуудыг Үндсэн хуулиар тодорхойлдог нь Үндсэн хуулийн хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үндсэн чиг үүргээс урган гарсан аксиом юм. Эдгээр зарчмыг

³⁷ Монгол Улсад Үндсэн хуулийн Цэцийн гишүүдийг томилох, чөлөөлж зарим онцлог! Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц(егүүлэл, илтгэлийн эмхэтгэл) УБ., 2007 он. 337-338 дахь тал.

процессын шударга зарчмууд (Due process of law) гэж нэрлэдэг бөгөөд уг гарвал нь Магна Хартаас эхтэй бөгөөд АНУ-ын Үндсэн хуулийн Нэмэлтийн 5, 14 дүгээр зүйлтэй холбогддог. Эдгээр зарчмыг зарим улс орон Үндсэн хуульдаа шууд заан тусгадагтуй нь Үндсэн хуулийн зохицуулах зүйл биш гэсэн утгаар бус, харин эдгээр зарчим аянаа хэрэгжих утгатай гэж үзэж үлдээдэг зарчим, соёл төлөвшиж байна.

Монгол Улсын тухайд Үндсэн хуульдаа процессын шударга зарчмуудыг Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэг болон Шүүх эрх мэдлийн бүлэгт³⁸ тодорхойлсон боловч тэдгээрийг хүний эрх, эрх чөлөөний баталгааны талаас, олон улсын жишиг, стандартын дагуу сайжруулах, чанаржуулах, илүү нарийвчлах, дэлгэрүүлэх, журамлан зохицуулах, үр нөлөөтэй болгох шаардлага бий.

Жишээ нь, Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт шударга шүүхээр шүүлгэх эрхийн асуудлыг заасан хэдий ч нэг гэмт хэрэгт хоёр удаа ял шийтгэхгүй хориглж зарчим бүрэн тусаагүй. Энэ зарчим нь хүнийг буруутгахаар улайрч нэг үйлдэлд олон дахин ял шийтгэх, ял шийтгэхээр завдах, мөрдэн шалгах ажиллагаа явууллахаас хориглосон агуулгатай байдал. Энэ зарчмыг эрх зүйт ёс хөгжсөн улс орнуудад Үндсэн хуульдаа тусган бэжүүлдэг жишиг бий. Жишээ нь ХБНГУ-ын Үндсэн хуулийн 103 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Эрүүгийн хуулийн дагуу хүнийг нэг үйлдэл нь хоёр удаа ял шийтгэж болохгүй”, АНУ-ын Үндсэн хуулийн V нэмэлтэд “Хэнийг ч хийсэн нэг үйлдэл нь хоёр удаа буруутган ял шийтгэж болохгүй”, Японы Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлд “Гэмт хэргийг үйлдсэн цаг хугацаанд тухайн үйлдэл, эс үйлдэхүй

нь хууль ёсны байсан, цагаатгагдсан эсхүл нэг үйлдэл нь дахин ял шийтгэхийг хориглоно” гэж тус тус зохицуулжээ.

Үүнээс гадна эрүүгийн хэргийг шалгах ажиллагаанд шүүхийн зөвшөөрөл Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 13 дахь хэсэгт “...хуульд заасан үндэслэл, журмаас гадарууд хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлах..”-ыг хориглосон ч эдгээр арга хэмжээг хэн, ямар арга ажиллагаагаар хэрэгжүүлэхийг тодорхой заагаагүй. Тодруулбал, шүүхийн үүргийг орхигдуулсан гэж хэлж болно.

Албадлагын зарим арга хэмжээг шүүхийн зөвшөөрлөөр явуулдгийн учир нь хүний эрх, эрх чөлөөг хараат бус субъектээр хянуулах, мөрдэн шалгах этгээдэд эрх мэдлийн төвлөрөл бий болох, мөрдэн шалгах ажилд нэг талыг хэт барих зэргээс сэргэжлэх шаардлага бодитой байдал. Үүний улмаас эрх зүйт ёс төвлөшсөн улс орнуудын Үндсэн хуульд шүүхийн зөвшөөрлийн асуудлыг тусгайлан зохицуулдаг. Тухайлбал, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хуулийн 104 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүний эрх чөлөөг хөндсэн шийдвэр гаргах, гарсан шийдвэрийг үргэлжлүүлэх эсэхийг гагчүү шүүгч тогтооно. Хойшлуулшигийг нехцэл байдлын улмаас шүүхийн зөвшөөрөлгүйгээр ийнхүү арга хэмжээ авсан бол нэн даруй шүүхэд мэдэгдэн. Цагдаагийн байгууллага хүнийг нэгзэс дээш хоногоор баривчлан саатуулж болохгүй. Бусад харилцааг хуулиар нарийвчлан зохицуулна”. З дахь хэсэгт “Гэмт хэрэгт сэжиглэн баривчлагдсан аливаа этгээдийг баривчлан саатуулснаас хойш нэг өдрийн дотор шүүхийн ёмне дуудах бөгөөд шүүгч түүнд баривчилсан үндэслэлийг тайлбарлах, мэдүүлэгт егч өөрийгөө өмгөөлөх боломжир хангах, холбогдох шийдвэрийг нэн даруй гаргах үүрэгтэй” гэж тус тус заажээ. Үүнтэй төстэй зохицуулалт АНУ-ын Үндсэн хуулийн

³⁸ Үндсэн хууль нийцэлгүй хуулийг шүүх шартынхгүй, иргэний говийнчирэгтэй оролцуулах, монгол хэлээр шүүх хуралдааныг ил явуулах, хамтарч ашиглахгээх кэлэрээр ярийн эрх олгох, өмгөөвүүлэх эрх эрдүүлэх, энэ бууруу зөвхөн шүүх тогтооши, давж завдах, эрүү шүүчтэйсэнгид байх, өөрийн эзэр мэдүүлж өгөхийг ул шаардах гэж мат.

XIV нэмэлтэд бий. Тус нэмэлтэд "Хувийн болон орон байрны халдашгүй байдал, албаны баримт бичиг нь үндэслэлгүй нэгжлэг, хураан авахаас зөрчигдэх ёсгүй ба нэгжлэг хийх, хураан авах эд зүйл, газар орон, баривчлах үндэслэл хүний талаар мэдээлсэн шүүхийн шийдвэрлгүйгээр албадан хурааж авч болохгүй" гэж заасан нь эрүүгийн процессыг ажиллагааны мөрдөн байцаалтын шатанд хүний эрх, эрх чөлөөг хөндөхгүй байх үндэслэл болно. Тус нэмэлтийг нэгдүгээрт, "гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үйлдэж байгаа хэмээн сэжиглэх хангалттай үндэслэл байх", хөөрдүгаарт "хойшуулшигүйгээс бусад тохиолдолд нэгжлэг, хураан авах, баривчлах зэрэг хүний эрх, эрх чөлөөнд халдах ажиллагааг гагцхүү хангалттай үндэслэл бүхий (англ. *Probable cause*) тохиолдолд шүүгчийн хүчин төгөлдөр захирамжийн дагуу явуулж болно" гэсэн хөөр үндсэн агуулгаар тайлбарладаг.

Энэ мэтээр хууль ёсны зарчмыг үндсэн хуульдаа бэхжүүлэх, гэм буруугүйн презумицийн зарчмыг дэлгэрүүлэн тодорхойлох³⁹, шударгаар шүүлгэх эрхийг хангах үүднээс шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын асуудлыг институцийн түвшинд бүрдүүлэх зэрэг асуудал цаашид шийдлээс хүлээж байна

Монгол Улсын Үндсэн хууль дахь шүүх эрх мэдлийн зохицуулалтын дээрх шинжилгээнээс харахад манай улс шүүх

³⁹ Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "... Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хуртал хэндигт ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож ул болно..." гэж заслас нь гэм буруугүйн презумицийн зарчмын тусгал бөгөөд хүний эрхийн олон улсын эрээз, конвенцийн нийцэлдэг. Харамсалтай нь гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч эрх бүхий албан төшвантнууд, мөн харицаанд оролцогч талууд гэмт хэргийн сэжигтний гэмт хэрэг үйлдсэн эсэхийг нь тоогоосоо илүү нэгэнт "гэмт хэрэг үйлдэччисэн" мэт хандах, гэмт хэргийг ирүүлэх ажлынхаа чанар биш, тооцд илүү анхаарч холбогдогийг буруутай мэтээр зарлах, тулган байдах, эрх аяглаа хамгаалас оролдлого хийнхд нь эсэрүүцэн заналхийг зэрэг үйлдэл байсаар байгааг судлааджин тэмдэглэх байна. (Үндсэн хууль ба эрх зүйт ёс. Илтгэлийн эмзэгтэл. УБ., 2011 он. 29 дэх тал) Иймд энэ зарчмыг үндсэн хуулиарас нарийвилан тодорхойлох, гэм буруу нь хуулийн дагуу шүүхээр нотлогдоогүй бийхдэд гэмт хэрэг үйлдсэн, урьдаас нотлогдсан мэтээр олон нийтдэд мэдээлэх, дурслахийг хориглосон зохицуулж болох юм.

эрх мэдлийн үндсэн хуулийн эрх зүйн суурь стандартын ихэнхийг хангасан зохицуулалттай улс гэж дүгнэж болох хэдий ч чанар, үр нэлээ, хэрэгжих баталгааны тал дээр шийдэх асуудал цөөнгүй байна.

4. Үндсэн хуулийн эрх зүй дэх шүүх эрх мэдлийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал

Үндсэн хууль, түүний судалгаа тасралтгүй хөгжиж, шинэ институц⁴⁰ийн болох, уламжлалт зохицуулалтыг эрэж харах, заримыг өргөжүүлэх⁴¹, шинчлэх, судалгааны болон бодлогын шийдэл хайсан цөөнгүй асуудал уүссэн байна. Үүний заримаас тоймлон дүгнэвэл:

(1) шүүх санхүүгийн хангалттай хэрэгсэлгүйгээр зорилгоо хэрэгжүүлж чадахгүй гэдэгтээ дэлхий даяар санал нэгдэгт атлаа зөв шийдэл олж чадаагүй⁴², одоогийн хэрэгжүүлж байгаа арга замыг эргэж харах ёстойгэж үзэхд хүрээд байна. Ялангуяа шүүгчийн цалинг бууруулахгүй байх тедийгүй амьдралын өртгийн өөрчлөлттэй уялдах нэмэгдэх байх зарчмыг хуульчлах шаардлагатай⁴³ гэдэг дээр санал нэгдэж байна. Уг асуудал манийн улсын тухайд хангалттай тохиолдол (case), асуудал үүсэж, шийдэгдсэн хэдий ч Үндсэн хуулийн болон өндөр түвшний эрх зүйн хамгаалалтгүй.

⁴⁰ Үндсэн хуулийн эдийн засаг гэсэн судалгааны шинэ чиглэл бий болсон тедийгүй далхийн улс орнуудын үндсэн хуульд шинээр туссан.

⁴¹ Opinion №1 (2001) of Consultative Council of European Judges (CCJE) for the attention of the committee of ministers of the council of europe on standards concerning the independence of the judiciary and the immovability of judges (recommendation No. R (94) 12 on the independence efficiency and role of judges and the relevance of its standards and any other international standards to current problems in these fields).

⁴² Opinion no 2 (2001) of the Consultative Council of European Judges (CCJE) for the attention of the Committee of Ministers of the Council of Europe on the funding and management of courts with reference to the efficiency of the judiciary and to article 6 of the European Convention on Human Rights.

⁴³ Opinion №1 (2001) of Consultative Council of European Judges (CCJE) for the attention of the committee of ministers of the council of europe on standards concerning the independence of the judiciary and the immovability of judges (recommendation No. R (94) 12 on the independence efficiency and role of judges and the relevance of its standards and any other international standards to current problems in these fields).

шийдлээ хүлээж байгаа нэн чухал асуудал мөн.

(2) Шүүгчийн томилгоо, албан тушаал ахиулах асуудал өдгөө шүүмжлэл, хэзэлцүүлэг дагуулж буй Европын зөвлөлийн дэргэдэх «Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөл» (Consultative Council of European Judges)-ын гаргасан дүгнэлт⁴⁴, зөвлөмжүүдэд⁴⁵ шүүгчийн томилгооны төлөө эрх бүхий байгууллага албан тушаалтан хариуцлага хүлээдэг, томилгоо болон шүүгчийн карьер ахиулах болзол, шалгуур бодитой, тодорхой, ил тод, нээлттэй, олон нийтэд мэдээлдэг тогтолцоо алга байна гэж дүгнээд ихэнх улс орон шүүхийн зөвлөлдитгэж найдсан, зарим улс оронд илэрхий улс төрийн оролцоотойгоор шүүгчийн томилгоо хийхийг Үндсэн хуулийн түвшинд хуульчилсныг дурдажээ. Жишээ нь, Итали, ХБНГУ эзэр орны Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг парламентаас сонгодог тогтолцоог шууд ардчиллын аргыг ашиглахыг зорьсон хэдий ч хэрэг дээрээ улс төрийн нөлөөтэй томилгоо болиж байгааг тэмдэглээд “Шүүгчийн томилгоо, хөдөлгөөний төлөө гишүүн улс бүрийн холбогдох эрх мэдлийн байгууллага хариуцлага хүлээж байх, мөн түүнчлэн энэ асуудлын хүрээнд шүүгчийг сонгон шалгаруулах, карьер ахиулах ажиллагааг мэргэшсэн байдал, шударга чанар, чадвар ба үр нөлөөт байдалд тулгуурласан, түүнийг хангахад чиглэсэн бодит шалгаруулж боловсруулах, нийтлэх, хэрэгжүүлэх ёстой”⁴⁶ гэж дүгнэжээ.

Мөн түүнчлэн Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг томилох гурван

үндсэн механизмыг⁴⁷ байгаа гэж АНУ-ын Чикагогийн их сургуулийн профессор Том Гинсбург үзжээ.⁴⁸ Нэг субъектийн томилгооны механизмын талаар Т.Гинсбург албан ёсоор ийм ангиллыг гаргаагүй ч тэрбэр ганц хүний томилгооны механизмыг (Single Appointing Mechanism)-ыг гүйцэтгэх эрх мэдлийн субъект хууль тогтоох эрх мэдлийн оролцоо, хяналтгүйгээр томилох ага гээд түүний жишээ болгож Тайванийг оруулжээ. Энэ улсад Ерөнхийлөгчийн томилгоо нь парламентаар дэмжигдсэн байх шаардлага тавигдаг хэдий ч тус улсын улс төр, нийгмийн уламжлал ёсоор Ерөнхийлөгч нь хамгийн олон санал авсан, эрх барьж байгаа намын лидер байгаад тул төдийлен сайн хяналт болдогтуй аж. Нэг субъект үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг томилгоо нь өдгөө цагт ардчиллыг бэхжүүлж буй улс орнуудад түгээмэл загвар биш гэж үздэг. Учир нь томилгоо нэг субъектээс хэт хамааралтай тохиолдолд Үндсэн хуулийн үр нөлөөтэй хязгаарлалт тогтох чадахгүй гэж үздэг байна.⁴⁹

⁴⁷ (1) мэргэжлийн томилгоо (Professional appointments): шин шүүгчийг одоо ажиллах байгаа шүүгчид томилдог бөгөөд томилогтой хийхдээ мэргэжлийн нэр хүнд, ёс зүй, нэр хүндийг харгалздаг давуу талтай. Харин шүүх дотор шүүгчийн зэрэбээгүйсэж, «хучин шүүгч нэрт эрх мэдэл төвлөрөх сүл талтай гэдэг. (2) хамтын томилгоо (Cooperative Appointing Mechanism): үндсэн хуулийн хөөр субъект зөвшнүүцж үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг томилдог загвар юм. АНУ, ОХУ, Унгар эзэр улсад Ерөнхийлөгч нь үндсэн хуулийн шүүхийн шүүгчид нэр давшуулж, парламент нь баталдаг. Энэ загвар томилсон хуулийн институт хоорондын зөвшнүүцийг шаарддаг. Хэрэв зөвшнүүцелд хүрч чадахгүй, улс төрийн зөрчилдэвшийн (political conflict) улмаас томилгоо хийгдэхгүй багас эрдэлтий. (3) төлөвлөлийн томилгоо (Representative Appointing Mechanism): үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг ерөнхийлөгч, парламент, дээд шүүх гэх мэт хэдэн субъектээс хуваан томилдог загвар юм. Сүл тал нь хэрэв төвийн сахисан бус шүүгч томилгогдовол томилсон этгээдийнхээ төвлөрөх (right agency of the appointors) болох эрдэлтий. Харин төвийн сахисан хүн шүүгчээр томилгогдовол томилсон этгээд түүнээс элдэв зүйл хүлээжтүүлж бөгөөд шүүхийг ямар нэг хэлбэрээр ашиглах, вэرت таатай шийдвэр гаргахыг шаарддагүй боловч тийм хүнийг томилох магадлал баа өндөр биш гэдэг.

⁴⁸ Tom Ginsburg. *Judicial Review in New Democracies: Constitutional Courts in Asian Cases*. Cambridge University Press, 2003. p.43.

⁴⁹ Энэ загварыг хамтын загвараас ялагх шаардлагатай. Хамтын загвар Ерөнхийлөгч нэр давшуулж, парламент баталдаг бол энэ загварт дан ганц Ерөнхийлөгчийн бүрэн эрх үйлчилдэг онцлогтой.

⁴⁴ Мөн тэнд

⁴⁵ Мөн тэнд

⁴⁶ Мөн тэнд

Дээр загварын харьцуулан үзвэл хамтын болон төлөөллийн томилгооны механизмын нь харьцангуй боломжит хувилбарт тооцогддог. Гэвч эдгээр давуу тал байхын хамт сүл тал бай. Тухайлбал, төлөөллийн томилгооны механизмын хэдийгээр дэлхийн олон улс оронд түгэн дэлгэрсэн боловч хамтын томилгооны загвартай харьцуулбал том дутагдалтай. Эмне дурдсаннаар төвч, голч, хараат бусаар ажиллаж чадах этгээдийг нэр давшигуулж томилож боломж байгаа хэдий ч улс төрчдийн оролцоотойгоор цэвэр байгууллагаа, эсхүл тодорхой хэсэг бүлгиг төлөөлөх зорилготой нэр давшигчдийг санал болгох эрсдэл бодитой оршдог. Ийм маяаар томилгожсон шүүгчидэй шүүхийн шийдвэр нь хамтын томилгооны механизмаар томилгожсон шүүгчдийн гаргасан шийдвэртэй харьцуулбал чанарын хувьд доогуур (*lower quality*), дотоод уялдаа холбоо, нэгдмэл байдал (*Internally fragmented*) таарууд тооцогддог. Харин хамтын томилгооны загвараар томилгождог шүүгчидэй шүүхийн хувьд нэгжт нэг нийтлэг ашиг сонирхлыг төлөөлэн ажилладаг тул харьцангуй төвлөрсөн, нэгдмэл гэм уздэг. Тэгвал хамтын томилгооны механизмын хувьд томилгооны шатанд мухардалд орох эрсдэлтэй бол төлөөллийн томилгооны механизмын нь томилго асуудалгүй боловч шүүхийг мухардалд оруулах эрсдэлтэй⁵⁰ гэдэг.

(3) Шүүгчийн томилгооны хугацааны талаар «Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөл»-ийн дүгнэлт, зөвлөмжид шүүгчийг өндөр насны тэтгэвэр авах эрх усаж хүртэл нь томилж байгаа олон улсын практикийг зргэж харж, тодорхой болон туршилтын богино хугацаатай болгох болцоотой гэж үзэж, хугацаатай томилж байгаа зарим орны туршлага⁵¹. Европын шүүх болон Европын хүний эрхийн шүүхийн

⁵² практикийг дэмжсэн байна.

(4) Үндсэн хуулийн хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чиг үүргийг улам хүчирхэг болгох чиг хандлагатай уялдах эмне нь төдийлөн Үндсэн хуулиар түгээмэл зохицуулж байгаагүй зарим шинэ институц үлс орнуудын үндсэн хуульд тусгай байна. Үүний жишээ бол цаазын ялгүй үлс гэдгээ үндсэн хуульдаа бичих явдал бий. Үүний жишээ бол ХБНГУ юм. Мен цөөнгүй улсын Үндсэн хуульд шүүхийн шийдвэр үндэслэлтэй байх тухай, шүүхээс хууль тайлбарлах уйл ажиллагаанд хязгаарлалт, стандартыг үндсэн хуулиар тогтоох хандлага ажилгаждаж байна. Тухайлбал, тайлбар ухаалааг байх⁵³ (эрүүл оюун ухааны шүүмжлэл даахуйц бай), улсын эрх ашигт хохирол уруулахаар тайлбарлах болгохгүй⁵⁴, здийн засгийн хувьд хэмнэлтэй байх⁵⁵ зэргийг дурдаж болно. Эдгэр асуудал амьдралаас урган гарсан манай улсад ч хэрэгзэг төрсөн асуудал гэж бодож байна. Өдгөө хууль дээдэлдэг, хууль нь хэрэгждэг улсад ямар хууль тогтоохын улс төрийн хүснэгтэй сориг бараг шийдэхээ больсон. Харин здийн засаг нь түүнийг шийддэг болжээ. Гэтэл здийн засгийн болопцоогоо харахгүй хууль тайлбарласны улмаас нийтийн эрх ашиг хохирох явдал цөөнгүй байгаа билээ.

(5) Шүүгчийн хараат бус байдал шүүгчийн хариуцлагын алтан дундажийг олох асуудал өдгөө шүүх эрх мэдлийн Үндсэн хуулийн болон органик хуулийн зохицуулалтын тulgамдсан асуудал болоод байна. Нэг талаас шүүгч тал бүрээр хамгаалалт, хараат бус байхын хамт эзсийн цийдвэр гаргадаг.

50 МӨН ТЭНД.

⁵¹ Бүгд найрамдах Солонгос улсын Үндсэн хуулийн 105 дугаар зүйлийг үзнэ үү.

⁴² Opinion №1 (2001) of Consultative Council of European Judges (CCJE) for the attention of the committee of ministers of the council of europe on standards concerning the independence of the judiciary and the irremovability of judges (recommendation No. R (94) 12 on the independence efficiency and role of judges and the relevance of its standards and any other international standards to current problems in these fields).

⁵³ Унгар улсын Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийг үзнэ үү.

⁵⁴ АНУ-ЫН Үндэснэ хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дугаар хэсгийн 2-ыг узэн үү.

⁵⁵ Үнгэр үсэсгүйн Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийг үзэв.

олон нийтийн итгэл дээр тогтдог субъектийн хувьд хариуцлагатай байх ёстой гэж хариуцлагын механизмын тухай ярьдаг бол нөгөө талаас шүүгчийн албаны хараат бус байдал хамгаалагдан, туштай хэрэгжих, шүүгчид улс төрчдийн ашиг сонирхлыг хөндсөн шийдвэрийг хараат бусаар гаргаж эхэмэгц бусад эрх мэдэл нь "шүүгчийн хариуцлага" гэдэг нэрийн дор шүүгчийн хараат бус байдлыг хязгаарлах арга замыг язь бүрийн шугамаар хайж эхлэх магадлалтай гэсэн хоёр хандлага оршиж байна.

Эх газрын эрх зүйн тогтолцоонд шүүгчдэд хариуцлага тооцох нэрийн доор сонгон шалгаруулах тогтолцоо, шүүгчдийн сургалт, шилжилт хөдөлгөөн, албан тушаал давшүүлэх зэрэг ажиллагааг тухайн дэлгээмийг хамгаалах үнэнч зарц болон ашигладаг тухай Мартин Шапиро бичсэн⁵⁵. Эрх баригчид заримдаа шүүгчдэд буулт хийж, таатай нөхцөл бий болгохын зэрэгцээ зарим чухал асуудлыг шүүхээс зугтаалах, хэрэг шийдэх эрхийг өөр байгууллагад шилжүүлэх, мөн шүүгчдэд хариуцлага тооцох механизмыг чангатгах зэрэг арга ажиллагаа хэрэгжүүлдгүйг сануулсан байдал.

(6) Шүүхийн захирагааны институт өдгөө дэлхийн 2 дугаар дайны дараагаас улс орнуудын Үндсэн хуулийн шүүх эрх мэдлийн хэсэгт онцгой байр

суурь залэх боллоо⁵⁷. Тухайлбал, 1939 онд АНУ-ын Конгрессын шийдвэрээр шүүхийн захирагааг Хууль зүйн яамнаас салгаж, Нэгдсэн улсын шүүхүүдийн Захирагааны албыг /Administrative Office of the United States Courts/ шинээр байгуулсан бөгөөд уг Албаны даргыг Нэгдсэн улсын Дээд шүүх томилдог.⁵⁸ Мөн эрх зүйт ёс, төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагын үүднээс шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангаж, хамгаалдаг Шүүхийн захирагааны байгууллага Европын зөвлөлийн дэргэдэх «Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөл» (Consultative Council of European Judges) бус нутгийн шүүхүүддээ зөвлөж байна.⁵⁹ Ийнхүү шүүхийн захирагааг Үндсэн хуулийн түвшинд онцгойлон анхаарч зохицуулах болсны учрыг эргэцүүлбэл түрван зүйл ажиглагдаж байна. Нэгдгээрт, шүүх, шүүгч өөрөө

⁵⁵Бэлгийн улсын "Шүүхийн дээд зөвлөл" нь Үндсэн хуулийн /1994/ 151 дугаар зүйл зааснаар бие даасан үндсэн хуулийн байгууллага, Франц улсын Үндсэн хуулийн /1958/ 64 дугаар зүйл зааснаар "Шүүх эрх мэдлийн дээд зөвлөл" нь Шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хангах Бүд найрамдах улсын Ерөнхийлгүчин чиг үүрэгтэй туслах бие даасан үндсэн хуулийн байгууллага. Итали улсын Үндсэн хуулийн /1947/ 104, 105, 106, 107 дугаар зүйл зааснаар "Шүүхийн дээд зөвлөл" нь бие даасан үндсэн хуулийн байгууллага. Листва улсын Үндсэн хуулийн /1992/ 112 дугаар зүйл зааснаар "Шүүхийн зөвлөл" нь шүүгчийн томилож, чөлөөлөх асуудлаар Бүд найрамдах улсын Ерөнхийлгүчид зөвлөх чиг үүрэгтэй шүүгчийн онгийг байгууллага. Польш улсын Үндсэн хуулийн /1997/ 186 дугаар зүйл зааснаар "Шүүх эрх мэдлийн Үндэслэний зөвлөл" нь бие даасан үндсэн хуулийн байгууллага, Португали улсын Үндсэн хуулийн /1976/ 217, 218 дугаар зүйл зааснаар "Шүүх эрх мэдлийн дээд зөвлөл" нь үндсэн хуулийн байгууллага. Румын улсын Үндсэн хуулийн /1991/ 133, 134 дугаар зүйл зааснаар "Шүүхийн дээд зөвлөл" нь шүүхийн бие даасан байдлыг хамгаалахгүй үндсэн хуулийн байгууллага. Словак улсын Үндсэн хуулийн /1991/ 141 дугаар зүйл зааснаар /2001/ "Бүд Найрамдах Словак улсын шүүхийн зөвлөл" нь үндсэн хуулийн байгууллага. Словени улсын Үндсэн хуулийн /1991/ 131 дугаар зүйл зааснаар /1991/ "Бүд Найрамдах Словени улсын шүүхийн зөвлөл" нь үндсэн хуулийн байгууллага, Ислами улсын Үндсэн хуулийн /1978/ 122 дугаар заснаар "Шүүх эрх мэдлийн дээд зөвлөл" нь үндсэн хуулийн байгууллага. Турк улсын Үндсэн хуулийн /1982/ 152 дугаар зүйл зааснаар "Шүүх, прокурорын дээд зөвлөл" нь үндсэн хуулийн байгууллага

⁵⁶ Anja Seibert-Fohr (ed.) *Judicial Independence in Transition* (2012), p.523.

⁵⁷ Opinion №10 (2007) of the Consultative Council of European Judges (CCJE) to the attention of the Committee of Ministers of the Council of Europe on the Council for the Judiciary at the service of society

* Shapiro M. Courts: a comparative and political analysis. Chicago, 1981. p 32-35

бие даасан, хараат бус байдлаа бусад эрх мэдлээс хамгаалах нь ашиг сонирхлын зөрчилд хүргэж болзошгүй юм. Өөрөөр хэлбэл, шаардлагатай үед өөрт байгаа эрх хэмжээгээ ил далд хэлбэрээр ашиглахгүй гэх баталгаагүй. **Хөөрдугаарт**, шүүх, шүүгч бие даасан, хараат бус байдлаа өөрөө хангаж, хамгаалах нь хараат бус байдлаа алдах эрсдэлийг ямарг дагуулж ирсэнтэй холбоотой гэж үзэж болно. **Гуравдугаарт**, шүүх эрх мэдэл бусад эрх мэдэл шиг олон нийтийн шууд дэмжлэгт тулгуурладаггүй, харин итгэл, хянгалтад оршдог, өөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх материалыяг болон санхүүгийн нөөцийн асуудалтай байгаад зэрэг байж болох юм. Тийм учраас шүүхийн захиргааны суурь асуудлыг олон улсын жишигийн дагуу Үндсэн хуулийн түвшинд нарийвчлан зохицуулах зөв юм.

Шүүхийн захиргааны чиг үүргийн судалгаа⁶⁰ ч замгүй хийгдэж, чиг хандлага олон улсын түвшинд тогтох байна.

⁶⁰ Шүүхийн захиргааны чиг үүргийг "Шүүх эрх мэдлийн зөвлөлийн Европын сүүлийн" ENJC. European network of Councils for the Judiciary, байгууллага дараах байдалар тодорхойлжээ. Үүнд; (1) Шүүгчийн тохиолд, давшумтга, (2) Шүүгчийн сургалт, (3) Шүүгчийн ё зүй ба саюнга, (4) Шүүхийн захиргаа, (5) Шүүх эрх мэдлийн саночуу, (6) Шүүх эрх мэдлийн гүйцэтгэлийн менежмент, (7) Харгийн оршилжчийн гаргасан гомдолыг хянан шийдвэрлэх, (8) Шударга ёсны нэр хүндиг хамгаалах, (9) Түүхийн улсын шүүхийн талаар болдогын чийтийн боловсруулах, (10) Шүүхийн байгууллагын узлах тогтолцоог бурдлуулах, (11) Шүүх эрх мэдлэг буюу шүүхийн тухай хуuluу тогтолцоомжийг төсөл боловсруулж, уламжлах, (12) Үндсэн хуулиар шүүхийн бие даасан байдлыг баталгаажуулсан байдлыг хангах.

---00---

МОНГОЛЫН ХУУЛЬЧ ЭРДЭМТДИЙН
ҮНДЭСНИЙ
АНХДУГААР ЧУУЛГАН

V САРД БОЛНО.

Данжижигийн мэдлийн 11-312825 улсынхан бий болсон
Мухүү түүхийн түркмөнчийн 204 тоот
төслийн ирээ тийн шүү.

Мийн хуульч эрдэмтэд
То бүхийн сропцахын уралж байна.
Чуулганы төслийн хувь нийтийн түркмөнчийн мэдлийн төслийн
То бүхийн сропцахын уралж байна.

БҮРГЭЛТ
Күрүүгээ үзүүлж хэрэгжүүлж 11-312825 чадвар
Тийн түүхийн түркмөнчийн мэдлийн төслийн хувь
Данжижигийн мэдлийн 11-312825 улсынхан бий болсон

ХЗДХ-ийн сайд С.Бямбацогтын санаачилгаар Монголын хууульч эрдэмтдийн үндэсний анхдугаар чуулганыг тавдугаар сард зохион байгуулахаар болжээ. Энэхүү чуулганыг зохион байгуулах ажлын хэсгийг ХЗДХ-ийн Терийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан ахалж байгаа юм. Ажлын хэсэг өнөөдөр хуралдаж, чуулганы зохион байгуулалтын талаар санал солилцов. Хууульч эрдэмтдийн анхдугаар чуулганыг зохион байгуулсанар салбарын эрдэмтдийн харилцаа холбоо бэхжих, эрдэмтэн судлаачдын бүтээлийг олон нийтийд таниулах, тэдний дуу хоолой, оюуны нөөц боломжийг ашиглах боломж нээгдэж байгаа юм.

ХУУЛЬЧДЫН ӨӨРИЙН УДИРДЛАГЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ



БНЧУ-ын Өмгөөлөгчдийн холбооны
өрөөхийлгч асан нөён Владимир
Ийроусектэй хийсэн ярилцлагээ

Социализмын үеэс эхлэн өмгөөлөгчөөр тасралтгүй ажиллаж, Чехийн Өмгөөлөгчдийн Холбооны шинэчлэлийг гардан хийсэн өмгөөлөгч нөён Владимир Ийроусек-тэй хийсэн ярилцлагыг та бүхэнд топилгуулж байна. Нөён Владимир Ийроусек нь Чехийн Өмгөөлөгчдийн Холбооны (ЧӨХ) Сахилгын хорооны гишүүн, Уйрдах зөвлөлийн гишүүн, Холбооны дад тэргүүн, тэрзүүнээр удаа дараа сонгодон ажиллаж ирсэн. Тэрзэр дунд ба том компаниудаа хууль зүйн үйлчилгээ үзүүлдэг “Ийроусек, Скалник, Берник ба туншүүд” хуулийн фирмийг үндэслэгч, хамтран өмчлөгч юм.

Юуны өмнө энэ ярилцлагыг өгөх хүснэгтийг хүлээж авсанд талархлаа илэрхийль. Ярилцлагыг Чехсловак улс гэж байх үеэс эхэльье. Та ажлын гараагаа хэрхэн эхэлсэн бэ?

Би Прага хотын Карлын Их Сургуулийн хууль зүйн факультетыг тэгссний дараа анх 1974 онд дагалдан хуульчaaar (junior lawyer) ажлын гараагаа эхэлсэн. Ахлах хуульчийн удирдлага доор турван жил дагалдан ажиллаж хуулийн дадлага хийсний дараа өмгөөлөгчийн шалгалт өгч, 1977 онд тухай үед төрийнх байсан

Острова хотын Хууль зүйн зөвлөгөө өгөх газар (ХЭӨГ) хөдөлмөрийн гэрээт өмгөөлөгчөөр ажиллаж эхэлсэн.

Социализмын үед Өмгөөлөгчдийн Холбоо (Bag Association) гэж байсан уу? Байсан бол харагт бус байсан уу?

Тухайн үед Чехийн өмгөөллийн төв (ЧӨТ) гэж мэргэжлийн байгууллага байсан. ЧӨТ нь хэлбэрийн хувьд бие даасан байсан хэдий ч бодит байдал дээр ийм байгаагүй. ХЭӨГ-ийн өмгөөлөгчид нь Өмгөөлөгчдийн Холбооны гишүүн байсан ба энэ бүх хэсгүүд бүгд ЧӨТ-ийн хяналтад байсан. Өмгөөллийн бүх байгууллагуудыг зарчмын хувьд коммунист намын хэдэн гишүүд удирдаж, хянаж байсан ба эдгээр намын гишүүд нь мэдээж “намын зааврыг” дагах ёстой байв. Бодит байдал ийм байсан хэдий ч өмгөөлөгчид хувь хүнийжээ хувьд харагт бус байдлыг чухалчилж, өмгөөлөгчийн мэргэжлийн үүргээ биелүүлэхийг эрхэмлж байсан. Энэ утгаараа тухайн үед систем хүлцэж байсан цорын ганц сөрөг хүчин нь өмгөөлөгчид байсан юм.

Чехословакт иргэд өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох эрхтэй байсан уу? Хуулийн хэрэг, маргааныг өмгөөлөгчдэд хэрхэн хуваарилж байсан бэ?

Эрүүгийн хэргийн хувьд иргэд өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох эрхгүй байсан. Эрүүгийн хэргийн өмгөөлөгчийг ХЭӨГ томилж байсан. Үүний дээр засаг захирагааны нэгж бүрт өмгөөлөгчийн тусгай жагсаалт гэж байсан ба энэ жагсаалтад багтсан өмгөөлөгчид л “нууц” гэж ангилагдсан асуудлуудад бусдыг өмгөөлөх, төлөөлөх эрхтэй байсан. Мэдээж намын хяналтад байх улс төрийн асуудлууд голчлон “нууц” байсан.

Өнөөдрийн өнцгөөс харвал монголд социализмын үед тухайн

үеийн БНМАУ-ын Өмгөөлөгчдийн Коллеги нь монополь хуулийн фирм шиг ажиллаж байсан юм шиг байгаа юм. “Өмгөөлөгчдийн Коллеги” нь өмгөөлөгчдийн орлогыг хянаж байсан бололтой. Чехословакт асуудал ямар байсан бэ?

Чехословакт талууд гэрээгэр чөлөөтэй үз тохирцохыг хориглож, хууль зүйн үйлчилгээний төлбөрийн хэмжээг урьдчилж тогтоосон байсан. ХЗӨГ-ын өмгөөлөгч бүр хөдөлмөрийн гэрээт ажилчид байсан (ХЗӨГ бүрийн өмгөөлөгчийн тоог урьдчилж тогтоосон байсан ба Острова хот ба орчинд нийт 27 өмгөөлөгч ажиллах тооны хязгаар тавьсан байсан) ба өмгөөлөгчдийн цалингийн хэмжээ прокурор, шүүгчдийнхээс хамаагүй бага байхаар цалинг тогтоосон байсан (таксины жолооч, үсчин өмгөөлөгчтэй харьцуулбал өндөр цалинтай байсан). Улирал тутам ХЗӨГ-ын дарга нь орон нутгийн Өмгөөлөгчдийн Холбооны удирдлагатай хамтарч өмгөөлөгч бүрээс ХЗӨГ-т оруулсан орлогыг тооцож, энэ дүнгээс хамаарч өмгөөлөгчдийн цалин дээр нь нэмж шагнал өгэх эсэхийг шийдэж байсан. Энэ ташрамд, социалист дэглэмийн үед ч гэсэн иргэд хууль зүйн үйлчилгээний төлбөрийг өөрөө төлдөр байсан гэдгийг онцолж бэ (ХЗӨГ бүрд төлбөрийн касс байрлуулсан байв.)

Коммунист дэглэмийг нуран унасын дараа иргэдийн өмгөөлөгчее чөлөөтэй сонгох эрхийг баталгаажуулахын тулд ямар шинэчлэлийг хийсэн бэ? ЧӨТ-ийг хэрхэн шинэчилсэн бэ? Хараат бус өмгөөллийн байгууллагыг (Bar Association) байгуулахын тулд юу хийсэн бэ?

Иргэд өмгөөлөгчее чөлөөтэй сонгох эрхийг хэрэгжүүлэхийн тулд дээр дурдсан жагсаалтыг (тооны хязгаарыг) байхгүй болго шаардлагатай байсан. Бидкоммунистдэглэмийг нуранунаамагц буюу даруй 1990 оны эхний хагаст хуулынийн мэргэжлийн шинэчлэлийг эхлүүлж, бэлтгэлийг хангаж, хуулийн шинэчлэлийг хийсэн. 1990 оны 7 дугаар сарын 1-ээс эхэлж, энэ өдрөөс

өмнө ЧӨТ-ийн хөдөлмөрийн гэрээт ажилтан байсан өмгөөлөгчид өөрийгөө цалинкуулдаг хараат бус хуулийд болсон бөгөөд хараат бус, бие дэасан мэргэжлийн байгууллага болох Чехийн өмгөөлөгчдийн холбооны (ЧХХ) түшүүн болсон. Энд бүүр анхнаас эхэлж, өнөөг хүртэл Чехийн Өмгөөлөгчдийн Холбоо (the Czech Bar Association) нь заавал гишүүнчлэлтэй байсан гэдгийг онцлон тэмдэглээ. Хараат бус өмгөөлөгчдийн холбоог байгуулах үндсэн алхмууд юу вэ? Гэсэн таны асуултад холбогдож нэн ялангуяа дараахийг нэрлэх ёстой: 1-т, өмгөөлөх эрх олж авах өрөнхий шаардлагыг хангахын зэрэгцээ тооны хязгаарлалт тавихыг бүрэн утгаар нь устгах. 2-т, өмгөөлөгчийн мэргэжлийг чөлөөтэйгөөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх. 3-т, хууль зүйн үйлчилгээний даатгалыг заавал хийлгэх нөхцөл тавих. 4-т, өмгөөлөгчийн сахилгын хариуцлагын журмыг тодорхойлох.

ЧХХ-ийн тэргүүн, удирдах зөвлөлийг хэрхэн сонгодог вэ? Коммунист дэглэмийн үеийн санал авах процесс одоогийнхоос ялгаатай юу? Танай холбоонд цөөн хэдэн хүмүүсийн бүлэглэл үеийн үед эрх мэдлийг гартаа байлгаж байсан тохиолдол гарч байсан уу? Өмгөөлөгчдийн Холбоог хэрхэн дотоод ардчилалтai болгосон бэ?

Дарвен жил тутам ЧХХ-ийн Их Хурал болдог. Ингэхдээ өмгөөлөгч бүр Их Хуралд оролцох эрхтэй байдаг. Их Хурлаар удирдах зөвлөлийн 11 гишүүн, тааван орлогч гишүүнийг томилдог. Удирдах зөвлөлөөс ЧХХ-ийн өрөнхийлэгчийг томилдог. Үүний дээр Их Хурлаар ЧХХ-ийн Хяналтын зөвлөл, Сахилтын хороо ба Давж заалдах сахилгын хорооны гишүүдийг тус тус сонгодог.

Социализмын үед ЧӨТ-ийн сонгуулийн хурал гэж байсан. Одоогийнхоос ялгаатай нь тухайн үед сонгуутийн ажилтан хийх хүнийг урьдчилсан товлож, сонгож томилдог байсан. Тухайн үед өмгөөлөгчдийн дунд маш цөөн тооны өмгөөлөгч намын гишүүн байсан боловч ЧӨТ-ийн удирдлагын олонх нь Коммунист намын

тишүүд байдаг байсан.

Өнөө цагт Өмгөөлөгчдийн Холбооны аль ч сонгуульт албандаа аль ч өмгөөлөгч өөрийнхөө нэрийг чөлөөтэйгөөр дэвшиүүлж болно. Өдгөө Чехийн Өмгөөлөгчдийн холбооны сонгуулийн компланит ажил гэж зүйл ердийн үзэгдэл болсон. 1990 оноос хойш Холбооны хяналтыг цөөн хэдэн хүмүүсийн бүлэглэл гартаас барьж ташианд тохиолдол хэзээ ч гараагүй. ЧӨХ-ийн ерөнхийгэч ЧӨХ-ийн удирдах зөвлөлөөс тусдаа байх хяналтын ба сахилгын эрх мэдлүүдийн хяналтад байдаг, дотоод ардчилалтай, хяналттай тогтолцоо юм.

БНЧУ эдийн засгийн хувьд европын хамтын нийгэмлэг ба дэлхийн зах зээлд хүчтэй холбогдсон. БНЧУ-д олон гадаадын хуулийн фирмүүдийн бий. Гэхдээ чех хуулийн фирмүүдийн өрсөлдөх чадвартай сайн юм шиг.

Бүүр 1990-ээд оноос эхэлж ЧӨХ нь гадаадын хуульчид ба гадаадын хуулийн фирмүүдийн БНЧУ-д үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн. Эхэн үедээ үүнд шүүмжлэлтэй хандах явдал гарч байсан. Гэхдээ энэ нь зөв алхам байсан гэдэг нь удахгүй ойлгомжтой болсон. Учир нь чех хуульчид, нэн ялангуяа томоохон амбицтай том хуулийн фирмүүд зах зээлд гадаадын тоглогчид орж ирмэгц өрсөлдөх чадвараа харуулж, чанартай үйлчилгээ үзүүлэх ёстой болсон. Одоо бол энэ асуудал ямар ч маргаангүй. Үүний дээр гадаадын гэгдэж байгаа хуулийн фирмүүдийн бараг бүгдийг нь чех өмгөөлөгчид удирдаж, тэнд чех өмгөөлөгчид ажилладаг. Үүнтэй холбогдок БНЧУ европын холбоонд элссэний дараа "европын хууль" ба "европын зочин хууль" гэсэн статус бий болсны дурдах хэрэгтэй.

Гадаадын хуульч, хуулийн фирмийн асуудлыг ерөнхийдөө хэрхэн зохицуулдаг вэ?

Ерөнхийдөө урьд хэлсэнчлэн Европын Холбооны нэг гишүүн улсын хуульид өөр нэг тишиүүн улсад "зочин хууль" эсвэл "байнгын хууль" гэсэн статустайгаар ойролцоогоор дотоодын

хуульчидтай ижил нэхцелөөр үйл ажиллагаа явуулдаг. Өмгөөллийн тухай хуулиар Европын хуульчийн үйл ажиллагааг зохицуулсан байдаг. Зочин хуульчийн хувьд нэгж хэргээ маргаанд оролдог тул зохицуулалт нь маш энгийн байдаг. Европын байнгын хуульчид нь ЧӨХ-ын бүртгэлд бүртгүүлсэн байх ёстой ба бүртгэлд орох нэхцэл нь харьцангуй өргөн, заавал биелүүлэх шинжтэй байдаг.

Негөө талаас БНЧУ-д бүртгэлтэй гадаадын хуулийн фирмүүдэд ЧӨХ-ийн жагсаалтад орсон чех өмгөөлөгчид голчлон ажилладаг. Ийм фирмүүд анх байгуулагдах үед удирдлага, менежментийг гаднын хуульчид хариуцаж байсан. Одоо бол ийм фирмүүдийн удирдлага, менежментийг голчлон чех өмгөөлөгчид хариуцах болсон. Энд Чехийн өмгөөллийн салбарыг дэлхийд нээлттэй байлагах бодлого нь ур ашгаа өгсөн гэдгийг онцлон тэмдэглэе.

Жишээ нь Германд хуулийн фирмүүдийг партнерүүд удирддаг ба партнерүүд нь ашиг хуваах эрхтэй хамтран өмчлөгчид байдаг. Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээг үйлчлүүлэгч ба хуулийн фирмийн хооронд хийдэг ерөнхий практик байдаг. Үйлчлүүлэгч хуулийн фирмд төлбөрөө төлдөг. Энэ нь хуулийн фирмийн санхүү нь өмчлөгчөөс (партнер) тусдаа байна гэсэн уг юм. Дундаж, гайгүй сайн ажилладаг чех хуулийн фирмийн хувьд санхүүгээ хэрхэн барьдаг вэ? Өмгөөлөгчид үйлчлүүлэгчийн өмнө хохирол нэхэн төлөх хариуцлага хэрхэн хүлээдэг вэ?

Өмгөөлөгч нь дангаараа эсвэл бусад өмгөөлөгчтэй хамтарч үйл ажиллагаа явуулж болно. Хамтрас тохиолдолд нэхэрлэлийн хэлбэрээр (германаар: Kommanditgesellschaft) эсвэл нээлттэй худалдааны нэхэрлэл (германаар: offene Handelsgesellschaft) хэлбэрээр ажилладаг. Хуульчид хуулийн фирмд нэгдэж ажиллаж байгаа бол зохион байгуулалт нь Германыхтай ойролцоо. Үүнээс гадна өмгөөлөгч дангаар хуулийн фирм хэлбэрээр

ажиллаж болно эсвэл өөр хуульчийн гэрээт ажилтан байж болно. Үүнээс гадна өмгэөлөгч нь бусад фирм, холбоо, өмгэөлөгчтэй Өмгээллийн тухай хуульд заасны дагуу гэрээний үндсэн дээр хамтарч ажиллаж болно.

Хохирол нөхөн төлөх хариуцлагын хувьд өмгэөлөгч дангаар эсвэл хамтран үүрдэг. Хэрэв өмгэөлөгч компани эсвэл гадаадын компани хэлбэрээр үйл ажиллага явуулбал хохирлыг компани хариуцдаг. Үүнээс ялгах үзэх ёстой өөр нэг зүйл нь өмгэөлөгч үйлчлүүлэгчид хэрхэн хандсаныхаа төлөө үүрэх ёс зүйн хариуцлага гэж бас байна. Энэ ташрамд дурдахад, БНЧУ-д өмгэөлөгч дангаар эсвэл хуулийн этгээд хэлбэрээр хамтран үйл ажиллага явуулах аль аль нь хөгжсөн. Энэ хэлбэр нь илүү гэж хэлэх зүйл байхгүй. Гэхдээ хуулийн фирмийн гишүүд, партнериүүд нь зөвхөн хуулийнд байх ёстой бөгөөд хуулийн фирмийн үйл ажиллагаа нь зөвхөн хууль зүйн үйлчилгээгээр хязгаарлагдах ёстой байдаг.

Хуулийн фирмийн зээд нь хуульчид байх нь дэлхий даяар нийтлэг байдаг. Ийм нэгдсэн олон улсын зарчим байгаа юм шиг санагддаг. Танай улсад хуулийн фирмийн партнериудад (өмчлөгчдөд) ямар шаардлага тавдаг вэ?

Хуулийн фирмийн өмчлөгчид нь зөвхөн хуульчид байх ёстой гэсэн зарчим дэлхий даяар үйлчилдэг гэж хэлж болохгүй. Нэн ялангуяа, англичансони концептоор олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг компанийд өөр төрлийн үйл ажиллагааны хажуугаар хууль зүйн үйлчилгээ үзүүлдэг тохиолдолд байдаг. Миний ойлгосноор зөвхөн Чөхэд биш, эх газрын европт олон төрлийн үйл ажиллагаа эрхлэх практикийг хориглодог.

Жишээ нь Германд Өмгэөлөгчдийн Холбооны (the German Bar Association) гишүүн биш буюу өмгэөлөгч биш хүн хараат бус хуульчийн хувиар хууль зүйн зөвлөгөө өгөх эрхгүй байсаар ирсэн. Үүнтэй нэгэн адил өмгэөлөгч биш хүн бусдыг шүүхийн өмнө хуульчийн

хувиар төлөөлөх эрхгүй байх зарчмыг байдал. БНЧУ үүнтэй адил тогтолцоотой юу? Хэрэв тийм бол хараат бус өмгээллийг хөгжүүлэхийн тулд ийм хязгаарлалт шаардлагатай гэж үзэж байна уу?

БНЧУ-ын тогтолцоо Германыхтай ойролцоо. Зарчмын хувьд хууль зүйн үйлчилгээ болон шүүхийн өмнө үйлчлүүлэгч төлөөлөх бизнесийн үйл ажиллагааг зөвхөн өмгэөлөгч, нотариатч нар явуулах эрхтэй байдал. Нотариатчаас гадна зөвхөн Өмгэөлөгчдийн Холбооны гишүүн өмгэөлөгч хууль зүйн асуудлаар бусдыг төлөөлэх эрхтэй байдал.

Гэхдээ энэ зарчмыг хязгаарласан зохицуулалт нь "өрөнхий төлөөлөл" буюу бусдыг уна төлбөргүй төлөөлөх тохиолдолд өмгэөлөгч биш хүн төлөөлөх боломжтой байх явдал юм. Ингэж төлөөлөх нь зөвхөн иргэний хэргийн хувьд зөвшөөрөгдсөн байдал. Ингэхээр өрөнхий төлөөлөл нь тусгай зохицуулалт юм.

Гэхдээ нэг компанийг, тухайн компанийн хууль өөрөө төлөөлөх боломжтой байдал. Түүнчлэн Засгийн газрын байгууллагад хөдөлмөрийн гарээтийг хууль тухайн байгууллагыг өмчийн асуудлаар шүүхийн өмнө төлөөлөх эрхтэй байдал.

Асуудлын гол нь сахилгын хариуцлага хүлээх, заавал хамрагдах мэргэжлийн хариуцлагын даатгалтай мэргэжилтэн болохын хувьд зүйн үйлчилгээг зарчмын хувьд өмгэөлөгч үзүүлэх ёстой гэсэн зарчим юм.

Монголд хуулийн зөвлөгөөний үйлчилгээ болон шүүхэд төлөөлөх үйлчилгээ гэсэн хоёр хэсэгт хууль зүйн үйлчилгээний зах зээлийг хуваах хандлага ажиглагддаг. Таны бодлоор үүний ач холбогдол, эрсдэл юу вэ?

Би Монголын практикин талаар мэдэхгүй. Гэхдээ хууль зүйн зах зээлийг хэсгчлэн хуваах нь эрүүл бус, улмаар шударга бус өрсөлдөөнд хүргэж, сэтгэцийн гажигтай юм шиг нөхцөл байдлыг ургэлж бүрдүүлэх болно гэдэгт би итгэдэг. Зөвлөгөө, шүүхэд төлөөлөх

асуудал нь хоорондоо холбоотой зүйл бөгөөд нэг нэгнээ тасралтгүй нөхөн харилцаанд байх зайлшгүй шаардлагатай гэж би үздэг.

Өмгөөлөгчид патентын итгэмжилгэсэн төлөөлөгч, татварын зөвлөх гэх мэт хуульч бус мэргэжилтнүүдтэй хамтарч ажиллах ёстой болдог. Германц өмгөөлөгчид хуулиар нэрлэж заасан тодорхой мэргэжлийн бүлгийнхэнтэй хамтарч хуулийн этгээд байгуулж болно. Чөхд үүнтэй ойролцоо зохицуулалт байдаг уу?

Бид олон чиглэлийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг хуулийн фирмүүдийг хориглодог. Бусад мэргэжлийнхэнтэй гэрээний нүндсэн дээр хамтрах нь нийтлэг байдаг. Та патентын итгэмжилгэсэн төлөөлөгчдийг ярж байгаа бол чехд патентын асуудлаар мэргэшсэн өмгөөлөгчид гэж байдаг.

БНЧУ-д залусс өмгөөлөгч болохын тулд ямар шаардлагыг хангах ёстой вэ?

Өмгөөлөгч болохын тuld эхлээд магадлан итгэмжилгэсэн их сургуулийг (Прага, Брно, Оломоуц, Плзен хотуудын Их Сургууль) хуулийн магистр зэрэгтэйээр тэгссен байх шаардлагатай. Ийм сургуулийг улсын шалгалтгеч, магистрын ажлыг хамгаалж дүүргэсний дараа нэг өмгөөлөгчийн дагалдангаар хөдөлмөрийн гэрээтэй турван жил ажиллах ёстой. Дагалдан хийх хугацаандаа ЧӨХ-өөс зохион байгуулахаа заавал суух ёстой мэргэжлийн сургалтуудад суух үүрэгтэй байдаг. Дээрх шаардлагуудын хангасан бол өмгөөлөгчийн шалгалт өгөх ёстой. Өмгөөлөгчийн шалгалт нь турван өдер үргэлжилсэн бичгийн шалгалт (гэр бүл, хөдөлмөрийн эрх зүй, багтаасан иргэний эрх зүй, худалдааны эрх зүй, зруүгийн эрх зүй гэсэн турван салбарыг хамарна) болон таван гишүүнээс бүрдсэн комисс авдагам шалгалт (дээрх турван салбар дээр нэмж үндсэн хууль, захиргааны эрх зүй, өмгөөлөгчийн мэргэжлийн эрх зүй) гэсэн хэсгүүдээс бүрдэг. Шалгалтын комиссын тэргүүн нь өмгөөлөгч байх ёстой боловч комисс

нь шүүгч, их сургуулийн багш-судлаач гэх мэтээс бүрдэнэ.

Өмгөөлөгчидөөрчлөгджэбайгаа хуулийн ба бизнесийн орчинтой хөл нийлүүлэх чухал. Хуульчийн мэргэжлийн давтан сургалтыг хариуцахад Өмгөөлөгчийн Холбоо чухал үүрэгтэй. Чехийн өмгөөлөгчид давтан сургалтад заавал хамрагдах үүрэг хүлээдэг үү?

Дээр дурдсанаар дагалдан хуульчид (junior lawyer) өмгөөлэгийн шалгалт өгөхөөс ёмне ЧӨХ-ийн сургалтад заавал суух үүрэгтэй байдаг. Намайг Өмгөөлөгчдийн Холбооны тэргүүн байх үед өмгөөлөгчид хорин цагийн давтан сургалтад заавал суух ёстай гэсэн хуулийн төслийг бид оруулсан боловч Чехийн Парламент төслийг батлаагүй. Яг үнэндээ бол энэ асуудал өнөөдөр дахин сөхөгдэж байна. Өмгөөлөгчид давтан сургалтад заавал суух ёстай гэсэн шаардлагыг улам олон хүн тавих болжээ. Негеэ талаас би Прага, Брно хотуудад өмгөөлөгчдийн сургалтын байнны төвүүдийг нээх ажлы удирадж, энэ төсөл амжилттай болсон. Энэ төвүүдэд сайн дураараа сургалтад орх байгаа өмгөөлөгчдийн тоо, сонирхол маш өндөр байдаг.

Коммунизм нуран унаснаас хойш 25 жилийн хугацаанд Монголд сайн зүйлс их хийгдсэн дээр цаашид сайжруулах шаардлагатай зүйлс ч их байна. Хамгийн томоохон асуудлуудын нэг нь шүүх засаглалын бие даасан байдал. Хүчтэй, хараат бус өмгөөллийн фирмүүд хараахан төрж гараагүй байгаа нь үүнд бас нөлөөлж байна. Үүнд холбогдож та монголчуудад, өмгөөлөгчдөд юу зөвлөх вэ?

Өмгөөлөгчийн хараат бус байдал нь өмгөөллийн үйл ажиллагааны үндсэн сурье нөхцөл. Иймээс Чехийн Өмгөөллийн тухай хуульд өмгөөлөгчийн хараат бус байдал онцой анхаарсан. Өмгөөлөгчийн хараат бус байдлыг хангахын тулд Өмгөөллийн бие даасан холбоо (Bar Association) гэж байх ёстой. Өмгөөлөгчдийн холбооны бие даасан (хараат бус) байдлыг зүгээр нэг хуулыилсан актаар биш, харин

хуулиар баталгаажуулж өгөх ёстой. Бие даасан байдал (бие даасан засаглал) гэдэг нь нийтийн эрх зүйн бүхий л эрх хэмжээг Өмгөөлөгчдийн холбоонд (Bar Association) хуулиар өгсөн байхыг хэлнэ. Нийтийн эрх зүйн бүхий л эрх хэмжээ гэдэг нь өмгөөллийн мэргэжлийн бүрэн, дотоод менежмент юм. Өмгөөллийн бие даасан байдалд нөлөөлөх Засгийн газрын аливаа халдлага нь хараат бус байдалд халдаж байгаа халдлага бөгөөд энэ нь өмгөөллийн үйл ажиллагааны үндсэн зорилгод халдах, улмаар ардчилсан шүүх засаглалын зарчмыг угтгасж аюултай. Өмгөөлөл гэдэг мэдээжээр, ямар ч эргэлзээгүйгээр өргөн утгаараа шүүх засаглалын нэг хэсэг юм. Бие даасан, хараат бус байдал нь өмгөөллийн мэргэжлийн өөр нэг үндсэн зарчмын болох мэргэжлийн нууцыг хамгаалах асуудалтай нягт холбоотой гэдгийг ухамсарлах чухал юм. Хэрэв Засгийн газар өмгөөллийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцдог бол нууцлалыг хадгалах боломжгүй болно.

Өдгөө Өмгөөлөгчдийн Холбооны хяналт, сахилгын хариуцлагын

асуудалд Засгийн газрын байгууллагууд хөндлөнгөөс оролцох оролдлогуудыг хийсээр байгаа учир ЧӨХ нь өмгөөлөгчдийн хяналт, сахилгыг мэргэжлийн байлагхыг чанга дуугаар шаарддаг.

Аливаа нэг төрийн албан тушаалтан өмгөөлөгчийн хараат бус байдалд халдана гэдэг нь өмгөөлөгчийн мэргэжлийн нууцад халдана гэсэн уг. Үүнтэй холбогдох мэргэжлийн нууцыг хамгаалах нь өмгөөлөгчийг өөрийг нь хамгаалах хэрэгсэл бус харин үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах хэрэгсэл гэдгийг байнга сануулж байж зайлшгүй шаардлагатай. Би монголчуудад юуг хүсэж байна вэ? гээл: Бие даасан (хараат бус), сахилгын хариуцлага хүлээдэг, зохих ёсоор даатгуулсан өмгөөлөгчид заавал гишүүнчлэлтэй байх цорын ганц, өөрийгөө удирдах байгууллагатай байхыг хүснэ.

Ярилцлагыг бэлтгэсэн: Хууль зүйн доктор Дэлгэрийн Уянга

---000---

“ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ЭМХЭТГЭЛ”-ИЙН ТАНИЛЦУУЛГА

“Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл” нь хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг бүрэн эхээр нь нийтэлдэг эмхэтгэл юм. Тус эмхэтгэл нь улиралд 9 дугаар, жилд 36 дугаар хэвлэгддэг.

ЗАХИАЛГЫН ИНДЕКС:

Монгол шуудан – 200195,
Улаанбаатар шуудан – 2001066,
Түгээмэл шуурхай шуудан – 250003,
Скай Пост – 200195.

ХУУЛЬ ЗҮЙН ФИРМ



Өмгөөлөгч, хууль зүйн доктор
3.Сүхбаатар

ТҮЛХҮҮР ҮГ:

Хууль зүйн фирм, хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх байгууллага, хууль зүйн фирмийн төрөл, хэлбэр.

ТОВЧЛОЛ:

Энэхүү өгүүлэлээр хууль зүйн фирмийн хөгжлийн хандлага, мөн чанар, үйл ажиллагаа, хууль зүйн фирмийн хэлбэр тэдгээрийн давуу болон сүл тал, мөн хууль зүйн фирмийн төрлийн талаар хөндсөн болно.

Нэг. Оршил

Өнөөдөр дэлхий дахинд улс төр, нийэм, эдийн засаг, техник технологи, соёл, боловсрол гэх мэт хүний харилцааны бүхий л салбард даяаршил, интеграчлал эрчимжик мэдээлэл, шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжил хувьсам асар хурдацтай явагдах боллоо. Үүнтэй холбоотойгоор хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх салбар ч ихээхэн глобалчлагдаж, эл чиг үүрэг бүхий хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаа улам өргөжин тэлж, гүнзгийрэн нарийч өрсөлдөөнт зах зээлийн орчин нөхцөлд ажиллах болсон билээ.

Түүнчлэн хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх, хүний эрх, эрх чөлөө, хувийн өмч, нийгмийн үнэт зүйлийг бүхий л талаар хамгаалсан таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд иргэд, байгууллагад хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх зорилго, чиглэл бүхий хууль зүйн фирмүүд ихэхэн үүргийг гүйцэтгэх болов.

Улс орнуудын хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх байгууллагуудын нийгмийн түгээмэл дүр төрх бол мэргэжлийн үйл ажиллагаандaa голлон анхаарлаа хандуулж, харин хүмүүсийг үр ашигтай, зохион байгуулалттай, бүтээнж болгон өөрчлөх тал дээр сүл анхаарч ирсэн байдал. Тухайлбал, АНУ-ын өмгөөлөгчид "1970-аад оны эхэн үеэс менежментийн үр нөлөөг ойлгож эхэлсэн бөгөөд үүнээс өмнө ажил хэргээ яаруу дааруу менежментээр явуулж байсан ба харамсалтай нь энэ байдал өнөөг хүртэл оршин тогтносоор байгаа" гэжээ. АНУ, Англи, ОХУ, Япон, БНХАУ, БНСУ гэх мэт дэлхийн ихэнх улсуудад хууль зүйн фирмүүдийг зөвхөн хуульч мэргэжлийн хүмүүс үүсгэн байгуулж, удирдах, мэргэжлийн ёс зүйг чанд журамласан, санхүү мөнгөний боломжийг зохих түвшинд хязгаарласан эрх зүйн орчин үйлчилсээр байна. Үүний улмаас хууль зүйн фирмүүд өөрийн үйл ажиллагаанд гадны болон бусад хөрөнгө оруулагчид, мэргэжлийн болон санхүүгийн менежерүүдийг татан оролцуулах хийгээд хөрөнгийн зах зээлд нийтэд санал болгон үнэт цаас гаргах (*Initial Public Offering*) зэрэг нь хориотой байгаа нь хууль зүйн мэргэжлийн бизнесийг орчин үеийн байдлаар хурдацтай хөгжлийн боломжийг хязгаарлаж байна. Сүүлийн жилүүдэд

¹Pamela Everett Nollkammer Fundamentals of Law office management: Systems, procedures, and ethics. USA 2014 . p 5-6

Англи-саксоны эрх зүйн системийн улс орнуудад эрх зүйн орчны либералчлах хандлага гарч эхэлж байна. Тухайлбал, 2007 онд Австрали улс хууль зүйн фирмүүдээс нийтэд санал болгон үнэт цаас гаргах хөрөнгө оруулалтыг татахыг зөвшөөрсөн тул Австрали улсын дунд хэмжээний хууль зүйн фирм болох Слейтэр энд Гордон (*Slater & Gordon*) нь 2007 оны 5 дугаар сард Австралийн хөрөнгийн бирж дээр хувьцаагаа амжилттай гаргасан байдаг². Их Британид ч мөн адил хууль зүйн салбарын бизнест өөрчлөлт хийж эхэлсэн бөгөөд 2009 онд “Эрх зүйн үйлчилгээ үзүүлэх тухай хууль” баталж, Английн хууль зүйн фирмүүдэд Лондонгийн хөрөнгийн биржид хувьцаа гаргах, түүнчлэн хуулын бус мэргэжлийн хүмүүсийг тодорхой түвшинд үйл ажиллагаандaa оролцуулах боломжийг олгосон байна. Үүний үр дунд 2015 онд Английн Гателей (*Gatetley*) хууль зүйн фирм Лондонгийн Хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргах 50 сая амдолларын хөрөнгө оруулалт татсан байна³.

Хэдий тийм ч үүний өсөлтийг дагасан зардлын өсөлт нь хууль зүйн фирмүүд үйлчилгүүлгэчээс авах хэлс төлбөрөө нэмэгдүүлэхэд хүргэж байна. Хуулын үр ашигтай технологи, өндөр үнэтэй систем, программ хангамж нэвтрүүлэхэд их хэмжээний хөрөнгө оруулалт хийж хэрэгтэй болдог гэх мэт мэргэжлийн болон санхүүгийн бусад олон хүчин зүйлс үр ашигтай бодлого, менежмент нэвтрүүлэхийг зүй ёсоор шаардааа байгаа билээ.

Хуулыч, өмгөөлөгчид нийгэмд хууль зүйн мэргэжлийн туслапцаа үзүүлэх үйл ажиллагаа нь хувь хүн, микро бүлгийн хэмжээнээс гарч хүмүүсийн мэдэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг бүрэн гүйцэд ашиглах, хөдөлмөрөө хорших, хамтрах, төрөлжих замаар үйлчилгээ нь үр дүнтэй, найдвартай, чанартай болоход хүмүүсийг нэгэн зорилтын дор нэгтгэж чадах боломж нь байгууллага болон зохион байгуулалтад орох явдал мян.

² <http://www.hbs.edu/faculty/Pages/item.aspx?num=43408>, <https://www.slatergordon.com.au/firm/our-history>

³ <http://business.financialpost.com/legal-pos/first-u-k-law-firm-loc-raises-50-million>.

Монгол Улс 1990 оноос ардчиллын замыг сонгож, хувийн өмчийг хүлээн зөвшөөрсөн эрх зүйн орчинг бий болгосон тул хувийн хэвшлүүд олон арваар байгуулгадаж, үйл ажиллагаа явуулах болсон нь хууль зүйн мэргэжлийн туслапцаа үзүүлэх хувийн байгууллагыг бий болгох нийгмийн хэрэгцээ, шаардлагыг бий болсон гэж үзэх боломжтой юм. Улмаар 1993 онд анхны хууль зүйн мэргэжлийн туслапцаа үзүүлэх байгууллага байгуулгадаж⁴ өнөөгийн байдлаар Хуулынхон холбоонд бүртгэлтэй, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 145⁵ өмгөөллийн нөхөрлөл байна.

Иймд хууль зүйн фирмийг тал бүрээр судлах нь чухал өч холбогдолтой болохыг онцлож, энэхүү өгүүлээр хууль зүйн фирмийн мөн чанар, үйл ажиллагааны чиглэл, хэлбэр, төрөл, хэмжээний талаар толилуулж байна.

Хоёр. Хууль зүйн фирмийн мөн чанар

Зассан алмааз, шижир алтнаас ч илүү үнэ цэнэтэй зүйлс гэж байдаг. Үндн яах арагтай хүний эрх, эрх чөлөө, нийгмийн шударга ёс орно. Энэхүү үнэ цэнэтэй зүйлийг бүхий л талаар хамгаалахын төлөө хууль зүйн фирм зориулагдсан байdag тул үйл ажиллагаа нь ёс суртахуун болон итгэлд сууринсан байдаг.

Хууль зүйн фирм (*law firm, юридическая фирма*) нь иргэд болон байгууллагад хууль зүйн мэргэжлийн туслапцаа үзүүлэх зорилготойгоор нэг болон хэд хэдэн хуулынхон үсгээн байгуулсан байгууллага юм.

Хууль зүйн фирмийн үндсэн зорилго нь хүн бүхэнд хуулиар

⁴ З.Сүхбаатар. Хууль зүйн мэргэжлийн туслапцаа үзүүлэх байгуулалтын түхэн уламжлал. Хууль нийс затгул. 2016 оны 02 дугаар сар №10 (11). 29 дах тал.

⁵ Монголын хуулынхон холбооны өмгөөлөгчдийн хорооноос 2017 оны 3 дугаар сарын 22-ны өдөр авсан мэдэг үндэслэл болгов. 2017 оны 3 дугаар сарын 21-нд Монголын хуулынхон холбооны өмгөөлөгчдийн хорооноо зохион байгуулсан “өмгөөллийн үйл ажиллагаанд ногдуулах татвар” садээв хэлэлцүүлэгт хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй 3520 нэхэрэл байгаа бөгөөд үүнээс 207 нь хэвлэгэлтэйдээ хариуцлагатай нэхэрлэл, үүний 197 нь татварын албанц бүртгэлтэй талаар тоон мэдээ танилцуулагдсан болно.

олгогдсон иргэний болон здийн засаг, нийэм, соёлын эрхийг үр нөлөөтэй хамгаалахад чиглэгдэх бөгөөд үйл ажиллагаандaa хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, шударга ёсиг сахих, хууль дээдлэх, үйлчлүүлэгчийнхээ эрх, эрх чөлөөг бүрэн туштай хамгаалах, нууц хадгалах зарчмыг удирдлага болгодог.

Уг зорилгын төлөө хууль зүйн фирм нь дараах үндсэн үйл ажиллагааг явуулдаг байна. Үнд:

- Нийгэм, здийн засгийн бүхий л салбарт хууль зүйн зөвлөгөөгөөгөө;
- Байгууллагын хууль зүйн хэрэгтээг хангахад чиглэсэн мэргэжлийн туслацаа;
- Шүүх, арбитрт үйлчлүүлэгчийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх;
- Эрх зүйн ач холбогдол бүхий баримт бичигт дүн шинжилгээ хийх;
- Эрх зүйн ач холбогдол бүхий өргөдөл, гарзээ, хэлэлцээр болон бусад баримт бичгийн эх боловсруулах;
- Хууль тогтоомжийн эмхэтгэл гаргах, хэм хэмжээний актуудыг сонгон түүвэрлэх хэвлэн нийтлэх;
- Төрийн болон төрийн бус байгууллагад үйлчлүүлэгчээ төлөөлөх;
- Эрх зүйн салбарт эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх;
- Байгууллагад здийн засаг, санхүү, татварын эрх зүйн зөвлөгөөгөө;
- Байгууллагыг өөрчлөн байгуулах асуудлаар удирдлагад зөвлөгөө, зааварчилгаа гөгөх;
- Хууль зүйн магадлан дүгнэлт гаргах;
- Хөрөнгө татах төлөвлөлтийг боловсруулах, анализ хийх, бизнес төлөвлөгөөг зохиход оролцох;
- Хууль зүйн салбарт ажилладаг мэргэжилтнүүдийг сургах зэрэг болно.

Хууль зүйн фирмийн дээрх үйл ажиллагааны фитюсийн нанхын алхам

нь түүний эрхэм зорилгыг удирдлага болгоос эхэлдэг. Гадаадын 50 гаруй хууль зүйн фирм эрхэм зорилгоо хэрээн тодорхойлсыг судлан үзэхэд голчлон нэн түрүүнд "үйлчлүүлэгч" рүүгээчилгэх, үйл ажиллагаандaa "ёс суртааууныг" дээдлэх, мэргэжлийн үйлчилгээгээ "өндөр түвшин" хийж түйцэгэх, тулгарсан асуудлыг нь хамгийн "сайн, оновчтой" арга замаар шийдвэрлэх, "багаар" гар нийлж ажиллах гэсэн нь мэргэжлийн байгууллагын онцлог шинж байдлыг илрхийлсэн тедийгүй мөн өөрсдийн эрхэмлэх үнэт зүйлсиг ялгаатай тусгасан нь яхын арагтай бие даасан байгууллагын өөр өөрсдийн зорилт, хөгжлийн өнгө төрхийг тодорхойлон харуулж байсан болно⁶.

Гурав. Хууль зүйн фирмийн хэлбэр

Хууль зүйн фирмүүд нь тухайн улс орны хууль тогтоомжид нийцсэн зохион байгуулалт, хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Нэг хүний эзэмшилийн хууль зүйн фирм. Нэг хүний эзэмшил (sole proprietorship)-ийн хууль зүйн фирмийг нэгемгэелегчдангаараа үйлажиллагаагаа нь эрхлэн хөтөлж явуулна. Фирм нь нэг өмгөөлөгчийн өмчлөлд байна. Харин тэрээр бусад өмгөөлөгчдөд ажил олгож болох бөгөөд үүнд ямарваа тооны хязгаарлалт тавигдахгүй. Нэг гишигчийн эзэмшилийн хууль зүйн фирм нь хэмжээний хувьд ихэвчлэн жижиг байдаг боловч АНУ-ын зарим муж улсад хэдийнээ 30 өмгөөлөгчид ажил олгосон тул дунд хэмжээний фирмд тооцогдох болсон байна⁷. АНУ-д нэг хүний эзэмшилийн хууль зүйн фирм нь гэр бүлийн эрх зүй, үл хөдлөх хөрөнгийн эрх зүй, гэм хор учруулснаас үүсэх үүрэг, эрүүгийн зөрчил, гэрээслэл гэрчлэх болон хөрөнгө төлөвлөлтийн чиглэлээр дагнан ажиллах байна.⁸

⁶ Сүхбаатар нар Хууль зүйн фирмүүдийн эрхэм зорилгоо юу вэ? Хууль нийсүүлж 2016 оны 02 дугаар сар №01 (08), 32-47 дахь талавс үзнэ УУ

⁷ Pamela L. Everett. Fundamentals of Law Office Management Systems, Procedures and Ethics. 1994., p. 10.

⁸ Мен тэнд р. 13

Өнөөгийн здийн засаг, төхнологи, болон хууль зүйн практикт гарсан өөрчлөлт нь ганцаарчлан ажилладаг өмгөөлөгчдийн хувьд дэндуу өндөр өртгөтэй болж байгаа учир өмгөөлөгчид багаар ажиллахыг илүү сонирхох хандлагатай болж байгаа. Энэ нь өнөөгийн өсөн нэмэгдэж байгаа өртгийг хуваарилах шалгарсан арга гэж үзэх боломжтой юм.

Нэг хүний эзэмшилийн хууль зүйн фирмийн давуу ба сул талууд

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> Бүх ашиг орлогыг дангаар эзэмшдэг; Илүү эрх чөлөө, бие даасан байдалтай; Фирмийн бүхий л шийдвэрүүдийг дангаар гаргах боломжтой; Фирмийн эргэн тойрны харилцагчтай ойр дотно байх бөгөөд бүдниг мэдэж байдаг. 	<ul style="list-style-type: none"> Фирмийн бүхий л зардуудыг дангаар хариуцдаг; Маш өндөр ачаалалтай ажилладаг бөгөөд хэргийн материалтай таницах, нотлох баримт цуглуулах, шүүх хуралдаанд оролцох бүрд бусад хуульчдын туслалцаа байдаггүй; Олсон орлогоосоо бүх зарлаад хасвал ашиг нь бага байдаг; Амартай байдаггүй бөгөөд гол төлөв уртасгасан цагаар ажилладаг; Ажил хэргийн бүхий л хүрээтэй (удирдах, үйлчлүүлэгчийг ирүүлэх, баримт бичиг боловсруулах, шүүхэд очих гэх мэт) нэг бүрчлэн харилцах хэрэгтэй болдог; Мэргэшний ажиллахад бэрхшээлтэй; Том номын сан, шинэ технологи, сүүлийн үеийн тоног төхөөрөмжжөөр хангаждах боломжтуй байдаг; Өмгөөлөгч цаашид өмгөөллийн үйл ажиллагаагаа явуулахгүй болсон (хунд өвчин туссан, нас барсан, өмгөөлөх эрхээ хасуулсан гэх мэт) тохиолдолд үйлчлүүлэгч орхигддог.

Албан тасалгаа хамтран эзэмшигчдийн нэгдэл (office-sharing association). Өмгөөлөгчид ганцаарчлан ажиллах нь маш өндөр өртгийг бий болгодог. Тиймээс эл өртгийг хуваарилах, багасгах цаашилбал мэргэжил, ур чадвараа хорших үүднээс өмгөөлөгчид албан тасалгаа хамтран эзэмшдэг. Албан тасалгаа хамтран эзэмшигчийг нийтэд дэлгэрснээр хууль зүйн нэгдэл (legal association) гэж нэрлэнэ.

Албан тасалгаа хамтран эзэмшигчдийн нэгдлийн давуу ба сул талууд

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> Үйл ажиллаганы өртэг, зардал бага; Эрх чөлөө, бие даасан байдалтай; Бусад өмгөөлөгчтэй ажил хэргийн ойр дотно холбоотой; Түрээслэгч буюу өмгөөлөгчтэй ойр дотно холбоотой байдал нь мэргэшлийн давуу талуудыг бий болгоно; Менежмент хүнд асуудал болдогтой; Фирмийн эргэн тойрон тав тухтай; Том номын сан болон сайтар тоноглолцон техник, тоног төхөөрөмжийг ашиглах боломжтой. 	<ul style="list-style-type: none"> Оффисийн менежментийн талаар саналын эрхгүй; Нийтээрээ дундын нарийн бичигтэй учраас үйлчлүүлэгчдээ хувийн анхаарал тавьж чаддаггүй; Өрөө, байрны түрээстэй холбоотойгоор ажлын байрны тогтвортгүй байдал үүсдэг.

Нөхөрлөл (partnership). Энэ нь хоёр буюу түүнээс дээш этгээдийн байгуулсан хууль зүйн фирм юм. Фирмд хандсан үйлчлүүлэгчдийн ажлыг өмгөөлөгчид хамтран хийх бөгөөд орлогoo гишүүдэд хуваарилна. Өмгөөлөгчид нөхөрлөлд ажиллах гишүүний болон хамтрагчдын гэсэн хоёр төрөл бий.

Гишүүний төрөл. Фирмийн өмчлөгчид нь фирмийн гишүүд байх бөгөөд тэд цалин, хөлс авах эрх бүхий ажилнуудад тооцогдохгүй. Харин фирмийн хэчинээн хувийг эзэмшиж байгаагаас шалтгаалаад олсон ашгаас тэр хэмжээгээрээ хувь

хүртэнэ. Фирмийн гишүүний хүртэх хувь нь тухайн гишүүний зэрэглээс хамаарна. Хууль зүйн фирмүүдэд гишүүний олон ангилал байдаг боловч ихэнх хууль зүйн фирмүүд нөхөрлөлийн үйл ажиллагаанаас үүдэн гарсан хариушлагыг хүлээдэг болон хүлээдэгтүй гишүүн гэсэн хоёр төрлийн ангиллыг голчлон хэрэглэж байна.

Хамтрагчийн төрөл. Хамтрагч (Associate) өмгөөлөгчид нь фирмийн ашаас хувь хүртэлгүй нөхөрлөлийн ажилтнууд байдаг. Тэдэнд ажлын хэлс цалин олгоно. Хамтрагчид нь тухайн хууль зүйн фирмд тодорхой хугацаанд ажилласны дараагаар фирмийн хувь зэмшигч болох эрхтэй болдог. 1940 оноос өмнө хамтрагчид хувь зэмшигч болохын тулд 20 жил болон түүнээс дээш хугацаанд ажилладаг байсан. 1970-аас 1980-аад онд хувь зэмшигч болохын тулд 5-7 жил ажиллах хэрэгтэй болсон. Харин 1990 оноос энэ хугацааг уртасгасан. Зарим хууль зүйн фирм тухайн хамтрагчийг гишүүн болгох уу? угүй юу гэдгийг дахин үнэлж эхэлсэн⁹ байна. Өнөөгийн хууль зүйн мэргэжлийн зах зээлийн өрслэдээний улмаас хууль зүйн фирмүүд цөн тооны хамтрагчийг хувь нийлүүлэгч болгох бодлогыг барих болсон.

Нөхөрлөлийн давуу ба сул талууд

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> Өмгөөлөгч өвчтэй, амралтаа авсан зэрэг шалтгаанаар тухайн хэрэг дээр ажиллас боломжгүй болсон тохиолдолд бусад өмгөөлөгчид үргэлжлүүлэн ажилладаг; Мэргэшн ажиллах илүү боломжтой; Фирмийн бусад өмгөөлөгчид, эсхүл тэдний туслахуудтай ажил хэргийн сүлжээнд байдаг; Фирмийн зардлыг гишүүд тэнцүү хувь хэмжээгээр хариуцдаг; Нууцлалын түвшин өндөр байдаг; Өндөр орлоготой; Олон нийттэй холбоотой байх илүү боломжтой байдаг. 	<ul style="list-style-type: none"> Ажлын туршлага сайжруулах шаардлагатай; Эрсдэлд өртөмтгийг байдаг. Гишүүн эсвэл хамтрагчийн мэргэжлийн алдааг нөхөрлөлийн бүх өмгөөлөгчид хариуцдаг; Буулт хийх чадвар хэрэгтэй; Ажлын хэлс төлөгдхөгүй хэргийг хулээн авч өмгөөлөхгүй ба өмгөөллийн хэлсийг багасгахыг гишүүд шийдвэрлэхээс бусад тохиолдолд хүлээн зөвшөөрөхгүй.

⁹ Мөн тэнд. р 14

¹⁰ Elspeth Berry, Partnership and LLP law. 2010., p.6.

баримт бичгүүдийн жагсаалт нь компани уүсгэн байгуулахад бүрдүүлдэг баримт бичгүүдээс хялбар бөгөөд цөөн байдаг байна.

Тусгай хуулийн этгээд. Ерөнхий болон хязгаарлагдмал нөхөрлөл (Шотландын нөхөрлөөс бусад) нь тусгай хуулийн этгээдийн шинжгүй байдаг харин ХХН нь компанийт адил хуулийн этгээд байдаг бөгөөд хуулийн дагуу өөрийн гишүүдийн өмнө тусгай хуулийн этгээдийн шинжкүй агуулдаг. Өмч. Ерөнхий болон хязгаарлагдмал нөхөрлөл нь өмч хөрөнгө шуд өмчилдэггүй. Үүнтэй холбоотойгоор өмчлөлийг бий болгох болон мөн чанарыг тогтоохтой холбогдуулан хүндэрэл учирдаг, тэгвэл ХХН нь аливаа хөрөнгийг шууд өмчлөх эрхтэй байна. **Татвар.** Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл нь аж ахуйн нэгжийн хувьд орлогын албан татвар төлдөггүй (татвараас чөлөөлгддэг), харин нөхөрлөлийн гишүүд нь орлогын албан татвар төлдөг байна¹¹. Харин компани яж ахуйн нэгжийн орлогын албан татвар, мөн түүний хувьцаа эзэмшигч болон захиран нь цалин хөлс болон ногдол ашгаасаа татвар төлдөг.

АНУ-ын хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл нь дараах онцлог шинжтэй. Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн оноосон нарийн ард «LLP» гэсэн ялгах тэмдэг заавал хэрэглэнэ. Энэ нь (Limited liability partnership) буюу хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл гэсэн бизнес эрхлэх хэлбэр юм. АНУ-д ХХН-ийг уүсгэн байгуулахын тулд Мужийн нарийн бичгийн даргад өргөдөл гаргах журамтай байдаг. Хуулийн этгээдийн эрхгүй. ХХН нь хуулийн этгээдийн эрхгүй, энэ утгаараа гишүүд (partner)-ийн цоморлог гэж үздэг. Гэхдээ Шүүх, Арбитрт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцох, бусдын өмнө хүлээсэн зд хөрөнгийн үүргээ билэвүүлэх, өмч, хөрөнгийг эзэмшиж, ашиглах, захиран зарцуулахад здэлдэг

эрхээрээ хуулийн этгээдтэй адил байдаг. **Татвар.** ХХН нь хуулийн этгээдийн эрхгүй байдаг тул гишүүд тус бүр өөрт ногдох татвараас тодорхойлж төлдөг, гишүүн бүр нөхөрлөлийг төлөөлж эрхтэй байдаг бөгөөд хоорондын харилцаа итгэлцэл сууринсан байна.

Мэргэжлийн корпорац. Олон хууль зүйн фирмийн хүсэл, эрмэлзэл нь мэргэжлийн корпорацийн хэлбэрт нэгдэх байдаг. Мэргэжлийн корпорац нь үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны үйл ажиллагаа явуулдаг бусад корпорацаас гол ялгагдах шинж нь бүх хувьцаа эзэмшигчид нь тухайн салбарын мэргэжилтнүүд байдагт оршино. Өөрөөр хэлбэл, хууль зүйн мэргэжлийн корпорацийн өмчлөгчид нь хуулынчид байна. Өмгөөлөгчийн эзэмшиж байгаа хувьцааны тоо нь тухайн өмгөөлөгчийн корпорацаас эзэмшиж ногдол хувийг тодорхойлно. АНУ-ын хувьд “ихэнх муж улсуудад зөвхөн өмгөөлөгчид хууль зүйн мэргэжлийн корпорацийн өмчлөгч, хувь эзэмшигчид байдаг”¹²⁵ байна. Мэргэжлийн корпорац нь хувьцаа эзэмшигчдийг оруулаад олон тооны өмгөөлөгчдөд ажил олгодог. Хэрэвээ мэргэжлийн корпорац нь ашигтай ажилласан бол хувьцаа эзэмшигчдийн хувьцааны тоонд ногдох ногдол ашгийг хуваарилна.

Мэргэжлийн корпорац нь нэг болон нэлзэд олон тооны хувьцаа эзэмшигчтэй байж болох ба зохион байгуулалт нь бусад корпорацийн (үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний гэх зэрэг) зохион байгуулалтаас ялгарах зүйл байхгүй юм.

Мэргэжлийн корпорац нь тусдаа, бие даасан байдалтай орших нэгжүүдийг өөртөө хамааруулсан байдаг тул корпорацийн өр зээл, нөхөн төлбөрийн асуудлаар хувьцаа эзэмшигчид хувийнхаа хөрөнгөөр хариуцлага хүлээхгүй.

¹¹ Elspeth Berry. Partnership and LLP law. Wildy, Simmonds and Hill Publishing. 2010., p.6.

¹² Pamela I. Everett. Fundamentals of Law Office Management Systems, Procedures and Ethics 1994., p.17

Мэргэжлийн корпорацийн давуу
ба сүл талууд

хувийг нь барагдуулсан бөгөөд үлдсэн
хэсгийг 109 партнер гишүүн нь хувааж

Давуу тал	Сүл тал
<ul style="list-style-type: none"> Зарим нэг татварын ашигтай; Уян хатан чанартай; Ажилтнуудад илүү ашигтай. Фирм дотооддоо хязгаарлагдмал хариуцлагатай. Нэг ёмгөөлгчийн учруулсан гэм хорыг өөр бусад ёмгөөлгчид хариуцахгүй. 	<ul style="list-style-type: none"> Ажиллагсдын өсслт нь татвар болон нийгмийн даатгалын зардлыг нэмэгдүүлдэг; Гол шийдвэрүүдийг захицуулдын дийлэнх олонхын санаалаар гаргадаг; Тэмдэглэл хөтөлсөн баримт бичгүүдийн хадгалалт өсөн нэмэгдсээр байдаг; Мэргэжлийн корпорацийн бүрэлдэхүүнд орж байгаа фирмүүд нь өөр улс, муухадад байх тохиолдолд нэгдлийн эрх зүйн байдалдасудал гаргах боломжтой.

Хязгаарлагдмал хариуцлагатай компани (limited liability company). АНУ-д 1990-ээд оны эхээс дунд үе хүртэл хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК)-ийн хэлбэрээр хууль зүйн фирмийг байгуулих эхэлсэн, Муж улс бүр хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрт тавьдаг өврийн гэсэн хууль зүйн шаардлагуудтай байдал. АНУ-ын зарим нэгэн муж улсад хууль зүйн фирмийг ХХК-ийн хэлбэрээр байгуулахыг зөвшөөрдөггүй. ХХК-ийн хэлбэртэй хууль зүйн фирмийг түүний хувьцаа эзэмшигчид өмчилдөг. Түүнийг хувьцаа эзэмшигч-өмчилгээ өөрөө эсхүл сонгон авсан менежерүүд удирдан зохион байгуудаг. Хууль зүйн фирмийн хязгаарлагдмал хариуцлагатай компани болон нөхөрлөл гэсэн хоёр хэлбэрийн хооронд хариуцлагын, үүсгэн байгуулах баримт бичгийг эрх бүхий байгууллагаас тогтоосон журмын, татварын төрөл түүнийг төлөх журмын хувьд ялгаатай тал байдаг.

ХХК-ийн хэлбэр нь хэд хэдэн давуу талтай. Үүнд: татварын хувь хэмжээгээ тодорхойлж шууд төлдөг, хязгаарлагдмал хариуцлага, уян хатан менежмент, өмчилэлийн бүтэц орно. Хамгийн сайн давуу тал нь бусад гишүүдийн ёмнөөс өөр гишүүн хариуцлага хүлэздэгтүй явдал юм. 1980-аад оны үед Кэе Шкулерийн нөхөрлөлийн хэлбэртэй хууль зүйн фирм нь Линкольнийн хадгаламжийн маргаанд оролцсонтой холбогдуулан Засгийн газраас нэхэмжилсэн 41 сая амдолларыг хариуцахаар болсон. Тус хууль зүйн фирмийн мэргэжлийн хариуцлагын даатгал нь дэнгэж тал

төлөх болсон байна. Ихэнх хууль зүйн фирмүүд нь энэхүү хэлбэрийн давуу талыг ашиглахаар байгуулагддаг. Гэвч зарим нь ХХК-ийн хэлбэрт шилжих сонирхолтгай байдал. Тэд үүнийгээ ХХК-ийн хэлбэрт шилжсанээр үйлчлүүлэгч нарт өөрдийнх нь эрх, хууль ёсны төлөө эцсийг нь хүртэл ажиллахгүй юм ши эсхүл зарим нэгэн гишүүн нь өөр бусад этгээдийн ажилд саад учруулах юм шиг сэтгэдэл төрүүлдэг тул ХХК-ийн хэлбэрт шилжих хэрэгтүй гэж үздэг.

Дөрөв. Хууль зүйн фирмийн төрөл

Хууль зүйн фирмийг үйл ажиллагааны чиглэл, цар хүрээнээс шалтгаалан дараах төрөлд ангилж болно.

Дагнасан (Boutique) хууль зүйн фирм. Дагнасан хууль зүйн фирм нь зөвхөн хууль зүйн нэг салбарт үйлчилгээ үзүүлэхээр зохион байгуулгасан байдал. "Дагнасан хууль зүйн фирм нь хууль зүйн практикийн нэг чиглэлээр мэргэшсэн жижиг хууль зүйн фирм юм"¹³. Дагнасан фирм нь ёмне дурдсанчлан жижиг фирм бөгөөд ёмгөөлгчид нь эрх зүйн зөвхөн нэг салбараар тусгайлан мэргэшсэн байдал. Дагнасан фирм нь магадгүй нэг хүний эзэмшлийн, нөхөрлөлийн эсвэл мэргэжлийн корпорацийн хэлбэрээр зохион байгуулгасан байж болох бөгөөд мэргэшлийн чиглэл нь татварын эрх зүйн, иоуны өмчийн эрх зүйн, гэрээний, хөдөлмөрийн маргааны,

¹³ Bryan A.Garner (editor in chief). Black's law dictionary. Eighth edition. 2004., p.223.

гэм хор учруулснаас үүсэх үүргийн, эрүүгийн эрх зүйн гэх мэт олон төрлийн аль нь ч байж болно. Дагнасан хууль зүйн фирмийн давуу тал нь хууль зүйн нэг салбаргаар дагнан ажиллах нь мэдлэг чадвар, туршлагатай болгох ба тухайн салбарын мэргэжилтнүүд болон, бусад өмгөөлгэгчидтэй ажил хэргийн нягт холбоотой байдаг, мэргэшилтэйгээ холбоотойгоор тусгай хүрээнд, нэг бүлгийн гэх зэрэг үйлчлүүлэгчидтэй ажиллах боломжтой байдаг бол сул тал нь тодорхой хүрээнд үйлчлүүлэгч нартай ажиллах шаардлагатай болдоос гадна, хууль зүйн бусад салбарт хүрч ажиллаж чадахгүй байх хандлагатай зэрэг болно.

Хууль зүйн клиник. Хууль зүйн клиник (legal clinic) нь зах зээлийн үнэ ханшинаас доогуур хөлслээр хууль зүйн мэргэжлийн ердийн үйлчилгээг бизнесийн харилцажаас илүүтэйгээр хувь хүмүүст үзүүлдэг. Зар сурталчилгааг ашигладаг, төлбөрийн тогтсон тарифтай, зардлыг багасгах үйлчилгээний хүрээ багтаамжийг ихэсгэх чиглэлээр үйл ажиллагаагаа журамласан фирм юм. Хууль зүйн клиник нь дундаж орлоготой хүмүүсийн хууль зүйн туслапцаа авах хэргээнд үндэслэн бий болсон боловч “клиник” гэдэг нэр нь “төлбөрийн чадваргүй нийгмийн эмзэг бүлгийнхэн, мөн ядуу хүмүүст хандсан үйлчилгээ” гэсэн нэмэгдлэл утгаар хүмүүст ойлгогдох болсон байна. Хууль зүйн клиникийн үйлчилгээ нь ертгийг багасгасан байдаг учраас үнэтэй оффист мөнгө зарцуулдаггүй, ихэвчлэн худалдааны төв дотор, томоохон дэлгүүрүүдийн өөдөөс харсан, мөн хөл хөдлөгөөн ихтэй гудамжинд байрлаж үйлчлүүлэгчийнхээ цаг завыг харгалzan амралтын өдрөөр, оройн цагаар ч цаг гарган уулздаг, ажилтнуудаа харьцангуй бага цалин олгодог ажээ. Хууль зүйн клиник нь гол төлөв шүүхээр шийдвэрлүүлэх хэрэг, маргааныг хүлээн авдаггүй, авах неөц, цагийн боломж хомс байдаг боловч ийм төрлийн хэрэг, маргааныг зөвшөөрч өмгөөлөх хүрээ заагийг гаргасан байдал.

Хууль зүйн клиникийн мөн чанарт дүн шинжилгээ хийж үзвэл зах зээлийн

үнэ ханшинаас доогуур хөлслэй; хууль зүйн харьцангуй ердийн үйлчилгээ үзүүлдэг; гол төлөв хувь хүмүүст үйлчилдэг; зарсурталчилгаагашигладаг; төлбөрийн тогтсон жишиг үзүүлгээдээ; зардлыг багасгах үйлчилгээний хүрээ багтаамжийг ихэсгэх чиглэлээр үйл ажиллагаагаа зохион байгуулсан байдаг шинжүүд ажилгагджад байна. Хууль зүйн клиникийн нэг хүний эзэмшилийн, нөхөрлөлийн, мэргэжлийнorporацийн, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үссэн байгуулж байна.

Виртуаль хууль зүйн фирм.

ХХI зуундаа хөгжил дэвшил “виртуаль” хууль зүйн фирмүүд үүсч хөгжлийн үндэс суурийг тавьж өгсөн. Энэ төрлийн фирмүүд нь тодорхой бизнес хаягтай боловч тухайсан оффис байхгүй, орчин үеийн харилцаа холбооны технологийн дэвшилэгийг ашиглан зайнлас үйлчилгээгээ үзүүлдэг, олон улсын үйлчлүүлэгчдэд ч зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх боломжийг бурдүүлдэг, ингэснээрээ биет өмч хөрөнгөтэй холбоотой зардлыг хэмнэдэг. Ингэж зардлыг хэмнэж чадсанаар үйлчлүүлэгчийн зөвлөгөө үйлчилгээ авах цагийг тооцон төлдөг үрдүүлгээг хөслийг зөвхөн өмгөөлөл, хууль зүйн зөвлөгөөнд суурилан үйлчилгээ үзүүлсний дараа тооцох боломжийг олгодог юм.

Иж бүрэн үйлчилгээ үзүүлдэг фирм. Энэхүү фирмүүд нь хууль зүйн мэргэжлийн туслалцааны бүх чиглэлээр үйл ажиллагааг явуулдаг. АНУ-д энэхүү бүх чиглэл гэдэгт аж ахуйн нэгжүүд нэгдэх, нэг аж ахуйн нэгж негээ аж ахуйн нэгжээ худалдан авах зэрэгтэй холбоотой эрх зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх, банк, том корпорациудын шүүхэд үсгэдэг тодорхой төрлийн маргаанд хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх зэргийг багтаан ойлгодог. Тиймээс эдгээр фирмүүд хувь хүний нэхэмжлэл, гомдоороо үссэн хэрэг, маргаан дээр ажилладагтуй байна.

Тав. Дүгнэлт

Бид хүний эрх, эрх чөлөөг илүү үр дүнтэй хамгаалахын тулд хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх байгууллага болох хууль зүйн фирмийн төрөл, хэлбэрийг судалж, давуу болон сул талын нь тооцох шаардлага тулгарсаар байна.

Өмгөөллийн хууль тогтоомжийг шинэтгэх бүрт энэ шаардлага тухай бүр тулгарч байсан болох нь тодорхой байдал. Тухайлбал: Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх байгууллагыг 1994 оны өмгөөллийн тухай хуулиар "хууль зүйн товчоо", 2002 оны өмгөөллийн тухай хуулиар "өмгөөллийн ўйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд (нөхөрлөл, компани)", 2012 оны хуульчийн эрх зүйн байдлын

тухай хуулиар "өмгөөллийн хуулийн этгээд (хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл)" байхаар хуульчилсан байдал.

Монголд хууль зүйн фирм хөгжжиг байсан баялаг уламжлалгүй. Тийм болохоор бусдаас сурх, судалж танин мэдэхээс өөр аргагүй. Цаашид хууль зүйн фирмийг амьд организм, мэргэжлийн байгууллага талаас нь авч үзэх шаардлага бий.

Мен хууль зүйн фирмийн төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, хүрээ, зохион байгуулалт, удирдлага зэрэг өөр хороондоо хариццан хамааралтай асуудлуудыг судалж өөрсдийн онцлогт нийцүүлэн нутагшуулах шаардлага үүсэн бий болсон болохыг онцлон тэмдэглэж байна.

--о0о--

"Хууль дээдлэх ёс" сэтгүүлийн захиалга

Та хууль дээдлэх болон шударга ёсыг нийгэмд төлөвшүүлэхэд онол, практикийн чухал ач холбогдол бүхий уг сэтгүүлийг худалдаж авах болон тогтмол захиалж уншихыг хүсвэл Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн номын худалдаанаас авах эсхүл өөрт байрлах шуудангийн салбарын дамжуулан захиалах боломжтой.

Жич: Улирлын захиалгын үнэ: 5000 төгрөг

Захиалгын индекс:

- Монгол шуудан-200279 (Лавлах утас: 1800-1613)
- Улаанбаатар шуудан2001065 (Лавлах утас: 7012-7027)
- Түгээмэл шуурхай шуудан-250002 (Лавлах утас: 7011-5015)
- Скай Пост-200279 (Лавлах утас: 7012-1294)

"Хууль дээдлэх ёс" сэтгүүлийн редакц

Цахим хаяг: lawjournal@legalinstitute.mn

Утас: 11-315734

ХУУЛЬ БҮТЭЭХ АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ АСУУДАЛ



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
магистрант П.Сэлэнзэв

ТҮЛХҮҮР ҮГ:

Үндсэн хууль, хууль зүйн техник, парламент, хууль бүтээх ажиллагаа, хуулийн төсөл.

ТОВЧИЛОЛ:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай хууль 2016 оны 5 дугаар сарын 13-ны өдөр, Гэр булийн хучирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2016 оны 5 дугаар сарын 19-ний өдөр, Прокурорын байгууллагын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2016 оны 5 дугаар сарын 20-ны өдөр тус тус батлгадсан. Харин шинэ парламент үйл ажиллагаа явуулж эхэлсэн даруйдаа 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгджэх эхлэх байсан тус хуулиудыг буцаах тухай Улсын Их Хурлын 26 дугаар тогтоол баталсан билээ.

Энэхүү үйл явдал нь 1992 оноос хойш анх удаа тохиолдсон бөгөөд дурдсан хуулиуд чухам хуулийн төсөл үү, хууль үү, хүчинтэй ю, хүчин төгөлдөр бус үү? гэдэг дээр багагүй маргаан дагуулаад байгаа юм.

Иймээс энэхүү асуудлын хүрээнд хууль бүтээх үйл ажиллагааны ажиллагааны талаар судлахыг зориллоо.

УДИРТГАЛ

Төрийн эрх мэдлийг хуваарилах онюофор эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх хэмээн засгийн турван салаанд хуваадаг. Өнөөгийн улс орнуудын төрийн тогтолцооны нийтлэг чиг хандлага болох энэхүү үзэл санааг анх Францын сэтгэгч Барон де Монтескье "Хуулийн амин сүнс" гэсэн бүтээлдээ (1748) тодорхойлсон байdag¹. Манай улсын хувьд ч эрх мэдлийг ийнхүү хуваарилсан ба хууль тогтоох эрх мэдлийг Улсын Их Хурал хэрэгжүүлдэг билээ.

Улсын Их Хурал нь төрийн эрх барих дээд байгууллагын хувьд, мөн ард түмний төлеөллийн хувьд хууль тогтоох үйл ажиллагааг хууль дээдлэх зарчимд үндэслэн хэрэгжүүлэх онцгой бүрэн эрх бүхий засаглалын институци юм. Өөрөөр хэлбэл, аль ч сонгуулиар бүрдсэн Улсын Их Хурал хууль тогтоох эрх мэдлээс хэрэгжүүлэхдээ нам, үзэл суртын шалгуураар биш, харин төрийн бодлого тогтвортой байх, мөн Үндсэн хуульд заасан зарчмыг³-ийг баримтлах ёстой.

Улсын Их Хурал хууль бүтээхдээ нийгмийн хэрэгцээ, шаардлагад тулгуурлан, улс төр, эдийн засгийн ач холбогдлыг шалгур болгохын зэрэгцээ

¹"Baron de Montesquieu, Charles-Louis de Secondat (Stanford Encyclopedia of Philosophy)".

Plato.stanford.edu. Retrieved 2008-10-29.

² "lawiki.org law – Separation of Powers: the reality". lawiki.org. Retrieved 2010-09-16.

³ Монгол Улсын Үндсэн хууль 1992 он. Нээлдүүзэр зүйл. 2 дахь хэсэс. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тээгш байдал, үндэслэний зэ нэгдлийн хянага, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын ман.

хоорондоо нягт холбоотой, дэсдараатай ўе шатуудыг заавал дамжих ёстай болдог. Нөгөө талаар, "Хууль бүтээх ажиллагаа нь иргэн, хүн бүрийн ашиг сонирхлыг хөндөг, бүх хүмүүсийн зан үйл (субъектив эрх, хууль зүйн үүрэг)-ийн хэмжээг тодорхойлдог онцгой чухал ажиллагаа"⁴ учраас түүнийг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай юм.

Энэ утгаараа манай улс хууль бүтээх ажиллагааг боловсронгуй болгох оролдлогыг удаа дараа хийсний үр дүнд 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр "Хууль тогтоомжийн тухай" хуулийг баталж, 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдж эхэлсэн. Харин хууль тогтоо ажиллагааг Монгол Улсын Их Хурлын чуулганы хурапдааны дэгийн тухай хуулиар зохицуулж байгаа хэдий ч 2016 оны сонгуулийн өмнөх болон дараах парламентын хууль тогтоох үйл ажиллагаатай холбоотойгоор дээрх хуулийг боловсронгуй болгох шаардлагатай харуулж байна.

Тодруулж, 2012 оны сонгуулиар бүрдсэн парламент Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хууль санхупах ажиллагааны тухай, Прокурорын байгуулалтын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудыг баталсан боловч 2016 оны сонгуулиар бүрдсэн Улсын Их Хурал тэдгээр хуулийг 2016 оны 26 дугаар тогтоолоороо буцаасан. Энэ нь эрдэмтэн судлаач, хуульч, улс төрийн хүчин болон Улсын Их Хурлын гишүүдийн хооронд "маргаан" өрнүүлж, судлах хэрэгцээг бий болгох байна.

Тиймээс энэхүү асуудлыг судлаачийн хувьд онолын болон практикийн үүднээс судалж, дүгнэлт, санал өгөхийг зорьсон болно. Хууль бүтээх ажиллагаатай холбоотой асуудлыг судалж, бүтээл, өгүүлэл, нийтлэл хэвлүүлсэн манай улсын

эрдэмтэн судлаачдыг дурдвал Б.Чимид, О.Амархүү, Ч.Энхбаатар, С.Нарангэрэл, С.Төмөр, Д.Лундээжанцан, С.Өлзийсайхан гэх зэрэг цөөн тооны судлаач хөндсөн байдаг.

ХУУЛЬ БҮТЭЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хууль бүтээх, тогтоох ажиллагааг эрдэмтэн судлаач нар олон янзаар тайлбарладаг бөгөөд нээдсэн ойлголтой болоогүй байна. Тухайлбал, Ч.Энхбаатар "Үндсэн хуулийн мэдлэг" бүтээлдээ⁵ "Хууль тогтоох процесс нь хууль бүтээх ажиллагаанаас явцуу хүрээтэй. Учир нь хэрэв хууль тогтоох процесс нь нэгэнт боловсруулагдан төслийг хууль санаачлах эрхийн дагуу Улсын Их Хуралд албан ёсоор өргөн мэдүүлэхээс эхэлдэг бол хууль бүтээх ажиллагаа нь хуулийн хэрэгцээг тодорхойлох, төсөл боловсруулах, төслийг хэлэлцэх төслийг батлах, ёсчлох, Ерөнхийлөгчийн хориг тавих бүрэн эрхийг хэрэгжүүлэх, хуулийг хэвлэн нийтлэх, системчлэх гэсэн үе шатуудыг дамжин явагддаг" гэжээ.

Оросын эрдэмтэн Т.В.Кашанина "хууль тогтоох үе шат нь хуулийн төсөл бэлтгэх, хэлэлцэх, батлах, хэвлэн нийтлэх, дагаж мөрдж эхлэхээс гадна хуулийн төсөл үрьдчилан боловсруулах бүхий л ажиллагааг хамаарна" гэж үзсэн байна.

Харин эрдэмтэн Б.Чимидийн 2008 онд хэвлүүлсэн "Үндсэн хуулийн мэдлэг" бүтээлд "хууль тогтоох эрх мэдэл" нь өргөн хүрээтэй агуулга талыг нь, харин "хууль тогтоох үйл ажиллагаа" нь тэр эрх мэдлийг хэрэгжүүлэх үйлдэл, үйл явцыг илэрхийлдэг гэж тодорхойлжээ.

Дээрхээс гадна хууль гаргах үйл ажиллагааг хууль тогтоох үйл явц /процесс/ гэж тайлбарлан, энэ үйл явц дараах үе шатнаас бүрддэгийг дурдсан байдаг.

• Хууль санаачлах;

⁴ Д.Лундээжанцан Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник.УБ , 2016 он, 15 дахь тал.

⁵ Ч.Энхбаатар. Үндсэн хуулийн мэдлэг. УБ , 2007 он.

- Хуулийн төсөл хэлэлцэх;
- Хууль батлах;
- Хууль нийтлэх /ард, түмэнд сонордуулах/ гэсэн дарааллаар дэглэсэн байдаг. Энэ бол Их хурлын "тогоон дотор" болдог үйл явц бөгөөд аль нэгэн хууль гаргах ажлын дараалал юм⁶.

Дэлхийн улс орнуудын хувьд парламентын хуралдааны дэгийг Үндсэн хууль, эсхүл парламентаас баталсан бусад хуулиар, мөн түүнчлэн парламентийн дотоод журмаар зохицуулсан байдаг.

Монгол Улсын хувьд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг 1992, 1997 онуудад хуулиар батлан мөрдөж байгаад 2001 оноос Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг нь чуулганы хуралдааны бэлтгэл ажил явуулах, хуралдаанд аливаа асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх үйл явцыг тоогосонжурамж үндэслэлээр заавал хуулиар зохицуулах шаардлагагүй гэж үзэн Улсын Их Хурлын тогтоол батлан зохицуулжээ.

Харин 2006 онд Улсын Их Хурлын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловронгуй болгох ажлын хүрээнд холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн баталсан бөгөөд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг 2001 оны жишигээр Улсын Их Хурлын тогтооолоор зохицуулсан. Өдгөө 2007 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг дагаж мөрдөж байгаа юм.

Хуулийн төсөл хууль болтлоо батлагдах хүртэл хуулиар зохицуулсан үе шатуудыг дамжин хуулийн төсливэс хууль болдог⁷. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар хууль тогтоох үйл явцыг хоёр хэсэгт хувааж үзэхээр байна.

⁶ Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008 он 186 дахь тал.

⁷ Лундзээнжанцан.Д., Өлзийсайхан.Л. Парламент 8с.УБ., 2005 он.


ХУУЛЬ БАТЛАХ

- Бийгүйн хорохиы туралдааныг ор тасалын улаан барилгааныг хийнээс;
- Нийгэмийн туралдааныг тасалын улаан барилгааныг хийнээс;
- Бийгүйн хорохиы туралдааныг ор тасалын ижил хамгаалалтуудыг тарласаа;
- Нийгэмийн туралдааныг тасалын ижил хамгаалалтуудыг тарласаа;

ХУУЛЬ БИЙГҮЙН ХУРЛАДААНЫ

- Засгийн шүүрхэгээ Улсын Их Хурлын тогтооолыг,
- Бийгүйн:
- Хамгаалалтуудыг, ижил хамгаалалтуудыг,

Дээрхээс хараад эхний хэсэгт хуулийн төсөл хэлэлцэхээс эхлээд хууль батлах хүртэл үргэлжлилж байгаа бол хоёр дахь хэсэгт хууль баталсаны дараах буюу Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 53 дугаар зүйлд заагтанчлан баталсан хуулийг биежүүлэх, хэлбэржүүлэх ажиллагаа хамгааграхаар байна. Ийнхүү үйл явцыг? үе ішт болгон хуваан, зааглах байгээ чь онолын болоод практик ач холбогдолтой.



Онолын хувьд эрх зүйн хэм хэмжээ нь баталснаар хүчинтэй болдог бол тодорхой нөхцөлийг хангаж байж хүчин төгөлдөр(бүрэн хүчинтэй) болдог.

Эхний үйлдэл нь тухайн хэм хэмжээний эх бичвэрийг хөдөлгүүгийг болгодог. Дахин өөрчлөх, гар хүрэхгүйгээр хууль тогтоогч буцалгүй хүлээн зөвшөөрч байна гэж үзн. Хэрэв энэ шатанд гар хүрэх бол хууль тогтоох ерөнхий журмаараа л хүрэх, засах боломжтой болно. Өөрөөр хэлбэл нэгэнт баталсан бол хууль тогтооход анхнаас нь барьдаг журам, зорчим мөн үйлчлэх ёстой Харин түүнийг хэлбэржүүлэх, нийтийн түрээл болгох, хугацаат нөхцөл зэрэг нь хүчин тэгүүдийр мөрдлөг болгох ач холбогдолтой.

ХУУЛЬ БҮТЭЭХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТЭД ҮССЧ БҮЙ АСУУДАЛ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай хууль 2016 оны 5 дугаар сарын 13-ны өдөр, Гэр бүлийн хучирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2016 оны 5 дугаар сарын 19-ны өдөр, Прокурорын байгууллагын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2016 оны 5 дугаар сарын 20-ны өдөр тус тус батлагдсан ба хүчин төгөлдөр болох хугацааг уг хуулиудаар 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр гэж заажээ.

Харин 2016 оны сонгуулиар бүрдсэн парламент "...тус хуулиудыг баталсан боловч Монгол Улсын Их Хурал тухайн хуулиудын эцсийн нийруулгатай танилцах, хуулиудыг ёсчлох, Ерөнхийлөгчид илгээх, албан ёсоор нийтлэх зэрэг хуулиар заавал хийгдэх ёстай ажиллагааг хийж дуусгалгүй бүрэн эрхийн хугацаа дууссан. Хууль эрх зүйн акт болохын хувьд эрх зүйн актыг батлах эрх бүхий субъект баталж, ёсчилж, хүчин төгөлдөр болсноор хэмжээ болж хэрэгжих ёстой. Энэ утгаараа дээрх хуулиудыг хүчинтэй хууль гэж үзэх хууль зүйн үндэслэл байхгүй байна⁸ гэх үндэслэлээр 2016 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 26 дугаар тогтоолыг баталж дээр дурдсан хуулиудыг хууль санаачлагчид нь буцааснаар хууль бүтээх буюу хууль тогтоох ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалттай холбоотой маргаан нийэмд өрнөсэн. Өөрөөр хэлбэл, тухайн асуудал нь Улсын Их Хурлын хууль тогтоох ажиллагаатай холбоотой юу, эсхүл түүний эрх зүйн зохицуулалттай нь холбоотой юу, хүчинтэй буюу батлагдсан хуулийг "буцаах" нь арга зүйн хувьд зөв үү, эсхүл батлагдсан хуулийг хүчин

төгөлдөр болгох ажилбар /ёсчлох, хэвлэн нийтлүүлэх гэх мэт/-ыг хийх нь Улсын Их Хурлын үүрэг байсан уу гэх мэт тодорхой болго шаардлагатай асуудлууд нээлттэй үлдсэн.

Харин судлаачийн хувьд нэгэнт теслийн эцсийн хэлэлцүүлгээр Улсын Их Хурлын гишүүдийн олонх дэмжиж баталсан хуулийг ёсчлох⁹, хэвлэн нийтлэх нь зайлшгүй хийх ажиллагаа гэж үзэж байна. Учир нь Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Улсын Их Хурал нь онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд хууль баталдаг бөгөөд харин хуулийг ёсчлох ажиллагааг Улсын Их Хурлын дарга, харин Улсын Их Хурлын Тамгын газар хууль тогтоомжийг хэвлэн нийтлэх¹⁰ -ийг хуулиар үүрэг болгон зохицуулсан.

Нэгөө талаар батлагдсан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, түүнийг хүчингүй болгох тохиолдолд хууль хүчингүй болсонд тооцох тухай, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлах замаар хуульд гар хүрдэг. Учир нь хууль бол хууль тогтоогчийн баталсан нийтээр дагаж биелүүлэх дээд хүчин чадалтай эрх зүйн хэмжээ¹¹ тул түүний адил хүчин чадал бүхий хэмжээний актаар л хүчингүй болж буй хэрэг юм.

Хууль тогтоох онцгой эрх бүхий субъектийн хувьд Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийг дурдахгүйгээр өнгөрч болохгүй. Засаг төрийн байгууллагаас чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд хийх ажил, эдлэх хууль зүйн боломжийг буюу үүргэг, эрх хөөрүүг нийлүүлээд бүрэн эрх гэж бөөндуулдэг. Үндсэн хуульд заасан УИХ-ын онцгой бүрэн эрхийн дотор хууль батлах гэж бий. Түүний гагцхуу эрх гэж ойлговоос тулгамдсан асуудлыг шийдвэрлэхгүй /хууль гаргахгүй/, эрх

⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай, Прокурорын байгууллагын тухай, Шүүхийн шинэцэр гүйцэтгэх тухай, Гэр бүлийн хучирхийлэхтэй тэмцэх тухай хуулиудыг буцаах тухай Улсын Их Хурлын тогтоогчын теслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт.

⁹ Монгол Улсын Их Хурлын Чуулганы хуралданын дэгийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.4 дахь хэсэг.

¹⁰ Хууль тогтоомжийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дахь хэсэг.

¹¹ Б. Чимид. Үндсэн хуулийн мэдлэг УБ., 2008 он. 184 дэх тап

юм чинь здэлсэн ч, байсан ч дур гээд тэр, түмний амьдралыг чедэрлеөд суучаж болох уу¹². Хуучин парламент хуульд заасан ажиллагааг дутуухийж, шинэ парламент нь алх цохижен баталсан хуулийг хууль ёсны дагуулж хэлбэржүүлээгүй нь Б.Чимид гуйншиг хэлж байсан шиг Улысын Их Хуралдааныг бүрэн эрхээ эрх дарх мэт ойлгож хуулиас дээзгүүр тогтоол баталж, Үндсэн хуулиа зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтала" хэмээн заасан. Харин Улсын Их Хурал 26 дугаар тогтолц гаргасан нь нэг талаараа сонгуулийн үр дунгэрэг байгуулагдсан засаг төрийн улс төржсөн үйл ажиллагааг, негеэс талаараа ард иргэдийн ашиг сонирхлыг ул хүндэтгэсэн үйлдэл болсон юм.

Түүнчлэн Улсын Их Хурал нь тогтоолоо хуулиас дээгүүрт тавьсан уйл явдал болсон төдийгүй төрийн үндсэн зарчим болох хууль дээдэлэх зарчмыг зөрчсөн гэж үзэж байна. Үндсэн хуулийн эхийг баригч эрдэмтэн Б.Чимид “Хууль батална” гэдэг нь нэг намын дохиогоор гар өргөхийн нэр биш. Долоо хэмжиж нэг оттол гэдэг. Олон хувилбар өрсөлдүүлэн хэлэлцээд жама ёсны бөгөөд түүхэн нөхцөлд аль илүү нийцсэнийг нь олонхи, эсвэл дийлэнх олонхын санаалаар баталдаг” хэмээн¹³ дурдсан байна.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Улсын Их Хурал нь бүрэн эрхээ чулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлэх бөгөөд парламентын шийдвэр гаргах үндсэн зарчмын нь олонхын буюу мажоритари ёс байдаг. Улсын Их Хурлын чуулганд гишүүдийн олонх нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэх, хураалдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг

шийдвэрлэдэг. Төреер хэлбэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай, Прокурорын байгууллагын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Гэр булийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийд нь Улсын Их Хурлын гишүүдийн олонхиын санаалаар батлагдсан хүчинтэй хуулиуд юм.

Хууль бүтээх ажиллагааны
шинжлэх ухааны үндэслэлийг
дээшлүүлэх чиглэлээр хийсэн
оролдлогууд бий. Харамсалтай нь
сонгуулжин үр дүнгээр байгуулагдсан
засаг төр энэ асуудлыг улс төрийн
өнцгөөс илүү авч үзээд байсан
учраас Монгол Улсын хууль тогтоомж
тогтвортгуйтэх нөхцөлийг бүрдүүлж
байна¹⁴.

Монгол Улсын Их хурлын 2016 оны үзэвжлэл бус чухалын Хууль түүнч байнгын хорооны 8 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийн:

Өмнөх парламент Хууль сахиулах үйл ажиллагааны тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай зэрэг процессын хуулиудын эсийн найрууллыг хэлэлцэж, албан ёсоор ёсчлоогүй, "Төрийн мэдээллийн эмхэтгэл" сэтгүүлд нийтлээгүй тул эдгэр хуулийг хүчин төгөлдөр гэж үзэх боломжгүй юм¹⁵ гэсэн нь үндэслэлтэй хэдий ч хүчинтэй хууль гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстай. Аливаа эрх зүйн акт баталснаар хүчинтэй болж нийтэд хүртээмжтэй болж байж хүчин төгөлдөр болдог, энэ тухай Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд тодорхой заасан байдаг билээ¹⁶.

¹² Мөн тэнд, 200 дахь тал.

¹³Мөн тэнд, 191 дэх тал.

¹⁴ Д.Лүндээжанцан. Хууль бутээх ажиллагаа ба хууль зүйн техник. УБ., 2016 он. 6 дахь тал.

¹⁵ <http://www.supremecourt.mn/news/228>

¹⁶ Монгол Улсын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дахь хэсэг.

Харин Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 3-т "Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрээ хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нийтлэснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно" гэх заалт нь хууль хэрэгжик эхлэх заалттай холбож тайлбарласан нь хуулийн зохицуулалт ойлгомжгүй байгаагийн илрэл юм. Дээрхээс харахад хууль тогтоох үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтад хийдэл буйг харуулж байна.

ДҮГНЭЛТ

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд гишүүдийн олонхын санаалаар батлагдсан хуулийн эцсийн найруулгыг хийх, түүнийг хянах, ёсчлох ажиллагааг процедурын хувьд нарийвчлан тогтоосон боловч тэдгээр ажиллагааны үйл явцын цаг хугацааг тодорхой заагаагүй. Тодруулбал:

- ✓ Байнгын хороо, УИХ-ын Тамгын газэр хууль батлагданаас хойш түүний эцсийн найруулга хийнз;
- ✓ Тамгын газрын ерөнхий


нарийн бичгийн дарга эцсийн найруулгыг хянах, УИХ-ын даргад танилцуулна;

- ✓ Улсын Их Хурлын Дарга Улсын Их Хуралд хуулийн эцсийн найруулгыг танилцуулахыг зөвшөөрөх;
- ✓ Улсын Их Хурал эцсийн найруулгыг ёсчлохыг зөвшөөрөх.

Хуулийн эцсийн найруулгыг хянах ажиллагаа нь хариуцлагатай ажил тул түүнийг хуульд заасан тодорхой үе шатуудаар, тодорхой субъектүүд хянах нь зөв. Гэхдээ хууль батлагданаас хойш эцсийн найруултыг хянах ажиллагааны хугацааны дээд хязгаарыг хуулиар тодорхой болгох шаардлагатай юм.

Ийнхүү тодорхой хугацаа заагаагүйгээс хууль батлахаас ёсчлох хүртэл ямар ч хугацаа өнгөрөх боломжтой байх бөгөөд хуулиар тодорхой хугацаа тогтоосноор Улсын Их хурал хууль батлахаас эхлэн хууль нийтлэх хүртэлх ажиллагааг бүрэн гүйцэд хийж дуусгах, цаг алдахгүй байх зөрэг талтайн зарэгцээ хариуцлагатай болох нөхцөл боломж бурдэнэ гэж үзэж байна.

---оо---



Та бүхэн Хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэлийг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн номын сангаас үзэх, судлах боломжтой.

Түүнчлэн тус эмхэтгэлийг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 1 дүгээр давхарт байрлах номын худалдаанаас авах эсхүл 11-315789, 11-312686 дугаарын утсаар холбогдон захиалан авах боломжтой.

ГЭМТ ХЭРГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ДӨРВӨН ТАЛТ ЭЛЕМЕНТ БҮХИЙ ОНОЛЫГ ШҮҮМЖЛЭХ НЬ:



МУИС-ийн ХЗС-ийн Нийтийн эрх зүйн тэмнхийн эрхлэгч, хууль зүйн доктор Д.Баярсайхан

ТҮЛХҮҮР ҮГ:

Гэмт хэргийн бүрэлдэхүүний дөрвөн талт элемент, Гэмт хэргийн бүрэлдэхүүн, гэмт хэрэг, эрүүгийн эрх зүй, эрүүгийн эрх зүйн онол.

ТОВЧЛОЛ:

Энэхүү өгүүллээр Гэмт хэргийн дөрвөн талт бүхий онолыг орчин үеийн нөхцөлд шинээр авч үзэх ялангуяа Монгол Улсын хувьд энэ онолын зарим өрөөсгөл талыг шүүмжлэх хандлага бий болж байгаатай холбогдуулан Гэмт хэргийн дөрвөн элементийн онолын зарим хуучинсаг зарчим, хандлагад шүүмжлэлтэй хандаж, харьцуулсан зүйн үүднээс олон талаас авч үзэх болно.

Удиртгал

Аливаа онол нь шинжлэх ухааны суурь мэдлэгийн чиглүүлэгч систем болохын хувьд хүн, нийгмийн амьдрал практикаар шалгагдаж, түүхэн цаг хугацааны шалгуураар үнэлгэдэн шүүгдсээр иржээ. Орчин үед эрүүгийн эрх зүй нь хүний эрхийн үнэт зүйлсийг хамгаалах, төр, иргэн, нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх,

аюулгүй байдлын баталгааг хангахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх болсноор түүнийг тэргүүлэгч салбарын буюу суурь эрх зүйн түвшинд авч үзэх болсон билээ. ХХI зуун гарсаар дэлхий дахинэг хамарсан даяарчлах үйл явц, эрх зүйн тогтолцооны интеграцилал, шинэтгэлийн хувьсал өөрчлөлтийн агуулга, чиг хандлагыг харгалзан хууль зүйн шинжлэх ухааны онол, агаа зүй шинэчлэгдэн өөрчлөгдсөөр байна.

Хөгжжик байгаа төдийгүй хөгжлийн улс орнуудад ч эрүүгийн эрх зүйн реформ эрчимтэй явагдаж, түүний үр дүн, үр дававар нийгмийн амьдрал, харилцаанд зохих нөлөө үзүүлэсээр байгаа юм. Шинэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэргийг гүйцлэлэн ангилах хандлагыг шинэчлэн өөрчлөх, зэрэглэсэн буюу хэсэгчилсэн эрүүгийн хуулиудыг шинээр гаргах замаар эрүүгийн хууль тогтоомжийн хүрээг өргөжүүлэх, гэмт хэргийн бүрэлдэхүүний догматик онол, материалист үзэл хандлагас татгалзах, ялын бодлогод хүмүүнлэгийн хандлагыг тусгах зэрэг эрүүгийн эрх зүйд шинэтгэлийн үйл явы идэвхтэй өрнөх болсныг үгүйсгэх араггүй.

Үндсэн хэсэг

Гэмт хэргийн бүрэлдэхүүний дөрвөн талт элемент бүхий онолыг орчин үеийн нөхцөлд шинээр авч үзэх, ялангуяа Монгол Улсын хувьд энэ онолын зарим өрөөсгөл талыг шүүмжлэх хандлага бий болж байна. Эрүүгийн эрх зүй судлаач, докторант Б.Эрдэнэбат: "...Гэмт хэргийн бүрэлдэхүүний 4 элементийн онолыг одоо хэрэглэсээр байгаа нь харамсалтай...Субъект гэх ухагдахуун нь сонгодог үзэл баримтлаасаа нэлзээд гажуу ойлголт, энэ нь бүрэлдэхүүний шинж биш, зөвхөн эрүүгийн хариуцлага хүлээх этгээд гэсэн тусдаа авч үзэх ухагдахуун... Объект нь угаасаа хууль зүйн үр

дагавар илэрхийлэхгүй..." гэж бичсэний дээр гэм буруугийн шүуд бус санаа ба болгоомжгүйн ойлголтын хооронд зөрчилтэй, хоорондоо авцалдахгүй нөхцөлүүд байгааг олж харж, дурдсан байдал.¹

Судлаач, магистр Т.Золбоо: "...Гэмт хэргийн бурдлийн дөрвөн элементийн бүхий үзэл баримтлал саяхныг хүртэл бүрэн ноёлж байсан... Энэ онолын хэргийн гадар болон дотор тал, субъект үйлдэлдээ сэтгэхүйн хувьд хэрхэн хандсан зэргийг нэг системээр шалгадгаараа онцлогтой." гэж бичсэний дээр Германы эрүүгийн эрх зүйн онолын концепцид тулгуурлан "Гэмт хэргийн бүтээц" гэсэн шинэ ойлголтыг дэвшүүлж гэм буруугийн элементийн субъектив талын утгад шууд хамааруулажгүй үндэслэлээр тайлбарласан байдал.² Гэхдээ Германы эрүүгийн эрх зүй дэх гэмт хэргийн бүтээцийн түрүүн элементийн онолыг авч үзэхдээ Монголын эрүүгийн эрх зүйд хэлбэрэжих тогтсон гэмт хэргийн бүрэлдэхүүний дөрвөн элементийн материалист онолын арга зүйг хэрэглэж, тайлбарлах оролдлого хийсэн нь онолын логикийн хувьд зарим талаар эргэлзэх байдалд хүргэж байна.

Эрүүгийн эрх зүй судлаач, доктор /Ph.D./ Г.Гантэмэр 2011 онд хэвлүүлсэн "Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол" номондoo ...Хуучнаар Зөвлөлтийн эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн бүрэлдэхүүний онолыг Германыхаас илүү өндөр түвшинд гарган нарийвчлан судалж боловсруулсан... Хэдийгээр сүүлийн үед энэ онолд зарим нэг шүүмжлэлтэй хандах оролдлого гарч байгаа ч өөрийн байр суурийг баттай зээлсэн хэвээр байна...³" гэж бичжээ.

Өнөөдөр Монгол Улсад эрүүгийн эрх зүйн онолын уламжлалт чиг хандлагад шүүмжлэлтэй хандах оролдлого хийгдэж байгааг зүгээр л нэг үзэл бодлын илэрхийлэл төдийгөөр

¹ Б.Эрдэнэбат. Эрүүгийн эрх зүй дахь хууль ёсны зарчим - гэмт хэргийн бүрэлдэхүүний онол - хууль зүйн техник. Хууль дээдэлжигж ёс. 2014 №4 /54/, 33 – 36 дахь тал.

² Т.Золбоо, Гэмт хэргийн бүтээц УБ. 2016 он, 40, 107, 163 дахь тал

³ Г.Гантэмэр, Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. УБ. 2011 он, 10 дахь тал

анзаарахгүй ёнгөрч боломгүй юм. Энэ талаараа Монгол Улсын эрүүгийн эрх зүйн эрдэмтэд болон эрүүгийн эрх зүйгээр мэргэшсэн хуульчид байр сууриа илэрхийлэх цаг нэгэнт болжээ,

Гэмт хэргийн бүрэлдэхүүний онолын мен чанар, агуулыг шинжлэн авч үзэхийн өмнө уг онолын гносеологи талын үндэс нь хэдийд анх ямар шалтгаанаар тавигдсан болон түүний үүсч бүрэлдсэн хийгээд яаж хөхжиж ирсэн түүхийг тоймлон дурдах нь зүйтэй.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний онолын герменевникийн болон терминологийн үндэслэл Ромын эрх зүйн үеэс анхлан тавигдсан гэж үздэг.

"Corpus delicti" гэх нэр томьёо нь "Гэмт хэргийг таних шинжүүдийн бүрдэл хэсгүүд" гэсэн утгыг илэрхийлж, формаль ба материаллаг агуулыг тусгахын дээр гэмт үйлийн болон гэм буруугийн хамаарал, онцлогийг тусгах учиртайг илэрхийлсэн ойлголт ажээ.

Ромын хуульчид гэмт хэргийг бусад зөрчлөөс ялгахын тулд материаллаг шинж болох үр дагавар буюу хохирол, бодит үйлдлийн нөхцөлөөс гадна формаль шинж болон зөвхөн хууль зөрчсөн байх, хуулинд тодорхой үйлдлийн хэлбэрээр тусгагдсан байх ёстойг өгүүлсэн нь бий. Гэхдээ үйлдлийн гадаад тал, формаль шинжид илүү ач холбогдол өгч байсан ба гэм буруу гэдэгт зөвхөн санаатай үйлдсэн шүүд хамаарал бүхий хэрэг хариуцах нөхцөлт шинжийг багтаан ойлгож байжээ.⁴

XVII зууны дунд үед Италийн криминалист, шинжээч Л.Фаринациусын анхлан дэвшигүүлсэн "Хэргийг илрүүлэхэд нотолгооны бүрдэл хэсгүүдээс гадна бүтцийн шалгур элементуудийг заавал тооцож шалгах ёстой" гэсэн үндэслэгээнд тулгуурлан "Corpus delicti" гэсэн латин нэр томьёог сэргээн, шинжлэх ухааны хэрэглээнд нэвтрүүлсэн байдал.

⁴ Buckland A. Text of Roman law from Augustus to Justinian on Cambridge 1972. Schulz Classical Roman law, Oxford, 1951. Д.Баярсайхан. Ромын эрх зүй. УБ, 2000 он.

⁵ Гэмт явдалт тэмцэх асуудал" согтуул УБ: 2010 №3, 27-28 дахь тал.

XVIII – XIX зууны үеийн Германы хуулын эрдэмтэд /А.Штюбел, Е.Белинг, Р.Билдинг/ гэмт хэргийн тэрлүүд олширж ирснийг харгалзан адил төст наг хэргийг негөөгөөс ялгахын тулд формаль шалгур тогтоох ёстой⁶ гэсэн үндэслэлийг дэвшүүлж байв. Е.Белинг гэмт хэргийн бүрэлдэхүүн гэсэн ойлголтод: а) Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжкуудын бүрдэл, б) Хууль зөрчсөн гэмт зан үйлийн нөхцөл, в) Гэм буруу гэсэн турван элементийг багтаа ойлгох уг санааг анхлан дэвшүүлсэн.⁷ Энэ нь өнөөгийн Германы эрүүгийн эрх зүй дэх турван элемент бүхий гэмт хэргийн бүрдлийн онолын эх үндэс, уг сурвалж болж өгчээ.

Германы сонгодог онолын нэйт төлөөлөгч А. Фойребах эрүүгийн эрх зүйн сонгодог зарчмыудыг боловсруулахын зэрэгцээ гэмт хэргийн бүрэлдэхүүний хууль зүйн агуулга нь а) Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн формаль бүрдлийг хангасан байх, б) Гэм буруутай байх гэсэн хоёр үндсэн нөхцөлүүр тайлбарлах байв.⁸

XIX зууны сүүлч, XX зууны эхэн үеэс Орост гэмт хэргийг зүйлчлэх материалыст онолын сургаал анхлан бий болж, Баруун Европт өмнө нь үүссэн "Corpus delicti"-ийн ойлголтыг бүтцийн шалгуураар догматик загварчлалд оруулж, тайлбарлах замаар "Теория состава преступления" гэсэн онолыг анхлан боловсруулжээ.

/Н.Я.Ройницкий, Н.С.Таганцев/ Оросын эрдэмтэд эхэн уедээ гэмт хэргийн объектив ба субъектив шинжкуудийг гэмт хэргийн бүрэлдэхүүний шалгур элементүүд гэж үзэж байсныг дурдах хэрэгтэй. Н.С.Таганцев объект, субъект гэсэн шинш элементийг нэмж тусгах санааг дэвшүүлсэн бол Н.Я. Ройницкий, А.Ф. Кистяковский зэрэг эрдэмтэд объектив, субъектив гэсэн шинжкууд нь объект ба субъектээс тусдаа элемент болж,

хэрэглэгдэх ёстой гэж үзжээ.⁹

ХХ зууны 50-аад оны эхэн, дунд үеэс Гэмт хэргийн бүрэлдэхүүний дөрвөн элементийн онолыг ЗХУ-ын /хуучнаар/ /Е.Фролов, Б.Никифоров, А.Пионтковский, А.Н. Трайнин/ эрдэмтэд цогц байдлаар боловсруулсан юм. Ялангуяа энд А.Н. Трайниний Состав преступления в Советском уголовном праве М; 1951, А.А. Пионтковский "Учение о преступлении по советскому уголовному праву" М; 1957 зэрэг бүтээлүүд нь өнөөгийн Орос болон манайд идэвхтэй хэрэглэгдэж ирсэн гэмт хэргийн дөрвөн талт элемент бүхий онолын суурь үндэс, эх сурвалж нь болдог.

Монгол Улсын хувьд гэмт хэргийн бүрэлдэхүүний онолын үзэл баримтлал нь 1960-иад оны эхэн, дунд үеэс нэвтрэх хэрэглэгдэж иржээ. Монгол хэл дээрх анхны суурь бүтээлүүд гэвлээд Б.Содовсурэн "БНМАУ-ын Эрүүгийн эрх" УБ; 1969, Г.Совд "БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс" УБ; 1973 зэргийг төлөөлөн дурдаж болно.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний онолын дөрөн элемент гэдэг нь 1) Объект, 2) Объектив тал, 3) Субъект, 4) Субъектив тал гэсэн бүрдэл хэсгүүд бөгөөд санаатай ба болгоомжгүй бүх терлийн гэмт хэрэгт материалылаг хүчин зүйл бүхий бодит байдлын нөхцөлүүдийг илүү чухалчлан нэг тогтолцоо бүхий загварчлалд оруулж, шалган үнэлж аргачлал юм.

Гэмт хэргийн шинжийг эрүүгийн хуульд ерөнхий байдлаар тодорхой бус зүйлчлэн томьёолсон нөхцөлдүүчүүдийн гэмт хэрэг үйлдсэн болон ямар объектод халдсан гэдэгт объектив шалгуураар үзэлэлт өгч хийсвэрлэн зүйлчлэх замаар хэргийн бүрэлдэхүүнийг шалгадаг байна. Эрүүгийн эрх зүй дэх "Nullum crimen sine lege" зарчим нь аливаа үйлдэл гэмт хэрэг мөн эсэхийг шалгахын тулд юуны өмнө тухайн хэргийн үндсэн шинжийг тагцхүү хуулиар нарийвчлан тодорхой зааж

⁶ А.Жалинский. Рерихта. Введение в Немецкое право М; 2001, С.48.

⁷ Г.Гантэмэр. Дурдсан бүтээл. 8 дахь тал.

⁸ А.З. Жалинский. Современное Немецкое уголовное право М;2004, С.112.

⁹ Н.С.Таганцев Русское уголовное право. Т-1 М; 1994. с.366. А.Ф. Кистяковский, Элементарный учебник уголовного права М; 1875.

урьдчилсан нөхцөлөөр тодорхойлсон байх агуулгыг илрхийлдэг. Ялангуяа гэмт хэрэгт тооцох бүх шинжийг бүрэн агуулгаар нь хуульд заах шаардлага нь хууль ёсны зарчмын мен чанар нь юм. Энэ нь гэмт хэргийн формаль шинж зонхилоо шалгуур болдгийг харуулдаг. Өөрөөр хэлбэл гэмт хэрэгт тооцох шалгуур шинжийг шууд заагаагүй буюу эсхүл хэлбэр төдий хэт өрөнхий байдлаар хуульчлах нь хууль ёсны зарчимтай төдийтөн нийцэхгүй бөгөөд хуулиас гадуур хийсвэрлэн тайлбарлах нөхцелийг аяндаа бүрдүүлдэг байна.

Субъектийн тухай ойлголт нь эрүүгийн хариуцлагагүй этгээд гэсэн агуулгаар гэмт хэргийн бүрэлдэхүүнд хамааралгүй огт тусдаас ойлголт ажээ. Чухамдаа формаль шалгуур бүхий гэмт үйлдлийн шинж болох объектив тал төдийгүй гэж бууруугийн хүрээнд нэг нөхцөл нь болж хэрэглэгддэг ухадахаун гэж үзэх үндэслэл бий. Өнөөгийн эрүүгийн эрх зүйн хэрэглээнд субъект гаргийг тодорхой этгээд илүү ач холбогдол өгөх замаар тухайн гэмт үйлдлийн үнэлж байгаа нь уг үйлдлийг нь гэмт хэрэгт тооцох эсэхийг эхэлж шалгаад дараа нь түүний үр дагавар, хариуцлагыг хэн хулээх эсэхийг магадлан тогтооход чиглэгдсэн нийтлаг жишигийн шаардлага, зарчимтай зөрчилдэж байна.¹⁰

Объектын тухайд авч үзвэл гэмт хэргийн бүрэлдэхүүний формаль шинжийг илт үгүйгэсэн ойлголт бөгөөд чухамдаа ямар эрх ашигт, ямар харилцаанд халдаж байгаа нь хууль зүйн ач холбогдолгуй, гагчхүү тухайн объектод ямар аргаар, яаях халдсангаар, ямар үр дагаврыг бий болгосон, энэ нь эрүүгийн хуульд заасан үйлдлийн агуулгыг хэрхэн хангаж байгаа нь илүү хамааралтгүй гэж тайлбарладаг.¹¹ Угаасаа гэмт үйлдлийн хэлбэр, агуулгад халдлагын зүйл шууд хамааралттай ба одоогийн ойлголтоор бол объектив талд илүү хамарагдах элемент болно.¹²

Гэмт хэргийн бүрэлдэхүүний

¹⁰ Criminal law: Wayne R la Fave. West.2010. p 21-22.

¹¹ Norman M Garland, Criminal Law. M.G.H. 2013. p.83-84.

¹² Н.П. Малышко, Е.Г. Тарло. Уголовно-правовые системы Российской и зарубежных стран, М, 2003. С.91.

субъектив талын элемент нь орчин үеийн нөхцөлд эрх зүйн логик талаас нь авч үзвэл нэлээд зөрчилтэй, төвөгтэй байдлыг бий болгосныг харж болно. Ялангуяа "гэм буруу" гэсэн ойлголтыг субъектив талын элементтэй шууд адилтган үнэлж, түүнийг сэтгэхүйн ухадахаун мэтээр явцуу төсөөлж ирсэн нь жишгийн бус хандлага бүхий гажуудлыг бий болгоход хүргэжээ. Германы болон дэлхийн хөгжлийн ихэнх орны эрүүгийн эрх зүйд "Гэм буруу" гэдэг нь санаатай ба болгоомжгүй гэсэн гэмт санааны хэлбэр биш, харин хэрэг хариуцах нөхцөл чадвартаар холбоотойгоор яригдаг тусдаа ухадахаун гэж үзэх нь түгээмэл ажээ. Германы эрүүгийн эрх зүйн зарим судлаачид: "...Гэм буруу гэдэг нь түүний гэмт үйлдлийн улмаас гарах үр дагаврыг өөрт нь ноогдуулж болох эсэх, эрүүгийн хариуцлагагүй хулээх чадвартай эсэх эзргийг хамруулан ойлгоно..."¹³ гэж бичжээ.

Латинаар "*Nulla poena sine culpa*" буюу гэм буруугийн зарчим нь гэм буруугийн хамааралгүй бол ялгуй гэсэн утгаас эх үндэстэй бөгөөд "...орчин үеийн эрүүгийн эрх зүйд гэм бурууг норматив байдлаар тодорхойлох хандлага зонхиолж байгаагийн дээр гэмт санааны санаатай, болгоомжгүй хэлбэрийг гэм буруугийн төрөл биш, үйлдлийн зүй бусын элемент гэж үзэж гэм буруугийн ойлголтод хамааруулалгүй, харин гэмт хэргийн бүрдлийн /бүрэлдэхүүний/ шинжид хамааруулж байна.¹⁴

Орчин үеийн эрүүгийн эрх зүйн онолд гэм буруугийн онолоос гадна гэмт санааны онол гэсэн үзэл баримтлалыг нэлээд тодотгон авч үздэг.

Монгол, Орос болон Постсоциалист голдуу орнуудад гэм бурууг субъектив хүчин зүйлд багтааж, сэтгэхүйн харьцаа, сэтгэл зүйн элементтэй холбон тайлбарладаг.¹⁵ Гэм буруугийн онолооор гэмт

¹³ Хилпандорф, Д.Чанцагдуулам. Германы эрүүгийн эрх зүйн өрөнхий арги. Уб. 2015 он, 29 дахь тал

¹⁴ Т.Золбоо. Дурдсан бутзэл 107 давх тал.

¹⁵ В.Н.Додонов. Сравнительное уголовное право Общая часть, М; 2009. С.137.

үйлдлийн субъектив шинж нь зөвхөн шууд санаатай үйлдэгдсэн үед л гэм буруугийн хамаарал бий болно гэж тайлбарладаг бол Гэмт санааны онолоор гэмт үйлдэл нь хүссэн ба мэдсэн байх субъектив шинжийг бүрэн хангаагүй боловч гэмт үр дагаврыг бий болгосон бол хуульд тусгайлан заасан хэргийн бурдлийн формаль шинжийг хангасан гэж үзэж эрүүгийн хариуцлага хулээх нехцэл бурдэх юм.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний дөрвөн талт элемент бүхий онол нь Монгол Улсад 50 шахам жил идэвхтэй хэрэглэгдсэн нь уг онол хууль зүйн шинжлэх ухааны үзэл баримтлал, арга зүй болтлоо хөгжин төлөвшенсийг харуулна.

Сүүлийн хорь шахам жилийн эрүүгийн эрх зүйн орчин, шүүхийн практикаас үзэждэнхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын 40-өөс доошгүй хувь нь явахгаа ёөрчлөгддэг, эрүүгийн хуулийг догматик байдлаар *Мэсийн Дээд Шүүх* нэр томьёо талаас нь тайлбарлаж ирснээс гадна адилт тест гэмт хэргийг зүйлчлэхэд хүндэрэл зөрчилдөөн яматг үүсдээ, нэг л удаа шийтгэх / *Non bis idem* / зарчим зөрчилдэг, эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх боломж бүрэн хязгаарлагдаагүйн дээр захиригааны зерчил ба гэмт хэргийг ялган таних шалтуур арга зүй өнөөг хүртэл бий болоогүй заргийг дурдаж болно. Түүнчлэн нуугдмал гэмт хэргийн тоо есч гэмт хэргийн илрүүлэлтийн түвшин буурсаар байгаа нь анхаарал татаж байна.

2002 оны Эрүүгийн хуулиар тогтоосон гэмт хэргийн каталогт хүний нэр тэр, ёс суртахуун, хувийн амьдрал, гэр бүлийн эсрэг гэмт хэргийн /сэтгэл зүйн гэмт/ үйлдлүүд/ төрлүүдийг тусгайлан зүйлчлэгүй орхигдуулсны дээр ялаас хэт хамааралтай гэмт хэргийн ангиллын апологи маягийн оновчгүй бүтэц оршиж ирсэнд бид дүгнэлт хийх шаардлагатай.

Гадаадын орнуудын эрүүгийн эрх зүйн онолын харьцуулалтын тухайд авч үзвэл:

I. Англи-Америкийн системийн орнуудад:

1) Mens Rea.

2) Actus Reus гэсэн хоёр шалгуурт элементийг гэмт хэргийн бүтцийн тогтолцоонд түгээмэл хэрэглэдэг. "Actus Reus" гэх элемент нь гэмт үйлдлийн биет хэлбэрэйн онцлогийг тусгадаг бол "Mens Rea" нь гэмт санааны зориуд хүссэн ба мэдсэн байх шинжээс гадна сэтгэхүйн нехцэлт ба болзолт хэлбэрэйн агуулыг илэрхийлдэг. Харин гэм буруугийн асуудлыг гэмт хэргийн үндсэн бутцээс ангид тусгай нехцэлт шинж болгон авч үзэг байна. Ихэнх тохиолдолд эрүүгийн хариуцлага хулээх шалгуур бүтэц гэсэн угтаар хэрэглэдэг.¹⁶

II. Германы эрүүгийн эрх зүй дэх гэмт хэргийн бүрэлдэхүүн нь

- 1) Хуульд заасан хэргийн бүрдэл,
- 2) Хуульд харш чанар,
- 3) Гэм буруу гэсэн 3 шалгуурт элементийн онолоор тайлбарлагддаг.

✓ Хуульд заасан хэргийн бүрдэл /Tatbestand/ гэдэг нь хуулиар тусгайлан тодорхойлж өгсэн гэмт хэргийн шинжүүдийн нийлбэр цогц юм. Энэ нь объектив ба субъектив гэсэн хоёр бүрдэлт шинжийг илэрхийлнэ. Объектив бүрдэл гэдэгт гэмт хэргийн гадна талын буюу гэмт үйлдлийн халбэр, үр дагавар, хор уршиг, гэмтэл, шалтгаант хамаарал зэрэг шинжийг хэлнэ. Субъектив бүрдэл гэдэг нь гэмт хэргийн дотоод тал, хүссэн ба мэдсэн байх хүсэл зоригийн шинж юм.

✓ Хуульд харш чанар /Rechswidrigkeit/ гэдэг нь гэмт хэргийн эрхийг зөвтгэх буюу гэмт хэргийн хор, аюулыг үгүйсгэх нехцэл байдал байгаа эсэхийг ойлгоно. Өөрөөр хэлбэл хуулиар

¹⁶ Norman M. Gerland. Дурдсан бутээл. р. 90.

зөвшөөрөгдөөгүй нөхцөлт
шинжийг авч үзэх боловч гэмт
үйлдэл нь хуульд тусгайлан заасан
бүрэлдэхүүнийг хангасан байхыг
шаарддаг.

- ✓ Гэмт буруугийн /Schuld/ элемент нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөл хангагдсан байх, өөрөөр хэлбэл хэрэг хариуцах чадвар, нас, сэтгэцийн хувьд ял онооход хамааралтай байх шинж юм.¹⁷

III. Франц, Бельги, Алжир болон Латин Америкийн орнуудад гэмт хэргийн гадаад ба дотоод тал буюу биет болон сэтгэхүйн шинжийн шалгуураар тайлбарладаг байна. /Mental and Physical elements/

НҮБ-аас 2007 онд дэмжиж таргасан Дэлхийн Эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлийн тайлбарт: "Гэмт хэрэг бүхэн бүтцийн хувьд хүлээн зөвшөөрдсөн шалгуур нөхцөлүүдтэй байх ёстай. Биет ба сэтгэхүйн элемент нь гэмт үйлдлийн болон хүсэл зоригийн шаардлагыг хангаснаар илрэх ёстай" тэмдэглэжээ.

Сүүлийн жилүүдэд Ж. Вигморын анхлан дэвшиүүлсэн гэмт хэргийн функционал бүрэлдэхүүний онолыг хүлээн авах хандлага нэлээд дэмжлэг хүлээж болжээ. Үүнд: 1) Гэмт үйлдлээр эрх зүйн үр дагавар бүхий хохирол, хор уршиг шууд бий болсон байх; 2) Гэмт буруугийн хамаарлаар холбогдсон байх; 3) Яллах нөхцөл, ялын санкцыг аяндаа бий болгосон байх¹⁸ г.м. Түүнчлэн нотолгооны, органик, процессын, функционал, институционал зэрэг янз бүрийн түвшинд гэмт хэргийн бүрэлдэхүүний онолыг авч үзэх үзэл баримтлал шинээр бий болж байна.

Дүгнэлт

Энэ бэсрэгхэн өгүүлэлд хөндсөн асуудал нь гэмт хэргийн бүрэлдэхүүний дөрвөн элементийн уламжлалт-онолыг бүхэлд нь үгүйсгэх зорилгыг агуулаагүй гэдгийг онцлон тэмдэглээ, Гагцүү гэмт хэргийн бүрэлдэхүүний онолын зарим хуучинсаг зарчим, хандлагад шүүмжлэлтэй хандаж, харьцуулсан эрх зүйн үүднээс олон талаас нь авч үзэх, шинжлэх ухааны мэтгэлцээн өрнүүлэх, өөрийн үзэл бодлыг илрэхийлэх гэсэн агуулга бүйг дурдах нь зүйтэй.

Сүүлийн үед Зүүн Европын орнуудын цөөнгүй нь /Словакия, Румыни, Чех, Эстон, Унгар, Молдав/ гэмт хэргийн бүрэлдэхүүний дөрвөн талт элемент бүхий энэхүү онолд шүүмжлэлтэй хандах явдал нэлээд ажиглагдах болсон юм.

Цаашдаа эдүгээ хэрэглэгдсээр байгаа гэмт хэргийн бүрэлдэхүүнээс субъект, объект гэсэн элементийг хасч, гэмт хэргийг зүйлчлэх тохиолдолд хэрэглэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, гэмт буруугийн ойлголтыг Герман, Баруун Европын орнуудын жишгээр шинээр авч үзэх, гэмт санааны талаараа буруу төсөөллөөс татгалзах сэтгэхүйн хүчин зүйлийн зохиостой шалгуурыг бий болгох зэрээр энэ онолын загварыг бүхэлд нь шинчлэн боловсруулж гаргах нь залшгүй тулгамдсан шаардлага болж байна.

Монгол улсад эрүүгийн хууль тогтоомжийг бүхэлд нь өөрчлөх реформ эрчимтэй хийгдэж буй энэ түүхэн цаг үед эрүүгийн эрх зүйн онол, агаа зүй ч мөн адил өөрчлөгдөн шинчлэгдэх нь дамжиггүй юм.

---00---

¹⁷ Хилтэндорф. Д Чанчалдулам Дурдсан бүтээл, 27-29 дак тал

¹⁸ J Wigmore Evidence: Corpus delicti. W.2006 p 59

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХАРИУЦЛАГЫН АСУУДАЛ



Хуульч, дипломатч Ж.Шишишиев

ТҮЛХҮҮР ҮГ:

Үндэсний аюулгүй байдал, үндсэн хуулийн нэг бүрийн хариуцлага, хамтын хариуцлага, төрийн болон иргэд нийгмийн хариуцлага. Эзрэг болон серег хариуцлага

ТОВЧЛОЛ:

Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа улс орны өнөөгийн нехцөл байдалд тэр бүр зохицож хэрэгжихгүй байгаа бөгөөд үүний нэг гол шалтгаан нь хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх ёстой төрийн төв болон орон нутгийн байгууллагын ажилтнуудын үндэсний аюулгүй байдлын талаарх онол, практикийн мэдлэг сүл, иргэдийн ойлголт хангалтгүй байгаатай холбоотой. Үүнээс үүдэн төрийн албан хаагчдын эрх зүй, материаллаг, ёс зүй, улс төрийн түүчлэн иргэдийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх шаардлага тавигдаж байгаа юм.

Орчин цагийн эрх зүйн онолд хариуцлагыг хөр төрөлд ангилдаг: - зөврөг болон серег хэмээн нэрийддэг.

Эзрэг /позитив/ хариуцлага нь зөв зүйтэй, нийгэмд үр ашигтай үргүйг гүйцэтгэх үйл ажиллагаанаас үүдэлтэй

бөгөөд үүрэг хүлээсэн тал нь хяналтад байх, тайланахаа түвшинд байх тийм эрх зүйн зохицуулах харилцаагаар хэрэгждэг. Энэ нь ажил албан тушаалаар хүлээсэн үүрэг, мэргжлийн ёс зүйтэй холбоотой буюу үүрэгжсэн хариуцлага юм.

Серег /негатив/ хариуцлага нь - эрх зүйн зөрчил гаргагчийн хууль тогтоомж зөрчсентэй холбоодоо үйлдлийнхээ түүнд таагүй, эрх зүйн шийтгэл хүлээж хүлээнэ гэсэн уг. Улс төрийн болон эрүү, иргэн, захиргааны хариуцлага үүнд орно.

Үдирдтгал

Эдүгээ аюулгүй байдал, түүнийг хэрхэн ямар арга замаар хангах онолын асуудал олон улсын түвшинд нэг мөр боловогүй ч улс орнуудын үндэсний аюулгүй байдлын хүрээнд яригдаж, судлагдаж, олон эшт үзэл, сургаалиуд бий болсоор байна.

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хууль¹ нь Үндэсний аюулгүй байдал /Цаашид "УАБ" гэх-/төрийн холбоотой төрийн бодлого боловсруулах, төлөвлөх, шийдвэр гаргах, хууль тогтоомж боловсруулан батлах үндэслэл, тулгуур баримт бичиг мөн.

Үндсэн хуулийн дагуу Үндэсний

¹ 1991 оны тавдугаар сард Улсын Бага Хурал /УБХ/ Үндсэн хуулийн төслийн хөөр удаа халапцан зөвлөхөөрөөр ард нийтээр халапцүүлэхээр шийдсэн. Санал авахад бусчилсан зөвлөлгөөн таван удаа зохион байгуулж, хэвлэл мэдээлэл, захидал, уулзант, хурал тээд олон аргаар сонгогчдын саналыг гурван сарын түрш ард нийтээр халапцүүлэхэд төрийн үдирдлэлтийн хэлбэр, газар очижелен зорг асуудлаар налзэн хүрц ширүүн маргавч гарч байсан. Тийм асуудлаар олон түмнэй санал болон мэргжлийн саналыг хин судалж олонхийн саналыг тусгасан юм. Нийт 1,2 сая сонгогчийн 75 орчим хувь нь оролцож, 200 мянга гаруй санал ирүүлсан байсан. Ард нийтийн саналыг дагуу хуулийн төслийн сийлгүүрүүс дараа УБХ дахин хөөр удаа халапцад Ардын Их Хуралд мэдүүлж, ард түмнүүг төлөвлөсөн 420 гаруй төлөвлөч ажлын 60 гаруй хоног хөөр удаа зүйл бүрзээр нь халапцаж баталсан.

аюулгүй байдлын талаарх дараах зохих бодлогын баримт бичиг бичгүүд ба хууль тогтоомж батлагдсан байна. Үнд:

1/ Бодлогын баримт бичгүүд боловсруулсан баталж бодлогоо тодорхойлсон: Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал /Цаашид "ҮАБҮБ" гэх², Гадаад бодлогын үзэл баримтлал³,

2/ Салбар хуулиуд:

а/ шууд аюул заналд хамааралтай : - Үндэсний аюулгүй байдлын тухай /Цаашид "ҮАБтХ" гэх⁴, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай / Цаашид "ҮАБЗтХ" гэх⁵, Онц байдлын тухай, Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчиний жанжин штабын тухай, Төрөролын эсрэг, Авлигатай тэмцэх;

б/ хариуцлагатай холбоотой хуулиуд⁶: Эрүүгийн хууль, Иргэнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай;

в/ аюулгүй байдлын бусад бүрэлдэхүүнд хамааралтай: - Гамшиглаж сэргийлэх тухай, Хүнсний аюулгүй байдлын тухай, Эрүүл мэндийн тухай гэх мэт хууль тогтоомжуудыг Улсын Их Хурал /Цаашид "УИХ" гэх/-аас батлан гаргасан билээ.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын асуудал ба төрийн бодлого

Монголын ард түмний нийтлэг ашиг сонирхлын цогц илэрхийлэл

² Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 1994 онд батлагдаж, 2010 онд шинчилэн найруулсан.

³ Гадаад бодлогын үзэл баримтлал. 1994 онд батлагдаж 2011 онд шинчилэн найруулсан.

⁴ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тухай хууль, 2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан.

⁵ Монгол Улс 1992 оны наадуулжар сарын 13-нд баталсан шинэ Үндэсний хуулиарас Ерөнхийлөгчийн институцийн билгээж, уг хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1-ийн 10 давьж хасагт Ерөнхийлөгчийн хархагчуудын буран аялгуудийн дотор "Лонгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг таргуулж" гэж заасан билээ 1990 оны өвлийн аялгуудын чөлөөт сонгуулжин үр дүнд байгуулжадсан Улсын Бэлгэ Хурал 1992 оны 5 дугаар сарын 29-нд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн баталж уг зөвлөлийг байгуулсан замч. Энэ хуулиар Зөвлөлийн үзэл ажиллагааны үндэсний зорилтуудыг тогтолцоо, түүнийг байдлыг хангах тогтолцоо, түүнийг бурдуулэгч субъектуудийн эрх үүргийг бурдуулжадсан.

⁶ Д.Адъяабазэр, "Монгол Улсын доодотой аюулгүй байдлын эрдэлээ бүхий зарим асуудал", Стратеогийн судалжамшиг, 2011 он, №53, 35 давьж тав.

боловсруулсан эх оронч үзэл билээ. болсон Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үзэл баримтлалын баталгаажилт нь эх байгаль, угацаатны болон үндэсний соёлын экологид суурилсан эх оронч үзэл билээ.

Улс үндэстнийхээ аюулгүй байдлын үндсэн баталгаа нь ямагт байх ёстой иргэдээз эх оронч соёл, үндсээ бадраахаа үзэл хүмүүжил төлөвшүүлэх нь улам бур даяаршиж буй дэлхийн өртөнцед Монголын ард түмэн өөрийнхөө эрхэм дээд үнэт зүйлс болох улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган хөгжүүлэх үндэсний хэрэгцээ, язгуур ашиг сонирхолд нийцэж, үндэсний түүх, соёл, ухамсырыг өв тэгш хадгалах, хамгаалах цаашид хөгжүүлэх, дархлаажуулалтыг нь улам бахлэн бататах нийгмийн захиалгаар нөхцөлдөж⁷ байна.

Монгол Улсын иргэдээд эх оронч үзэлтөлөвшүүлэх ижбурэн хөтөлбөрийг иргэд, олон нийт, эрдэмтэн, судлаачид, улс төрчдийн төлөөлөл, холбогдох яамдын санал санаачилгэд тулгуурлаж боловсруулан мөрдэж ажиллах нь Засгийн газрын гол үүргийн нэг мен хэмээн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигт⁸ нэгэнтээ заасныг хэрэгжүүлэх нь өнөөгийн тулгамдсан зорилтын нэг мөн.

Монгол Улс аюулгүй байдлын бодлогоо бие даан боловсруулан холбогдох хууль тогтоомжийг батлан мөрдэж байгаа бөгөөд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийг 1992 онд, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг 1994, 2010 онд, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийг 2001 онд тус тус УИХ-аас батлан гаргаж, энэ салбарын хууль, эрх зүйн орчин үндсэндээ бүрдсэн билээ. Эдгээр хууль, тогтоомжид үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо, түүнийг бурдуулэгч субъектуудийн эрх үүргийг бурдуулжадсан.

⁷ Д.Адъяабазэр, "Монгол Улсын доодотой аюулгүй байдлын эрдэлээ бүхий зарим асуудал", Стратеогийн судалжамшиг, 2011 он, №53, 35 давьж тав.

⁸ Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг: Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг оюун хувайн, эс сурталхуусын хүрээнд төлөвшүүлэх хөтөлбөр боловсруулж мөрдэх тухай. 2002 он. Дугаар 190.

талаар тодорхой тусгасан болно.

1994-2001 үе бол Монголчууд УАБ гэдэг нь "...ундэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байхыг хэлнэ"⁸ гэсэн ойлголт үнэмшлээс улбаалан "...улс тэр-дипломатын аргаар хангана"⁹ гэдэг Гадаад бодлогын үзэл баримтлалд тулгуурлан, Үндэсний аюулгүй байдлын УАБ/ талаарх нийгмийн сэтгэлгээнд эргэлт гарсан билээ. УАБ-ыг хангах тогтолцоо, түүний үндсэн бурдэл бүтцүүд бэхжиж, байнгын үйл ажиллагаа явуулах болсны зэрэгцээ шийдвэр гаргах ба түүнийг хянан хэрэгжүүлэх үйл явцыг тодорхой журамласнаар шинэ тогтолцооны ажиллагаа хиждэрх төлөвшсөн цаг үе билээ. Монгол Улсын төрийн дээд институтийн тувшинд аюулгүй байдлын үндсэн асуудлуудын талаарх эрх эйн орчин, зохицуулалтыг хангах тогтолцоо бий болсон нь төрийн жолоодлого, удирдлагын зохион байгуулалтад гарсан чанарын шинэчлэлийн нэг байсан юм.

Улс орны үнэт зүйлсийг арчилал, эрх чөлөө, хүний эрх хэмээн дээдлэн үзэх болсон, улс орны гадаад, дотоод бүхий л өөрчлөлт нь аюулгүй байдлын шинэ үзэл баримтлал, шинэ тогтолцоог бий болгохыг шаардав. Иймд аюулгүй байдлыг "ундэсний" хэмжээнд авч үзэх, үндэсний аюулгүй байдал нь зөвхөн цэргийн бус олон талтай ойлголт болсныг нэгтгэсэн, уламжлалт бус аюул заналхийлэл шинээр бий болсныг тооцсон, үндэсний аюулгүй байдал нь төрийн төдийгүй олон нийт, хэвлэл мэдээлэл, иргэний хяналтад байх зарчмуудыг тусгасан төрийн бодлогыг үндэслэх, боловсруулах шаардлагатай болсонтой уядан анхны Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг 1994 онд батлан гаргасан билээ.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалыг УИХ 2010 оны хаврын чуулганаараа баталсан. Өргөн цар хүрээтэй асуудлыг

⁸ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Нэгдүгээр зуйлийн 1 дахь хэсэг. 2010 он.

⁹ Гадаад бодлогын үзэл баримтлал. Нэгдүгээр зуйлийн 3 дахь хэсэг. 2011 он.

хамарсан төрийн бодлогын чухал үндэс, Үндэсний хуулийн дараа орох энэ баримт бичгийг шинчлэн батлахдаа аюулгүй байдлын гадаад, дотоод нөхцөл байдалд дүгнэлт хийж, улмаар тэдээр чиглэлд төреөс баримтлах бодлогыг тодорхойлсон юм.

Гадаад, дотоод хүчин зүйлүүдийг Үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалыг батлахдаа харгалаж үзсэн бөгөөд үүнээс үүдэн аюулгүй байдлын талаар Төреөс хүзээх хариуцлагын асуудал дараах хүрээнд тавигдаж байна.

Үндэс:

- Улс орны хөгжлийн өнөөгийн эздрээтийг үе шатанд Монголын тэр үндэсний эрх ашигаа дээдлэсэн бодлого явуулах чадвартай байх. Энэ бол дотоод аюулгүй байдлын чухал зангилаа асуудал болж байна гэж үзнэ. Үндэсний эв нэгдэл, тогтвортой байдал ч гэсэн ахаарал татаж байгаа,
- Хүнсний аюулгүй байдал хангамж, хүн амын эрүүл ахуйн асуудал улам хурцаар тавигдан Монгол Улсын иргэд амьд явж, эрүүл аюулгүй орчинд амьдрах баталгааг бий болгох, өөрөөр хэлбэр хүний аюулгүй байдлыг бий болгох нь манай улсад тулгамдсан асуудал болж байна,
- Дэлхий даяар явагдаж буй уур амьсгалын өөрчлөлт, түүнчлэн манай улсад аж ахуйн үйл ажиллагаа, хүний хүчин зүйлээс үүдэлтэй хүрээлэн буй орчинд байгаль экологийн доройтол, экологийн аюулгүй байдлыг хангах нь улс үндэстний оршин тогтолцын чухал асуудал болж эхэлснийг харуулж байна.
- Олон улсын хэмжээнд мэдээллээр дамжин бусад орны тэр засаг иргэдийг тагнах, хянах, хорлон сүйтгэх, зохион байгуулалттай болон гэмт хэргийн чанартай ажиллагаа идэвхижих байгаа нь олон улсын аюулгүй байдал шинээр гарч ирж байгаа уламжлалт бус аюул болж байна.

Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа улс орны өнөөгийн нөхцөл байдалд тэр бүр зохицож хэрэгжихгүй байгаа бөгөөд үүний нэг гол шалтгаан нь хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх ёстой төрийн төв болон орон нутгийн байгууллагын ажилтнуудын үндэсний аюулгүй байдлын талаарх онол, практикийн мэдлэг сүл, иргэдийн ойлгот хангалтгүй байгаатай холбоотой. Үүнээс үүдэн төрийн албан хаагчдын эрх зүй, материаллаг, ёс зүй, улс төрийн түүнчлэн иргэдийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх шаардлага тавигдаж байгаа юм.

Үндэсний аюулгүй байдалд Хариуцлагын асуудал холбогдох нь

Орчин цагийн эрх зүйн онолд хариуцлагыг хоёр төрөлд ангилдаг: зөрөг болон сөрөг хэмээн нэрийддэг.

Зөрөг /позитив/ хариуцлага нь зөв зүйтэй, нийгэмд үр ашигтай үүргийг гүйцэтгэх үйл ажиллагаанаас үүдэлтэй бөгөөд үүргэг хүлээсэн тал нь хяналтад байх, тайлгахаа түвшинд байх тийм эрх зүйн зохицуулахаар харилцаагаар хэрэгждэг. Энэ нь ажай албан тушаалаараа хүлээсэн үүргэг мэргэжлийн ёс зүйтэй холбоотой буюу үүрэгжсэн хариуцлага юм.

Энэ нь **Төрийн албаны хүрээнд:**

- Улс төрийн албан тушаалтны хариуцлага
- Захиргааны албан тушаалтны хариуцлага
- Тусгай албаны албан тушаалтны хариуцлага
- Үйлчилгээний албан тушаалтны хариуцлага – гэж ангилагдаж байна.

Сөрөг/негатив/ хариуцлага нь - эрх зүйн зөрийн гаргагчийн хууль тогтоомж зөрчсөнтэй холбогдок үйлдлийнхээ төлөө түүнд таагүй, эрх зүйн шийдвэрээ хүлээнэ гэсэн үг. Улс төрийн болон эрүү, иргэн, захиргааны хариуцлага үүнд орно.

Төрийн хариуцлага:

Аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны чухал зарчим нь тэр, иргэний хамтын ажиллагаа бөгөөд “Үндэсний аюулгүй байдлыг хангах нь төрийн анхдагч үүргэг гэдгээр төрийн үүргэг хариуцлага тодорхойлогдож байна.

Иргэдээ аюулгүй байдлын асуудлаар өргөн мэдээлэл, мэдлэгтэй байх, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмэрээ оруулах боломжкоор хангах, хамтран ажиллахад тэр онцгой анхаарна” гэж УАБТХ 1.2.2/ заасны дагуу төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгэм, аж ахуйн нэгж, судалгааны хүрээнд, иргэдийн хамтын ажиллагааг хангасан, шийдвэр гаргах үйл ажиллагааг нэг урсгалтай бус ард иргэд, нийгмийнхээ санал санаачилгэд тулгуурласан, ил тод, “Хоёр урсгалтай” байгах нь стратегийн мэдээллийн удирдлагын нэгэн онцлог юм. Энэ удирдлага бол Үндэсний аюулгүй байдлын зөвлөл¹⁰ мөнөөс мөн.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл тухайн үеийн байдлыг харгалzan УАБУБ-ыг хэрэгжүүлэх стратеги, тактикийг **уялдуулан зохицуулах** үүргийг хүлээх бөгөөд үндэсний аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаад хянантай тавьж, УИХ-д мэдээлж байхаар заажээ¹¹.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нэгдмэл шийдвэр гаргах учиртай. Зөвшүүлэх хүрэггүй бол шийдвэрийг хэрхэн гаргах вэ?

Онц чухал цаг үед шуурхай шийдвэр гаргаж чадахгүй бол хэн, ямар хариуцлага хүлээх вэ?

Нэгдмэл шийдвэр гаргах зарчмын үүднээс үзвэл хамтын хариуцлага хүлээх ёстой юу гэдэг эрх зүйн асуудлууд гарахаа магадлал бий. Манай УАБЗ-ийн

¹⁰ Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай хуулиин 2 дугаар зүйл “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдлээ болдого боловсруулах үйл ажиллагаа болон түүнчлийн хэрэгжүүлэх явдлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалт нь хэрхэн хангагдаж байгаад хянантай төрийн зөвлөлдөх байгууллага мөн” 1992 он

¹¹ “Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай хуулиин 3 дугаар зүйлийн 4 дахь хэсэг “Зөвлөл нь лялва Улсын Их Хурлын өмнө хариуцна 1992 он.

гишүүдийн хооронд санал нэгдэхгүй, үйл ажиллагаа нь зөрчилдөх байдал ажиглагдах буйг Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд баримтаар нотолж байгаа.

Дараах олон нөхцөл байдлыг анхаарч, судлах, дүгнэлт хийх, шийдвэрлэх шуурхай арга хэмжээ авах нь Төр, засаг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн үүрэг хариуцлагын тутамдсан асуудал болж байна:

- Хууль тогтоох, гүйцэтгэх засаглал, шүүх эрх мэдлийн тогтолцоо, үйл ажиллагаа хямралтай, тогтвортгүй байна. Түрүүчийн болон өнөөгийн УИХ, Засгийн газар үйл явдлыг бүрэн хянах, шуурхай зохицуулалт хийж арга хэмжээ авах чадамжгүй байна.
- УИХ, түүний гишүүд Үндсэн хуульд заагдсан, түүнийг хамгаалагч ганц субъект Үндсэн хуулийн цэц¹² рүү дайрч давшлах, нэр хүндэд нь хялдах зэргээр төрийн хүчгүйдүүлэх ажиллагаа үе үе явуулж байсан. Үндэсний эрх ашгийг хамгаалах зэвсэг нь / хатуу, зөвлөн/ хүч мөн. Төрийн засаглалын эрх мэдэл буюу хүч сергэлдэвэл Төрийн тогтолцоог хямраана. Эрх зүй, эрх зүйтэй сергэлдэвэл мүйхар хүч ажиллаж эхэндэг – гэж нэг улс төрч хэлсан нь бий.
- Эдийн засгийн хямрал бизнес хийгээд ард иргэдийн үйл ажиллагаа, ахуй амьдралд хүндээр тусг байна.
- Эрүүгийн орчин, ялангуяа авлига, хар тамхи, хүн амины болон хулгай дээрмийн хэргүүд нийтийн санаа түвшээх асуудал болж байна. Сүүлийн үед эх ороосоо урвах, төрийн нууц задруулах болон бусдын эрх чөлөөнд халдаж хүний

¹² Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн билэлтэд дээд хянант тавих, түүний заалтыг зөрчжин тухай дүгнэлт гаргах, маргарынгын магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийн чандлан сахиулах баталгаа мөн”. 1992 он.

эрх зерчих, хүн амины хэрэгт териийн албан хаагч, цэргийн болон цагдаагийн албан тушаалтнууд холбогдож байгаа нь нийгмийн эрх зүйн ухамсарт серег нөлөө үзүүлэх хүчин зүйл болж байна

Манай чиг үүрэг хүлээсэн байгууллагууд цомхон хүчээр асуудлын гол чиглэлд алсын хараатай, салбар нэгжүүдийн харилцан ажиллагаанд тулгуурлан маш үр дүнтэй, бас нягт нямбай ажилладаг болж сурх хэрэгтэй байна. Учир нь, бид яматг цомхон хүчээр, бага хөрөнгө мөнгөөр ажиллааас өөр аргагүй байдалд байгаа билээ. Өөрөөр халбэл, манай нөхцөл байдал бидэнд цомхон хүчээр ажиллахыг тулгаж байна. Түүнчлэн хөршүүдээсээ тэхник хэрэгслийн хувьд төдийгүй сэтгэлгээ, сургалтын хувьд ихээхэн хоцрогдож яваагаа мартаж болохгүй. Тэгэхлээр бид цаашид яах ёстойг судалж тодорхойлох шаардлага тулгарч байна. Техник хэрэгслийн хувьд хөршүүдээс дэхэж очно, хөршүүдээсээ давж гарна гэдэг ойрын ирээдүйд биелэгдэшгүй хэрэг юм. Тиймээс үүний хөршүүдийнхээ хойноса хөөх бус арай өөр аргачлаалаар шийдэхийг бодож ёстай.

Харин сэтгэлгээ, сургалтын түвшинд бид шинчлэл хийж, өвөрмөц бодлогоор ажиллаж чадвал хөршүүдээсээ энэ хөөр салбарт дутагчий болох, давж гарах далд боломж бий.

Иргэдийн буюу нийгмийн хариуцлага:

Нийгмийн хариуцлагын арга хэмжээг дурдвал:

- төрийн бодлого боловсруулахад оролцуулах, тесев гаргах, зардлыг хянахад оролцох, төрийн үйлчилгээг үзүүлэхэд иргэд хяналт тавих, үнэлгээ хийх
- иргэдийн мэдээлэл, мэдлэгийг сайжруулах, хариуцлагын энгийн механизмуудыг ашиглах “дотоодын” хариуцлагын механизмын үр нөлөөг сайжруулах /жишээлбэл ТББ, олон нийтийн

хороо болон шүүх ажиллагаа, иргэдийн зөвлөлдөх зөвлөл, хяналтын хороонд иргэдийг оролцуулах зэрэг/

Нийгмийн хариуцлага гэдэг ойлголт нь: - эрх мэдлийн тогтолцоонд иргэдийг оролцуулах гэсэн уг.

Терийн механизм болон зах зээлийн хүчин зүйлс, олон нийтийн өмчийг дэмжихгүй байгаа, ялангуяа авилга, ядуурлаас гарах ажлыг хийхгүй байгаа үед иргэд засаглалын илэрхийг асуудлуудад шууд оролцох хөдөлгөөн гарч эхлэн.

Гол оролцогчид нь: иргэдийн бүлэг болон засгийн газар байдал.

Засгийн газар нь бүх мэдээллийг ашиглах боломжоор хангах үүрэгтэй бол иргэд нь засаглалыг бий болгож, хөгжүүлэхэд оролцох эрхээ илэрхийлэх ёстой. Ардчилсан засаглалын бүхий л мечлэгийн аль ч үе шатанд нийгмийн хариуцлага байх ёстой.

Нийгмийн хариуцлагын арга нь иргэдээс сонгогдсон удирдагчид, хүнд сурталтнууд, төрийн үйлчилгээ үзүүлэгчдийг ялангуяа сонгуулийн дараа гүйцэтгэлийнхээ төлөө хариуцлага хүлээгдэг байх, үүний тулд тэдний гүйцэтгэлийг байнга хянаж, ажигладаг, бэрхшээлгүй урьдчилан харж чаддаг байхыг шаарддаг.

Нийгмийн хариуцлагаар дамжуулан энгийн иргэд засгийн газрын томоохон асуудалтай бүгд санаа нэгдэн үйл ажиллагаагаа нэгдмэл байдаар явуулж байх томоохон хэсүү асуудлын эсрэг тэмцэж чадна.

Хариуцлагын төрөл

Хууль, тогтоомж, гэрээний үүрэг зөрчсөн тохиопдолд гэм буруутай эзээдийг танин мэдэж, зөрчлийн шинж чанар, гэрээний үүргийн онцлог, нотолгоонд үндэслэн хариуцлагыг бодитойгоор, ялгамжтай оногдуулах нь чухал.

Улс төрийн, иргээний эрх зүйн, эрүүгийн, захирагааны хариуцлага.

Гэрээний хариуцлага -гэрээний харилцаанд оролцогчдын эдийн засгийн хэвийн харилцааг хөхүүлэн дэмжих, тэдний зөрчигдсэн эрхийг нэхэн сэргээхэд чиглэсэн эд хөрөнгийн шинжтэй санкц

Хэсгээр /нэг бурийн/ хүлээх хариуцлага /Ерөнхийлөгчийн, УАБЗ-ийн Тэргүүний болон гишүүний/ - Оногдох хариуцлагын хэмжээ нь тодорхой бөгөөд бусад Үүрэг гүйцэтгэгчдээс харилцан хамааралтгүйгээр хүлээх санкц /Хууль тогтоомж зөрчсөн, Тангаргаа зөрчсөн/

Хамтран хүлээх хариуцлага - хэд хэдэн үүрэг гүйцэтгэгч байгаа бөгөөд үүргийн мөн чанараас хамааран бие биенээсээ харилцан хамааралтай бөгөөд хамтран хүлээж буй санкц /Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн, УАБЗ-ийн гишүүдийн, Засгийн газрын Танхимын/

Өсгөн нэмэгдүүлсэн хариуцлага – хууль, ёс зүйн журам /тангаргаасаа няцаа гм/ болон дүрэм, журам, гарээнд заснаар үндсэн хариуцлагаас гадна нэмэгдэл байдаараа хүлээх санкц бий.

Дүгнэлт

Монголын ард түмний нийтлэг ашиг сонирхлын цогц илэрхийлэл болсон Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах узл баримтлалын баталгаажилт нь эх байгаль, угсаатны болон үндэсний соёлын экологид сууринсан эх оронч узл юм.

Монгол Улс аюулгүй байдлын бодлогоо бие даан боловсруулан холбогдох хууль тогтоомжийг батлан, мөрдэх байгаагийн дунд энэ салбарын хууль, эрх зүйн орчин үндэснээд бурдсан гэж ойлгож болохоор байна. Гэвч Үндэсний аюулгүй байдлыг хангахад тэр , иргэд нийгмийн хариуцлагын асуудал талаарх зохицуулалт хангалтгүй байгаа бөгөөд энэ нь зайлшгүй анхаарх ач холбогдол бүхий хүчин зүйл болоод байгааг онцлох хэрэгтэй.

Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаарх судлаачдын дунд академик маргаан, хэлэлцүүлэг багажий өрнөж байна. Мен УИХ-ын гишүүд болон судлаачдаас бурдсан ажлын хэсэг холбогдох судалгааг хийж байгаа билээ. Үндсэн хуулийн

нэмэлт өөрчлөлтөд Хариуцлагын тухай асуудлыг нарийвчлан тусгах эсхүл хариуцлагын тухай бие даасан тусгай хууль боловсруулан батлах шаардлага манай төр нийгмийн ёмне эн тэргүүний зорилт болж байгааг дурдах нь зүйтэй юм.

—909—



НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО) анх 1995 онд жил бурийн дөрөвдүгээр сарын 23-ны өдрийг "Дэлхийн номын өдөр" болгон зарласан билээ. Энэ өдөр дэлхийн 100 гаруй оронд зохиолч, хэвлэн нийтлэгчдэд хүндэтгэл үзүүлэх, ном уншихын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулж иржээ.

Энэ өдрийг тохиолдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын номын сангаас санаачлан “Дэлхийн номын едер”-т зориулж Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газар, хэвлэлийн газруудтай хамтран Төрийн ордонд зохион байгуулсан тус едерлэгт Хууль зүйн үндэсний хувцасын оролцов.

CEDAW БА СҮҮДЭР ИЛТГЭЛ

Хууль зүйн магистр Т.Саруул

ТҮЛХҮҮР ҮГ:

CEDAW, жендер, феминизм, эмэгтэйчүүдийн эрх, гэр бүл, гэрэлтэл, уламжлалт хандлага, харилцаа, хүний эрх, тэгш эрхийн зарчим.

ТОВЧЛЛОУ:

Энэхүү өгүүллээр CEDAW буюу „Эмэгтэйчүүдийг Алагчлах Бүх Хэлбэрийг Устгах Тухай Конвенцийн зарим агуулын хувьд олон улсын эрдэмтэн судлаачдаас илрхийлдэг шүүмжлэлтэй байр суурийг манай судлаачдын байр суурьтай харьцуулан дүгнэлт хийхийг зорьсон ба үндсэн хөөр асуудлыг давшигуулэв. Нэгдүгээрт жендерийн тэгш эрхийн зарчим нь хүйсийн тэгш эрхийн онолын хөгжлийн хувьд феминизмийн дараагийн үе шат гэж үзээд хүний эрхийг хангахад илүү боловсронгуй арга хэрэгсэл болох тухайд, хоёрдугаарт гэр булийн хүрээний асуудлыг хууль, олон улсын хэм хэмжээгээр зохицуулахад тямар хүрээ хязгаар байж болох талаар санал, дүгнэлтээс үндэслэхийг хичээлээ. Түүнчлэн, эмэгтэйчүүдийн эрхийн талаар Монгол улсын хүрсэн түвшин болон ахуйн соёл, сэтгэлгээний уламжлалаас хараад жендерийн тэгш эрхийн зарчим, түүний хэрэгжилтэд дүгнэлт хийг асуудалд өөр хандлага шаардлагатай байна гэж үзээд, ялангуяа феминизмийн үзэл санаагаар жендерийн тэгш эрхийн зарчимд хандах нь эргээд жендерийн тэгш эрхийн зарчмын ач холбогдлыг серөг үнэлэх хандлага нийгмэд бий болоход нелөөлөх магадлалтай гэсэн санааг дэвшиүүлсэн болно. Өгүүллийн хэмжээ. тавьсан зорилго хязгаартай

тул Эмэгтэйчүүдийг Алагчлах Бүх Хэлбэрийг Устгах Тухай Конвенцийн 5 дугаар зүйл болон Монгол улсын Засгийн газраас бэлтгэсэн 8 ба 9 дүгээр ээлжит илтгэлийн Сүүдэр илтгэлийн 1.2.1 дүгээр зүйлийг онцлон авч үзсэн гэдгийг тэмдэглэе.

ОРШИЛ

Жендерийн тэгш эрх ба феминизмийн тухайд олон улсын эрх зүйн баримт бичиг болон хүний эрхийн талаарх ном зохиолд ихэнхдээ ижил агуулгаар тодорхойлж ирсэн боловч өөрөөр үзэх хандлага ч хүчтэй яригдах болсон байна. Энэхүү “өөр” үзэл баримтлалын талаар өгүүлэлд тайлбарлахыг зорино.

Жендер гэдэг үг нь 14 дүгээр зуун хуртэл Латин хэлний дүрэмд нэр үгийг эр, эм, саармаг хэмээн ангилах дүрмийг нэрлэж байгаад явваандaa хүний биологийн эр эм хүйсийг заахад нэвтэрч эхлээд олон зууны турш энэ үгийн хэрэглээ хязгаарлагдмал хүрээнд байсан байна. Орчин үеийн нийгмэд хүний эрх, эмэгтэйчүүдийн эрх хүчтэй яригдаж ирсэн үес буюу 1940-аад онос sex ба gender гэсэн үгийн ялаанд илүүтэй анхааралт хандуулж иржээ. Одоо бол хүн биологийн амьтан болохын хувьд эр ба эм хүйс гэж ангилсныг sex гэж харин нийгмийн амьтан болохын хувьд эргэйтэй ба эмэгтэй хүн гэж ангилсныг gender гэж нэрлэх тухайд нэгээнт хэшин тогтжээ. Энэхүү өгүүллийн эхний хэсэгт дээрх ангиллыг феминизм ба жендерийн асуудалтай холбон тайлбарлахыг оролдох ба гарах дүгнэлт нь өгүүллийн дараагийн хэсэг буюу CEDAW-ийн үзэл баримтлалд шүүмжлэлтэй хандах байр суурийг нотлоход холбон авч үзэх юм.

ФЕМИНИЗМ БА ЖЕНДЭРИЙН ЗАРЧИМ

Социологийн шинжлэх ухааны дүгнэлт гаргалгаанууд нь эргтэй хүн тэр дундаа цагаан захт, дундаж боловсролтой европ эргтэй хүнд тулгуурлан хийгдсэнтүйлээгээдийн нийгэм, социологийн асуудлыг тусгаж чадаагүй өрөөсгөл ба ийм дүгнэлт гаргалгаанууд үзэн байж чадахгүй тул өөрчлөх ёстой гэсэн шаардлагыг феминист судлаачид тавьж байв¹. Ийнхүү цэвэр эмэгтэйчүүдийн байр сууринасаа тэдний нийгмийн асуудалд эрчүүдийг сергүүлэн хэлэлцэх болсон ба энэ нь 20 дугаар зууны эмэгтэйчүүдийн амьдрал, сэтгэлгээ, хүснэг мөрөөдөл дэвшил авчирсан онц сонирхолтой үйл явдлууд нийгмдэг давалгаалах эхийг тавьжээ. Тухайлбал, их сургуулиуд, судлаачид феминизмийн төрөл бүрийн онолыг санал болгож, 1960-аад онд барууны өртөнцөд секс хувьсгал эздин засаг, улс төр, нийгмийн бүхий л салбар нөлөөлж эхлэсэн нь дэлхийн бусад өнцөг буланд ч давалгаа нь хүрч байсан билээ.

Тэгвэл хүний эрхийн үзэл санаа анх дэлгэрсэн гэж үздэг барууны нийгмдэг эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурь, нөхцөл байдал билдний төсөөлж байдгаас ч доогуур байсан байдаг. Аливаа зүйл байх ёстой хэмжээнээсээ хит халивал мөн тийм хэмжээний серег үр дагавар авчирдаг. Хүний эрх, эрх чөлөөг аль 13 дугаар зуунд Англид Их Харт, 1679 онд Хебеас Корпус, Францад 1789 онд Хүний болон иргэний эрхийн тунхаглал, АНУ-д 1791 онд Хүний эрхийн Билл зэрэг нэр алдар нь түгсэн эрх зүйн бичиг баримтуудаар анхлан тунхагласан гэж бид мэдэх ба ардчилал, хүний эрхийн сонгодог эхлэл хэмээн суралцдаг билээ. Гэвч эдгэрэрх зүйн баримт бичгүүд нь эмэгтэйчүүдийн эдлэл эрх, эрх чөлөөний хувьд үл гүйцэлдэх, хоссон зүйл байсан юм. Бодит байдалд эмэгтэйчүүдийн гэр бүлдээ, нийгмэд эзлэх байр суурь маш суп, эмэгтэйчүүдийг дорд үзэх явдал

нийгмийн сэтгэл зүйд гүн бат суусан, тер, шашны институт нь ийм үзэл болдлыг дэмжэдт байснаас барууны нийгэм дэх эмэгтэйчүүд хүний заргат вөрсдүүгээ тооцуулахын тулд хамгийн хатуу ширүүн, удаан хугацааны тэмдлийг өрнүүлсэн юм. Үүнийг бид дундад зууны үеийн шулмын анггуулчалас эхлээд 18 дугаар зүн хурталь нийтлэг эрх зүйн тогтолцонон шүүхэд хэрэглэж байсан “Эрхийн хурууны дүрэм” гэгчээс харж болно. Хүний эрхийн үлгэр жишээ болдог барууны нийгэмд ийм дүрэм үнэхээр байсан эсэхтэй эргэлзэх явдал байdag ч тухайн үеийн шүүхийн шийдвэрт баримтжин үлдээж, Жишиэ нь 1874 онд Хойд Каролинагийн шүүхээр State v. Oliver хэргийг шүүсэн шүүхийн шийдвэрт (*North Carolina Reports*, Vol. 70, Sec. 60, p. 44). Нехэр нь эхнэрээ саваадан шийдэх эрхтэй бөгөөд савааны өргөн гарын эрхийн хуруунаас өргөнгийг байх ёстой гэсэн хуучны бурангийг хуулийг Хойд Каролинад хэрэглэхээс татгалзаж шийдвэрээв.” гэсэн байdag². Тухайн үеийн нийгмдэг эмэгтэй хүн эрх зүйн хариуцлага хулээх чадаа субъектэд тооцогдохгүй, нехрийн асрамж хамгаалалтад байх, түүний эмчийн нэг хэсэг мэтээр үзэж ирсэн тул эхнэрийн өмнөөс нехэр нь хариуцлага хулээх нь зүй ёсных байв. Иймд аливаа зүйл бус зүйлээс сэргийлэх үүднээс эхнэрээ шийтгэн арга хэмжээ авах эрхийг хууль ёсоор нехэр нь ергэд байсан нь эрхийн хурууны дүрэм гэдгээр түүхэнд үлдсэн байна. Энэ дүрмийн дагуу эхнэрээ нехэр нь зодож шийтгэх эрхтэй ба харин зодоо савааны өргөн нь эрхийн хурууны өргөнөөс хэтрэхгүй байх ёстой ажээ.

Шүүхийн энэ бурангийг жишигийг тухайн үеийн шог зурагт ийнхүү дүрслэсэн байdag³.

² North Carolina-Violence women. <http://www.europrefam.org/contr/2_04_en/en-viol/28en_vio.htm>

³ Шог зурган дээр. Эхнэр: “Алуурчин! Бурхны бодаж авраач!”. Нехэр: “Алуурчин гэнээ? Энэ бол хууль өвлөгүүн миний! Миний эрхийн хуруунаас өргөнгүй байна! Зүргийн өмнө хасгат шүүчгийг томоор дурсалжээ. Тэрээр тэртээ 2 багц даваа барьсан байх ба даваа бүрийн тогтолцэхийн зурагт хүснэгтэй хүн байна уу? Танай гэр бул өвлийн шанийн зурагтай интэрьераах зүйл наадад байна шуу. Хэн авах вэ?”

¹ Жишиэ нь энэ талбар Feminist theories. pdf. https://www.zadernib.com/sites/default/files/upm-binaries/38628_7.pdf эмхэтгэл Dorothy E. Smith Feminism and Marxism. 1977 номоос эшлен втгүүлсан.



Зураг 1 Америкийн нэгэн хэвлэлд гарч байсан Шүүгч ба эрхийн хуруу гэдэг зураг. 1782 он.

Зураг 2. Бид үүнийг чадна. Америкт феминизм ид дэлгэрч эхэлж байсан чөйчин үзэл суртын ухуулах хуудас. 1944 он

13 дугаар зуунд эрэгтэйчүүдийн хууль ёсоор эдэлж эхэлсэн хүний

эрх, эрх чөлөө эмэгтэйчүүдийн хувьд зарим газартай дөнгөж 20 дугаар зууны дунд үе гэхэд (францад тухайлбал эмэгтэйчүүдийн сонгууль өгөх эрх 1944 онд хууль ёсны болсон) биеллээ олноос харвал үнэхээр зууны зууныг дамжсан тэмцэл байжээ. Ийнхүү шашин, төрийн уламжлалт хандлага, түүхэн нөхцөл байдлаас шалтгаалан барууны нийгэм феминистүүдийн тэмцэл өрнөсөн өлгий нутаг нь болж, онолын үзэл баримтлалууд ч тэнд үүсэн бий болсон нь тийм ч гайхалтай зүйл биш бөгөөд цаашид дэлхийн бусад өнцөг булан бүрт эмэгтэйчүүдийн эрхийн асуудал түгэн дэлгэрэхэд гол нөлөө үзүүлжээ.

Феминизмийн оночид эдийн засаг, хууль эрх зүй, эрүүл мэнд, социологи, улс төрийн үүднээс гэх мэтийлэн тодорхой шинжлэх ухааны салбарыг суурин болгон онолын янз бүрийн чиглэлийг боловсруулж иржээ. 1940-1980 аад оны хооронд феминизм борооны дараах меөг мэт олон урсгал чиглэлээр гарч ирсэн байдаг. Зөвхөн улс төрийн чиг баримжаан дээр боловсруулсан феминизмийн үзэл баримтлал гэхэд л либерал феминизм, радикал феминизм, марксист феминизм зэрэг урсгалаар өөрдийн гол төлөөлөгчдийн онолыг дэлгэрүүлсэн юм.

Феминизмийн онолын урсгал олон янз боловч хүний эрхээс зөвхөн эмэгтэйчүүдийн эрхийн асуудлыг салангид авч үздэг өрөөсгөл хандлага нийтлэг ажилгадаг. Феминизм дэлхийн өнцөг булан бүрт ямар нэг хэмжээгээр түгэн дэлгэрч эцэстээ НҮБ-аас 1981 онд CEDAW буюу "Эмэгтэйчүүдийг алгачлах бүх хэлбэрээс ангид байлагх тухай конвенц" (цаашид өгүүлэлд "Конвенц" хэмээн товчилно) батлагдсан нь оргил үе нь болжээ. CEDAW-г сурталчилдаг „жендэрээр мэргшсэн“ хүний эрхийн байгууллагууд, судлаачид CEDAW-г жөндэрийн тэгш эрхийн зарчмыг хангах баримт бичиг гэж конвенцийн биелэлтэд хяналт тавих, зөвлөгөө өгөх зэрэгээр ажилладаг боловч үүнтэй санал нийлэхэд учир дутагдалтай. Тухайлбал конвенцод

„Gender“ гэсэн үгийг огт хэрэглээгүй байдаг. Энэ нь 1980-аад онд жендерийн тэгш эрхийн зарчмыг одоогийн хэмжээнд авч үзэх нехцел бүрэлдээгүй байсны нэг нотолгоо бөгөөд зөвхөн эмэгтэйчүүдийн эрхийн асуудлыг л онцгойлон тусгах нь Конвенцийн зорилго байсан гэж үзж болох юм. Түүнчлэн Конвенцийн удирталт хэсэгт хүний эрхийг тунхагласан олон улсын зохицуулалтууд үр дүнтэй хэрэгжихгүй байгаа бөгөөд шалтгаан нь улс орнууд одоог хүртэл эмэгтэйчүүдийн эрхийг хүлээн зөвшөөрч, хууль тогтоомждоо тусгах явдал хангатгүй байгаа тул энэ асуудлыг онцгойлон авч үзэх шаардлагын үүднээс “эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахын эсрэг бүх хэлбэрийг устгах” зохицуулалтыг санаачлан баталж байна гэж тэмдэглэсэн байдаг нь мөн л жендерийн тэгш эрхийн зарчмын орчин үеийн агуулга конвенцод тусгагдаагүйг нотолдог.

Харин Конвенц батлагдсанасаас хойш хориод жилийн дараа л эмэгтэйчүүд төдийгүй эргэгчийн эрхийн зөрчлийг адил авч хэлэлцэх ёстой ба үүнийг жендерийн тэгш эрхийн зарчмаар тайлбарлах ёстой гэдэгт, судлаачид санаалаа илэрхийлэх болсон юм. Ялангуяа эргэгчийн дүйн бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөрийн нехцел, насжилт зэрэг асуудлаар жендерийн эрх нь зөрчигдэх байгаа талаар судлаачид авч хэлэлцэх болов⁴. Тэр байтугай феминизмийг эсэргүүцэгчид эргэгчийн тэгш эрхийн асуудлыг олон улсад бодлогын хэмжээнд яригдах болсон нь 2000 оны эхэн үесэс гэж үздэг⁵. Тухайлбал, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр 2003 оноос жендерийн тэгш эрхийн асуудлаар “жендерт сууриссан хөгжлийн индекс”, “Жендерийн тэгш эрхийг хангах арга хэмжээ” зэрэг

⁴ R. W. Connell "Change among the Gatekeepers: Men, Masculinities, and Gender Equality in the Global Arena" from Signs: Journal of Women in Culture and Society, Vol. 30, no. 3, p. 1801-1826.

⁵ Feminist and gender theories. pdf. <https://www.sagepub.com/sites/default/files/upm-binaries/38628_7.pdf>

статистик судалгаанд үндэслэн эргэгчийүүдийн эрх зөрчигдэх байгаад нухаатай анхаарал хандуулж эхэлсэн байдаг. Эндээс харвал эргэгч ба эмэгтэй хумусийн хамтын, харилцаан хамааралтай, заавал зохицон амьдрах биологийн болон нийгмийн хэрэгцээ шаардлагыг дуту үзэж зөвхөн нэг хүйсийн эрхийн асуудлыг хөндөж байсан нь явваандаа феминизмийн үзэл санаа супарч, жендерийн тэгш эрхийн зарчим түлхүү хөгжих хандлага олон улсын хэмжээнд бий болж байгааг анзаарч болохоор байна.

Феминизм ба жендерийн тэгш эрхийн зарчмын ялгааг жэл зүйн үүднээс харьцуулсан бяцхан дүгнэлт өгүүллийн дараагийн хэсэг буюу Конвенцийн талаарх шүүмжлэлт байр суурийт танилцуулахад гүүр болж болох юм. Англи хэлээрх эх сурвалжуудад биологийн хүйсийг тэмдэглэхдээ “эр, эм” гэж ганц төонд харин жендерийн агуулгаар эр эм хүйсийг тэмдэглэхдээ “эргэгчийд, эмэгтэйчүүд” гэж олон тоогоор илэрхийлсэнтэй таардаг⁶. Сонирхолтой нь Монгол хэлэнд ч хүйс хоорондын биологийн харилцааг жишиг нь эр эмийн явдал гэж цөөн тоонд хэлдэг бол нийгмийн харилцаанд тухайлбал эрхийн тухай ярихад эр, эмийн эрэг гэхэгийн харин эмэгтэйчүүдийн эрх, эргэгчийн эрх гэж олон тоогоор ялгаатай илэрхийлдэг. Аливаа шинжлэх ухаанд ойлголт, ухадаахун нь логик зөрчилгүй нэр томъёогоор илэрхийлэгдэх байж сая утга агуулга нь бүрэн илэрхийлэгдэн. Тэгвэл эр ба эм, эргэгчийд бай эмэгтэйчүүд гэсэн томъёолол феминизм ба жендерийн тодорхойлолтод ямар агуулгыг авчирч болох вэ гэдэг асуулт сонирхолтой юм.

Биологийн үүднээс эр ба эм хүйсийн харилцаа нь хувь хүн буюу нэг талаас эр хүйстэн нөгөө талаас эм хүйстэн эсвэл эхнэр ба нөхрийн хооронд байх тул уг харилцаанд оролцогчид (үүнийг хүйсийн дотогшоо харилцаа гэе) угаас ганц тоогоор илэрхийлэгдэх боломжтой. Иймд эр, эмийн хоорондын харилцаа ямар байвал зохистой эсэх тухайд төрөөс

⁶ R.W.Connell. <http://www.sagepub.com/sites/default/files/upm-binaries/38628_7.pdf> page 316

тогтоосон хууль тогтоомж гэхээсээ илүү тухайн үндэстний ард түмэн өөрсдийн ахуй, соёл, ёс суртахуул, уламжлал, заншлын хүрээнд хэрхэн үнэлж цэгнэдэг тэр л хэм хэмжээ үйлчлэх нь зүй ёсны юм. Жендерийн агуулгаар хүйсийг олон тоогоор илэрхийлж байгаа нь аль нэг эр ба эм хүмүүсийн хувь харилцаа биш (тухайлбал эхнэр ба нөхөр гэсэн 2 субъектээс бүрдэх эсрүүлийн харилцаа) харин илуу олон тоонд, илуу өргөн хүрээнд нийгмийн харилцаанд орж байгаа эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн харилцааг (үүнийг хүйсийн гадагшaa харилцаа гэе) тэмдэглэх тул хэл зүйн хувьд олон тоогоор илэрхийлэх нь логик авцалдаатай байна. Тээвэр ийм олон талт харилцааг зан заншлын хэм хэмжээнээс илүүтэй төрөөс тогтоосон заавал биелүүлх, норматив хэм хэмжээгээр зохицуулах хэрэгцээ шаардлага байх нь мэдээлж. Эндээс феминизмийг дэмжигчид ба эс дэмжигчдийн зөрчлийн шалтгааныг олж харж болно. Өөрөөр хэлбэл феминистүүд хүйсийн дотогшоо харилцааг хууль тогтоомжийн хэм хэмжээгээр зохицуулах оролдлого хийнсээрээ жам ёсны хэм хэмжээг зөрчихдэд хүрдэг бөгөөд энэ нь болдит байдалд нийцэхгүй олон тооны зөрчлийг үсгэдэг. Үүний тод илрэл нь CEDAW бөгөөд гэр бүлийн уламжлалт харилцааг эвдэх, соёл, заншлын хэм хэмжээнд нөлөөлөх серегүүр дагавартай гэсэн шүүмжлэлд өртдөг. Энэ талаар бид өгүүгүйлийн дараагийн хэсэгт авч үзэх болно.

КОНВЕНЦИЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ШҮҮМЖ

1948 онд батлагдсан Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг дэлхийн улс орнууд хүлээн зөвшөөрснөөр эрэтэйчүүд ба эмэгтэйчүүдийн тэгш эрхийн зарчмыг олон улсын хэмжээнд анх хүлээн зөвшөөрч, өргөн дэмжилгийг хүлээжээ. Үүний дараагаар НҮБ-аас 1975-1985 оныг эмэгтэйчүүдийн 10 жил болгоюн зарласан нь эмэгтэйчүүдийн эрхийг онцгойлон авч үзэх үүнтэй зэрэгцэн феминизмийн үзэл санаа онол академик түвшинд өргөн хэлэлцэгдэх үндэс болжээ. Яг энэ үеээр

"Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц" батлагдсан байна.

Конвенцийг тухайн үеийн "хөрөнгөтөн" нийгмээс санаачлах шалтгаан нь хувь хүний эрх чөлөөг гэр бүлийн уламжлалт харилцаанаас илүүд тавих либерал үзэл суртлыг ашиглан капиталист-глобализмыг дэлгэрүүлэх улс төрийн зорилго байхыг ч угүйсгэхгүй гэж зарим улс төр судлаачид тэмдэглэсэн байдал. Мөн Конвенц батлагдсан цаг хугацаа нь социализмын үзэл суртал оргилдоо хүрсэн буюу 1981 он бөгөөд эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш эрхийг улс төрийн зорилгоор хөхүүлэн сайсаах нь наамын үзэл суртлын нэг зэвсэг байсан. Тухайн үеийн БНМАУ бусад социалистлагерийн улсуудын адил Конвенцийг талархалтай хүлээн авсан юм. Ийнхүү конвенцийг сайсаах нь хүйтэн дайны үеийн хоёр лагерийн өрсөлдөгч улсууд хүний эрхийн чиглэлээр нийтлэг олдот амжилтаа батлан харуулах тедийгүй үзэл суртал, улс төрийн ашиг сонирхлын хувьд алж алинд нь ашигтай байсан бололтой. 1980 оны 7 сар гэхэд 64 улс Конвенцод нэгдэн орох гарын үсгээ зурсан бол 1981 оны 9 сар гэхэд 20 улс Конвенцийг соёрхон баталсанраа хучин төгөлдөр хэрэгжих эхэлжээ. Уг конвенц нь НҮБ-ын хэмжээнд хүний эрхийн конвецуудаас хамгийн хурдан хугацаанд хүчин төгөлдөр болж батлагдсан конвенц болж түүхэнд орсон билээ¹.

КОНВЕНЦИЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ШҮҮМЖ

Конвенцийн заалтуудыг ерөнхийд нь норматив хэм хэмжээг өөрчлөх, уламжлал, заншлын хэм хэмжээг өөрчлөхийг шаардсан хэмээн ангилан харж болох юм. Конвенцийн шаардлагад нийцүүлэхийн тулд хуучин хэм хэмжээг өөрчлөх эсвэл шинээр хууль тогтоомж гаргах арга замыг улс

¹ United Nations Entity for Gender Equality and the Empowerment of Women. Short history of CEDAW convention <http://www.un.org/womenwatch/daw/cedaw/history.htm>

орнуудад үүрэг болгохээ⁸. Хуулийн заавал биөлүүлэх хэм хэмжээтээр зохицуулах боломжгүй тухайн улс үндэстний ахуйн ба соёлын түвшинд гүн бат суусан байдаг гэр булийн уламжлал, ёс заншлын хэм хэмжээг өөрчлөх хууль тогтоомж мөрдүүлэхийг шаардсан конвенцийн зүйл заалтыг буруушаан судлаач эрдэмтэд үзэл бодлоо илрхийлсээр ирсэн юм. Тэд шашин шутгалг ба соёлын хувьд өөр өөр боловч шуумжлэх асуудалд нэг байр сууртай байгаа нь нэгийг өгүүлдэг.

АНУ-ын судлаач Др. Жанис болон Др.Вэнди нар⁹ “Энэхүү конвенцод нэгдэх нь Америкийн нийгэм дэх гэр булийн хүрээний буюу л асуудалд нөлөөлж эхэлнэ. Гэр булийн эр эмийн хооронд байх ёстой ялгааг угстахын тулд тухайн улсын хууль тогтоомж, ёс заншлыг өөрчлөх тухай заалтууд нь гэр булийн амьдралд хор хоирол үзүүлэх төдийгүй эзэг эхийн үүрэг, шашны зан үйлээ чөлөөтэй хэрэгжүүлэх эрх чөлөө ... түүнчлэн АНУ-ын Үндсэн хуулиар олгогдсон өөрөө өөрийгөө тодорхойлох (the right of self-determination) эрхийг ч мөн угүйгүйсэх юм. Ийм учраас АНУ конвенцийн гишүүн болох ёсгүй” гэж өгүүлсэн байдаг. Тэд мөн НҮБ-ын “Жендерийн зөвлөх”-үүд засгийн газарт тэдгээрийн гар хөл болох нөхцүүдтэй нийлэн Америкийн социал бүтцийг өөрчлөх оролдлогуудаа чөлөөтэй гүйцэтгэх аюул занал үүснэ хэмээн нэлээн хатуу, илэн далангуй шүүмжлэлийг илэрхийлжээ. Өөр нэг жишээ. Исланд улс конвенцод нэгдэн ороогүй улсын нэг. Исландын хүний эрхийг хамгаалах соён гэгээрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг цахим хуудсанд мэдээллийн зорилгоор

⁸ Тухайлбал, конвенцийн оршил хэсэгт “эрэгтай, эмэгтэйчүүдийн хооронд бүрэн тэгш байдал тогтоохын түдүү нийгэм болон гэв бүрдээгүйчүүд, эмэгтэйчүүдийн уламжлалт үүргэг өөрчлөлт оруулах шаардлагатайг хүлээн зөвшөөрөх тухай онцгойлон дурдаад Нэгдүгээр хэсгийн 2 (f) залварт эмэгтэйчүүдийг алгассан хууль, зохицуулалт, заншил, дадллыг өөрчлөв буюу хүчингүй болгох талаар зохицтийн бүх арга хэмжээ, үүний дотор хууль тогтоо арга хэмжээг авахыг үүрэг болгохээ.

⁹ (Janice&Wendey ,2010) Makia G. A. Himat. Sociological Approach to the Convention on the Elimination of All Forms of Discrimination against Women (CEDAW) (Critical – Comparative - Study). International Journal of Gender and Women's Studies December 2015, Vol. 3, No. 2, p. 120-137.

хувийн болон гэр булийн эрхийг хүндэтгэх, хамгаалах талаарх олон улсын зохицуулалтыг жагсаасныг доор хүснэгтээс харж болно.¹⁰

Relevant human rights treaties

Article 18 African Charter on Human and Peoples' Right,

Article 10 African Charter on the Rights and Welfare of the Child

Article 11 American Convention on Human Rights

Articles 8 and 12 and Protocol 7 to the European Convention for the Protection of Human Rights and Fundamental Freedoms

Articles 17 and 23 International Covenant on Civil and Political Rights

Articles 10 and 16 Convention on the Rights of the Child

Article 14 Convention on the Protection of the Rights of Migrant Workers and Members of their Families

Other relevant instruments

Articles 12 and 16 Universal Declaration of Human Rights

Article 5 American Declaration of the Rights and Duties of Man

Жагсаалтад¹¹ CEDAW-г оруулаагүй нь тохиолдлынх биш бизээ Эндээс Исланд улс хүний эрхийг дэмжэдэг, ардчилсан углэр жишээ орон хэдий ч CEDAW-г гэр булийн эрхийг камгаалсан зохицуулалт гэдэг талаас нь дэмжихгүй хандлага байгааг харж болож,ч.

Арабын ихэнх улсууд конвенцод анхнаасаас шүүмжлэлтэй хандаж ирсэн байдаг бөгөөд тэд уламжлалт гэр булийн соёл, заншил, шашны хэм хэмжээг угүйсгэж байгаа нь конвенцийн дутагдалтай тал гэж үзсэн байна. Эрэгтэй эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй байх нь исламын шашны үнэт эзлийн нэг үндэс юм. Тэд шашны үүдлийээс ч эрх зүйн үүднээс ч тэгш байна тэдгийг тэнцүү байх гэдгээс ялгаж ойлтийг нь зүйтэй гэсэн өвөрмөц дүгнэлтийг

¹⁰ Здэээр ОУ-ын гарээз конвенцийн дийлэнх нь Монгол халига орчуулагдаагүй тул сонирхсон хүн Англи халинаас олж үншижад дөхөмтэйг бодож орчуулагдаж тавьсан болно.

¹¹ Icelandic Human Rights Centre <[http://www.humanrights.is/en/human-rights-education-project/comparative-analysis-of-selected-case-law-echr-achr-hrc/the-right-to-respect-for-private-and-family-life](http://www.humanrights.is/en/human-rights-education-project/comparative-analysis-of-selected-case-law-echr-achr-hrc/the-right-to-respect-for-private-and-family-life>)

хийсэн байдаг¹².

Нэгдэн орсон бусад улсуудын хувьд нэлзэн зүйл заалтад, үүний дотор Конвенцийн 2, 9, 11, 15, 16, 29 дугаар зүйлүүдэд ихэвчлэн өөрсдийн тайлбарыг (reservation) хийсэн байдаг. Харин Конвенцийн зөвлөлөөс ялангуяа 2 ба 16 дугаар зүйл нь Конвенцийн гол зохицуулалт тул ийнхүү тайлбар хийх явдал нь Конвенцийн зорилгод нийцэхгүй байна гээд эдгэр зүйлүүдэд тайлбар хийх явдлаас аль болох тайлсхийх, хийсэн тайлбараа эргэж харах, буцаах татахыг зөвлөсөн байдаг. Эндээс харвал тайлбар хийн нэгдэн орсон улс орнуудын хувьд ч гэсэн Конвенцийн гол гэх зохицуулалтыг дэмжээгүй байр сууринаас хандсан байна. Харин шуумжлэгч судлаачдын хувьд Конвенцийн 5 дугаар зүйл голчлон анхаарал хандуулдаг.

5 дугаар зүйл. Оролцогч улсууд дараахаар хоистих бүр арга хэмжээг хэрэгжүүлнэ: (a) аль нэг хийсийн доорх, эсхүл дээрээ үзэх, эсхүл эргэгтэй, эмэгтэйчүүдийн үүргийн талаарх хэвээнд тунгуурласан хоирхолтой үйл ажиллагаа, заншил болон бусад бүх дадлыг устах зорилгоор эргэгтэй, эмэгтэйчүүдийн зан төлөвлөн нийгэм, соёлын хэв шинжийг вөрчлөх; (b) гэр бүлийн боловсролд эх үүн байгыг нийгмийн үүргэд хэмээн зөвөр ойлгох, хүхдийг есөн хүмүүжүүлэх, хөгжүүлэхэд эргэгтэй, эмэгтэйчүүд хамтын хариуцлагыг хүлээн зөвшөөрөхжүүлэх, бүх тохиолдолд хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэрүүнд тавих.

Судлаач Makia. G. A. Hirata, Janice Ba Wendey¹³ нар үзэхдээ энэхүү 5 дугаар зүйлийн эргэгтэй ба эмэгтэй хүмүүсийн нийгэм, соёлын хэв шинжийг вөрчлөх гэж заасанд онцгой анхаарал хандуулах

¹² Makia G. A. Hirata. Sociological Approach to the Convention on the Elimination of All Forms of Discrimination against Women (CEDAW) (Critical – Comparative – Study). International Journal of Gender and Women's Studies December 2015. Vol. 3, No. 2. p. 120-137.

MUSAWAH CEDAW and MUSLIM FAMILY LAWS In Search of Common Ground. <http://www.peacewomen.org/assets/file/Resources/NGO/wps_cedawandmuslimfamilylaws_march2011.pdf>

¹³ Makia. G. A. Hirata. Sociological Approach to the Convention on the Elimination of All Forms of Discrimination against Women (CEDAW) (Critical – Comparative – Study). International Journal of Gender and Women's Studies December 2015. Vol. 3, No. 2. p. 120-137. MUSAWAH CEDAW and MUSLIM FAMILY LAWS In Search of Common Ground <http://www.peacewomen.org/assets/file/Resources/NGO/wps_cedawandmuslimfamilylaws_march2011.pdf>

ёстой юм гэжээ. Энэ нь эрэгтэй ба эмэгтэй хүйсийн ялгаатай байх байгалиас заясан тэрхүү гайхамшигт зохицлыг үүгүйсгэх агуулгатай. Мөн гэр бүлд эх хүн байх нийгмийн төдийгүй биологийн хосолмол үүрэг хариуцлагыг дан ганц нийгмийн хариуцлагыг хэмээн салангид тодорхойлсон нь эцэстээ уламжлалт бус гэр булийн харилцааг (ижил хүйтэн гэр бүл байх ба ийм гэр бүл хүүхэд үргэлэн авах гэх мэт) илтгэд дэмжих зорилготой байна гэж үзээхэр байна. Хүн төрөлхтний олон зуун жилийн уламжлалт сэтгэлгээ болон дэлхийн аль ч шашин нийтлэг хүлээн зөвшөөрдэг ойлголтоор бол тэр бүл гэдэг нь эргэгтэй ба эмэгтэй хүмүүсийн хамтын амьдралын хэлбэр бөгөөд хүүхэд ийм гэр булийн ур амьсгалд есэн торних нь тэдний эрх ашигт хамгийн их нийцэх юм. Иймээс энэхүү заалт нь хүн төрөлхтний жам ёсны амьдралыг аажмаар вөрчлөх, энэ үйлдээ хуульчлах гэсэн оролдлого гэж дээрх судлаачид дүгнэсэн байдаг.

Дээрх 5 дугаар зүйлийн утга агуулгад Монгол улсын зүгээс ямар нэгэн тайлбар хийгээгүй бөгөөд Конвенцийг хүлээн зөвшөөрсөн эхийн оруудын нэг байсан нь өмнөх хэсэгт өгүүлсэнчлэн улс төр, үзэл суртын нөлөө байсных бизээ. Харин даяарчлах бас дангаарчлах үзэл хамтдаа бие биенээ нөхөн аль зөв хувилбарыг эрэлхийлэх боломж нээлттэй энэ үед Конвенцийн утга агуулгыг Монгол улсын хүний эрх, эмэгтэйчүүдийн эрхийн талаар хурсэн тувшинд нийцүүлэн ойлгок хэрэглэх нь зүйтэй юм. Монгол Улсын шинэ үндсэн хууль 1992 онд буюу Конвенцийг соёрхон баталсны дараа батлагдсан. Жэнэдээр тэгш эрхийн талаар шууд заагаагүй Ч Үндсэн хуулийн 16.11 дүгээр зүйлд “Улс төр, нийгэм, соёлын амьдрал, гэр булийн харилцаанд эргэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хурсэн эргэгтэй, эмэгтэй хоёрьн тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэлэн. Гэр бүл, эх няляс, хүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасан нь Конвенцийн дээрх заалттай харьцуулахад илүү өргөн хүрээтэй, нийгмийн болон гэр булийн асуудалд

илүү холыг харсан зохицуулалт болж чадсан юм. Үндсэн хуульд нийцүүлэн хүний эрхийг хамгаалах чиглэлийн суурь хуулиудыг батлан гаргасан нь ардчилсан нийгмийн том ололтын нэг болсон. Жендерийн тэгш эрхийн зарчмыг тусгасан эрх зүйн орчин хангальтай бүрдсэн байна гэдэг дүгнэлтийг саяхны нэг судалгаагаар гаргасан байна.¹⁴

Гагцхуу жендерийн тэгш эрхийн зарчмыг баталгаажуулсан өврийн улсын эрх зүйн орчинг судалж, ирэздүйг харсан оновчтой зөв онолын тайлбар, судалгаа хийх асуудал хуульч, хүний эрхийн судлаачдын дунд дутагдалтай байгаа юм. Тухайлбал, манай төрийн бус байгууллагуудын үндэсний сүлжээнээс конвенцийн хэрэгжилтийн асуудлаар Монгол улсын Засгийн газраас бэлтгэсэн 8 ба 9 дүгээр эзлэж илтгэлийн Сүүдэр илтгэлийн агуулгаас харгадж байна¹⁵. Сүүдэр илтгэлийн 1.2.1-д „Хүн амаа ёсгэх пронааталист бодлого болон эмэгтэйчүүдийг нэхэн уржихүйн хэрэгслэл мэт харх байгаа Засгийн газрын бодлого, түүний үр дагаварууд гэдэг гарчийн доор „Хүн амаа ёсгэх, төрөлтийг урамшуулах зорилгоор бэлэн мөнгө тараах, хүүхэд асрах нь зөвхөн эмэгтэй хүний асуудал гэжүүзэх хэвшил хандлагыг бэхжүүлсэн бодлого баримтлах, эмэгтэйчүүдийн нуруун дээр хөлслгүй хөдөлмөр (гэр орны болон хүүхэд асрах гэх мэт)-ийн ачаалал буюу ирж байна“ гээд „үүнээс шалтгаалан эмэгтэйчүүд албан/хөлстэй хөдөлмөрийн зах зээл дээр нэхэн уржихүйн үүрэг хариуцлагаас шалтгаалсан ялгаварлан гадуурхалтад өртөж, хүүхдээ ёсгэх болон орлого хөдөлмөр эрхэлж, олох боломжийг хослуулах, ёмчлех, нийгмийн баялгаас

тэгш хүртэх боломж нь хязгаарлагдаж, улам эмзэг, эрсдэлт байдалд орж байна.“ гэжээ.

Эндээс жендерийн тэгш эрхийн асуудалд ийм хуучирсан хандлага, узал баримтлалаар хандах нь хир зохистой вэ? Эмэгтэйчүүдийн нэхэн үржих байгалийн жам ёсны эрхийг дэмжсэн төрийн бодлогыг хэт феминист байр сууринаас тайлбарлан үүнийгээ жендерийн тэгш эрх зөрчигдэх байгаа мэтээр нотлох оролдлого нь хир зөв дүгнэлт бэ? гэдэг асуулт аянаадаа гарч байгаа юм. Үнэндээ соёлын хувьстal, улаан тарианы үе тухайн цаг үедээ үүргээ гүйцэтгэж ач холбогдол нь байхгүй болсон шиг манай улсын хувьд эмэгтэйчүүдийн эрхийг дагаар ярих нь төдийлен өндөр ач холбогдолтой биш болсон ба зарим талаар илүү чухал асуудлын ач холбогдлыг бууруулах нэхцэлийг бурдүүлж байна. Тэр илүү чухал асуудал нь жендерийн тэгш эрхийн зарчим юм. Эмэгтэйчүүд төдийгүй эрэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь, эдийн засаг, улс төр, хөдөлмөрлөх эрх, нийгмийн халамжийг хүртэх боломж гээд нийгмийн харилцааны бүхий л хүрээнд адил тэгш боломжоор хангах төрийн чиг үүргийг жендерийн тэгш эрхийн зарчим илэрхийлж байгаа юм. Энэхүү тэгш байх боломжийг хууль тогтоомжкор баталгаажуулах зайлшгүй хэрэгцээ шаардлага байдаг учир жендерийн асуудал нь төрийн үндсэн чиг үүргийн нэг болдог.

Эмэгтэйчүүдийн эрхийн асуудал улс орны түүхийн нийгмийн хөгжлийн хурсэн түвшин, түүхэн үйл явцаас хамааран тухайн нэг улсын хувьд ихээхэн ач холбогдолтой садэв, узал суртал болон тавигдаж байсныг түүхээс харх болно. Манай улсын хувьд түүхийн ийм цаг уеийг нэгэнт ардаа хийсэн гэж дүгнэж болох юм. Нүүдлийн соёлтой ард түмний ахуйд сэтгэлгээний өвөрмөц хэвшил болсон эрх чөлөөт байдлыг эрхэмлэх явдал нь нэн түгээмп тул эмэгтэйчүүдийн нийгэм, улс төрд эзлэх байр суурийг орчин үед нийцүүлэн хулээн зөвшөөрөх явдалд нийгмийн сэтгэл зүй суурин соёлтой ард түмнийг

¹⁴ Швейцарийн Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр хэрэгжсан «Монгол улс дахь жендерийн тэгш байдлын талаарх узал хандлага: Олон нийтийн тандылын судалгаа»-ны төслийн Монгол улс дахь жендерийн эрх этийн байдал, нэхцэл байдлын төвч үзлэгээ баримт бичигийн судалгаа. 2014 он.

¹⁵ МОНФЕМНИТ Үндэсний Суликаз. Эмэгтэйчүүдийг ялгаварлас гадуурхан бүх хэлбэрийг устив тухайнНҮБ-н конвенцийн хэрэгжилтийг асуудлаар Монгол улсын Засгийн газрас балтгасан 8 ба 9 дугаар заалжит илтгэлийн сүүдэр илтгэл. 2015 он. <http://ibinamet.ohchr.org/Treaties/CEDAW/Shared%20Documents/MNG/INT_CEDAW NGO_MNG_23100_O.pdf>

бодвол илүү уян хатан байжээ гэж харгадаг. Шашны нөлөөгөөр эмэгтэй хүнийг дорд үзэх бурангуй сургаал, муухар сусгийн холбогдолтой ёс заншил байсан хэдий ч нүүдэлчин түмний өдөр тутмын амьдралын хэвшилд, бодит амьдралд эмэгтэй хүний гүйцэтгэх үүргэж жам ёсоороо явагдаж байсан нь гарцаагүй. Энэхүү нүүдэлчний ёс зүй, амьдралын хэвшил дадал нь эмэгтэй хүн сул дорий, эрх мэдэлгүй байх нөхцөлийг бий болгодоггүй. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харилцан хүлээн зөвшееерсэн ажил үргийн хуваарь, ижил терлийн алжлыг нэг нь негеөгээ нөхөн хийх чадвар (бага нааснаасаа хурга ишигийн хойноос хүү охин гэлгүй бүгд гүйнэ, морь унана, аян нүүдлийн ажилд бэлгэнэ гэх мэт) эд хөрөнгийн эрх мэдэл (гол хоол хүнс мах цагаан идээгээ бэлгэх, боловсруулах, хувваафлах зэрэгт эмэгтэй хүн гол үүрэг гүйцэтгэнэ, өөрийн гэсэн өмч хөрөнгөө захиран зарцуулах, эд өгүйн өмчлөх, өвлийзэх гэх мэт)-ийн хувьд зэрэгтэй ба эмэгтэй хүмүүсийн тэгш эрхийн асуудал харьцангуй сайн нөхцөлтэй байсныг харж болно. Социологич судлаач Д.Ганхуягийн дараах дүгнэлтэй зүн хувь санал нийлэхгүй хүн байж болох боловч отг угүйсгэхгүй болов уу. Тэрээр “Гэр бүлийн барууны үнэт зүйлсийг сурталдан хүмүүс п.өөрийгөө судлаач гэж нэрлэн тогтолцун хийж байна. Гэтэл Монголын гар бул отг өөр мөн чанар бүхий ойлголт юм. Асуулт асууя. Монголчууд эхийн эрхт ёстой ю, эзгийн эрхт ёстой ю? Үүнд хэн ч хариулж чадахгүй. Бяцхан ажиглалтын судалгаагаар Монгол хүмүүсийн 70 хувь нь эхийнхээ талыг дагаж ойр дотно байдаг, 20 хувь нь эзгийнхээ талыг дагадаг, 10 хувь нь хоёр талтайгаа жигд харилцдаг юм. Хэрэв хувь хүний нийтэмшилийн үйл явц эхийнхээ талыг илүүтэй дагаж байвал түүний эхийн эрхт ёс гэж нэрлэж болох уу? Бас л хэн ч хариулж чадахгүй. Дээрх ажиглалтаас Монголын нийгэм эзгэхийн ёсыг хослуулсан ард түмэн гэх дүгнэх болох уу”¹⁶ гэж өгүүлсэн байна. Энэ мэтчилен харьцуулан дүгнэвэл ахуйн болон

сэтгэлгээний уламжлал нь монгол эмэгтэйчүүд нийгэмд эзлэх байр суурь, улс төрийн эрх чөлөөгөө орчин үеийн түүхэндээ нэн дэвшилттэй хэрэгжүүлэх үндэс суурь болжээ. Тухайлбал Монгол улсад ардын хувьсгал ялж 1924 онд анхны Үндсэн Хууль батлах маш богино хугацаанд эр ардууд хэн боловч тэгш эрхтэй бөгөөд улсыг байгуулах сонгуульд тэгш эрхтэй санал өгөх эрхийг шууд баталгаажуулсан байдал. Ийнхүү түүхэн үүднээс харвал радикал феминизмийн үеийг Монголчууд аль социализмын эхэн үед даван туулж дараагаар ардчилсан тогтолцоонд шилжих үед эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчны үндсэндээ хангаж чадсан юм. Харин одоо үед феминизмийн үзэл санаанаас илүү жендерийн тэгш эрхийн агуулгыг хүний эрхийн талаар өөрийн орны нөхцөл, хүрснэ түвшин, үндэсний сэтгэлгээгээр онолын түвшинд хөгжүүлэх нь илүү үр дүнг авчрах юм. Сүүдэр илтгэлд хөндсөн асуудалд эргэн орьё. Жам ёсны хуулийг зөрчин байж хангадах нийгмийн хэрэгцээ шаардлага гэж байж болохгүй. Жирэмсэн эмэгтэй хүүхэд төрүүлэх эсэхээ шийдвэрлэх эсэх (аборты чөвлөтэй болгох), хөхөвөв тэжээх эсэх, төрсний дараа эх хүүхдэд эцгээс нь илүү хөдөлмөр, цаг зарцуулах зэргийг жендерийн тэгш эрх зөрчигдэх, эмэгтэй хүний эрх тэр дундаа хөдөлмөрлөх эрхийг зөрчиж байна гэсэн хандлагаар хандах явдал зохисгүй бөгөөд эргээд гэр бүл, эх хүүхдийн жам ёсны эрхэд халдаж байгаа хэрэг юм. Учир нь энэ бол байгалиас эмэгтэй хүнд оногдсон жам ёсны үүргэж хариуцлага юм. Жам ёсны эрх гэж байдаг бол бас жам ёсны хариуцлага гэж байх ёстой.

ДҮГНЭЛТ

Энэхүү өгүүллээр нэгдгээрт жендерийн тэгш эрхийн зарчим нь хүйсийн тэгш эрхийн онолын хөгжлийн хувьд феминизмийн дараагийн үе шат гэж үзээд хүний эрхийг хангахад илүү боловсронгуй арга хэрэгсэл болох тухайд, хөрдугаарт гэр бүлийн хүрээний асуудлыг хууль, олон улсын

¹⁶ Д.Ганхуяг: Нийгмийн тулхүүр судалгааны тухайд <<https://genzav.mn/2016/11/23/bidlikhgjfkdu/>>

хэм хэмжээгэр зохицуулахад ямар хүрээ хязгаар байж болох талаар санал, дүгнэлтээ үндэслэхийг хичээсэн болно.

Монголчуудын хүний эрх, эрх чөлөөний мэдрэмж тэдний соёл, заншил нүүдлэн амьдрах ахуягаар нөхцөлдсөн байdag ба энэ нь гэр булийн эхнэр нөхрийн харилцаа, хүлээх үүрэг хариуцлагын хувьд бүрч илүү гүн гунзгийг утга агуулгатай зохицуулагдан байdag. Ийм онцлогийг ойшион судлахгүйгээр, негэе талаар эмэгтэйчүүдийн эрхийн талаар Монгол улсын хурсэн түвшинг бодитой үнэлж дүгнэхгүйгээр жендэрийн тэгш эрхийн зарчим, түүний хэрэгжилтэд дүгнэлт хийх нь оновчтой биш байна. Ялангуяа феминизмийн үзэл санаагаар жендэрийн тэгш эрхийн зарчимд хандах нь эргээд нийгэмд жендэрийн тэгш эрхийн зарчмын ач холбогдыг серег үнэлхэх хандлага бий болоход нөлөөлж болох юм. Энэхүү өгүүлэлд CEDAW буюу Эмэгтэйчүүдийг Алагчлах Бүх Хэлбэрийг Устгах Тухай Конвенцийн агуулга түүний зүйл заалтын талаар олон улсын эрдэмтэн судлаачид шүүмжлэлтэй байр суурийг өөрийн орны нөхцөл байдалдаа харьцуулан дүгнэлт хийхийг зорив.

Гэр булийн эр эмийн хоорондох харилцаа тухайн үндэстний ёс заншил,

уlamжлал, ахуйн болон сэтгэлгээний онцлог дээр үндэслэсэн байдаг тул энэ харилцааг бухээд нь албадлагын, заавал биелүүлэх шинжтэй хэм хэмжээгэр зохицуулах боломжижүүлж юм. Энэ нь нийтлэг хэм хэмжээгэр зохицуулдаг нийгмийн харилцааны бусад хэлбэрээс өвөрмөц ялгатай, гэр булийн хүмүүсийн хооронд байж болох сэтгэл зүйн болон физиологийн хамгийн наандин дотнын харилцаанд тооцогдох байнгын, хамтын, харилцан хамааралтай байдалд байdag онцлогтой. Энэ бүх онцлогос шалтгаалан гэр булийн харилцаанд ёс, заншилын хэм хэмжээй илүүтэй үйлчилдэг хэсгийн дотогшоо Чиглэсэн харилцаа гээд харин гэр булийн гишүүд өөр бусад нийгмийн төрөл бурийн харилцаанд орж байгаа бол түүнийг гадагшах чиглэсэн гэж тодорхойлж узсэн. Ингэж ангилах нь Чухам ямар харилцааг уламжлал, заншилын хэм хэмжээнд үлдээх, ямар харилцааг заавал биелүүлэх хэм хэмжээгэр зохицуулах хүрээ хязгаарыг тоогоход ач холбогдолтой байж болох юм гасэн санааг дэвшиүүлсэн. Ийм хэмжээ хязгаарыг CEDAW-ийн зарим зүйл заалт давсан гэж үзээд олон улсын судлаач эрдэмтдийн санал, шүүмжлэлийг жишээ болгон өгүүлэлд тусгасан болно.

---00---



"Хуульчдын номын сан"-д ирсэн шинэ номын мэдээз

Монгол улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал 2016. УБ., 2017.-231 х.

Цагдаагийн ерөнхий газраас Монгол улсын хэмжээнд гарсан гэмт хэрэг, захиргааны зөрчлийн статистик мэдээг албан хэрэгцээнд зориулан эмхтгэж цувралаар хүргэдэг бөгөөд энэ эмхтгэлд 2016 оны мэдээг бэлтгэн хэвлүүлжээ.

ДИСПОЗИТИВ ЗАРЧМЫН МӨН ЧАНАР



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
магистрант С.Номынбаясгалан

ТҮЛХҮҮР ҮГ:

Диспозитив зарчим, хүсэл зориг,
субъектив эрх

ТОВЧЛОЛ:

Процессын эрх зүйн гол судлаждахууны нэг нь диспозитив зарчим юм. Энэхүү ухадахаачны эрх зүйн онолоор нийтлэг болон тухайлсан шинжээр ялан тодорхойлж агууллын хүрээнд судлах хэрэгцээ шаардлага бий болсоор байна. Сэдвийг "Диспозитив зарчмын мөн чанар" гэж томьёолон, агуултыг субъектив эрх хамгаалах асуудлаар хялзагаарласан.

I. Удиртгал

II. Нэр томьёоны тухайд

III. Диспозитив зарчмын агуулгыг тодорхойлох нь

IV. Субъектив эрх хамгаалах асуудал

V. Дүгнэлт

I. Удиртгал

Процессын эрх зүйд нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн түгээмэл үнэт зүйлсийн нэг нь диспозитив зарчим юм. Хувь

хүний эрх, эрх чөлөө болон нийтийн ашиг сонирхлын зерчилдээн дунд Үндсэн хууль зерчигдсэн эсэхийг тогтоо шалгур нь тухайн эрхийн онцлогос хамааран ялгаатай байдаг. Диспозитив зарчмын хувьд зөвхөн аль нэг тодорхой эрх, эрх чөлөө зерчигдсэн тохиолдолд бус Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөө зерчигдсэн эсэх маргааны хянан шийдвэрлэхэд хэрэглэгдэг нийтлэг зарчим юм. Гээтэл Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэхэд ажиллагаанд маргагч тал өөрийн шаардлагын үндэслэл, зүйлийг өөрчлөх, хэмжээг ихэсэж, багасгах, эсхүл шаардлагас бүхэлд нь буюу зээрийн хэсгээс нь татгалзах онцгой эрхтэй¹ хэдий ч алийг нь хураалданаа балтгэл шатанд эсвэл хураалданаа завсарлах өмнө хүртэл эдлэхийг хуульд нарийвчлан зааглаагүй. Тиймээс маргааныг иргэн болон захиргааны хэргийн шүүхийн нэгэн адил маргагч талын гаргасан шаардлагын хүрээнд л Үндсэн хуулийн цэц шийдвэрлэх үү гэсэн асуудал үүсдэг. Үүнээс шалтгаалан маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд хүндэрэл учирдаг болох нь Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээс ажиглагддаг.² Түүнчлэн иргэд өргөдөл, мэдээллийн шаардлагаасаа

¹ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тukай хуулиин 18 дугаар зүйлийн 4 дахь хэсэг хуулийнгэдэnsэн. ТМ 1997 он №06 дугаарт нийтлэгдсэн.

² Тайлбар: Энэхүү өгүүлэлд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн "шийдвэрийн нэр (Дүгнэлт, Тогтолц, Магадлал), дугаар (№), огноо (ОН, сар, өдөр), эх сурвалж (Төрийн мэдээлэлтэй, огноо, дугаар) гэсэн дарааллаар бичив. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунголтийн "МУҮХЦД", тогтолын "МУҮХЦТ", магадлалын "МУҮХЦМ", Төрийн мэдээллийн "МУҮХЦТМ" тус тус товчлон тэмдэглэв. Жишээ нь: "МУҮХЦТМ/01/1993.01.13., ТМ 1993 он №02" гэснэй "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 1 дугаар сарын 13-ны өдрийн 01 дугаар тогтолц, "Төрийн мэдээлэлтэй" эмхэгээлийн 1993 оны 02 дугаарт нийтлэгдсэн" гэж ойлгоно. МУҮХЦД№03/1998 03.27., ТМ 1998 он №05; МУҮХЦД№02/2005 03.31., ТМ 2005 он №14 дугаарт тус нийтлэгдсэн.

татгалзсанаас шалтгаалан тухайн асуудлаар шийдвэр гаргахгүй байх жишиг тогтжээ.³

Энэ нь диспозитив зарчмын үйлчлэх онцлогийг Үндсэн хуульд тунхагласан бол аяндаа хэрэгкинэ гэж үзэж болохгүй илэрхийлж байна. Тиймээс уг зарчмын агуулгыг зөв ойлгон хэрэглэх нь чухал. Ингэж онцлохын учир диспозитив зарчмын агуулгыг маргач талын эрхээр хязгаарлах бус нийтийн эрх ашигт үндэслэн тайлбарлах нь зохимжтой. Гэвч энэ зарчмын мен чанар **амьдралын бичигдээгүй хуулиар** зөрчгидэх нь бий. Энэ энд **субъектив** өөрөөс болон **объектив**⁴ бусдаас хамаарах хүчин зүйлс нелөөлж болох юм. Энэ гажуудыг арилгахад диспозитив зарчмын онолын үндэслэлийг гаргах нь нэн чухал. Тиймээс энэхүү өгүүлээр процессын салбар эрх зүй тус бүрийн онцлогт тулгуурлан диспозитив зарчмын нийтлэг агуулгыг тодорхойлохыг зорилгоо. Учир нь хувийн эрх зүйд хуулиар хориглоозуу бүхнийг зөвшөөрөх⁵ бол харин нийтийн эрх зүйд хуулиар **зөвшөөрснөөс бусдыг хориглох зарчим үйлчилдэг онцлогтой**.⁶ Түүхийн хуудсыг сөхөхөд эртний Ромд ард түмний нэхэмжлэл болох *actio popularis*(ард түмний нэхэмжлэл)-ийг ямар ч этгээд гаргаж болдог байжээ.⁷ Энэ ч утгаараа Гай, Цельз, Ульпиан нарын тайлбаруудад <<хэргийн эцсийн хувь заяаг шуух шийднэ>> гэх буюу <<нэхэмжлэгчийн хүсэл зориг нь хариуцагчид оноох шийтгэлийг тодорхойлно>> гэсэн

номлож байжээ.⁸ Энэ нь диспозитив зарчмын уг сурвалж эртнээс улбаатайг харуулж байна.

II. Нэр томъёоны тухайд

Хуулийн хэлний онцлог нь нэр томъёотой шууд холбостой.⁹ Энэ нь уг, өгүүлбэрээр дамжин илэрдэг. Нэр томъёо төвч, очижвийт, утга санаа бүрэн төгс байх нэг гол үндэс нь үгийг зөв сонжж хэрэглэх явдал юм.¹⁰ Тиймээс хууль зүйн нэр томъёог гадаад хэлнээс гадаад нэр томъёонд нутагшуулан оноон хэрэглэх эсэх сонголтыг шинээр нэр томъёо бүтээхэд баримтлах зарчмын дагуу хийх ёстой. Гэхдээ нэгэнт тогтсон хууль зүйн нэр томъёог өөрчлөх гэхээсээ илүүтэй утга агуулга, узэл санааг нь нэг мөр ойлгох нь чухал билээ.¹¹ Чухамдаа нэр томъёог нэр томъёогоор орчуулах¹² зарчмыг харгалзан узэх шаардлагатай юм.

Нийтээр хэвшсэн нэр томъёог аль болох хэвээр нь хэрэглэхийн хамт уг хэмнэх зарчмын баримтлах нь зохимжтой.¹³ Тиймээс энэхүү судалгааны ажлын судлалдахууныг диспозицийн зарчим¹⁴, диспозитив байдлын зарчим¹⁵ гэж нэрлэхийн оронд *диспозитив зарчим гэсэн нэр томъёог ашиглав. Учир нь БНМАУ-ын

³ Амарсанаа Ж. "Үндсэн хуулийн маргаан" (Анхны хэвлэл) УБ хот, 1999 он, 145 дахь тал.

⁴ Амархүү О. "Эрх зүйн онолын араван таван сэдэв" УБ хот, 2008 он, 52 дахь тал.

⁵ Амарсанаа Ж. "Эрх зүй-нийгмийн харицааг тохицуулагч" УБ хот, 1988 он, 67 дахь тал.

⁶ "Хууль зүйн нэр томъёони судалгаа, хэрэгтэй" (Улсын киймээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмзэгтэл) УБ хот, 2016 он, 73 ба 77 дахь тал.

⁷ Сергей Влахов, Сидер Флорин. "Непереводимое в переводе" Москва, 1980, С.285.

⁸ "Улсын нэр томъёоны комиссын мэдээ" Хууль зүйн нэр томъёо №107-108 (Тэргүүн дэвтэр) УБ хот, 1978 он, 5 дахь тал.

⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (Өгүүлэл, илтгэлийн эмзэгтэл) УБ хот 2007 он, 374 дахь тал. Сарантүяа Ц. "Монгол Ул дахь Үндсэн хуулийн процессын эрх зүйн үүсэл, төлөөшил, тулгуурсан асуудал" (Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл) УБ хот, 2008 он, 129 дахь тал.

¹⁰ "Процессын эрх зүй онол, туршилгаа" (Хамтын бүтээл) УБ хот, 2014 он, 181 дахь тал. "Иргэнхий хэргэ шүүхэд хянал шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрнүүд тайлбар" (Хамтын бүтээл) УБ хот, 2008 он, 37-38 дахь тал.

³ Амарсанаа Ж. "Үндсэн хуулийн маргаан" (Анхны хэвлэл) УБ, 2012 он, 247 дахь тал.

⁴ Арин Мавчин. "Үндсэн хуулийн хянват" (орч) УБ, 2014 он, 63 дахь тал.

⁵ "Эрх зүйн философи" (Хамтын бүтээл) УБ хот, 2014, 239 дахь тал. Одонхүү Т. "Эрх зүйн философи" УБ хот, 1999, 107-108 дахь тал. "Эрх зүйн философи" (Хамтын бүтээл) УБ, 1998 он, 56 дахь тал.

⁶ "Хууль дээдлэх ёс сатгуй" УБ хот, 2005 он, №01(08), 54 дахь тал.

⁷ Минийнхүүдорж Б. "Ромын хувийн эрх зүй" УБ хот, 2004 он, 159 дахь тал.

Улсын нэр томъёоны комиссоос (орос хэлнээс монгол хэлэнд) **диспозитив** гэдгийг **зөвшмэл, диспозитив; диспозитивность** гэдгийг **диспозитив чанар, зөвшлийг гэсэн бол диспозиция правовых норм** гэснийг эрхийн хэм хэмжээний диспозиции гэж тус тус ялган тодорхойлжээ.¹⁶ Тэгвэл монгол хууль зүйн толь бичигт **диспозитив** (Латин. *Dispositivus*)-ийг **сонголт хийх боломж хэмээн үглэн тайлбарласан байна.**¹⁷ Харин монгол хэлэнд **зөвшилдэх** гэдгийг олноороо зөвших, зөвлөлдөх; **зөвших** гэдгийг аливаа хэрэг явдлыг санал **солицлон, шүүмжлэн хэлэлцэх** гэсэн утгаар ойлгогдог.¹⁸ Хэдий тийм ч хууль зүйн тольд монгол болон гадаад нэр томъёо, хэллэгийг хооронд нь харьцуулахдаа “**диспозитив – дисплизитивность – dispositif**” гэж бичжээ.¹⁹ Энэ нь уг нэр томъёог нийтээр ойлгон хэрэглэж дадсн гэдгийг нотпон харуулах нэгэн жишээ юм.

Харин бусад гадаад хэлэнд (*Герман Dispositionsmaxime, Verfuegungsgrundsatz; Англи Disposition*) хэд хэдэн байдлаар нэрлэгдэн бичигдэх нь бий. Гэхдээ здэээр нэр томъёог тайлбарласан хууль зүйн толь бичгүүдийг харьцуулахад ялгаатай оруулагдсан байдал.²⁰ Зарим толь бичигт уг нэр томъёоны утга санааг шүүхийн шийдвэрт тулгуурлан гаргажээ.²¹ Тэгвэл монголхуульзүйн толь

¹⁶ “Улсын нэр томъёоны комиссийн мэдээ” Хууль зүйн нэр томъёо №107–108 (Тэргүүн дэвтэр) УБ хот, 1978 он, 51 дахь тал.

¹⁷ Нарангэрэл С. “Монголын эрх зүйн эх толь” (Дөрөв дэх хэвлэл) УБ хот, 2015 он, 669 дахь тал.

¹⁸ Цэвэл Я. “Монгол халийн төвч тайлбар толь” УБ хот, 1966 он, 278 дахь тал.

¹⁹ Монгол – Орос – Герман хууль зүйн төвч толь. УБ хот, 2013 он, 80 дахь тал.

²⁰ Монгол – Орос – Герман хууль зүйн төвч толь. УБ хот, 2013 он, 80 дахь тал. Англи – Солонгос – Монгол – Орос – Герман хууль зүйн толь. УБ хот, 2011 он, 262 дахь тал. “*Compact English – Russian and Russian – English law dictionary*” printed in Moscow, 2009, p.78. “*Compact English – Russian and Russian – English law dictionary*” printed in Moscow, 2009, p.62.

²¹ “*Stroud’s Judicial Dictionary of words and phrases*” (Fifth edition) Volume 2, D-H. printed in London, 1986, p.740–742.

бичигт²² **диспозитив** гэсэн нэр томъёог (1) эрх зүйн онолд **материаллаг ба байцаан шийтгэх ажиллагааны төрөл бурийн салбарт хэрэглэгдээг эрх зүйн зохицуулалтын веермэц аргын онцлог, гол мөн чанарын шинж; (2) эрх зүйн субъектийн сонголтоор буюу здэээр хэм хэмжээгээр зохицуулагдам байгаа харилцааг талуудын хэлэлциэрээр тодорхой болгох, тодотгох журам тогтоосон эрх зүйн хэм хэмжээний шинж чанар; (3) иргэнийн байцаан шийтгэх ажиллагааны хамгаалалтын арга хэрэглүүрийг ашиглах боломж гэж дэлгэрэнгүй тайлбарлажээ. Энэ нь бичвэрийн утга, санаа өргөн агуулгатай мөн нэгдмэл байдлаар тодорхойлох боломжтой илтгэж байна. Гэтэл зээлдсэн диспозитив гэх нэр томъёог зээлдсэн диспозиц гэсэн нэр томъёогор²³ орлуулан хэрэглэснээр эрх зүйн хэм хэмжээний бутцийн бүрдэл диспозици хэсэгтэй²⁴ андуурагдан ойлгогдох боломжтой. **Диспозици** гэсэн нэр томъёо нь эрх зүйн харилцаанд оролцогчдын зан үйлийн хэмжээ хязгаарыг заасан заалт²⁵, эсхүл эрх олгосон, үүрэг болгосон, зөвшөөрсөн, хориглосон байдлыг илэрхийлдэг.²⁶ Тиймээс нэр томъёо онож өгснөөс шалтгаалан хөёрдмөл утгаар ойлгогдох үр дагавартай.**

Эрх зүйн онопын бүтээлд **диспозитив** гэдгийг зохицуулагдаж буй харилцаанд оролцогчдын веерсдийн зан үйлийг бутгээлчээр бие даан сонгах боломж олгохоос гадна эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш байдлыг хангах гэсэн нийтлэг байдалаар

²² Нарангэрэл С. “Монголын эрх зүйн эх толь бичиг” (Дөрөв дэх хэвлэл) УБ хот, 2015 он, 178 дахь тал.

²³ “Хууль зүйн нэр томъёоны судалгаа, хэрэглээ” (Улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмзэгтэл) УБ хот, 2016 он, 35 дахь тал.

²⁴ Баярсайхан Д. “Эрх зүйн оноп” УБ хот, 2010 он, 120–121 дахь тал

²⁵ Баярсайхан Д. “Эрх зүйн оноп” УБ хот, 2010 он, 146 дахь тал.

²⁶ Амархүү О. “Эрх зүйн онопын арван таван садэв” УБ хот, 2008 он, 30 дахь тал.

оилгодог.²⁷ Энэ утгаараа судлаачид талуудын хүсэл зоригийн тэнцвэртэй байдлыг хангахад чиглэгдсэн эрх зүйн зарчим гэж тодорхойлдог.²⁸ Монгол эрх зүй судлаачид вөрсдийн бүтээлдээ “диспозитив зарчим” гэж нэг мөр буулгасан байдал.²⁹ Зарим тохиолдолд мэтгэлцэх зарчим гэж зөрүүтэй оруулагджээ.³⁰ Олон улсын эрх зүйд *jus dispositivum* (Латин. Хасн болох эрх) зөвшилцсэн хууль ёсны гэрээ хэлэлцээрээр вөрчилж болох хэм хэмжээг хэлнэ. *Jus cogens* (vs. *jus dispositivum*)-ийн эсрэг утгатай гэж үздэг.³¹ Хэдий тийм ч салбар эрх зүй бүрт адил утгаар ойлган хэрэглэгдэг нийтлэг нэр томъёо байна.

Зарим хууль зүйн тольд диспозитив зарчмыг хэргийг эхлүүлэх, шүүхээр хянан шийдвэрлүүлэх, маргааны зүйлийг тодорхойлох, маргааныг дуусгахтай холбоотойгоор талуудад голлон удирдах эрхийн хүлээн зөвшөөрөч даатгаж байгаа хууль тогтоогчийн байр суурь гэж тодорхойлжээ.³² Мен зарим тольд маргааны зүйл, түүний хүрээ хязгаарыг тодорхойлох, маргааныг дуусгахтай холбоотойгоор талуудад бие даан шийдвэр гаргах эрхийг хүлээн зөвшөөрсөн зарчим гэж бичээс.³³ Үүнээс улбаалан нэхэмжилгэчийн эрх гэж узсэн байдал.³⁴ Иргэний процессын хуулийн тайлбарт

²⁷ Нямсүрэн Ч. “Эрх зүй, терийн ерөнхий оноп” УБ хот, 2004 он, 234 дахь тал, Баярсайхан Д. “Эрх зүйн оноп” УБ хот, 2010 он, 191 дахь тал, Гантугэл Н. “Төр, эрх зүйн ерөнхий оноп” УБ хот, 1998 он, 139 дахь тал, Наранзэрэл С. “Монголын ба далхийн эрх зүйн тогтолцоо” УБ хот, 2001 он, 79 дахь тал, ... гэх мэт.

²⁸ Баярсайхан Д. “Эрх зүйн оноп” УБ хот, 2010 он, 230 дахь тал.

²⁹ Чимидж. Б. “Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн” УБ хот, 2004 он, 91 дахь тал, Эрдэнэцогт А. “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй” УБ хот, 2012 он, 29 дахь тал, ... гэх мэт.

³⁰ “Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэштэл, далхийн улсуудын жишиг” УБ хот, 2004 он, 146 дахь тал.

³¹ Виктор Кондэ Х. “Хүний эрийн олон улсын нэр томъёόны гарын авлагэ” (Боть 4) 1999 он, 90 дахь тал.

³² 法令用語研究会, 有斐閣, 第3版, 2006年, 759頁

³³ 金子宏、新堂泰司、平井 宜雄, 法律学小事典, 有斐閣, 第4版, 2008年, 661頁.

³⁴ 国解による法律用語辞典, 自由国民社, 第3版, 2009年, 78頁.

диспозитив (*dispositivus*-эзэмшиж байна, захирч байна гэсэн утгатай латин үс) байдлын зарчмыг нь тухайн хэрэгт оролцож байгаа талуудаас хуулиар олгогдсон эрх, хамгаалалтын арга хэрэгслийг вөрийн үзэмжийр ашиглах боломж гэж тодорхойлжээ.³⁵ Харин захиргааны процессын хуулийн тайлбарт шуух хэрэг маргааныг зохигчын гаргасан нэхэмжилэлийн үндсэн дээр буюу нэхэмжилэлийн шаардлагын хүрээнд шийдвэрлэхийг ойлгоно гэж тайлбарласан байдал.³⁶ Тэгвэл процессын эрх зүйн бүтээлүүдэд диспозитив гадгийг зөвшилцэх³⁷, харилцан тохиролцох / зөвшмел³⁸ гэж буулгажээ. Тэгвэл зарим бутгазд уг зарчмыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохигчдын санаачилга буюу хүсэлтийн үндсэн дээр явуулах зарчим гэж тэмдэглэжээ.³⁹ Түүнчлэн зарим судлаачид⁴⁰ “диспозитив зарчим гэдгийг зөвшилцэх зарчим хэмээн оноон нэрлэж болно” гэж үзжээ. Тэгвэл зарчим гэдэг нь латини ріпсірим

³⁵ “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн далгэрнүүгийн тайлбарт” (Хамтрын бүтээл) УБ хот, 2007 он, 37 дахь тал.

³⁶ “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбарт” (Хамтрын бүтээл) УБ хот, 2012 он, 62 дахь тал.

³⁷ Шүүгчийн гарын авлагы (Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиидыг хэрэлзэж онол арга зүй) УБ хот, 2004 он, 156 дахь тал, Менжкаргал З. “Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй” (Ерөнхий аяны) УБ хот, 2005 он, 97 дахь тал, “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” (Гарын авлагы) цуврал №10, УБ хот, 2007 он, 9 дахь тал.

³⁸ Менжкаргал Т. “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй” (Ерөнхий аяны) УБ хот, 1999 он, 4-5 дахь тал, Менжкаргал Т. “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй” (Ерөнхий аяны) УБ хот, 2004 он, 5-6 дахь тал, Менжкаргал Т. “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй” (Ерөнхий аяны) Гурав дахь хэвлэл, УБ хот, 2008 он, 6 дахь тал, Менжкаргал Т. “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй” (Ерөнхий аяны) Дээрээ дахь хэвлэл, УБ хот, 2011 он, 6 дахь тал, Эрдэнэцогт А. “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй” (Хөхбэр дахь хэвлэл) УБ хот, 2012 он, 20 дахь тал.

³⁹ Менжкаргал З. “Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй” (Ерөнхий аяны) УБ хот, 2009 он, 105 дахь тал.

⁴⁰ Оюунцаграл О. “Захиргааны процессын эрх зүйг иргэний процессын эрх зүйтэй харьцуулах нь” (Магистрын дипломын аякон) УБ хот, 2009 он.

буую үндэс, эхлэл⁴¹ гэсэн агуулгыг илрхийлсэн үгнээс гаралтай ойлголт юм. Эндээс *диспозитив зарчим гэж нэрлэн хэрэглэх нь хууль зүйн нэр томъёонд зайлшгүй тавигддаг нэгдмэл, нийтээр хулээн зөвшөөрөгдсөн, тоогтвортой байх гэсэн шинжүүдийг ханган илүү тохиомжтой байна.

III. Диспозитив зарчмын агуулгыг тодорхойлох нь

Диспозитив зарчмын нийтлэг агуулгыг процессын салбар эрх зүй тус бурийн өвөрмөц онцлогийг харгалзан судлаачдын бүтээлүүдээс тодорхойлон гаргахыг оролдоо. Тодруулбал,

Захиргааны процессын эрх зүйн бүтээлийн хувьд:

Диспозитив зарчим (*Dispositionmaxime*). Захиргааны хэргийн шүүх тухайн хэрэг маргааныг шийдвэрлэхдээ талуудын тавьсан нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд шийдвэрээ гаргана. Талууд нь нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагын хулээн зөвшөөрөх эрхтэй. Эдгээрийн алины сонгот баримтлах боломжтой байхыг диспозитив зарчим гэнэ.⁴² Энэ нь шүүхээс хэрэг маргааныг зөвхөн (1) талуудын гаргасан нэхэмжлэлийн үндсэн дээр үүсгэж; (2) нэхэмжлэлийн хүрээнд шийдвэрлэх; (3) нэхэмжлэч процессын аль чүе шаманд нэхэмжлэлээсээ татгалзах эрхтэй гэсэн утга агуулгыг илрхийлдэг.⁴³ Зарим бүтээлд нэхэмжлэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх, дуусгавар болгох бүрэн эрхийн зарчим гэсэн агуулаар тайлбарласан байдаг.⁴⁴

Харин зарим судлаачид тухайн

⁴¹ Юридическая энциклопедия, Москва, 2000, С 362.

⁴² Чимид Б “Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэжүүн” (Гарын авлагы) УБ хот, 2004 он, 91 дахь тал

⁴³ “Захиргааны хэрэг маргаан хянан шийдвэрлэх зарчим” (Гарын авлагы) цуврал №4, УБ хот, 2005 он, 33 дахь тал. Эрдэнэцогт А “Захиргааны процессын эрх зүй” (Гарын авлагы) УБ хот, 2013 он, 18 дахь тал. “Процессын эрх үйл, туршилга” (Хамтын бүтээл) УБ хот, 2014 он, 97 дахь тал ... газ мат

⁴⁴ “Гадвад орнуудын захиргааны хэргийн шүүх” (Гарын авлагы) цуврал №6. УБ хот, 2005 он, 13 дахь тал.

хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын зан үйлийн хэмжээ хязгаарыг тодорхойлж өгдөг зарчмыг хэлдэг.⁴⁵ Тиймээс диспозитив зарчим нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогоос хамаарч хариулсан адилгүй гэж үзэж.⁴⁶ Зарим судлаач энэ зарчмыг нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд шийдвэрлэх гэж үзсэн байдаг.⁴⁷ Тэгвэл нэхэмжлэлийн шаардлага нь тухайн нэхэмжлэлийн зүйл, шүүхийн шийдвэрийн хэмжээ хязгаарыг тодорхойлох бөгөөд шүүх нэхэмжлэлийн шаардлагасаа хэтэрсэн шийдвэр гаргаж болохгүй. Тиймээс нэхэмжлэгчээс тавьж буй болдит шаардлага, түүний хүсэл зориг, эрхээс хамгаалуулах гэсэн хүсэлт л гол ач холбогдолтой байхаас тухайн нэхэмжлэлийн хэлбэр, агуулгасаа хамаарахгүй гэж үздэг.⁴⁸ Диспозитив зарчим нь нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлээсээ татгалзах, эвлэрэх зэрэг хэргийн оролцогчдын эрхийн тухай юм.⁴⁹ Захиргааны процессын хуулийн дагуу энэ зарчим хэрэгждэг.⁵⁰ Учир нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим гэдэг нь шүүхээс хэргийг хянан шийдвэрлэх явцад дагаж мөрдөх, удирдлага болговол зохих үзэл баримтлал болон хуулиар тогтоосон хэм хэмжээний нийлбэр цогц юм.⁵¹

Тиймээс диспозитив зарчмын хүрээнд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад захиргааны хэргийн шүүх зэрим

⁴⁵ үндэр А. “Захиргааны хэргийн шүүхийн нотолгооны чиг үүрэг” (Магистрын дипломын ажил) УБ хот, 2010 он, 16 дахь тал.

⁴⁶ Үндэр А. “Захиргааны хэргийн шүүхийн нотолгооны чиг үүрэг” (Магистрын дипломын ажил) УБ хот, 2010 он, 17 дахь тал.

⁴⁷ “Эрх зүй сэтгүүл” УБ хот, 2010, №1–2, 30 дахь тал.

⁴⁸ “Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жижиг” УБ хот, 2004 он, 140 дахь тал.

⁴⁹ “Захиргааны хэрэг маргаан хянан шийдвэрлэх зарчим” (Гарын авлагы) цуврал №4, УБ хот, 2005 он, 36 дахь тал.

⁵⁰ “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар” (Хамтын бүтээл) УБ хот, 2004 он, 162 дахь тал.

⁵¹ “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар” (Хамтын бүтээл) УБ хот, 2012 он, 60 дахь тал.

ажиллагааг зохицдын өөрсдийн санаачилга, хүсэлтийн үндсэн дээр явуулдаг.⁵² Энэ зарчмын дагуу нэхэмжлэгч нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцаач нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, хариуцаач нэхэмжлэлийн шаардлагыг биөлүүлэх, талууд эвлэрэвэл шүүх маргааныг дуусгавар болгодог.⁵³ Энэ зарчим захирагааны хэрэг үүсгэхээс эхлээд уг хэргийг хянан шийдвэрлэх дусах бүх шатанд хамаарна.⁵⁴

Зарим хялбарчилсан албан бус тайлбарт хэрэг үүсгэх, шүүх хуралдааны бэлтгэл хангах үед нэхэмжлэгч нэхэмжлэлээ өөрчлөх; хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд нэхэмжлэгч өөрийн хүсэл зоригийн дагуу нэхэмжлэлийн бүх шаардлагаас бүрэн хэмжээгээр татгалзах гэж эрхээ здлэхийг зааглажээ.⁵⁵ Ингэснээр хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэх хүртэлх хугацаанд хэргийн оролцгчийн хүсэл зориоос хамааран хэргийг хэрэгсэхгүй болгох боломжтойг харуулж байна. Нэхэмжлэл гаргах нь нийтийн эрх ашиг хөндөгдсэн (*Popularklage*) болон зөвхөн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн (*Verletztenklage*) бол гэсэн хэлбэртэй. Үүнээс хамааран уг зарчмын үйлчлэх онцлогийг тодорхойлж болох юм.

Харин процессын хуулийн албан бус тайлбарт диспозитив зарчим гэдгийг шүүх хэрэг маргааныг зохицдын гаргасан нэхэмжлэлийн үндсэн дээр буюу нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд шийдвэрлэхийг

ойлгоно гэжээ.⁵⁶ Шүүх өөрийн санаачилгаар хэрэг үүсгэхгүй, зөвхөн нэхэмжилэл, өргөдөл, гомдол, хүсэлтээр хэрэг үүсгэж, талуудын хүсэл зоригийн үндсэн дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагддаг гэсэн ёт. Энэ зарчим нь талуудын нэхэмжилэл болон тэдний хэргийг үүсгэх, дусгавар болгох хүсэл зоригт онцгой ан холбогдол егех бөгөөд энэ нь шүүхийн өмнө иргэдийн субъектив эрхийг хамгаалах арга хэрэгээ болдог.⁵⁷ Судлаачид ЗХХША-г субъектив эрхийн хяналтаас гадна объектив эрхийн хяналтыг хэрэгжиулах нь зүйтэй гэж узсан байдаг.⁵⁸

Тэгвэл нийтийн эрх ашгийн үүднээс шуухад нэхэмжилэл гаргасан нэхэмжлэгчийн итгэл хүлээн байдал, өөртөө итгэхгүй, шударга, найдвартай, шийдэмгий, тууштай чигч байдал гэсэн хувийн зан чанар нь шүүх хуралдаанд дөхөм үзүүлдэг. Нэхэмжлэгч нь уг хэрэгт дуустал нь явах хүсэлтэй эсэхийг нь анхнаасаа тодорхойлох нь чухал юм.⁵⁹ Захирагааны процессын эрх зүйд диспозитив зарчим зөвхөн хэргийн оролцгчдын эрхээр илрэх тул энэ зарчим үр нелөөтэй үйлчилдэг.⁶⁰ Энэ нь нэхэмжлэл гаргах, нэхэмжлэгч нэхэмжлэлээ өөрчлөх, түүний шаардлагын хэмжээг ихэсгэх буюу багасах, нэхэмжлэлээсээ татгалзах, нэхэмжлэгч хариуцаач эвлэрэх зэрэг эрхүүдээр тайлбарлагдана.⁶¹ Энэ зарчмын агуулгаас түүний шинжүүдийг

⁵² “Захирагааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” (Гарын авлагы) цуврал №10, УБ хот, 2007 он, 15 дахь тал.

⁵³ “Монгол Улсын Захирагааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” (Шүүгчид зориулсан гарын авлагы) УБ хот, 2004 он, 100 дахь тал.

⁵⁴ “Захирагааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” (Гарын авлагы) цуврал №10, УБ хот, 2007 он, 16 дахь тал.

⁵⁵ “Захирагааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль” (Халбаршуулсан зурагт тайлбар) УБ хот, 2004 он, 48 дахь тал.

⁵⁶ “Захирагааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар” (Хамтын бүтээл) УБ хот, 2012 он, 62 дахь тал.

⁵⁷ “Захирагааны хэрэг, маргван хянан шийдвэрлэх зарчим” (Гарын авлагы) цуврал №4, УБ хот, 2005 он, 34 дахь тал.

⁵⁸ “Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: Өнөө ба ирээдүй” (Олон улсын Эрдэм шинжилгээний хурлын эмзэтгэл) УБ хот, 2015 он, 121 дахь тал.

⁵⁹ “Стратегийн өмгөөлэл: Нийтийн эрх ашиг нэхэмжлэн хамгаалах нь” (Өмгөөлэгчдэд зориулсан гарын авлагы) УБ хот, 2006 он, 59 дахь тал.

⁶⁰ “Эрдэнэцогт А. “Монгол Улсын Захирагааны процессын эрх зүй” (Хоёр дахь хэвлэл) УБ хот, 2012 он, 29 дахь тал.

⁶¹ Эрдэнэцогт А. “Захирагааны процессын эрх зүй” (Гарын авлагы) УБ хот, 2013 он, 19 дахь тал.

нь тодорхойлж болох юм.⁶²

Иргэний процессын эрх зүйн бүтээлийн хувьд:

Диспозитив зарчим нь ИХШХША-ны өвөрмөц зарчмын нэг юм.⁶³ Энэ зарчмын агуулга нь хэргийн оролцогчид өөрсдийн узэмжээрээ материаллаг эрх зүйн болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрхээ санаачилгаараа бие даан хэрэгжүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны арга хэрэгслийг чөлөөтэй сонгон өөрийн ашиг сонирхлоо хамгаалдагт оршино.⁶⁴ Өөрөөр хэлбэрэл, нэхэмжлэгч хэзээ, хэнээс, юу шаардахыг өөрөө шийдвэрлэхийг хэлнэ.⁶⁵ Иргэний хэрэг үүсгэх, дуусгавар болгохтой холбогдсон бүх үйл ажиллагаа нь сонирхогч этгээдийн хүсэл зориоос хамаарч байдаг явдал нь диспозитив зарчмын гол агуулга юм.⁶⁶ ИХШХША-нд хэргийн оролцогчид хуулиар олгогдсон материаллаг болон процессын эрхээ здлэх боломжийг энэ зарчим олгодог.⁶⁷ ИХШХША-ны гол хөдөлгөгч хүч нь уг ажиллагаанд оролцож байгаа этгээдийн санаачилга бөгөөд иргэний хэрэг үүсгэх нэг үндэслэл нь нэхэмжлэл юм.⁶⁸ Нэхэмжлэлд нэхэмжлэгчийн эрх, ашгаа шүүхээр сэргээлгэх, хамгаалаулах хүсэл сонирхол тусгагддаг.⁶⁹

⁶² Оюунгаргал О “Захиргааны процессын эрх зүйг иргэний процессын эрх зүйтэй харшуулж нь” (Магистрын дипломын ажил) УБ хот. 2009 он, “Эрх зүй сэтгүүл” УБ хот. 2010 он, №1-2. 31 дэх тал.

⁶³ Менжкаргал Т. “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй” (Ерөнхий ангил) УБ хот. 2008 он, 34 дэх тал.

⁶⁴ Шүүгчийн гарын авлага (Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар) (Хамтын бутээл) УБ хот. 2007 он, 92 дахь тал.

⁶⁵ “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар” (Хамтын бутээл) УБ хот. 2007 он, 92 дахь тал.

⁶⁶ “Эрх зүй сэтгүүл” УБ хот. 2002, №8-9. 111 дэх тал.

⁶⁷ “Монгол Улсын төр, эрх зүйн үндэс” (Хамтын бутээл) УБ хот. 2000 он, 343 дахь тал.

⁶⁸ Менжкаргал Т. “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй” Ерөнхий ангил. УБ хот. 2011 он, 43 дахь тал.

⁶⁹ Менжкаргал З. “Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй” (Ерөнхий ангил) УБ хот. 2009 он, 105 дахь тал.

Нэхэмжлэлийн зүйл нь нэхэмжлэгчийн шаардлага байдаг бол уг шаардлага гаргах болсон нэхцэл нь үндэслэл болно. Энэ үүднээс нэхэмжлэгч маргаж байгаа болон эрх зөрчигдсөн үндэслэлээ нэхэмжлэлд тодорхой бичсэн байх шаардлагатай. Тиймээс нэхэмжлэл бүр нэхэмжлэгчийн эрх ашиг, зорилтыг агуулдаг. Тэрхүү зорилго нь нэхэмжлэлийн зүйл болон үндэслэл, нэхэмжлэлийн шаардлагасааны хамаарал ИХШХША-ны агуулга, хэлбэрт нелөөлдөг. Энэ нь уг ажиллагааны явцад нэхэмжлэлийн зүйл, шаардлагыг өөрчлөх, багасгах, ихэсгэх, буцаан авах эрхээр илэрдэг байна.⁷⁰ Тиймээс ИХШХША хэргийн оролцогчийн санаачилга, хүсэлтийн дагуу явагдана. Хэргийн оролцогчид хоорондоо маргаж буй зүйлийн талаараа эвлээрэх, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх зэрэг хариулсан зөвшилцэж, сайн дурын үндсэн дээр асуудлаа өөрсдийн хүсэл зоригоор шийдвэрлэх боломжтой. Энэ боломжийг хуулиар тогтоож өгсөн нь энэ зарчим хэрэгжих үндсийг тогтоож байгаа юм.⁷¹ ИХШХША нь ИХШХШТХ-ийн З дугаар зүйлд заасны дагуу шүүхэд мэдүүлснээр эхэнц. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйд диспозитив зарчим хэрэгжин гэдэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицгийн санаачилга буюу хүсэлтийн үндсэн дээр явуулна гэсэн уг юм.⁷² Тиймээс нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрөх явдлыг ИХШХША дахь диспозитив зарчмын илрэл гэж үздэг.⁷³ Гэхдээ зарим судлаач

⁷⁰ Төмөрбаатар З. “Арбитрын журмаар иргэний маргаан шийдвэрлэх болон шүүхээр маргван шийдвэрлүүлэх процессын онцлог, ялгаа” (Магистрын дипломын ажил) УБ хот. 2011 он, 7 дахь тал.

⁷¹ Дүргэрмаа А. “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй” (Гарын авлагын) УБ хот. 2007, 52 дахь тал.

⁷² Хуяг Д. “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн үндэс болон тулгамдсан асуудлууд” УБ хот. 2013, 62 дахь тал.

⁷³ “Процессийн эрх зүйн толь” (Анхны хэвлэл) УБ хот. 2014, 97 болон 102 дахь тал.

өөрийн бүтээлдээ үүнийг мэтгэлцэх зарчмын илрэл гэж бичжээ.⁷⁴ Түүнчлэн нэхэмжлэлийн шаардлагыг багасгах нь нэхэмжлэлийн тухайн хэсгээс татгалзаж байгаа гэсэн үг юм. Энэ зарчим нь иргэний хэрэг үүсгэхээс эхлээд хөргийг хянан шийдвэрлэх бүх үе шатанд хамаардаг.⁷⁵

Зарим гадаадын судлаачдын бүтээлд⁷⁶ диспозитив зарчим талуудад маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх, шүүхээр хянан шийдвэрлэгдэх маргааны зүйлийг тодорхойлох, түүний хүрээг хязгаарлахыг тогтоох, түүнчлэн шүүхийн шийдвэрээс үл шалтгаалан үг ажиллагааг дуусгах эрх хэмжээг хулээн зөвшөөрдөг гэсэн урьдчилсан нөхцлийг ойлгоно гэж тодорхойлолт өгчээ. Энэ зарчим нь маргааныг хэрэн шийдвэрлэх талаарх хэлбэр, загварыг эрх чөлөөтэй сонгох баталгаа, маргааны зүйлийг бие дааж тодорхойлох (жалбэрхүүлэх) баталгаа, процессын баталгааг бурдүүлэх гэсэн чиг үүрэгтэй. Тэгвэл зарим бүтээлд диспозитив зарчим нь өөртөө үндсэн түрвэн агуулгыг багтаадаг гэж үздэг. Нэгдүгээрт, маргааныг эхлүүлэх буюу шүүхэд нэхэмжлэл гаргаагүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явулахгүй. Хөөрдугаарт, маргааны зүйлийг тодорхойлох буюу шүүгчээс бичих шүүхийн шийдвэрийн агуулга нь талуудын маргасан зүйлийн хүрээгээр хязгаарлагдахыг, Гуравдугаарт, маргааныг дуусгах зэрэг юм. Тодруулбал, (1) Маргааны зүйлийг тодорхойлон мэдүүлэх; (2) Эвлэрэл; (3) Шаардлагасаа татгалзах, шаардлагыг хулээн зөвшөөрөх гэсэн агуулгатай гэж

тэмдэглэжээ.⁷⁷

Харин зарим бүтээлд диспозитив зарчим нь хэрэг маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх эсэх, юуны талаар шаардах, маргааны зүйлийг хэрэн тодорхойлох зэрэг нь талуудын хүснэгтийн зорилгоос хамаарна гэсэн агуулгаар тайлбарласан байдаг. Ингэснээр талууд маргааны зүйлээ чөлөөтэй тодорхойлон шийдвэрлүүлэх, шаардлагасаа татгалзах, шаардлагыг хулээн зөвшөөрөх, түүнчлэн нэхэмжлэлийн талаар эвлэрэх боломжтой юм. Энэ үндсэн дээр талууд нэхэмжлэл гаргахаас гадна шаардах, эрхээсээ татгалзах боломжтой ч уг зарчим нь нийтийн эрх ашигт ямар нэг байдлаар хамаарахаай нөхцөлд л хэрэгжинэ гэж үзжээ.⁷⁸ Түүнчлэн зарим бүтээлд диспозитив зарчим нь шаардлагыг чухалчилдаг бол мэтгэлцэх зарчим нь шаардлагын үндэслэл, түүний бодит байдал, шалтгаан болон эсрэргүүлийн түвшинд оршдог гэж үзүүлээрээ адилхан мөн чанартай. Мэдээж үйлчлэх хүрээ хязгаарын хувьд харилцан адилгүй учир диспозитив зарчим ба мөрдөн шалгах шалгах зарчмын уялдаа холбоог авч боломжтой.⁷⁹

Үндсэн хуулийн процессын эрх зүйн бүтээлийн хувьд:

Зарим судлаачид *dispositionsmaxime* нь бусад (эрүү, иргэн, захиргааны) процесст хэрэгждэг боловч үндсэн хуулийн процесст хамаардаггүй гэж үздэг.⁸⁰ Гэхдээ Үндсэн хуулийн шүүхэд хандсанаар Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа эхлдэг нийтэг журамтай. Ингэснээр Үндсэн хуулийн шүүхийн зориулалт нь түүний Үндсэн

⁷⁴ Есахимски Юпп. "Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар" УБ хот, 2004 он, 52 дахь тал.

⁷⁵ Шүүгчийн гарын явлага (Эрүүгийн байцавн шийтгэх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудыг хэрэглэх оногд агаар зүй) УБ хот, 2004, 157 дахь тал.

⁷⁶ 伊藤真.『民事訴訟法』初版、弘文堂、2006年、264–285頁。

⁷⁷ 木山博嗣. 民事訴訟法. 法学書院. 第9刷. 2013年. 107–108頁.

⁷⁸ 大島慎一. 民事訴訟法. 民事法研究会. 第4刷. 2011年. 280頁.

⁷⁹ 高橋宏志. 重点講義 民事訴訟法. 有斐閣. 第7刷. 2008年. 369頁.

⁸⁰ "Эрх зүй сэргүүл" УБ хот, 2010 он, №1–2, 30 дахь тал. "Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа" (Шүүгчид) УБ хот, 2004 он, 100 дахь тал.

хууль дахь чиг үүргийг (үндсэн хуулийг тайлбарлах болон үндсэн хуулийг шууд үйлчилдэг эрх зүй болгох)⁸¹ илтгэдэг. Энэ нь диспозитив зарчмын гол мөн чанарыг илэрхийлнэ. Энэ үндсэн дээр Үндсэн хуулийн шүүх өөрийн санаачилгаар аливаа маргааныг үүсгэдэгтэй. Үүнийг Үндсэн хуулийн цэцийн практикаас харж болно.⁸² Тийм ч учраас, диспозитив зарчим Үндсэн хуулийн шүүхийг шүүх болох шинж, шалгуурыг нь нөхцөлдүүлэн тодотгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Хэдий тийм ч үндсэн хуулийн процессын бүтээлүүдэд *диспозитив зарчим гэсэн нэр томьёогор бичигдээгүй харин диспозицийн зарчим гэсэн нэрээр дурдагджээ.⁸³ Энэ зарчмын агуултыг дараах байдлаар тодорхойлжээ.

Бусад шүүхийн хувьд, шүүхэд нэхэмжлэл гаргагч нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг өөрөө шийддэг ба нэхэмжлэлээс татгалзах явдал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болго үндэслэл болдог. Гэтэл үндсэн хуулийн шүүхийн хувьд шийдвэрлэж буй маргаан нь тодорхой нэг хүний биш, харин нийтийн ашиг сонирхлыг хөндөх байдаг тул өргөдлийг буцаан авсан тохиолдолд ч маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулж шийдвэр гаргах боломжтой байдаг хэмээн үздэг.⁸⁴ Тэгвэл ХХША нь нэхэмжлэгчийн хүсэл зориоос хамаарах бол МХША нь өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргагчийн хүсэл зориоос үл хамаардаг.⁸⁵ Тиймээс үндсэн хуулийн шүүхэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа өргөдлийн

⁸¹ "Эрх зүй сэтгүүл" №01(33), УБ хот. 2016 он, 164 дахь тал.

⁸² "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн лавлах" (Гарын авлага) УБ хот. 2016 он.

⁸³ Сарантуга Ц. "Монгол Улс дахь Үндсэн хуулийн процессын эрх зүйн үүсэл, төлөвшин, тулгамдсан асуудал" (Хууль зүйн шинжлих ухааны докторын эзргэгийнсон бүтээл) УБ хот. 2008 он.

⁸⁴ Сарантуга Ц. "Үндсэн хуулийн процессын эрх зүй: суурин ойлголт, тулгамдсан асуудал" УБ хот. 2005 он, 163 дахь тал.

⁸⁵ Сарантуга Ц. "Үндсэн хуулийн процессын эрх зүй" (Гарын авлага) УБ хот. 2011 он, 53 дахь тал.

шаардлагаас шууд хамааралтай биш юм.⁸⁶ Уг зарчмын агуулыг тодорхойлоход маргагч талын онцгой эрхийн асуудал хөндөгддэг учраас түүнийг үндсэн хуулийн шүүхийн чиг үүрэгтэй нь холбон тайлбарлах нь зохижтой.

Эрүүгийн процессын эрх зүйн бүтээлийн хувьд:

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хүртэл диспозитив зарчмын үзэл санаа эвлээрэл, хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэсэн байдлаар тусгагджээ. Үүнээс гадна ЭБША дахь иргэний нэхэмжлэлд тодорхойлогдсон байдаг.

Гэмт хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх ажиллагаа нь 1) хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоо зарчимд үндэслэхгүй; 2) хялбаршуулсан журмаар явуулах цаг хугацаа нь ердийнхөөс богино; 3) тухайн эрүүгийн хэрэгт нотлогдвол зохих байдлыг нэг бүрчлэн тогтоох шаардлагагүй; 4) хохирогч хохирлын талаар маргааныгүй; 5) сэжигтэн, яллагдагч, хохирогч харилцан зөвшөөрч хүсэлт гаргасан; 6) сэжигтэн, яллагдагч гэмт хэрэг үйлдэсэнээс хүлээн зөвшөөрсөн; 7) 18 насанд хүрээгүй этгээдийн үйлдэсэн гэмт хэрэгт энэ журмыг баримтлахгүй гэсэн онцлог шинжүүдтэй.⁸⁷

Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэл нь ЭБШ-ийн⁸⁸ 25 дугаар зүйлд заасан эвлэрлээс ялгаатай хэдий ч эвлэрийн хүсэл зоригийг илэрхийлсэн тохиролцоонд үндэслэдэг. Хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэхдэд талууд эвлэрч хэрэгсэхгүй болоогүй боловч талуудын хооронд мөн л эвлэрийн хүсэл

⁸⁶ "Монгол Улсын Үндсэн хуулийн цэц" (Өгүүэл, илтгэлийн эмхтгэл) УБ хот. 2007 он, 374 дахь тал.

⁸⁷ "Гэмт явдлытай тэмцэх асуудал сэтгүүл" УБ хот, 2007 он № 143 дахь тал.

⁸⁸ ТМ 2002 он №05 дугаарт нийтлэгдсэн.

зоригийг илрэхийлсэн ялын тохиролцоо явагддаг.⁸⁹ ЭХ-ийн⁹⁰ 70 дугаар зүйлд заасан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх нэг үндэслэл нь гэм буруутай этгээд хохирогчтой звлэрсэн байх явдал юм. Энэхүү нехцэл гагчхүү хөнгөн гэмт хэрэг нэхцэл худалдааны удаа үйлдсэн этгээдэд хамаардаараа онцлог.⁹¹

Эл асуудлыг шийдвэрлэх эрх бүхий субъект **ЭБШХ-ийн 25.1** дэх хэсэгт заасан үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгоход а) тухайн хэрэг нь эрүүгийн хуульд заасан хөнгөн гэмт хэргийн ангилалд багтсан; б) сэжигтэн, яллагдаж, шүүгдэгч уг гэмт хэргийг үйлдсэн нь нотлогдсон гэдгийг тэд хүлээн зөвхөөр, гэм буруушилан талаар маргаажгүй, шүүхээр шүүлгэх шаардлагагүй гэдээз албан ёсоор мэдүүлсэн; в) звлэрэх саналыг аль ч тал эхлэн гаргаж болох бөгөөд гагчхүү хохирогч звлэрэхийг өөрөө хүссэн, эсхүл звлэрэх саналыг хүлээн зөвхөөрсөн нь дарамт шахалт, заналхийлэл зэрэг гадны ямар нэгэн нелөөгүйгээр сайн дурын үндсэн дээр хийгдсэн гэдгийг нотлогсон байх ёстой, мөн хохирогчоо тийнхүү звлэрэх, зөвлэл звлэрэх саналыг хүлээн авах болсон шалтгааныг тогтоосон; г) хэргийн хохирогч нь яллагдажиin эрхшээлд байгаагас, эсхүл бусад шалтгааны улмаас өөрийн эрх, хууль ёсны сонирхлыг хамгаалж чадахгүй тохиолдол байхгүй гэдгийг хангалттай шалгасан байх гэсэн харгалzan үзэх шаардлагуудыг тавьжээ.⁹²

Ийнхүү звлэрэх болсон шалтгааныг нарийвчлан тогтоосны эцэст эрх бүхий субъект хэргийг хэрэгсэхгүй тогтоол, магадлал гаргаж, тийм нехцэл байдал

⁸⁹ Мөнхмандах З. «Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журнаар хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын зорим асуудал» (Магистрын дипломын ажлыг УБ хот, 2016 он, 46 дахь тал).

⁹⁰ ТМ 2002 он №03 дувтаргын нийтлэгээд.

⁹¹ «Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль» (Хялбаршуулсан тайлбар) УБ хот, 2010 он, 29 дахь тал.

⁹² «Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар» (Хамтын бүтээл) УБ хот, 2003 он, 29 дахь тал.

тогтоогодохгүй бол хэргийг шүүхэд шилжүүлэн шүүх ердийн журнаар хянан шийдвэрлэн.⁹³ Харин зруутийн хэрэг гаргасан иргэний нэхэмжлэлийг хархэн шийдвэрлэхийг шүүх тогтоодог бол иргэний хэргийн хувьд нэхэмжлэгч, хариуцагчийн хүсэл зоригоос хамааран хялбаршуулсан журнаар шийдвэрлэж болдог онцлогтой.⁹⁴

Иргэний нэхэмжлэгч гэх гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн, түүнийгээ нөхөн телтуулэх буюу сэргээлгэхээр шаардлагат тавьж байгаа иргэн, хуулийн этгээдийг хэлнэ. Түүнийг ЭБША-ны аль ч үед эрх бүхий субъектүүд тогтоож болох бөгөөд ингэхдээ түүнээс гаргасан нэхэмжлэлийн үндэслэл, нотлогдсон байдал зэргийг нотлох баримтын хүрээнд шүүх авч үзэж нэхэмжлэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хангах, эсхүл хэргэсэхгүй болож шийдвэрлэдэг.⁹⁵ Эрүүгийн хэргийн иргэний нэхэмжлэлийн гол шинж нь хохирол бодитой учирсан байх бөгөөд энэхүү хохирол, гэмт үйлдэл, эс үйлдэхүү нь шалтгаант холбоотой байх явдал юм. Тиймээс иргэний нэхэмжлэлийг эрүүгийн хэргийг үүсгэснээс эхлэн шүүхийн хэлэлцүүлэг хүртэлх шатанд гаргах бөгөөд нэхэмжлэл гаргах нь аливаа этгээдээс өөрийн зөрчигдсэн эрх, ашиг сонирхлоо сэргээлгэх боломж гэж үздэг. Түүнийг гаргах нь эрх учраас иргэн, хуулийн этгээд түүнээс татгалзаж болно. Энэхүү татгалзал нь бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй, хууль зөрчөөгүй байх учиртай.⁹⁶

Албан бус тайлбарт нэхэмжлэлээс татгалзах гэдгий

⁹³ «Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль» (Хялбаршуулсан тайлбар) УБ хот, 2010 он, 30 дахь тал.

⁹⁴ Уранчимэг. Д. «Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шүүхийн шатанд шийдвэрлэх асуудал» (Магистрын дипломын ажлыг) УБ хот, 2015 он, 16 дахь тал.

⁹⁵ «Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль» (Хялбаршуулсан тайлбар) УБ хот, 2010 он, 50 дахь тал.

⁹⁶ «Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль» (Хялбаршуулсан тайлбар) УБ хот, 2010 он, 104–106 дахь тал.

иргэний нэхэмжлэгчээр тогтоогдсон этгээд өмнө нь гаргасан нэхэмжлэлээсээ татгалзах тухай хүснэгтээ эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хандаж гаргахыг; хууль зөрчсөн гэдгийт нэхэмжлэгчээр тогтоогдоогүй, эсхүл нэхэмжлэгчийг төвлөөлөх эрхгүй этгээд хүснэгт гаргасан болон нэхэмжлэлээс татгалзсан нь түүний хүснэгт зоригийн шлэрхийлэл биш хөнгөнгийн дарамт, нөлөөллөөс шалтгаалсан зэрэг нөхцөл байдлыг; аль нэг этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохирох гэдгийг хууль зөрчвөгүй боловч тийнхүү нэхэмжлэлээс татгалзах нь аль нэг гуравдагч этгээдийн хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахгүй байх явдал гэж тайлбарлажээ.⁹⁷ Харин ЭБША дахь иргэний нэхэмжлэгчийн эрх, үргүй зөвхөн нэхэмжлэлийн агуулгаар тодорхойлгодох⁹⁸ бөгөөд иргэний нэхэмжлэгч нь нэхэмжлэлээсээ татгалзах болон өөр бусад эрхийг здэлнэ.⁹⁹ Нэхэмжлэлээс татгалзах нь урьд гаргасан нэхэмжлэлээсээ татгалзах, харин нэхэмжлэлээс татгалзах нь нэхэмжлэл гаргахаас татгалзаж байгаа ойлголт юм. Нэхэмжлэлээсээ татгалзах нь иргэний эрхийн асуудал хэдий ч өөрийн сайн дурын хүснэгт зоригийнүүднээст татгалзаж бөйгээ эсэхийг тодруулах нь иргэний эрх, ашиг сонирхлын баталгааг төрөөс анхаарч буйн илрэхийлэл гэж үздэг.¹⁰⁰ Зарим бүтээлд иргэний нэхэмжлэгчийн эсэхийг тодорхойлон тайлбарлахдаа нэхэмжлэлээс татгалзах гэсэн эрхийг авч үздэггүй байжээ.¹⁰¹ Өмнөх хэсэгт диспозитив зарчмын агуулгыг

⁹⁷ "Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар" (Хамтын бутээл) УБ хот, 2003 он, 128 дахь тал.

⁹⁸ "Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар" (Хамтын бутээл) УБ хот, 2003 он, 55 дахь тал.

⁹⁹ Ганболд Г. "Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй" УБ хот, 2008 он, 144–145 дахь тал, Бат – Эрдэнэ Б. "Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй" (Ерөнхий англ) УБ хот, 2004 он, 122 дахь тал ... гэх мэт

¹⁰⁰ "Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбаруулсан тайлбар" УБ хот, 2010 он, 109 дахь тал.

¹⁰¹ "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй" УБ хот, 1987 он, 39–40 дахь тал.

(процессын салбар эрх зүй тус бүрээр нь) тодорхойлсны үндсэн дээр энэ зарчмын нийтлэг шинжийг дараах байдлаар гаргаж болох юм. Үнд:

- Хэрэг үүсгэх, дуусгавар болгох хүснэгт зоригтой байх;

- Нэхэмжлэлийн зүйлээ чөлөөтэй, өөрөө тодорхойлох;

- Онцгой эрх зөвхөн хэргийн оролцогчдод хадгалагдах зарг болно. Энэ шинжээрээ захирагааны процессын эрх зүй нь иргэний процессын эрх зүйтэй нийтлэг болно.¹⁰² Гэхдээ эдгээр нийтлэг шинж Үндсэн хуулийн цэцийн практикт ажиглагддаг.¹⁰³ Дагнасан шүүхийн шийдвэр нь зөвхөн хэргийн оролцогчид буюу тодорхой субъектэд чиглэгдэх¹⁰⁴ учир хэрэг (маргаан) хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдоос гадна эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдод диспозитив эрх хадгалагддаг байна.

IV. Субъектив эрх хамгаалах асуудал

Эрх зүйн тольд субъектив эрхийг (Англи. *Subjective right*; Орос. Субъективное право) өөрсдийнхөө ашиг сонирхлыг хангахтай холбоодсон зорилгод хүрэхэд чиглэгдсэн этгээдийн боломжтой зэн үйлийн хуулиар хангагдсан арга хэмжээ гэж тодорхойлжээ.¹⁰⁵

Субъектив эрх нь эрх зүйн дэглэмийн дагуу хувь этгээдүүдийн ашиг сонирхлыг ханган хэрэгжүүлэхийн тулд тэдгээрт олгосон хүснэгт зоригийн эрх мэдэл юм.¹⁰⁶ Энэ ойлголтын

¹⁰² Эрдэнэцогт А. "Монгол Улсын Закиргааны процессын эрх зүй" (Хөөр дахь хэвлэл) УБ хот, 2012 он, 29 дахь тал.

¹⁰³ "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн лавлах" (Гарын авлагы) УБ хот, 2016 он.

¹⁰⁴ Оюунжэрэл О. "Закиргааны процессын эрх зүйг иргэний процессын эрх зүйтэй харьцуулалтад нь" (Магистрын дипломын ажлы) УБ хот, 2009 он.

¹⁰⁵ Наранжэрэл С. "Эрх зүйн эх толь бичиг" (Гурас давж хэвлэл) УБ хот, 2011 он, 408 дахь тал.

¹⁰⁶ Тэмүүлэн Б., Энхтуяа Д., Буяжкишиг Б. "Иргэний эрх зүй өрөнхий англ" (Анхны хэвлэл) УБ хот, 2010 он, 204 дахь тал.

агуулгыг: а) *Субъектив эрх нь эрхийн тухай ойлголтоос урган гардаг.* б) *Субъектив эрх нь тодорхой нэг субъектэд олгогддог. Субъектгүйгээр энэ эрхийг хуульчлан тодорхойлохоос аль болох зайлсхий нь зүйтэй.* в) *Субъектив эрх бол субъектэд олгогдож буй хүсэл зоригийн эрх мэдэл. Субъектив эрхийг эдлэгч нь эрхийг хэрэгжүүлэх эсэх талаар өөрөө шийдвэр гаргах эрхтэй. Ингэснээр уг эрх нь тодорхой субъектүүдэд эрх чөлөөт байдлыг нь хангах баталгаа болдог.* г) *Субъектив эрх нь хувь этгээдүүдийн ашиг сонирхлыг ханган хэрэгжүүлэхэд чиглэгддэг. Энэ эрхээр хамгаалагдаж буй ашиг сонирхол нь тухайн субъектив эрхийн агуулгаар тодорхойлоходо гэж задлан тайлбарлаж болно.*¹⁰⁷

Тэгвэл субъектив эрх нь гагцхүү шүүх үүргээ билэулээгүй тохиолдолд ногдуулах санкцыг ийнхүү үүргээ билэулээгүй улмаас өөрийнх нь эрх зерчигдсэн субъект гомдол гаргасан нөхцөлд бий болно. Тиймээс санкцыг хэрэгжүүлэх тухай нэгбүрчилсэн хэм хэмжээг тогтоох нь билэулэлх ёстой үүргээ билэулээгүй явдлыг эсргүүцсэн этгээдээс хийх үйлдэл болох гомдол, нэхэмжилээс хамаарна. Энэ тохиолдолд үүргийг тогтоосон хууль түүнд үйлчлэх ба хууль нь түүний эрх болно. Ингэснээр субъектив шинж чанартай эрх нь объектив шинж чанартай эрхээс өөр, хуулиар хамгаалагдсан эрх ашиг биш юм.¹⁰⁸

Энэ бол тодорхой тохиолдолд тодорхой субъективийн гаргасан идэхвихт үйлдээс хамаарах санкцыг тогтоох нэгбүрчилсэн хэм хэмжээ учраас үйлдэл хийх бүрэн эрхийг тухайн этгээдэд олгож буй хэм хэмжээ юм. Энэ бол хуулиар хамгаалагдсан

эрх ашиг биш, харин эрх ашигийн хамгаалал юм. Энэхүү хамгаалал нь объектив эрх зүй (хууль) хэрэгжүүлсэн идэвхтэй үйлдлийн үр дүнд өөрийнх нь үүргийг зөрчсөн субъективийн эзрэг чиглэсэн санкцыг хэрэгжүүлэх тухай нэгбүрчилсэн хэм хэмжээ тогтоох процессыг эхлүүлэх эрх мэдлийг нэгэн субъектэд олгох замаар хэрэгжина. Энэ утгаар бол субъектив эрх эдлэх гэдэг нь объектив эрх зүйгээ олгогдсон эрх мэдлийн дагуу гомдол, нэхэмжилэл гаргах замаар эрх зүйн нэгбүрчилсэн хэм хэмжээ тогтооход оролцох эрхтэй байна гэсэн үт.¹⁰⁹

V. Дүгнэлт

Диспозитив зарчмын түүнд хамаарах суурь асуудлыг хөндөх замаар уг зарчмын хэрэгжилтээс үүсч буй, үүсж болох тулгамдсан асуудлаас хэрхэн сэргийлэх гарцыг эрэлхийлсний үндсэн дээр дараах дүгнэлт, саналыг дэвшүүллээ. Үүнд:

Нэг. Диспозитив зарчмын агуулгыг тодорхойлоход нэхэмжлэгч эзвэл маргагч талын онцгой эрхийн асуудал хөндөгддөг учраас түүний үзэл санаа түүхэн уламжлал, шинэтгэл хоёрын тусгал – үр дүнд бүрэлджээ. Процессын эрх зүйн зохицуулалтын зөрэг уламжлал (серэг сургамж) нь шинэ хуулийн үзэл баримтлал бүрдэхэд ерөнхий суурь дэвсгэр болсон гэж болох юм. Дагнасан шүүхээс гадна Үндсэн хуулийн цэц талуудын санал санаачилга гаргаснаар, эсхүл хуулиар тогтоосон эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэг (маргаан) хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж байна. Энэ утгаараа онцгой эрхийн үзэл санаа “ex hihii” буюу “хоосноос гээ гэнэт бий болоогүй” гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Хоёр. Диспозитив зарчмын дагуу Хэрээ хянан шийдвэрлэх ажиллагаа нь зөвхөн нэхэмжилэл, хүсэлтийн үндсэн

¹⁰⁷ Тэмүүлэн Б., Энхзүүл Д., Буянхишиг Б. “Иргэний эрх зүй өрөөний ангийн” (Анхны хувьлалт) УБ хот, 2010 он, 205 дахь тал.

¹⁰⁸ Ханс Кельзен. Хэм хэмжээний тухай өрөөний онол (Ред. Ж.Амарсанбаа, Ц.Сарантуяа) УБ хот, 2013 он, 138 дахь тал.

¹⁰⁹ Ханс Кельзен. Хэм хэмжээний тухай өрөөний онол (Ред. Ж.Амарсанбаа, Ц.Сарантуяа) УБ хот, 2013 он, 139 дахь тал.

дээр хэрэг үүсэх бол маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа нь өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргасан тохиолдолд маргаан үүсдэг гэсэн нийтлэг шинжтэй. Тиймээс нэхэмжлэгч эсвэл маргагч гэдгээс үл хамааран онцгой эрх эдлэх нь зарчмын агуулгад бүрэн нийцнэ. Харин диспозитив зарчмын агуулгыг зөвхөн онцгой эрхэд тулгуурлан хязгаарлагдмал хүрээнд тодорхойлох нь учир дутгагдтай.

Гурав. Энэ зарчмын мөн чанар нь хэрэг (маргаан) хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчын эрхийг хамгаалаас гадна нийтний эрх ашгийг хамгаалахад чиглэгдэг онцлогтой. Энэ нь маргааны зүйлээрээ төрөлжсөн шүүхээс үнэн зөв шийдвэр гаргахыг

нийтийн эрх ашиг шаарддагтай холбон узж болох юм. Ингэснээр шуух тодорхой тохиолдолд нэг талаас өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргагчийн эрхийг, негээ талаас энхүү нийтийн эрх ашгийг хамгаалахын түлд маргааны нехцэл байдлыг бодитой, бүрэн дүүрэн тодорхойлох онцгой үүргийг хүлээх юм. Тиймээс уг зарчмыг (онцлог) ерөөс нийтийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн бүхий л шүүхийн ажиллагаанд баримтлах боломжтой.

Дөрөв. Субъектив эрх хамгаалагдаж буй тохиолдолд мөрдөн шалгах зарчмын хэрэгжилт диспозитив зарчмын хэрэгжилтээр хязгаарлагдаж болох юм.

---ооо---

"Хууль дээдлэх ёс" сэтгүүлд нийтлүүлэх эрдэм шинжилгээний бүтээл хүлээн авах тухай

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 14 дэх жилдээ эрхлэн гаргаж буй хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, практикийн улирал тутмын "Хууль дээдлэх ёс" сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл тогтмол хүлээн авч байна.

Тус сэтгүүлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээлд Хуульчийн үргэлжилсэн сургалтын багц цаг болон Хууль зүйн их, дээд сургуулиудын магистр, докторын сургалтын хөтөлбөрт эрдэм шинжилгээний багц цаг тооцдог болно.

Тус сэтгүүлд ирүүлэх эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл нь "Хууль дээдлэх ёс" сэтгүүлийн журмын 3 дугаар болон 4 дүгээр зүйлд заасан эрдэм шинжилгээний бүтээлд тавигдах шаардлагыг хангасан байвал зохино. (Сэтгүүлийн журмыг дараах холбоосоор орж үзнэ үү: <http://nli.gov.mn/?p=435>)

Сэтгүүлийн редакц

Цахим хаяг: lawjournal@legalinstitute.mn

Утас: 11-315734

ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНД ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ ЯВДЛЫГ ХОРИГЛОХ ЗАРЧИМ БА ХӨДӨЛМӨРИЙН МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭЖ БҮЙ ШҮҮХИЙН ПРАКТИК

Үдирдлагын Академийн багш, хууль зүйн
доктор Б.Уранцэцэг

ТҮЛХҮҮР ҮГ:

Хөдөлмөрийн харилцаанд ялгаварлал, гадуурхал, давуу байдлыг хориглох зарчим, шүүхийн шийдвэр, ажилтны тоог цөөрүүлэх, хөдөлмөрийн гарзэг ажил олгогчийн санаачилгаар цуцлах.

ТОВЧЛОЛ:

Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан "Хөдөлмөрийн харилцаанд ялгаварлал, гадуурхал, давуу байдал тогтоохыг хориглох зарчим" хөдөлмөрийн харилцааны практикт зөрчигдэх явдал их байна. Энэ зарчим хөдөлмөрийн харилцаанд хөдөлмөрийн тухай хууль хэрэглэн ажил олгогчийн гаргах шийдвэрт, хөдөлмөрийн маргааны хянан гаргасан шүүхийн шийдвэрээр дамжин ихэвчлэн хэрэгжих онцлогтой билээ. Энэ зарчмыг зөрчих, уг зөрчлөөс үүдэлтэй хөдөлмөрийн маргааны шүүх шийдвэрлэхдээ ажил олгогчийн тухайн зөрчлийг үл харгалзах нь Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гарзэнд тусгагдаж Хөдөлмөрийн тухай хуульд давхар бэхжэсэн хөдөлмөрийн харилцааны нэг суурь зарчим алдагдах, хүний суурь эрх хөндөгдөхөд шууд нөвлөлдөг. Иймд үл ялгаварлах, гадуурхах зарчмын агуулга, онцлогын талаар ойлголт өгөх нь хөдөлмөрийн харилцаанд хувь хүн, ажилтан тэгш оролцох боломжийг практикт хангах нэг нөхцөл болох юм.

ОРШИЛ

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага 1998 онд Хөдөлмөрхөд баримтлах суурь зарчим ба эрхийн талаар гаргасан тунхаглалдаа хөдөлмөрийн харилцаанд үл ялгаварлах зарчмыг суурь зарчим ялгаварлалаас ангид байх явдлыг суурь эрхийн нэг хэмээн тодорхойлсон. 1999 онд батлагдан здүүгээ хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хуульд хөдөлмөрийн харилцаанд ялгаварлал, гадуурхал, давуу байдал олгохыг хориглох зарчим тусгагдсаны зэрэгцээ түүнийг зөрчсөн ажил олгогч аж ахуйн нэлж, байгууллага, албан тушаалтанд шүүхээс торгуулийн хэлбэрээр захирагааны хариуцлага ногдуулахаар заасан. Гэдээ хуульд бий зарчмыг тунхаглалын шинжтэй мэт ойлгож түүний агуулга хуулиар зохицуулагдах хөдөлмөрийн харилцааны зөрчих явдал практикт илэрсээр байна. Иймд хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхах явдлыг хориглох зарчим, түүнийг хэрэгжүүлэх арга зам, агуулга зэргийн талаар нийгэмд, ажил олгогчид болон хөдөлмөрийн маргаан шийдвэрлэгдэг шүүгчдэд нэгдсэн ойлголт өгөх шаардлагатай байна. Ялангуяа дурдаж бий зарчмын хүрээнд шийдвэрлэгдэхээр хөдөлмөрийн маргаан бас байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

Монгол Улс Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллага болох Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын гишүүнээр элссэнхийээ дараахан түүний хэд хэдэн конвенццд нэгдэн орсны нэг нь "Ялгаварлан гадуурхах явдлыг хориглох тухай" 111

дүгээр конвенц¹ (1958 он) байдаг.

Ялгаварлан гадуурхах явдлыг хориглох зарчим, түүнд тусгагдсан "хүн хөдөлмөрийн харилцаанд оролцохдоо ялгаварлан гадуурхагдахаас ангид байх эрх"-ийг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийн харилцаан дах суурь нэг зарчим, мөн хүний хөдөлмөрлөх суурь нэг эрх гэж зарлан тунхагласан Монгол Улсын Үндсэн хууль (1992 он)-д хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл болод боловсролоо нь ялгаварлан гадуурхаж үл болно гэж тодорхойлон бажижүүлжээ. Тэгвэл хөдөлмөрийн гэрээний харилцааны онцлогтой холбоотойгоор Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-7.5 дахь хэсэгт уг харилцаанд хувь хүн, ажилтан оролцоход зүй бусаар ялгаварлагдаж гадуурхадж болзошгүй үндэслэлүүдийг (тухайлбал, үзэл болод, эрэгтэй эмэгтэй гэх мэт) нэрлэн зааж адгээрийн аль нэгэнд тулгуурлан гадуурхах, ялгаварлах эсхүл давуу байдал тогтоохыг хориглосон агуулга бүхий зарчмыг тусгажээ.

Монгол Улс нэгдэн орж улмаар үндэсний хууль тогтоомжийн адил үйлчлэх Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенцод энэ зарчмыг ажил, мэргэжил, хөдөлмөрийн харилцааны хүрээ хамруулсан агуулгаар тусгасан ажээ. Энэ нь хөдөлмөрийн харилцаа түүний гол, үндсэн хэсэг болсон хөлслүү хөдөлмөрийн харилцаа мөн чанарын хувьд эдийн засгийн тэнцвэргүй талууд хооронд үүсдэгтэй холбоотойгоор нэгэнт түүний талууд тэнцвэрт бус байдалд байдаг, ажил олгогч илрэхий давуу талын хувьд өөрөөс хараат, хамааралттай тал болох ажилтан (ажилд орох хүснэгтэй хувь хүн)-ыг зүй бусаар ялгаварлах, гадуурхах бодит боломж байдгийг Олон Улсын хөдөлмөрийн стандарт хэм хэмжээнд харгалзсан хэрэг юм. Конвенцод ялгаварлан

гадуурхал гэдэг ойлголтыг ялгаварлах, хавчин гадуурхах, давуу байдал олгох гэсэн илрэх үндсэн гурван хэлбэрээр тодорхойлжээ. Эдгээр хэлбэрийн хүрээнд арьс үндэс, арьсны өнгө, хүйс, шашин шүтлэг, улс төрийн үзэл болод, үндэс угсаа буюу нийгмийн гарал гэсэн үндэслэлэйн аль нэг буюу нэг хэсгийг харгалзан хүнийг ажил, мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн салбарт тэгш эрхтэй оролцох, ийнхүү тэгш оролцох хандлагыг үүгүйгэсэн эсхүл зөрчсөн аливаа үйл ажиллагааг ялгаварлан гадуурхах явдал гэж уг зарчмын хууль зүйн агуулгыг конвенцод тодорхойлж өгчээ. Үүний хамт гадаад хэлбэрээрээ ялгаварлан гадуурхал эсхүл давуу байдал олгосон мэт ойлгогдох боловч ингэж үзэхгүй тохиолдлыг бас конвенцод заажээ. Эрхлэх гүйцэтгэх ажил үүрэгтэй холбоотой тавигдах шаардлагад үндэслэсэн ямар нэг хязгаарлал, давуу байдал олгохыг нь ялгаварлал, гадуурхалд тооцохгүй. Жишээ нь, төрийн бус байгууллагын ажлын аппаратад түүний гишүүн хүн ажиллах шаардлага тавигдаж болно. Мөн хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд бусад хүний адил тэгш оролцох болопкоо нь бие махбод, эрүүл мэндийн байдал, гэр булийн амьдралын нөхцөл зэрэгээс болж хязгаарлагдах явдал бий. Жишээ нь, хөгжлийн бэрхшээлтэй байх, гэр булийн гишүүн хүнд өвчтэй хүний асрах сувилах үүрэг бүхий байх гэх мэт. Эдгээрт тэгш боломж олгох зорилгоор ажил олгогчийн зүгээс, төрийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ²-г тэдэнд давуу байдал олгон бусдыг нь ялгаварлагдсан гэж үзэхгүй. Үүнээс гадна конвенцод зарчмын хамаарах хүрээг зөвхөн хөдөлмөрийн харилцаа төдийгүй ажил, мэргэжлийн харилцааг багтааж тусгасан нь хувь хүн тодорхой ажил эрхлэх, хөдөлмөрийн харилцаанд оролцохын тулд зохих мэргэжил эзэмших, сургалтад хамаарах шаардлагатай байдагтай холбоотой юм.

¹ Үг конвенцод Монгол Улс 1969 онд нэгдэн орсон

² Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын конвенц зөвлөмжүүдийн эмхтэгэл. УБ., 2012 он. 48-51 дэх тал.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 111 дүгээр конвенцийн агуулгаас үзэвл, энэ зарчим нь төрийн, төрийн байгууллага болон өмчийн төрөл хэлбэрийг үл харгалзан аливаа ажил олгогч оролцсон ажил мэргэжлийн болон хөдөлмөрийн харилцаанд хамаарах бөгөөд мөн түүнийг зөрчсөн практик тогтоох, хэвшүүлэхийг төрийн зүгээс таслан зогсох сэргийлэх үргийг нэгдэн орсон улс орны төр Засгийн газарт үүрэг болгожээ.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийн харилцаан дах суурь зарчим хэмээн тунхаглаж улмаар хөдөлмөр эрхлэгч хүний суурь эрх гэх олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээнд тодорхойлсон ялгаварлан гадуурхалтыг хориглох зарчим ба ялгаварлан гадуурхлаас ангид байж эрхмийг түүний гишүүн улс олон үндэсний хууль тогтоомждоо янз бүрийн хэлбэрээр тусгасан байна. Тухайлбал, манай Үндэсн хууль (1992 он)-ийн арван дөрөвдүгээр зүйлд хүн бүр тэгш эрхтэй байх, ялгаварлан гадуурхагдахгүй байх зармын хэлбэрээр гэхдээ өргөн утгаар тусгасны зэрэгцээ хөдөлмөрийн харилцаанд энэ зарчим хэрэгжих явдлыг Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлд нарийвчлан тодорхойлж бэхжүүлжээ. Тэгвэл Японы "Хөдөлмөрийн стандартын хууль" (1947 он)-ийн 1 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэгт: хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд гарал, үндэс, нийгмийн байдлыг нь харгалzan цалин хэлс, ажлын цагийг болон ажлын бусад нөхцлийг тогтоохыг эмэгтэй хүнийг энэ харилцаанд ялгаварлан гадуурхахыг тус тус хоригложээ.³ Италийн "Хөдөлмөрчдийн эрх чөлөө, нэр төрийг хамгаалах, ажлын байранд Үйлдвэрчний Эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөө, хөдөлмөр эрхлэлтийг нь зохион байгуулах журмын тухай хууль" (1970 он)-ийн 15 дугаар зүйлээр хөдөлмөр эрхлүүлэх явдлыг Үйлдвэрчний Эвлэлд нэгдэн орох эсхүл түүнээс гарах болзотой

³ Labor Laws of Japan. 1995. Ministry of Labour Japan p.726.

холбох, аливаа ялгаварлал гадуурхлын шинжтэй үндэслэлээр ажилд авах, өөр ажилд шилжүүлэх, шийтгэх, халах үр дагавар бүхий хэлэлцээ хийх, ийм эгуулгатай үйл ажиллагаа явуулсан бол хүчин төгөлдөр бус гэж тооцохоор заажээ. Ийнхүү зохих хуульд хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхахаас явдлыг хориглох зарчим тусгагдсаны зэрэгцээ зарим улс орны үндэсний хууль тогтоомжид хувь хүн хөдөлмөрийн харилцаанд оролцож явцад эдлэх эрхүүдийг тодорхойлоходоо ялгаварлал, гадуурхлаас ангид байх эрхийг багтаасан байх юм. Жишээ нь, Испанийн "Хөдөлмөрчдийн статутын тухай хууль"⁴ (1980 он)-ийн 4 дүгээр зүйлд ажилтын хөдөлмөрлөх эрхүүдийг багцлан тодорхойлсан дотор "арыс ёнг, нийгмийн байдал, шашны болон улс төрийн үзэл бодол, хандлага, Үйлдвэрчний эвлэлд нэгдсэн эсэх, хэлний ялгаанаас ул хамаарч ямар нэг ялгаварлал, гадуурхлаас ангид эрх, эрх чөөтөйт байх"⁵ гэж багтаан оруулжээ.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлд тусгагдсан зарчим нь хүн ажилд авах буюу хөдөлмөрийн гэрээ байгуулах үесэс хөдөлмөрийн гэрээний харилцаа дуусгавар болох хүртэлх үе шатанд үсч хэрэгжих хөдөлмөрийн цогц харилцааг агуулгаараа хамарч байна. Өөрөөр хэлбэл, Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулгадах хамтын гэрээ хэлэлцээр, хөдөлмөрийн гарз, ажил, амралтын цаг, цалин хэлс олговор, хөдөлмөрийн эрүүл, аюулгүй ажиллагаа, сахильтын ба эд хөрөнгийн харилцлага, хөдөлмөрийн маргаан гэсэн цогц харилцааны аль нэг нь үүсч, хэрэгжих явцад хувь хүн, ажилтны ялгаварлах, гадуурхах эсхүл зүй бусаар давуу эрх олгох ямар нэг үйл ажиллагаа явуулж болохгүй гэсэн утгаар тусгагдсан ажээ. Зүй бус гэдэг нь ажил Үүргийн онцлог хэрэгцээ шаардлагатай

⁴ И.Я.Киселев. Сравнительное и международное трудовое право. Учебник для вузов. М., Изд-во "Дело". 1999. С.685.

⁵ И.Я.Киселев. Сравнительное и международное трудовое право. Учебник для вузов. М., Изд-во "Дело". 1999. С.688.

холбоогүй, ажил олгогчийн үзэмж, субъектив хандлагад тулгуурласан үндэслэл байхыг ойлгоно.

Хөдөлмөрийн харилцаанд ялгаварлал, гадуурхал, давуу байдал олгох явдал нь шууд ба шууд бус хэлбэрээр илэрдэг гэж олон улсын практикт үздэг ажээ. Иймээс ч олон улсын хөдөлмөрийн стандартуудад дурдаж буй зарчмын талаар тусгаж тодорхойлоходоо "шууд ба шууд бус хэлбэрээр ялгаварлах, гадуурхан хавчих, давуу байдал тогтоох" гэж тодотголоор томьёолон тусгасан байдаг. Шууд хэлбэр нь хүн ялгаварлагдан гадуурхагдаж болзошгүй үндэслэлүүд гэж хууль тогтоомж, конвенцод нэг бүрчлэн нэрлэгдсэн хүйс, шашин шүтлэг гэх мэт үндэслэлийн аль нэгийг буюу нэг хэсгийг үндэслэн ажил, мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд хувь хүн, ажилтын тэшгүүрүүдээрээ эрхийг хязгаарлах, алдагдуулах явдал ажээ. Шууд хэлбэрээр ялгаварлан гадуурхах нь енөөгийн практикт бараг арилсан гэж үзэж болох юм. Харин шууд бус хэлбэрээр ялгаварлан гадуурхах, давуу байдал олгох хөдөлмөрийн харилцааны суурь зарчмыг зөрчих хүний суурь эрхийг хэндэх нь түгзэмэл байна. Энэ нь, хэлбэр талаасаа бүгдэд адил тэгш боломж олгосон мэт боловч үр дагавар, үзүүлэх нөлөө нь хувь хүн ажилтан тадний аль хэсгийн хөдөлмөр эрхэлж, хөдөлмөрэе шударга үнзлүүлэх, ажлын байраа хадгалах, ажил албан тушаал ахиж давших, ажлаас хөндийрхгүйээр сурч боловсрох зэрэг боломжийг хязгаарласан, алдагдуулсан, супруулсан шинжтэй үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг ойлгодог. Практикт энэ хэлбэрийн ялгаварлал, гадуурхал нь ажил олгогч хэн нэг ажилтан буюу хэсэг бүлэг ажилтанд тодорхой шалгур, үзүүлэлтгүйээр эсхүл яямар шалгур үзүүлэлтийг үндэслэснээ бусад нь тайлбарлах, ойлгуулах үйл ажиллагааг хийхгүйээр зохих эрх эдлүүлах, хангамж олгох, хөнгөлөлт үзүүлэх байдлаар ижэвчлэн илэрдэг. Шууд бус хэлбэрээр илрэх ялгаварлал, гадуурхал

нь шууд хэлбэртэйгээ харьцуулбал илүү хор уршигтай тооцогддог ажээ.⁶ Ийм хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг тогтооход хүндрэлтэй, төдийгүй ямар нэг хууль дурэм журам зэрэг хэм хэмжээний тодорхой зүйл, заалтыг шууд зөрчсөн байдал агуулагдаагүй мэт байдаг. Гэхдээ үүнийг тогтоож болно.

Манай хөдөлмөрийн практикт ялангуяа ажилтны хөдөлмөрийн гэрээг цүлах тохиолдолд шууд бус хэлбэрийн ялгаварлал, гадуурхалыг ажил олгогч гаргадаг боловч үүний нийгмийн зүгээс ч, маргаан шийдвэрлэж буй шүүхийн зүгээс ч хуулиар хориглосон зарчим зөрчигдсөн гэж үзэхгүй байдал үндсэндээ хэвшиж байна. Гэхдээ хөдөлмөрийн маргааны шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр дотор хөдөлмөрийн тухайн харилцаанд ажилтнууд эрх тэгш боломжкор адил хангагдсан байх нهцэлчилж ажил олгогчийн зүгээс хангаж чадсан эсээзд шүүгчид анхаарлаа хандуулж үүнтэй холбоотой дүгнэлтийг тусгасан, үл ялгаварлах зарчимтай холбон тайлбар хийсэн шийдвэр бас байна.

Хувийн нэг компанид ажиллаж байх үед нь "Б"-г эрхэлж байсан ажлын байрны нь хоёр орон тооны нэг хасагдсан гэж хөдөлмөрийн гэрээг нь ажил олгогч санаачлан Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1 дэх хэсэгт заасан "ажилтнуудын тоо цөөрөх" гасэх үндэслэлээр цуцалжээ. Тэрээр шүүхэд хандсан нэхэмжлэлдээ: ажил олгогч орон тоог цөөрүүлэхдээ сонгон шалгаруулалт явуулаагүй, өөрөөс нь сүүлд ажилд орсон, дадлага туршлага мутуйт ажилтан нөгөө үлдсэн орон тоон дээр одоо ажиллаж байгаа гэж дурдсан. Энэ нэхэмжлэгчийн хувьд орон тоо нь хасагдсан үндэслэлээр гэрээг цуцлахдаа ажил олгогч нэг ажлын байрны хоёр орон тоон дээр зэрэгцэн ажиллаж байгаа ажилтнуудад адил тэгш хандаагүй гэсэн утгатай

⁶ Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага. Конвенц залвемжийн хэрэгжилтийг хянан шалгах хорооны суурь конвенцийндаан талаарх ерөнхий судалгаа. УБ.2012 он. 475 дахь тал.

гомдлыг нэхэмжлэлдээ дурдсан байв. Анхан шатны шүүх энэ маргааныг шийдвэрлэсэн шийдвартээ орон тоо нь угүй болсон гэх ч шүүх хэнийг нь яагаад улдээх болсон талаар Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг зааснаар ажилтанд мэдээлэх үүрэгтэй гэж дурджээ. Давж заалдах шатны шүүх уг шийдвэрийг хянаад гаргасан магадлалдаа анхан шатны шүүхийн энэ тайлбарыг үндэслэлтэй гэж дүгнээд ажил олгогчийн зүгээс улдсан ажилтан нь маркетингийн чиглэлээр бакалаврын боловсрол эзэмшсэн нь "Б"-ээс давуу тул улдээсэн гэж тайлбларласныг "уг ажлын байранд маркетингийн чиглэлийн бакалаврын боловсрол бүхий мэргэжил зайлшгүй шаардлагатай гэдгээ хариуцагч тал нотлохгүй байна"⁷ гэж дүгнэжээ. Ийнхүү дурдсан жишэн дээр давж заалдах шатны шүүхийн хувьд орон тооны цөөрүүлэлтийг бодит үндэстэй хийсан гэдгээ нотлох нь ажил олгогчийн хулээх үүрэг болохыг магадлалдаа дурдсан гэж үзэхээр байна. Анхан ба давж заалдах шатны шүүх Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1 дахь хэсэгт байгаа "орон тоо цөөрүүлэх" гэсэн үндэслэлийг ажил олгогч хөдөлмөрийн харицаанаа практикт хэрэглэхдээ ут хуулийн 7 дугаар зүйлд тусгагдсан зарчмын хүрээнд, түүний агуулгад нийцүүлж эрхээ здэлсэн эсхийг ийнхүү зохих журмаар нь давхар хянан шийдвэрлэжээ.

Төрийн өмчийн оролцоотой, хамтарсан хөрөнгө оруулалт бүхий ХХК-д холбогдуулж "Э"-ийн хууль бусаар халагдсан гэсэн нэхэмжлэлд зэрэглэлгүй хуулийн зөвлөхийн зургаан орон тооноос цөөрүүлэлт хийхдээ зөвхөн өөрийнх нь гэрээг цуцалсныг үндэсгүй гэж үзэх байгаагаа дурджээ. Энэ маргааныг талууд гурван шатны шүүхээр шийдвэрлүүлсэн бөгөөд хариуцагч тал орон тоог цөөрүүлэх, нэмэх нь ажил олгогчийн эрх гэж тайлбартаа дурдсан байв. Харин шүүх шийдвартээ зэрэглэлгүй зургаан

⁷ Анхан шатны шүүхийн 2015 оны 5764 дугаар шийдвэр. www.shukh.mn

зөвлөхийн хэн нь цомхогтолд орохыг шийдвэрлэсэн ямар нэг баримт алга, орон тоо өөрчлөх болсон үндэслэл, ийм өөрчлөлт бусад нэгжид хийгдсэн эсэх нь тодорхойгүй байна гэж дүгнэлт хийжээ.⁸ Шүүхийн шийдвэрийн дүгнэлтийг ажилтны орон тоо цаэрүүлэх үедээ нийт зургаан ажилтны хувьд хэн нэг нь хууль бусаар буюу бодит үзүүлэлт шалгуургүйгээр ялгарварлан гадуурхадж гэрээ нь цуцлагдсан, негэх хэсэг нь субъектив шалтгаанаар (найз, нөхөд гэх мат) давуу эрх эзлэж ажилдаа улдсан зэрэгээр хуульд тусгагдсан зарчмын хүрээнд ажилтнаа сонгах эрхээ ажил олгогч эзлэсан эсхийг нягтлан шийдвэрлэжээ гэж дүгнэхээр байна. Нэхэмжлэгчийг нэг ажлын байран дээр зэрэгцэн ажиллаж байгаа бусад таван ажилтны хамт ажил хэргийн шинжтэй бодит үзүүлэлтээр харьцуулж үзсэн эзлэст ажил олгогч гэрээг цуцлах эрхээ здлэх ёстойт байсныг энэ шийдвэрийг уншсан хэн боловч ойлгоохор байгаа юм. Иймэрхүү шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбар, дүгнэлт бүхий шүүхийн шийдвэрийг уншсан бусад ажил олгогч, удирдах ажилт, албан тушаалтан олон тооны цөөрүүлэлт хийхдээ мөрдөх баримтлах хууль зүйн ач холбогдолтой арга зүйг мэдэж авах, хуулийн тодорхой зохицуулалтын агуулга, хэрэглэх нөхцөлийн талаар мэдлэгтэй болох юм. Ингэснээр шүүхийн шийдвэр нь зөвхөн маргаан шийдвэрлэх төдийгүй хууль сурталчлах, таниулах, соён гэгээрүүлэх учир холбогдолтой.

Хувийн компанид холбогдуулж ажилд эгүүлэн тогтоолгож ажилгүй байсан хугацааны цалинтай тэнцэх хэмжээний олговор гаргуулах, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын дэвтэрт нөхөн бичилт хийлгүүлэх шаардлага бүхий "У"-ын нэхэмжлэлээр үүссэн маргааныг шүүх хянан хэлэлцэх үед нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн зүгээс хүний нөөцийн менежер гэсэн орон тоон дээр дервэн хүн байсан, гэтэл эднээс "У"-г яг ямар үндэслэл

⁸ Улсын Дээд Шүүхийн 2012 оны 281 дугаар тогтоол www.shukh.mn

шалтгаанаар сонгон авч цөөрүүлэлтэд хамаарулсан нь тодорхойгүй байна гэж мэтгэлцэн. Энэ нь хөдөлмер эрхэлж байх уедээ ажилтан аливаа ялгаварлал, гадуурхлаас ангид байх эрхийнхээ дагуу орон тоог цөөрүүлэхдээ адил буюу нэг нэрийн ажлын байрны хэд хэдэн орон тоон дээр зэрэгцэн ажиллах буй ажилтнуудаас ямар нэг ялгаварлал, гадуурхалгүйгээр ажил үүргийн холбогдолтой үзүүлэлт шалгуурын дагуу сонголт хийснээс ажил олгогч нотлох үүргээ биелүүлсэн эсэхийг л шаардсан хэрэг гэж үзэх нь үндэстэй.

Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1 дэх хэсэгт заасан ажилтны тоог цөөрүүлж гэсэн үндэслэлтийн холбоотой гэрээг цуцалсан маргааны шүүх шийдвэрлэхдээс ихэвчлэн ялгаварлан гадуурхажыг хориглоо зарчмаас салангид, түүнтэй холбон авч үзэхгүйгээр харин ч хэнийгээ авч үлдэх нь ажил олгогчийн эрх мэт шийдвэртээ тайлбарлах нь их байна.

Шүүхийн шийдвэрт: Хөдөлмөрийн тухай хуульд орон тоо хасагдах буй тохиолдолд (энэ нь орон тоо хасагдах бус харин орон тоог цөөрүүлсэн тохиолдолд байсан юм. Б.У)-д хуучин ажилтнуудаас хэнийг нь сонгож үлдээх шалгуур журамлагдаагауй, энэ талаараа байгууллагад дагаж мөрдөх тухайлсан дотоод журам үйлчилдэг гэх байдал тогтоогоогүй нөхцөлдөө өөрийн байгууллагад ажиллуулах ажилтныг сонгох ажил олгогчийн эрхийг хязгаарлах эрх зүйн үндэс байхгүйгээ тайлбарласан байна. Эх нэг шийдвэрт ажилтны тоог цөөрүүлсэн үед ажил олгогч нь тухайн албан тушаалд хэнийг авч үлдэх талаараа хуульд ямар нэг зохицуулалт байхгүй учраас үйлчлэгчийн наажмын онцлогийг харгалзан хамт олны хурлаар хэлэлцэж хамт олны санаалыг үндэслэн "A"-г ажлаас чөлөөлөх асуудлыг шийдвэрлэсэн ажил олгогчийн шийдвэрийг буруутгах

боловсруулж гэсэн байх юм. Шүүхийн здгээр шийдвэрт Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1 дэх хэсэгт байгаа ажилтны тоо цөөрүүлж үндэслэлийг ажил олгогч хэрэглэх эрхтэй, энэ нь ямар нэг хязгаарлалтгүй, зохицуулалтгүй мэт тайлбарлажээ. Гэтэл эрх зүйн онолын үүднээс хэн нэгний эрх нөгөө нээнтэй эрхээр хязгаарлагддаг гэж үздэг, хөдөлмөрийн харилцаанд ажил олгогчийн эрхийг түүнтэй гэрээнд харилцаа тогтоосон нөгөө тал-ажилтны эрхтэй аль болох тэнцвэртэй түвшинд, байлагах зорилтыг Хөдөлмөрийн тухай хууль агуулдаг билээ. Иймээс ч уг хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт: ...талуудын харилцан эрх тэгш байдлыг хангах зорилт тусгаждээ. Чухам энэ зорилтын хүрээнд л ажил олгогч ба ажилтны хоорондын хөдөлмөрийн эрх зүйн харилцаа хэрэгжих ёстой. Үүнээс гадна энэ хуулийн 7 дугаар зүйлд агуулга нь тусгажсан зарчим тухайн тохиолдолд ажилтан ажил олгогчийн эрх үүргийн тэнцвэрийг хангахад чиглэгддэг. Үүний нэг илрэл нь ажилтны тоо цөөрөх болсон тохиолдолд нэг ажил, албан тушаалын хэд хэдэн орон тоонд зэрэгцэн ажиллаж байгаа ажилтнуудаас хөдөлмөрийн гэрээ нь цуцлагдах ажилтныг ажил хэрэгч байдалтай нь холбоогүй субъектив үндэслэлээр ялгаварлгадан гадуурхагдах халагдах, бусад нь зүй бус давуу эрхээр үлдэх явдлаас сэргийлж түүний "алагчлагдах явдлаас ангид байх эрх"-ийг хангах нь ажил олгогч давуу болопцоогоо хууль бусаар ашиглахгүй, ялгаварлан гадуурхажыг хориглоо хуулиар хүлээлгэсэн үүргийг нь гүйцэтгүүлэх замаар талууд хоорондын тэнцвэр эрх тэгш байдал хангагдах юм.

Хөдөлмөрийн харилцаанд ялгаварлал, гадуурхал, давуу байдал тогтоохыг хориглоо зарчмын а) Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулагдах бүх харилцааны хүрээнд агуулга нь хэрэгжихээр хуульнлагдсан. Тайлбарлал, аж ахуйн нэгж, байгууллага

^{*} Улсын Дэд Шүүхийн 2015 оны 1122 дугаар тогтооюус www.skuukh.mn сайтас

¹⁾ Давх заалдах шатны шүүхийн 2015 оны 20 дугаар магадлалаа www.skuukh.mn сайтас

жилийн эцсийн ашгаасаа ажилтнууддаа нэмэгдэл, урамшуулалт олгоо коршийдвэрлэхдээ эрхэлж буй ажил, албан тушаалыг нь үндэслэж бус, харин ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан ажил үргийн гүйцэтгэл, түүний үнэлгээг харгалзан ялгаатай хэмжээ тогтоох нь дурдаж буй зарчмын агуулгад нийцэлж байгаа хэрэг юм. Мөн ажлын орчин нэхцэлийг өөрчлөн тохиуулж зарим ажлын байрны сул орон тоон дээр хөгжлийн бархшээлтэй хүнийг авч ажиллуулах нь уг хүнд давуу байдал олгож бусад хүний хувьд орох эрхийг нь хязгаарласан хэрэг бус, харин эрүүл мэнд, бие махбодийн тогтолцоо зэргээсээ болж хөдөлмөрлөх эрх нь бусадтай харьцуулахад хязгаарлагаад байгаа хүнд тэгш боломж олгоход чиглэгдсэн. Энэ утгаараа ялгаварлан гадуурхах явдлыг хориглох зарчмын агуулгад нийцсэн үйл ажиллагаа болно. Энэ мэгчилэн ялгаварлал, гадуурхал, давуу байдал тогтоохыг хориглох зарчим нь зөвхөн гэрээг цуцлахад бус энэ хуулиар зохицуулагдах бүхий харилцааны аль ч шатанд агуулгаараа хэрэгжинэ. б) Энэ зарчим тодорхой нэг буюу нэг хэсэг хүний хувьд зөрийгдэж буй зсэхийт тогтоохын тулд тухайн нехцэл, тохиолдолд бусадтай нь харьцуулж үзэх ёстай. Жишээ нь, сул, чөлөөтэй ажлын байранд сонгон шалгаруулалт явуулах тохиолдолд ажилд орлогыг гориолж ирсэн боловч шалгаруулалтад тэнцээгүй хүн өөрийгөө нас, хүйс гэх мэт зүй бус үндэслэлээр ялгаварлан гадуурхагдлаа гэж үзэж байгаа тохиолдолд гомдлыг шийдвэрлэхийн тулд өрслөдөг бусад хүн түүн дотроо эсрэг хүйсийн, нас залуу хүмүүсийн шалгаруулалтад орсон байдал, оноо үнзлэгээ авсан байдлыг гомдол гаргагчийнхтай зэрэгцүүлж дүгнэх зэрэг, в) Хөдөлмөрийн тухай хуулийн үйлчилгээнд хамрагддаг хөдөлмөрийн цогц харилцааны дотроос ажил олгогч илрэхий давуу байдлаа ашиглан ажилтны ялгаварлан гадуурхах эсхүл зүй бусаар давуу байдал олгож бүрэн бололцоог агуулсан тийм хэсэг харилцаа бий. Ажилд авах, хувь хүнтэй байгуулах хөдөлмөрийн

гэрээний төрөл (хөдөлмөрийн гэрээг хугацаагүй байгуулах)-ийг сонгох, ажилд авах, цалин хэлс тогтоох, урамшуулах, ажил үргийг дүгнэх, албан тушаал ахиулах, байгуулалын зардааар сургалтад хамруулах, хөдөлмөрийн гэрээний хугацааг сунгах, ажил олгогчийн санаачилгаар хуульд заасан зарим үндэслэлээр гэрээг цуцлахад холбогдсон харилцааг энд зориуд нэрлэх болох юм. Иймд эдгээр харилцаатай холбоотой үүссэн хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэхдээ шүүх ажил олгогч ёөрийн давуу байдаддад дулдүйдан ялгаварлах гадуурхах хандлага гаргасан эсэхийг давхар анхаарч байвал зохино, г) Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлд тусгагдан бэхжэсэн зарчим нь "тунхаглал"-ын шинжтэй бус, харин хөдөлмөрийн харилцааны талтуудад тодорхой эрх, үргийг бий болгосон "зохицуулант"-ын шинжийг агуулдаг. Энэ зүйлд заасан зарчмын хүрээнд ажил олгогч нь хөдөлмөрийн харилцаанд оролцохдоо хэн нэгнийг зүй бусаар ялгаварлах гадуурхсан эсхүл зүй бусаар хэн нэгэнд давуу эрх олгосон үйлдэл (эс үйлдэхүй)-г гаргахгүй байх үүрэг хүлээнэ. Харин ажилтны болон ажилд орох гэж буй хувь хүний хувьд хөдөлмөрийн харилцаанд оролцохдоо аливаа ялгаварлал, гадуурхлаас ангирийн байх эрхийг энэ зарчмаар олгож байна. Иймд хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэхдээ шүүгчид уг маргаантай тохиолдолд ажил олгогч энэ үргээ биелүүлсэн эсэхийг анхаарч байх нь зүйтэй.

ДҮГНЭЛТ

1. Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлд тусгагдан бэхжэсэн хөдөлмөрийн харилцаанд ялгаварлал, гадуурхал, давуу байдал тогтоохыг хориглох зарчим нь Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас тунхагласан ажил мэргжээл, хөдөлмөрийн харилцаанд суурь зарчмуудын нэг төдийгүй хувь хүн ялгаварлал,

- гадуурхлаас ангид байж хөдөлмөрлөх үндсэн эрхийг агуулгаараа бий болгодог.
2. Өмнө дурдсанд үндэслэн Хөдөлмөрийн тухай хуульд энэхүү зарчмыг тусгаж агуулж байгаа 7 дугаар зүйл дэх хэм хэмжээнүүд уг хуулиар зохицуулгадж хөдөлмөрийн цогц харилцаанд хүний үндсэн эрх хэрэгжихэд шаардлагатай нэг чухал баталгаа тогтоон ажил олгогч ажилтан тус бүрт тодорхой эрх, үүргийг хүлээлгэсэн хэм хэмжээ юм. Ажил олгогч нь зүй бус ямар нэг ялгаварлал, гадуурхал үндэслгүй давуу эрхийг бий болгосон, ийм үр дагаврыг агуулсан шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг гаргахгүй, хийгүй байх үүргийг ажилтан (хувь хүн) хөдөлмөрийн харилцаанд оролцоходо ялгаварлал, гадуурхлаас ангид байх эрхийг тухайн зарчим агуулгаараа бий болгодог.
3. Ялгаварлал, гадуурхал, давуу байдал тогтоохыг хориглох зарчим нь Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулгагдаг бүх харилцаанд хамаараах бөгөөд агуулга нь эдгэр харилцаа тус бүрт хэрэгжих ёстой.
4. Зарчмын хэрэгжилтэд хөдөлмөрийн маргаан шийдвэрлэдэг байгууллагууд түүн дотроо шүүх чухал үүрэг гүйцэтгэнэ; "Ажилтын тоог цөөрүүлэх" гэсэн үндэслэлээр ажил олгогч санаачлан ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцлах тохиолдолд ажил олгогч хөдөлмөрийн харилцаанд ялгаварлах, гадуурхах, давуу байдал тогтоохыг хориглох зарчмын хүрээнд хүлээсэн үүргээ зөрчин ажилтны ялгаварлал гадуурхлаас ангид байх эрх хөндөгдхөн эрэдээ болдит оршдог. Үүнийг шүүх хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх үедээ зайлшгүй хारгалзаж хэд хэдэн ажилтнаас чухам хэнийн нь орон тоог хасахыг узэмжээрээ, субъектив байдлаар бус, харин мэргэжлийн түвшин, хөдөлмөрийн Үр дүн, бүтээмж зэрэг зайлшгүй шинжтэй бодит шалгуурыг үндэслэн шийдвэрлэсэн нотлох үүргийг ажил олгогч хариуцагч талд үүнийгээ нотолж байгаа эсэх зэрэгт анхаарлаа хандуулж шийдвэртээ энэ талаар тайлбарлах, зохиц дүгнэлт тусгаж байх нь шийдвэрийн агуулга, дүгнэлт, тайлбар шинжлэх ухааны үндэслэгээтий, оновчтой болоход нөлөөлнө.

---00---

"Хуульчдын номын сан"-д ирсэн шинэ номын мэдээ



Монгол улсын бэлчээр ашиглалт, хамгаалалт (эрх зүйн судалгаа). УБ., 2016.-356х.

Доктор М.Сувд бэлчээр ашиглалт, хамгаалалтын асуудлын түүхэн эх сурвалж, өнөөгийн зохицуулалт, бэлчээр ашиглалтын төлөв байдлын судалгаа, өөрийн боловсруулсан Монгол улсын бэлчээрийн тухай хуулийн төсөл, түүний узэл баримтлал холбогдох баримт бичгүүд болон төрийн болон иргэний нийгмийн байгууллагаас боловсруулсан бэлчээрийн тухай хуулийн төслийдийг он дарааллаар бүтээлийн хавсралт болгон тусгасан. Хууль санаачлагч, салбарын мэргэжилтэн ажилтан, хуульч, багш, оюутнуудад зориулан хэвлэлжээ.

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ



ҮЕПГ-ын Сургалт, судалгааны төвийн
сургагч багш, хяналтын прокурор
Г.Оюунболд

ТУЛХҮҮР ҮГ:

Гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн, гэр бул, гэмт хэрэг, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Захиргааны зерчил.

ТОВЧЛОЛ:

Энэ өгүүлэлд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдсантай холбогдуулан хуулийг хуулийг нэг мөр хэрэгжүүлэх шаардлага байгааг онцолжон. Энэ хүрээнд тус хуулийн зарим зүйл заалтын бусад хуультай холбогдох зарим ойролцоо төрлийн гэмт хэргээс ялган зүйлчлэх талаар дурдсан болно.

Нэг. Суурь нөхцөл

Криминологийн судалгаанаас үзвэл гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхийг урьд нь гэмт хэрэг, зерчил аль алинд тооцдоггүй байснаас шалтгаалж онц хүнд гэмт хэрэг буюу хүний санаатай алах, хүнд гэмтэл санаатай учруулах зэрэг хэргийн үзүүлэлтэд


шууд нөлөөлж байгааг нотолсон байна.¹ Цагдаагийн байгууллагад бүртгэгдэг 100 мянга орчим зөрчлийн 20-30 хувийг "танхайрах" захиргааны зерчил зээлж байгаа боловч бодит байдал дээр уг зөрчлийн дийлдэх нь гэр бүлдээ агсан тавьсан, сэтгэл зүйн дарамт учруулсан, байнга зодсон шинжтэй үйлдлүүд байна. Нэг жилд бүртгэгдэг 30 орчим мянган танхайрах зөрчлийн 60 гаран хувьд нь Захиргааны хариуцлагын тухай хууль (Цаашид ЗХТХ)-ийн 21 дүгээр зүйлд заасны дагуу торгох эсхүл 7-30 хоног баривчлах шийтгэл оногуулдаг байна. Хэсгийн байцаагчтай хийсан ярилцлагын судалгаанаас үзвэл сардаа 3-4 удаа "танхайрах" захиргааны зөрчилд баривчлах шийтгэл оногууллааар материалжуулан шүүхэд шилжүүлдэг гэх ба здгэр нь мен чанартай будг гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй үйлдлүүд байдаг аж.²

Нэгэн судалгаанд хамрагдсан респонтентуудын 15,2 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлт хамгийн их гарч байна гэсэн төдийгүй нийгмийн тогтвортой байдлын хамгийн чухал нэгж болох гэр бүлийн хүрээнд гэмт хэрэг их үйлэдэгж байгааг таван хүний нь хүлээн зөвшөөрсөн нь анхаарал татаж байна.³ Цаашид Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг нэг мөр хэрэгжүүлэх шаардлага байгаа нь дээрхээс ажиглагддаг.

¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинжилсан найруулжин төвлөр боловсруулажад ашигласан судалгааны тайлангаас. 2014 он.

² Эрүүгийн болон Захиргааны хариуцлагын тухай хуулийн харьцуулсан судалгаа. ХЗХ. 2007 он /судалгааны хавсралт. фокус бүлгийн ярилцлагатас/.

³ "Гэмт харгийн шалтвам, нөхцөл" Судалгааны тайлан. хэдхяя, ФСЭХ. 2005 он.



Гэмт хэрэг үйлдэх болон түүнд орооцолдоход тухайн хүний эргэн тойрын хүмүс, нийгмийн орчин, тухайн тодорхой тохиолдол нөлөөтэй ч хувь хүний өөрийн ухамсар, хүмүүжил гол хүчин зүйл болдог. Хувь хүний ухамсар, хүмүүжилд хүчирхийлэлд дасан зохицох хандлага хүчтэй нөлөөлж энэ удаан хугацааны дараа өөрөө хүчирхийлэл үйлдэх хэлбэрээр илрэн гардаг. Хүчирхийлэл хүчирхийлийг төрүүлдэг гэдэгчлэн гэр бүлийн орчин таагай байх нь гэмт хэрэг гарах шалтгаан болдог төдийгүй нэг жилд 300 орчим гарч, бүртгэгддэг "хүнийг санаатай алах" гэмт хэрэг 80 орчим хувь гэр бүлийн орчинд үйлдэгдсэнээс харагдаг.⁴ Дээр дурдсан криминологийн судалгаанаас дүгнэн үзэг энэ нь нийгмийн феномен буюу үзэгдэл болсон байна. Цаашид гэр бүлийн хүчирхийлийг гэмт хэрэг зөрчилд тооцож даамжрахаас урьдчилан сэргийлэх, үр дүнтэй арга хэрэгслээр хүчирхийлэл үйлдэгчид нөлөөлөх шаардлага нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг бусад хуультай уялдуулан гаргах үндсэн нөхцөл болсон байна.

Хоёр. Хуулийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /шинэчилсэн найруулга/ энэ оны 2 дугаар сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан энэ төрлийн гэмт хэрэг, захиргааны зөрчлийг ялгах, ойролцоо төрлийн зарим гэмт хэрэгээс ялган зүйлчлэх асуудал зайлшгүй хөндөгддэж байна.

⁴"Homicide" 3 Термандах, Г.Цоодол Хамтын бүтээл. 2008 он

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдсан холбогдуулан Захиргааны хариуцлагын тухай хуульд 22¹ дүгээр зүйл болох "Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх" гэсэн захиргааны зөрчлийг шинээр нэмж тусгасан байна. Захиргааны зөрчлийн диспозицийг "Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, хүсэл зоригийн нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийгүй байхыг албадсан, мөрдэн мэшээсэн, заналхийлээн, бусадтай харилцахыг хязгаарласан, гутаан доромжилсон, хуваарыт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захирсан зарцуулах эрхэд халдсан бол" гэж авасан байна.

Энэ захиргааны зөрчлийн шийтгэлийг шүүгч оногдуулах бөгөөд 7-30 хоногийн хугацаатай баривчилж, албадан сургалтад хамруулахаар тусгасан байна. Өөрөөр хэлбэл энэ нь түр хугацааны зохицуулалт болж байна. Хууль тогтоогчдоос Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга болон Зөрчлийн тухай хууль хэрэгжих эхлэх хүртэл хугацаанд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудад нэмэлт, өөрчлөлтийд оруулсан нь зөрчил гаргагчдад нөлөөлөх зорилготой болно.

ЗХТХ-ийн 4 дүгээр зүйл болох захиргааны шийтгэлийн хугацаа нь 7-30 хоногийн баривчлах хугацаанаас хамаарах бөгөөд едерт 2 цагаас ихгүй байхаар "Албадан сургалтад хамруулах шийтгэлийг хэрэгкүүлэх журам", "Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрт" тус тус заасан байна. Дээрх журмыг хуулиар эрх олгосны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн баталсан.

"Согтуурах, мансуурах донтой евчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай" хуулийн 3 дугаар зүйлд

оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр албадан сургалтад хамруулах шийтгэлийг баривчлах шийтгэлийг эдэлж байх хугацаанд хэрэгжүүлэхээр /3 дугаар зүйлийн 3.6/, албадан сургалтыг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн гүйцэтгүүлж болохоор /3 дугаар зүйлийн 3.7/, энэ шийтгэлийг хэрэгжүүлэх журмын хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн гарын гишүүн батлахаар /3 дугаар зүйлийн 3.8/ тус тус заасан байна.

Практикт ЗХТХ-ийн 21 дүгээр зүйл буюу “Танхайрах” захирагааны зөрчлеөр шалгаж, шийдвэрлэж ирсэн гэр булийн хамаарал бухий харилцаатай хүмүүсийн хооронд гарсан зарим үйлдлийг ЗХТХ-ийн 22¹ дүгээр зүйл болох “Гэр булийн хүчирхийлэл үйлдэх” гэсэн зүйл, хэсгээр шалгаж, шийдвэрлэнз.

Өөрөөр хэлбэл гэр булийн хүчирхийллийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйн шинжийг тодорхой ялангаа залгах бичсэн тул хэсгийн байцаагч, хэв журмын байцаагч, хэрэг бүртгэгчээс захирагааны хэрэг бүртгэлтийн материалыг хуульд заасны бүрдүүлж, шүүгчээр шийдвэрлүүлнэ.

Хууль тогтоогчоос Гэр булийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Захирагааны хариуцлагын тухай хууль, Эрүүгийн хууль, Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захирагааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулиудад 2016 оны 12 сарын 22-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Эрх бүхий цагдаагийн алба хаагч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас шалгасан эрүүгийн хэргийг хянах явцад Эрүүгийн хуулийн 100 дугаар зүйл “Тарчлаах” болон шинээр нэмж оруулсан 120¹ дүгээр зүйл “Гэр булийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийг хэрхэн ялангаа зүйлчлэхэд

дараах шинжийг харгалzan үзүүлэх үнд:

1.гэр булийн хамаарал бухий харилцаатай хүний эсрэг үйлдсэн байх

2.байнга зодсон, харгис хэрцгийн харьцаан, догшин авирласан, тарчлаасан, хуваарыт болон дундын эд хөрөнгөе эээмшиж, ашиглах, захиран зарцуулах эрхад халдсан үйлдэл, эс үйлдэхүйн байхыг шаардана.

Хууль тогтоогчоос Эрүүгийн хуулийн 120¹ дүгээр зүйлд тайлбар оруулсан бөгөөд “гэр булийн хамаарал бүхий харилцаатай хүн” гэдэгт Гэр булийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг ойлгохоор заажээ.

Үүнд дараах хүн хамаарна: эхнэр, нөхөр, гэр булийн бусад гишүүн, хамтран амьдрягч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдээрийн асрамж, хамгаалаалтад байгаа этгээд, тухайн гэр бүлхамт амьдарч байгаа этгээд; тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дуу; гэрлэлтээ цүцлүүлсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр булийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд нэгэн адил хамаарна.

Өөрөөр хэлбэл энэ гэмт хэрэг нь эрх мэдлийн хувьд нэгнээсээ харилцан хамааралтай хүмүүсийн хооронд үйлдэгдэг онцлогийг анхаарах нь зүйтэй юм. “Тарчлаах” гэмт хэргийн хувьд гэр булийн хамаарал бухий харилцаа байхыг шаардахгүйгээр энэ гэмт хэргээс ялгагдана. Түүнчлэн тарчлаах болон догшин авирлах гэсэн үйлдлийг энэ гэмт хэргийн бүрэлдэхүүнд тусгасан учраас ЭХ-ийн 99, 181 дүгээр зүйлээр давхар зүйлчлэхгүй.

Гурав. Хохирогчийг хамгаалах нь

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийг хамгаалахын тулд ЭБШХ-ийн 72 зүйлд

нэмэлт, өөрчлөлт оруулж, 76 дугаар зүйлийг бүхэлд өөрчилсөн бөгөөд урьд нь “эд хөрөнгө захиран зарцуулах эрхийг хязгаарлах” гэсэн албадлагын бусад арга хэмжээг “Тодорхой эрхийг хязгаарлах” арга хэмжээ болгосон байна.

Албадлагын энэхүү арга хэмжээ авах үндэслэл, журмыг “сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах, гэрч, хохирогчид нөлөөлөх үндэслэлтэй бол тогтоосон газар, нутаг дэвсгэрээс гарч явах, тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хориглох, эд хөрөнгөе захиран зарцуулах эрхийг түр хугацаагаар шүүх, прокурор, түүнчлэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь прокурорын зөвшөөрөлтэйгээр тогтоол гарган хязгаарлах болно.” гэж өөрчлен найруулсан байна.

ЭБШХ-ийн 76 дугаар зүйлийн 76.2 дахь хэсэгт оруулсан нэмэлтэд “Тодорхой эрхийг хязгаарлах албадлагын арга хэмжээг аваадаа тогтоосон газар, нутаг дэвсгэрээс гарч явах, тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хориглох, эд хөрөнгөе захиран зарцуулах эрхийг хязгаарлаж байгааг тогтоопд нэг бүрчлэн заана.” гэсэн тул хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас ирүүлж байгаа эрүүгийн хэрэг, тогтоолтой танилцаж батлахаа дээрх үндэслэлбайгаа эсэхийг шалгана.

Түүнчлэн ЭБШХ-ийн 76 дугаар зүйлийн 76.8 дахь хэсэгт “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь сэжигтэн яллагдагч, шүүгдэгчид энэ хуулийн 76.1 дэх хэсэгт заасан албадлагын арга хэмжээг зөрчсөнөөс үүсэх үр дагаврыг урьдчилан танилцуулна.” гэснийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад анхаарвал зохино.

Эрүүгийн хуулийн 120¹ дүгээр зүйл “Гэр бүлийн хүчирхийлэлтэй үйлдэх” гэсэн хэргийг шинээр нэмж тусгахдаа гэрч, хохирогчийг

хамгаалах зорилгоор хууль тогтоогооч албадлагын энэхүү арга хэмжээг өөрчилсөн болно.

Мөн энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт эрх олгож заасны дагуу “Хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам”-ыг Улсын ерөнхий прокуророос Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран баталсан болно. Энэхүү журамд гомдол, мэдээллийг шалгахаас авахуулаад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хохирогчийн аюулгүй байдлыг хангах, тухайн хэргийг шалгаж буй эрх бүхий албан хаагч, прокуророос ямар эрх хэмжээтэй оролцох талаар тусгайлсан зохицуулалтууд туссан болно.

Мөн шинээр батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийн дөрөвдүгээр бүлэг болох “Цагдаагийн байгууллага, алба хаагчаас тодорхой ажиллагаа явуулах журам”-ын 23 дугаар зүйл.Шаардлага тавих, 24 дүгээр зүйл. Тайлбар авах, 25 дугаар зүйл.Хүний бичиг баримт шалгах, 26 дугаар зүйл. Түр саатуулах, 28 дугаар зүйл.Орон байр, бусад газарт нэвтрэн орох, 29 дүгээр зүйл.Үзлэг хийх, 30 дугаар зүйл. Эд зүйл, баримт бичиг түр хураан авах, 32 дугаар зүйл.Согтуурсан, мансуурсан байдлыг шалгах, 46 дугаар зүйл.Гэр булийн хүчирхийллийг таслан зогсох гэсэн зүйлийг захирагааны зерчил шалгахад хэрэгжүүлж ажиллана.

Дөрөв. Шалтгаан нөхцөлийг судлах

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 17 дугаар зүйлд Прокурорын байгууллагын чиг үүргийг заахдаа “Прокурорын байгууллага гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүний амь нас хохирсон тохиолдол бүрийг нарийвчлан судалж дүгнэлт гаргах, үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар холбогдох байгууллага,

албан тушаалтанд мэдэгдэл хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавина" гэсэн байна.

Дүгнэлт

Цаашид прокуророос "Хүнийг санаатай алах", "Амиа хорлох нехцөл, байдалд хүргэх" гэсэн зүйл, хэсгээр шалгагдаж байгаа эрүүгийн хэрэгт хяналт тавих явцдаа гэр булийн

хүчирхийллээс үүдсэн шалтгаан нехцөлийг бодитой тогтоож, энэ тухай танилцуулга, дүгнэлт бичиж хэвших шаардлагатай.

Иймд хууль шинээр хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан гарсан журам, заавруудтай сайтар танилцах, түүнийг хэрэгжүүлэхдэд анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

---oo---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛӨНГИЙН ХЭВЛЭХ ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны "Шүүх, эрх зүйн шинчлэлт" төслийн хүрээнд хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдийг суурилуулж 2008 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр ашиглалтад оруулсан.

Хэвлэх үйлдвэр нь хүрээлэнгийн тогтмол хэвлэл "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл", "Хууль дээдлэх ёс" сэлтүүл мөн тус хүрээлэнгээс эрхлэн гаргаж байгаа эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, эрх зүйн ном, гарын авлага, сургалт, сурталчилгааны материал хэвлэхээс гадна харилшагч байгууллагуудын захиалгат хэвлэлийн бүтээгдэхүүнийг хэвлэж байна.

B5 форматтай, 1+1 өнгөтэй, 25 хэвлэлийн хуудас бүхий 1500 ширхэг номыг ажлын 5 өдөрт үйлдвэрлэн бэлэн болгох хүчин чадалтай.

Тус хэвлэх үйлдвэр нь жилдээ 80-110 нэр төрлийн ном, сэлтүүл, сонин, гарын авлага хэвлэж байна.



ХОЛБОО БАРИХ УТАС: 11-323317, 99057342

ХАЯГ: Улаанбаатар-46, Чингелтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Бага тойруу /15160/, Хуульчдын гудамж 1,
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн байр

ЗАХИРГААНЫ ГЭРЭЭНД ИРГЭНИЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ НӨХӨН ТОХИРУУЛЖ ХЭРЭГЛЭХ АСУУДАЛ



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн дэдлагажаач бааш, хууль зүйн магистр Т.Мөнх-Эрдэнэ

ТУЛХҮҮР УГ:

Захиргааны гэрээ, нийтийн эрх зүйн гэрээ, эзлэцэл, субсидиар байх шиник. Захиргааны ерөнхий хууль, ХБНГУ-ын Захиргааны үйл ажиллагааны тухай хууль, Иргэний хууль.

ТОВЧЛОЛ:

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Захиргааны ерөнхий хууль (цаашид "ЗЕХ" гэх)-ийг баталснаар анх удаа Монгол Улсын захиргааны эрх зүйн ерөнхий аянг бие даасан материаллаг хуультай болсон билээ.

Уг хуулийн Гуравдугаар бүлэгт "Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа"-г бүхэлд нь хуульчлан журамлаж, 11 дүгээр зүйлд "Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны хэлбэр"-ийг захиргааны акт гаргах, захиргааны гаралт байгуулахаар, захиргааны хэм хэмжээний акт батлах гэсэн үндсэн хэлбэрүүдтэй байхаар тодорхойлж

өгсөн нь нийтийн захиргааны бүхий л байгууллагын үйл ажиллагааны үндсэн хэлбэрийг тогтоож, улмаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль дээдлэх, хуульд үндэслэх зарчмын дагуу ажиллах, тэдгээр зарчим, үнэт зүйлс амьдрал дээр бодитой хэрэгжих эрх зүйн үндсийг улам бур баталгажуулав.

Дээрхээс "захиргааны гэрээ" гэсэн бие даасан эрх зүйн институт хууль зүйн утаараа Монголын захиргааны эрх зүйд шинээр нэвтрч, энэ нь нэг талаар Монголын захиргааны эрх зүй нь орчин үед дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн Германын "сонгодог" захиргааны эрх зүйтэй хэл нийлүүлэн алхах томоохон ач холбогдолтой болсон бөгөөд нөгөө талаараа "захиргааны гэрээ" хэмээх эрх зүйн институтийг Монголын хууль зүйн шинжлэх ухаанд сайтар судлах, хууль зүйн шинжлэх ухааны оноп, арга зүй, зарчимд үндэслэн үр нөлөөтэй сурьшуулах, улмаар нэг мөр хэрэглэх зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

§1. Захиргааны гэрээнд Иргэний хуулийг хэрэглэх үндэслэл

Нэг. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Захиргааны ерөнхий хууль (цаашид "ЗЕХ" гэх)-ийг баталснаар анх удаа Монгол Улсын захиргааны эрх зүйн ерөнхий аянг бие даасан материаллаг хуультай болсон билээ.

Уг хуулийн Гуравдугаар бүлэгт "Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа"-г бүхэлд нь хуульчлан журамлаж, 11 дүгээр зүйлд "Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны хэлбэр"-ийг захиргааны акт гаргах, захиргааны гаралт байгуулахаар, захиргааны хэм хэмжээний акт батлах гэсэн үндсэн хэлбэрүүдтэй байхаар тодорхойлж

гэрээ байгуулах, захирагааны хэм хэмжээний акт батлах гэсэн үндсэн хэлбэрүүдтэй байхаар тодорхойлж өгсөн нь нийтийн захирагааны бүхий л байгууллагын үйл ажиллагааны үндсэн хэлбэрийт тогтоож, улмаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль дээдлэх, хуульд үндэслэх зарчмын дагуу ажиллах, тэдгэр зарчим, үнэт зүйлс амьдрал дээр бодитой хэрэгжих эрх зүйн үндсийг улам бүр баталгаажуулав.

Дээрхээс "захирагааны гэрээ" гэсэн бие даасан эрх зүйн институт хууль зүйн утгаараа Монголын захирагааны эрх зүйд шинээр нэвтрэч, энэ нь нэг талаар Монголын захирагааны эрх зүй нь орчин үед дэлхий нийтээр хулээн зөвшөөрсэн Германын "сонгодог" захирагааны эрх зүйтэй хөл нийлуулэн алхах томоохон ач холбогдолтой болсон бөгөөд негеэ талаараа "захирагааны гэрээ" хэмээн эрх зүйн институтийг Монголын хууль зүйн шинжлэх ухаанд сайтар судлах, хууль зүйн шинжлэх ухааны онол, арга зүй, зарчмын үндэслэн үр нөлөөтэй суурьшуулах, улмаар нэг мөр хэрэглэх зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

ХБНГУ-ын захирагааны эрх зүйн онолын хамгийн нэр хүндтэй төлөвлөгөө Otto Mayer¹ захирагааны акт хэмээх эрх зүйн бие даасан институтийн сонгодог томъёоллыг² онолын өндөр түвшинд бий болгосон бөгөөд тэрээр захирагааны эрх зүй нь захирах-захирагдах шинжтэй харилцаанд сууриссан, нэг талд нь териин эрх мэдлийг хэрэгжүүлэгч эрх бүхий этгээд (=захирага), негеэ талд нь иргэн, хуулийн этгээд оролцдог

¹ Otto Mayer. 1846 оны 3 дугаар сарын 29-ний өдөр Германы Форт хотноо мэндэлж, 1924 оны 8 дугаар сарын 8-ны өдөр Хильпертсай хотноо вед болсон. Тэрээр Германын захирагааны эрх зүй, сум хийдийн эрх зүйн оногч, хуулын-эрдэмтэн байсан. 1864 онд Эрлангенийн Их Сургуульд элсэн орж суралцаад. 1868 онд улсын наадмын шалгалтаваа егч тэгсөн. 1869 онд улсын хөбөрдүгээр шалгалтаваа егч, улмөвр хууль зүйн докторын зэрэг хамгаалсан. 1872 оноос Мюльхайзен хотноо имевелгеч, Ёнгөвлөгчийн танхимын таргүүнээр ажилласх Байгаад 1882 оноос Страсбургийн Их Сургуулийн профессор, 1902-1903 онд тус сургуулийн ректор, 1903 оноос Лайпцигийн Их Сургуулийн профессор. 1913-1914 онд тус сургуулийн ректороор тус тус ажиллаж байжээ.

² Монголын эрх зүйч, хуулын мэдэх болсон "Захирагааны актын 6 шинж", Т.М.

харилцааг зохицуулдаг учраас захирагаа болон иргэдийн хооронд тэгш эрхийн зарчим дээр сууриссан харилцаа буюу гэрээний харилцаа байх боломжгүй хэмээн үзэг байсан.³

Гээн нийтийн эрх зүйн салбарт нийгмийн бух харилцааг хуулиар бүрэн зохицуулсан хэмээн үзэх боломжгүй⁴, түүнчлэн, нийгмийн хөгжил хурдаатай өөрчлөгдхөхийн хэрээр захирагааны зүгээс дан ганц захирагааны акт, захирагааны хэм хэмжээний актаар нийгмийн харилцааг зохицуулах нь учир дутагдалтай болсон учраас захирагааны акт, захирагааны хэм хэмжээний актаар зохицуулах боломжгүй болж (тухайлбал, бүтээн байгуулалтын ажил, нийтийн захирагааны байгууллагас хөрөнгө оруулалтыг дэмжих асуудал, нийтийн захирагааны байгууллагын зарим чиг түргийг хувийн эрх зүйн хуулийн этгээдэд шилжүүлэх асуудал г.)⁵, тэрхүү орон зайг захирагааны гэрээ хэмээх ойлголтын хүрээнд нөхөх зайлшгүй шаардлага амьдралаас урган гарсан байдаг.

Тиймийн учир Otto Mayerын боловсруулсан захирагааны эрх зүйн сонгодог онолын буюу захирагааны актын хажуугаар 19 дүгээр зунаас захирагааны гэрээ бие даасан институт болж хулээн зөвшөөрөгдж эхэлсэн түүхтэй.⁶

Энэ талаар ХБНГУ-ын захирагааны эрх зүйн эрт, эдүгээгийн олон эрдэмтэд, тухайлбал, Loening, Stengel нар 1884-1886 онд хэвлүүлсэн бүтээлүүдээз "захирагааны актын хажуугаар нийтийн эрх зүйн гэрээ бол захирагааны үйл ажиллагааны нэг хэлбэр" гэж, Laband "тер бол эрх мэдлийг хэрэгжүүлэгч этгээд учраас өөрт нь ашиг тустай гэж үзсэн эрх зүйн бүхий л хэлбэрийт, тэр дундаа гэрэг ашиглах бүрэн боломжтой" гэж тус тус захирагааны гэрээ хэмээх институтийн ач холбогдлыг Otto Mayerын эсрэг сергүүлэн тавьж

³ Hartmut Maurer, Allgemeines Verwaltungsrecht, 16. Aufl. Verlag C.H.Beck, Muenchen, 2006, S.378.

⁴ П. Одгэрэл, Захирагааны эрх зүйн ерөнхий вигс, З дэхь эхэлэлт, УБ, 2016 он, 272 дахь тал.

⁵ Hartmut Maurer, Allgemeines Verwaltungsrecht, 16. Aufl. Verlag C.H.Beck, Muenchen, 2006, S.378.

иэрэн байдал.⁶

Хоёр. Гэвч орчин үед захиргааны гэрээ гэж чухам байх боломжтой эсэх, захиргааны гэрээ захиргааны үйл ажиллагааны нэг хэлбэр мөн эсэх, захиргааны гэрээ ач холбогдолтой эсэх гэх мэт онолын маргаан нэгэнт утгаад алдсан бөгөөд ХБНГУ-ын хууль тогтоогчид 1976 оны 5 дугаар сарын 25-нд “Verwaltungsverfahrensgesetz” буюу Захиргааны үйл ажиллагааны тухай хууль (цаашид “ЗҮАТХ” гэх)-ийг баталсаар нийтийн эрх зүйн гарээ⁷ нь захиргааны үйл ажиллагааны нэг үндсэн хэлбэр болж хуульлагдсан эрх зүйн институт болсон.

ХБНГУ-ын ЗҮАТХ-д “нийтийн эрх зүйн гарээ” хэмээн томъёолсон хэдий ч энд зөвхөн захиргааны гэрээг ойлгодог болох нь маргаангуй юм. Өөрөөр хэлбэл, энд Үндсэн хуулийн эрх зүйн гарээ, олон улсын эрх зүйн гарээ зэрэг хамааралгуй юм.⁸

Ийнхүү захиргааны гэрээ нь ХБНГУ-ын хувьд ч тэр, манай улсын хувьд ч тэр захиргааны үйл ажиллагааны үндсэн хэлбэрний нэг болж хулээн зөвшөөрөгдсөн байна.

Гэсэн хэдий ч ЗЕХ нь нийтлэг зарчмын зохицуулалтыг агуулдаг бөгөөд ямар нэгэн тухайн тохиолдлын зохицуулалт дутагдах нь олонтаа тохиолдог.⁹ Иймд захиргааны гэрээний хувьд тухайн тохиолдлын зохицуулалт байхгүй бол иргэний эрх зүйн хэм хэмжээнүүдийг, тодруулбал, Иргэний хуулийн зохицуулалтыг хэрэглэх боломжтой хэмээн үздэг болно.

Ийм ч учраас ЗЕХ-ийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсэгт “Захиргааны гэрээнд энэ хуулийн Тавдугаар бүлэгт зааснаас гадна Иргэний хуульд

заасан гэрээний суурь зохицуулалт¹⁰ нэгэн адил үйлчлэх бөгөөд өөрөөр зохицуулсан захиргааны хэм хэмжээ байхгүй тохиолдолд нөхөн тохишуулж хэрэглэн¹¹ гэж захиргааны гэрээнд Иргэний хуулийг нөхөн тохишуулж хэрэглэж болох эрх зүйн үндэслэлийг заасан.

Түүнчлэн, “Нөхөн тохишуулж хэрэглэх гэж тухайн асуудлыг зохицуулсан заалт энэ хуульд байхгүй тохиолдолд Иргэний хуулиас нөхөж хэрэглэх бөгөөд түүний хэрэглэхдээ нийтийн эрх зүйн зарчимтай уялдуулан захиргааны үйл ажиллагаа болон захиргааны гэрээнд тохирч байгаа эсэхийн нягтлан шалгаж тохиуулан хэрэглэхийг ойлгоно” хэмээн хууль тогтоогчийн аутентик тайлбар хийгдсэн байна.

ЗЕХ-ийн дурдсан зохицуулалт болон аутентик тайлбараас үзэвл, захиргааны гэрээнд Иргэний хуулийг нөхөн тохишуулж хэрэглэх нь субсидиар¹² шинжтэй байна.

Тодруулбал, захиргааны гэрээнд ЗЕХ-ийн 52-57 дугаар зүйл, түүн нийцүүлэн байгуулсан захиргааны гэрээний өөрийн зохицуулалтууд, түүнчлэн, тухайн захиргааны гэрээ нь салбарын бусад хууль тогтоомжуудад тусгайлан зохицуулагдсан бол тэр хуулийн зохицуулалтууд түрүүлж хэрэглэдэх бөгөөд хэрэв тийм тухайлсан зохицуулалт байхгүй буюу дутагдах байгаа тохиолдолд Иргэний хуулийн зохицуулалтыг нөхөн хэрэглэн.

Ийнхүү нөхөн хэрэглэхдээ нийтийн эрх зүйн зарчимтай уялдуулан захиргааны үйл ажиллагаа болон захиргааны гэрээнд тохирч байгаа

⁶ Мен тэнд

⁷ ХБНГУ-ын Захиргааны үйл ажиллагааны тухай хуулийн 52 дугаар булаг буюу 54-62 дугаар зүйлд “Нийтийн эрх зүйн гарээ”-т зөвшөөрүүлсан.

⁸ Winfried Schuhvabe, Berljan Finkel. Allgemeines Verwaltungsrecht und Verwaltungsprozessrecht, 2. Aufl. Achso Verlag, Frankfurt a.M., S. 241.

⁹ Т.Одгоржап, Захиргааны эрх зүйн ерөнхий анги, З дахь хэвлэлт. УБ 2016 он, 272 дахь тал

¹⁰ Иргэний хуульд заасан гэрээний суурь зохицуулалт гээд Иргэний хуулийн ерөнхий анги, тэр дотроо үүргийн эрх зүйн ерөнхий ангин холбогдох зохицуулалтыг хамааруулж ойлгоно. Үргийн эрх зүйн тусгай ангин зохицуулалт шууд хэрэглэдэх боломжгүй ТМ.

¹¹ ХБНГУ-ын Захиргааны үйл ажиллагааны тухай хуулийн 54 дугаар зүйл “Зохицуулалтыг нөхөн хэрэглэх” гэсэн баях багаад “Энэ хуулийн 54-61 дүгээр зүйлд оновчтой зохицуулалт байхгүй бол энэ хуулийн бусад заалтуудыг хэрэглэн. Иргэний Кодексийн холбогдох зохицуулалтууд нөхөн хэрэглэгдээ “тэж заасан байдаг.”

¹² Хөөрдөгч байх шинж, Т.М.

эсэхийг нягтлан шалгаж тохиуулан хэрэглэх зарчмыг баримтална.

Эндээс ямар тохиолдолд захиргааны гэрээнд Иргэний хуулийг нөхөн тохиуулж хэрэглэж болох хийгээд ямар тохиолдолд болохгүй тухай асуудал үүсэх бөгөөд үүнийг зөв тодорхойлоход хуульч, эрх зүйчдээс онолын мэдлэг, ур чадвар ихээхэн шаарддаг болно.

§2. Захиргааны гэрээнд Иргэний хуулийг нөхөн тохиуулж хэрэглэж болохгүй тохиолдолт

Нэг. Захиргааны гэрээ байгуулах шатанд хэрэглэгдэхгүй зохицуулалт.

1. Захиргааны гэрээ нь гэрээ гэдэг утгаараа иргэний эрх зүйн буюу гэрээний эрх зүйн еренхий онолын объект болох ч “захиргааны” байх шинжээрээ зарим онцлог шинжийг агуулдаг.

Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1 дэх хэсэгт “Гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг вөрсдэв тодорхойлох эрхтэй” хэмээн гэрээний чөлөөт байдлын зарчмыг хуулычилжээ.

Гэвч Захиргааны гэрээнд Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1 дэх хэсэгт заасан “гэрээний чөлөөт байдлын зарчим” хязгаарлагддаг. Хэдийгээр нийтийн эрх зүй, түүний гол салбар болох териин болон захиргааны эрх зүйд захиргааг гэдгийг захираамжилсан үйл ажиллагаа явуулагч, эрх мэдлийг хэрэгжүүлэгч гэж үздэгийнхээ хувьд тэдний эрх хэмжээг үндэслэдэг болон зааглагдааг нийтийн эрх зүйн хэм хэмжээнүүдийг судалдаг.¹³ Гэхдээ үүнээс үндэслэж захиргааг хувийн эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэгч биш гэж үзэж болохгүй хэдий ч захиргааны аливаа үйл ажиллагаанд хувийн эрх зүйн хэм хэмжээний хэрэглээ зөвхөн онцлог тохиолдолд зөвшөөрөгдж, ихэнх тохиолдолд хязгаарлагддаг.¹⁴

ЗХК-ийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэгт заасан “эрх зүйн хэм хэмжээнд нийцэж байх” гэсэн шинж

¹³ Hartmut Maurer, Allgemeines Verwaltungsrecht, 16. Aufl. Verlag C.H.Beck, Muenchen, 2006, S.48.

¹⁴ Мен тэнд.

нь захиргааны гэрээ зөвхөн эрх зүйн зохицуулалтаар зөвшөөрөгдсэн хүрээнд байгуулгадахаа ойлондо.¹⁵ Тодруулбал, “хуульд үндэслэх зарчим” нь гэрээний чөлөөт байдлын зарчмыг хязгаарлана.¹⁶ Ийм ч ураас иргэний эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдсэн “гэрээний чөлөөт байдал” нь иргэнтэй харьцуулбал захиргааны байгууллагын хувьд хязгаарлагддаг.

Тухайлбал, Газрын тосны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэгт “Эрэл хийсэн этгээд доор дурдсан нөхцөлийг тусгасан бүтээгдэхүүн хуваах гэрээний төслийг боловсруулж териин захиргааны байгууллагад ирүүлнэ: 1.ашигт газрын тосны Засгийн газарт ногдох хувь; 2.нөөц ашигласны төлбөрийн хувь; 3.өртөгт газрын тосны хязгаарын хувь; 4.хайгуулын хөрөнгө оруулалтын хэмжээ; 5.байгаль орчны нөхөн сэргээлэлт зарцуулах хөрөнгийн хэмжээ; 6.сургалтын урамшууллын хэмжээ; 7.гэрээнд гарын усгүй зурсны урамшууллын хэмжээ; 8.олборлолт эхэлсний урамшууллын хэмжээ; 9.олборлолт нэмэгдүүлсний урамшууллын хэмжээ; 10.орон нутгийг хөгжүүлэх урамшууллын хэмжээ; 11.төвлөгөчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг; 12.Засгийн газарт санал болгох бусад ашигтай нөхцөл” хэмээн зааснаас гэрээний чөлөөт байдлын зарчим хязгаарлагдаж байгааг харж болно.

Түүнчлэн, Захиргааны гэрээний хувьд дээр дурдсанаар гэрээний чөлөөт байдлын зарчим шууд хэрэгжих боломжгүй талаар Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 57¹⁷ дугаар шийдвэрийн үндэслэл хэсэгт ... концессиын гэрээ нь нэг талаас териин эрх бүхий байгууллагаас нийтийн ашиг сонирхол, тусын тулд томоохон төслийг хэрэгжүүлэх зорилгоор бусад

¹⁵ П.Одгэрэл. Захиргааны эрх зүйн еренхий анги. З дахь хэлэлцэлт, УБ, 2016 он, 266 дахь тал.

¹⁶ Hartmut Maurer, Allgemeines Verwaltungsrecht, 16. Aufl. Verlag C.H.Beck, Muenchen, 2006, p.381.

¹⁷ <http://new.shuukh.mn/irgeolanhan/32156/view> нээжмэлэгч “Шинжин Шинфа” ХХК, хирицаач Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг. Хөрөнгө оруулалтын газарт холбогдох иргэний хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, 6 дахь тал.

этгээдэд онцгой эрх шилжүүлэх замаар байгуулах захирагааны гэрээ бөгөөд энэ төрлийн гэрээг дусгавар болгох, цуцлах зэрэг харилцаанд иргэний эрх зүйн талуудын тэгш эрх, гэрээний чөлөөт байдлын зарчим тодорхой түвшинд хязгаарлагдмал байдаар хэрэгждэг болохы дурдах нь зүйтэй" гэсэн үндэслэл бүхий дүгнэлтийг хийжээ.

2. Захирагааны гэрээнд Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.5 дахь хэсэгт "Энэ хуулиар зохицуулаагүй, шууд нэрлэгдээгүй боловч гэрээний үндсэн шинж, хэлбэрийг илрэхийлсэн өөрмөц агуулга бүхий гэрээг нэрлэгдээгүй гэрээ гэнэ. Нэрлэгдээгүй гэрээнд энэ хуулийн үргийн тухай нийтлэг үндэслэл хамаарна" гэж заасан нэрлэгдээгүй гэрээний зохицуулалт хэрэглэдэхгүй. Учир нь, холбогдох нийтийн эрх зүйн хэм хэмжээнд буюу захирагааны эрх зүйн тусгай ангийн салбарын хууль тогтоомжуудад захирагааны зүгээс байгуулж болох захирагааны гэрээг зааж өгсөн байдаараа тайлбарлагдана.

Хоёр. Гэрээний агуулгын ач холбогдол бүхий харилцаа тухайн гэрээ байгуулсаас хойш бүхэлдээ өөрчлөгдсөний улмаас гэрээнд өөрчлөлт оруулах харилцаанд хэрэглэдэхгүй зохицуулалт.

Иргэний хуулийн 220 дугаар зүйл буюу нөхцөл байдал өөрчлөгдсөнөөс үүрэг гүйцэтгэх боломжгүй болох тухай зохицуулалт, тухайлбал, 220 дугаар зүйлийн 220.1 дэх хэсэгт "Гэрээ байгуулах үндэслэл болсон нөхцөл байдал гэрээ байгуулсны дараа илтэд өөрчлөгдсөн, ийнхүү өөрчлөгдхөхийг талууд урьдчилан мэджэй байсан бөгөөд гэрээг байгуулахгүй байх буюу өөр агуулгаар байгуулах боломжтой байсан бол гэрээ өөрчлөгдсөн нөхцөл байдалд нийцүүлэхийг талууд харилцан шаардах эрхтэй". 220.4 дэх хэсэгт "Гэрээ өөрчлөгдсөн нөхцөл байдалд зохицуулах боломжгүй, эсхүл нөгөө тал нь зөвшөөрөгүй бол эрх ашиг нь хөндөгдсөн тал гэрээнээс татгалзах эрхтэй" гэж заасан зохицуулалтууд захирагааны гэрээнд хэрэглэдэхгүй.

Учир нь, ЗЭХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэгт "Захирагааны гэрээний агуулгын голлох ач холбогдол бүхий харилцаа тухайн гэрээг байгуулсаас хойш бүхэлдээ өөрчлөгдсөн, гэрээний аль нэг тал гэрээний анхны зохицуулалтыг цаашид баримтлах боломжгүй гэж үзсэн бол уг гэрээнд өөрчлөлт оруулахыг шаардах эрхтэй". 56.2 дахь хэсэгт "Өөрчлөх боломжгүй, эсхүл гэрээний аль нэг тал өөрчлөлт оруулахгүй гэж үзвэл захирагааны гэрээг цуцална" гэж тус тус тусгайлан зааж, татгалзах биш цуцлах байдлаар зохицуулалт хийж өгчээ.

Гурав. Захирагааны гэрээг илт хүчин төгөлдөр бус байх үндэслэлд Иргэний хуулийг хэрэглэхгүй.

Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1-56.1.10 дахь хэсгүүдэд заасан хэлцэл хүчин төгөлдөр байх үндэслэлийг захирагааны гэрээнд хэрэглэхгүй.

Учир нь, ЗЭХ-ийн 55 дугаар зүйлийн 55.1.1-55.1.14 дэх хэсгүүдэд захирагааны гэрээ илт хууль бус байх үндэслэлүүдийг тусгайлан заасан болно.

§3. Захирагааны гэрээнд Иргэний хуулийг нөхөн тохируулж хэрэглэж болох тохиолдол

Нэг. Гэрээ байгуулах шатанд хэрэглэдэх зохицуулалт.

Захирагааны гэрээ нь "гэрээ" гэсэн эрх зүйн бие даасан институт болохынхоо хувьд иргэний эрх зүйн буюу гэрээний эрх зүйн ерөнхий онолын ойлголт, агуулга, шинжийг өөртөө нэгэн адил багтаана.

Гэрээ бол хүсэл зоригийн харилцан тохиолцоюм. Тодруулж хэлбэл, хоёр ба түүнээс дээш этгээдийн агуулгын хувьд нийцсэн, харилцан илрэхийлсэн хүсэл зоригийн илрэхийллээс бүрдэх хэллцийн гэрээ гэх ойлгоно.¹⁴

Өөрөөр хэлбэл, нэг талаас гэрээ байгуулах санал, нөгөө талаас түүнийг нь хүлээн зөвшөөрснөн хариу

¹⁴ Б.Тэмүүлэн, Д.Энхуул, Б.Баянхишиг нар. Иргэний эрх зүйн ерөнхий аянги, УБ, 2010 он, 33 дахь тал.

санал давхацсан тохиолдолд гэрээ байгуулагдсан гэж үздэг билээ.

Гэрээ байгуулах санал гэж гэрээ байгуулахаар илэрхийлж буй, негээв талын зөвшөөрлөөс гэрээ байгуулагдах эсэх нь хамаарах, негээв тал нь хулээн авах шаардлагатай хүсэл зоригийн илэрхийллийг ойлгоно.¹⁹

Гэрээний саналын хариу гэдэг нь зарчмын хувьд негээв тал нь хулээн авах шаардлагатай, түүнийг хүлээн авагч этгээдийн зөвшөөрлөөс гэрээ байгуулагдах эсэх нь хамаарах хүсэл зоригийн илэрхийллийг ойлгоно.²⁰

Захиргааны гэрээний хувьд дээр дурдсан элементүүд буюу гэрээ байгуулах санал, гэрээ байгуулах саналын хариу санал гэсэн хоёр үндсэн элемент нэгэн зэрэг байж гэмзэнэ байгуулагдсанд тооцогддог.

Тодруулбал, захиргааны гэрээ байгуулах шатанд Иргэний хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2 дахь хэсгүүд²¹ болон 195 дугаар зүйлийн 195.1 дэх хэсэг²² тус тус шууд хэрэглэгдэн.²³

Хоёр. Захиргааны гэрээг дуусгавар болгох шатанд хэрэглэгдэх зохицуулалт.

1. Аливаа гэрээг түүний аль нэг талын хүсэл зоригийн үүднээс дуусгавар болгоход татгалзах, эсхүл цуцлах зохицуулалтыг хэрэглэдэг.

Гэрээнээс татгалзах гэдэг нь үүргийн харилцааг дуусгавар болгож, өгсөн авснаа буцаах зорилтыг

хэрэгжүүлэхийг хэлнэ.²⁴ Татгалзах эрхийг талууд ямар нэг тодорхой тохиолдолд эдлэх тухай гарзээнд тохирсон эсхүл энэ эрх нь хуульд тусгагдсан байдаг.

Иргэний хуулийн 225 дугаар зүйлд татгалзах эрхийн ерөнхий үндэслэлийг зохицуулсан бөгөөд мөн хуулийн 204, 205 дугаар зүйлд татгалзах эрхийг хэрэгжүүлсний үр дагаврыг хуульчилсан. Тодруулбал, гэрээний аль нэг тал үүрэг зөрчсөнээс гэрээнээс татгалзсан тохиолдолд энэ тухайгаа негээв талдаа зайлшгүй мэдэгдэх үүрэгтэй (=негээв талд заавал хүрэх ёстой хүсэл зоригийн илэрхийлэл) ба ийнхүү татгалзсанаар талууд гэрээний дагуу авсан, өгснээ буцааж өгөх үүрэг хулээдэг.

Харин гэрээг цуцлах гэдэг нь онолын үүднээс үүргийн харилцааг зөвхөн ирээдүйд үгүй болгох үр дагавартай. Энэ тохиолдолд өгсөн авснаа буцаах үр дагавар үүсэжгүй. Тиймээс гэрээг цуцлах хэмээх ойлголтыг зөвхөн урт хугацааны гэрээний харилцаанд л хэрэглэх нь тохиromжтой.²⁵

Эндээс захиргааны гэрээнд “гэрээнээс татгалзах” тухай Иргэний хуулийн зохицуулалт үйлчлэх үү? гэсэн асуулт урган гарна. Гэвч энд нэг зүйлийг зайлшгүй анхаарах ёстой бөгөөд тэр нь манай улсын Иргэний хуульд “гэрээнээс татгалзах”, “гэрээг цуцлах” зохицуулалтын онолын зааг ялгааг нарийн гаргаж хуульчилж чадаагүй явдал юм.²⁶

Тэгэхээр захиргааны гэрээнд Иргэний хуулийн гэрээнээс татгалзахтай холбоотой 204, 205, 221, 227 дугаар зүйлүүдийг нөхөн тохируулж хэрэглэж

¹⁹ Б.Тэмүүлэн, Д.Энхзүүл, Б.Бүянишиг нар, Иргэний эрх зүйн ерөнхий анти, УБ, 2010 он, 64 дахь тал.

²⁰ Б.Тэмүүлэн, Д.Энхзүүл, Б.Бүянишиг нар, Иргэний эрх зүйн ерөнхий анти, УБ, 2010 он, 69 дахь тал.

²¹ Иргэний хууль §195.1. Нэг этгээд өөрийн хувь зоригийн илэрхийлэл нь негээв тал түүний хулээн авсанэр хүчин төгөлдөр болно.

²² Иргэний хууль §195.1. Нэг этгээд өөрийн хувь зөвшөөрсөн этгээдтэй эрх үүргийн хувь холбогдохор нэг буюу хэдийн тодорхой этгээдэд хандас хувь зоригийн бодитойгоор, хангальттай тодорхой илэрхийлсан илэрхийллийг гэрээ байгуулах санал гэнэ.

²³ Энэ тухай ХБНГУ-ын адил төстий зохицуулалтыг тайбларласан Winfried Schwabe, Bastian Finkel, Allgemeines Verwaltungsrecht und Verwaltungsprozessrecht, 2. Auf, Achso Verlag, Frankfurt a.M., S.242; Hartmut Maurer, Allgemeines Verwaltungsrecht, 16. Auf, Verlag C.H.Beck, Muenchen, 2006, S.384. зэрэг бүтээлээс узсан болно.

²⁴ Иргэний хуулийн тайлбар толь: Ерөнхий анти, 2006 он, 884-886 дахь тал, Б.Бүянишиг, Үүргийн эрх зүйн ерөнхий анти II, УБ, 2013 он, 144 дахь тал, Hans-Joachim Musielak, Grundkurs BGB, 10. Auf, Verlag C.H.Beck, Muenchen, 2007, S.108.

²⁵ Б.Бүянишиг, Үүргийн эрх зүйн ерөнхий анти II, УБ, 2013 он, 146 дахь тал, Hans-Joachim Musielak, Grundkurs BGB, 10. Auf, Verlag C.H.Beck, Muenchen, 2007, S.116.

²⁶ Энэ тухай мөн Б.Бүянишиг, Үүргийн эрх зүйн ерөнхий анти II, УБ, 2013 он, 146 дахь талаас узж болно. Тайблар, Иргэний хуулийн 221 дүгээр зүйлд “урт хугацааны гэрээ”-ний тухай ачм үзсэн атлаа “татгалзак” гэсэн томъёоллыг хэрэглэсэн бий, Т.М.

болно. Ингэж хэрэглэхдээ ЗЕХ-ийн 58 дугаар зүйлд заасан "... өөрөөр зохицуулсан захирагааны хэм хэмжээ байгүй тохиолдолд" Иргэний хуулийн холбогдох заалтуудыг нөхөн тохируулж хэрэглэх зарчмыг зайлшгүй баримтална. Тодруулбал, захирагааны гэрээний тодорхой тохиолдлыг хуульчилсан салбарын хуульд гарзэнээс татгалзах хийгээд гэрээг цүцлах зохицуулалт байгаа бол түүнийг эхэлж хэрэглэх, хэрвээ байхгүй тохиолдолд Иргэний хуулийн дурдсан зохицуулалтыг нөхөн тохируулж хэрэглэн.

Түүнчлэн захирагааны гэрээ нь дийлэнх тохиолдолд урт хугацаатай байгуулгадагаас гадна манай улсын Иргэний хуульд гэрзэнээс татгалзах, гэрээг цүцлах ойлголтыг нарийчлан зааглаагүй тул захирагааны тэрээнд гэрээг цүцлах тухай ойлголтыг нэгэн адил хэрэглэнэ. Энэ хэсэгт Концессын тухай, Газрын тосны тухай зэрэг хуулиудыг жишээ татаан авч үзвэл, концессын гэрээг Концессын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасан үндэслэлээр эрх бүхий захирагааны байгууллага, 24.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр концесс эзэмшигч этгээд цүцлах тухай, газрын тосны бутзэгдэхүүн хуваах гэрээг Газрын тосны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дахь хэсэгт заасан үндэслэлээр Засгийн газар цүцлах туй тус таажээ.

Дээрхээс үндэслэн дахин дүгнэвэл, захирагааны гэрээг цүцлах болон татгалзах асуудалд хэм хэмжээг хэрэглэх эрэмбийн хувьд талуудын хооронд байгуулсан захирагааны гэрээний цүцлах зохицуулалтыг эхэлж хэрэглэх бөгөөд түүний дараа холбогдох салбарын хуульд заасан цүцлах үндэслэлийг хэрэглэх зарчмыг баримтална. Харин цүцлах болон татгалзах зохицуулалт салбарын хуульд байхгүй бол Иргэний хуулийн холбогдох зохицуулалтыг нөхөн тохируулж хэрэглэн.

Захирагааны гэрээг цуцалсны (татгалзсаны) эрх зүйн үр дагавар: Захирагааны гэрээг цуцалсны дараах эрх зүйн үр дагаврыг зарим тохиолдолд

холбогдох салбарын хуульд тусгайлан заасан байдгийг зайлшгүй анхаарах учиртай. Жишээлбэл, Концессын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дахь хэсэгт "Концессын гэрээг цуцлахад талуудад олгох нөхөн олговрыг хэрхэн тооцохыг гэрэнд заах ба ингэхдээ концессын гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын зохиц үнз цэнэ, гарсан зардал, тухайн талд учирсан хохирол, үүний дотор шаардлагатай тохиолдолд олох боломжтой байсан ашгийг оруулна". Газрын тосны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэгт "Энэ хуулийн 12.1 дахь хэсэгт заасан үндэслэлээр бутзэгдэхүүн хуваах гэрээг цуцалсан тохиолдолд хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг нөхөн олгохгүй бөгөөд энэ хуулийн 11.2.9 дахь хэсэгт зааснаар эскроу дансанд байршуулсан мөнгийг байгаль орчныг бүрэн гүйцэд нөхөн сэргээх, шаардлагатай тохиолдолд хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгахад зарцуулж, үлдсэн мөнгийг гэрээлгэгид буцаан олгоно" хэмээн тус таажээ.

2. ЗЕХ-ийн 56 дугаар зүйлийн 56.2, 56.3 дахь заалтын хүрээнд захирагааны гэрээг цүцлах асуудал.

ЗЕХ-ийн 56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсэгт "Өөрчлөх боломжгүй, эсхүл гэрээний аль нэг тал өөрчлөлт оруулахгүй гэж үзвэл захирагааны гэрээг цуцална", 56.3 дахь хэсэгт "Захирагааны байгууллага нийтийн ашиг сонирхолд ноцтой хор уршиг учруулахаар бол түүнээс урьдчилан сэргийлэх, эсхүл арилгах үүднээс захирагааны гэрээг дангаар цуцалж болно" хэмээн захирагааны гэрээг цүцлах тусгай тохиолдлыг хуульчилсан.

ЗЕХ-ийн 56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсэг нь мөн зүйлийн 56.1 дахь хэсэгтэй шууд хамааралтай буюу захирагааны гэрээний агуулгын голлох ач холбогдол бүхий харилцаа тухайн гэрээг байгуулсанас хойш бухэлдээ өөрчлөгдсөн, гэрээний аль нэг тал гэрээний анхын зохицуулалтыг цашид баримтлах боломжгүй гэж үзсэн бол уг гэрээнд өөрчлөлт оруулахыг шаардсан ч өөрчлөх боломжгүй, эсхүл гэрээний

аль нэг тал өөрчлөлт оруулахгүй гэж үзвэл хэрэгжих зохицуулалт юм. Тодруулбал, бүх тохиолдолд үйлчлэхгүй юм. Тиймээс цуцлах тусгай тохиолдолд гэжээ.²⁷

Харин ЗЕХ-ийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь хэсэгт захиргааны байгууллагаас захиргааны гэрээг нийтийн сайн сийханд учруулж болзошгүй ноцтой аюулаас урьдчилан сэргийлэх эсвэл арилгах зорилгоор цуцлахаар²⁸ заасан удаах тусгай тохиолдол. Энэхүү тусгай тохиолдолыг зохицуулсан хэм хэмжээ нь тодорхой тохиолдолд салбарын болон Иргэний хуулиас давуу үйлчлэх шинжийг агуулна.

Түүнчлэн, энэ нь нэг талын, тэгш байдлыг үгүйсгэсэн захиргааны байгууллагын халдах эрх бөгөөд хязгаарлагдмал явцуу хүрээнд тайлбарлах шаардлагатай байдаг.²⁹ Ийнхүү тусгай тохиолдоор цуцалсан тохиолдолд үр дагаврын хувьд Иргэний хуулийн 221, 227 дугаар зүйл заасан хэм хэмжээ хэрэглэгдэж, учирсан хохирлыг барагдуулах үр дагаврыг бий болгоно.

Тэрчлэн, захиргааны гэрээг цуцлах тухай захиргааны байгууллагаас гаргаж буй шийдвэр нь хэдийгээр ЗЕХ-ийн 11 дүгээр зүйл заасан шийдвэр гаргах ажиллагааны нэг хэлбэр мэн боловч тэрхүү цуцлах тухай шийдвэр нь захиргааны акт биш байдгийг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй байна.³⁰ Захиргааны байгууллагаас гаргах буй цуцлах тухай шийдвэр нь албан бичгийн хэлбэрээр хэлбэржсэн негеэ тал нь хүлээж авах шаардлагатай нийтийн эрх зүйн хүсэл зоригийн илэрхийлэл

²⁷ Энэ тухай П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий аги, З дахь хэвлэлт, УБ, 2016 он, 276 дахь талаас үзж болно.

²⁸ Мен тэнд.

²⁹ Энэ тухай П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий аги, З дахь хэвлэлт, УБ, 2016 он, 276-277 дахь тал.

³⁰ Энэ тухай П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий аги, З дахь хэвлэлт, УБ, 2016 он, 276-277 дахь тал, Hartmut Maurer, Allgemeines Verwaltungsrecht, 16. Aufl, Verlag C.H.Beck, Muenchen, 2006, S.402. Энэ хэсгээс үзж болно. Түүнчлэн, манай захиргааны хэргийн шүүхийн практикт захиргааны гэрээг цуцлах тухай захиргааны байгууллагын шийдвэрийг захиргааны акт гэж үзж, шийдсэн хэд хэдэн тохиолдол байгаа болохыг үзж.

боловхоос захиргааны акт биш юм.

Гурав. Захиргааны гэрээ илт хууль бус байсны эрх зүйн үр дагавар буюу хохирлыг арилгах асуудалд хэрэглэгдэж Иргэний хуулийн зохицуулалт.

Өмнөх хэсэгт захиргааны гэрээ илт хууль бус байх үндэслэлд Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1-56.1.10 дахь хэсгүүдийг хэрэглэж болохгүй тухай дурдсан билээ.

Харин захиргааны гэрээ илт хууль бус байсны эрх зүйн үр дагавар буюу аливаа хохирлыг арилгахадаа Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.5, 56.6 дахь хэсгүүдийг мен хуулийн 492 дугаар зүйл (Үндэслэлгүйгээр хөрөнгөхийн)-тэй хамтгатан хэрэглэж болно.

Түүнчлэн, Иргэний хуулийн 58-60 дугаар зүйлд заасан хэлшийг хүчин төгөлдөр бус гэж тооцох болох Үндэслэлүүдийг захиргааны гэрээний хувьд илт хууль бус байх үндэслэлд (ЗЕХ §55.1.11-55.1.12 дахь хэсгүүдэд) хамааруулан хуулынисгын дурдах нь зүйтэй байх бөгөөд энэ тохиолдолд ноцтой төөрөгдөл (илэрхийллийн төөрөгдэл, агуулын төөрөгдөл, эрхийн төөрөгдэл г.м)-ийг тайлбарлахын тулд Иргэний хуулийн 58 дугаар зүйлийг, хууран мэхээсэн гэдгийг тайлбарлахын тулд Иргэний хуулийн 59 дүгээр зүйлийг, хүчинд, автсан гэдгийг тайлбарлахын тулд Иргэний хуулийн 60 дугаар зүйлийг нөхөн тохиоруулж хэрэглэж болно.

Дөрөв. Үүргийн зөрчлийн улмаас учирсан хохирлыг шаардах асуудалд Иргэний хуулийн хэрэглэгдэх зохицуулалт.

Захиргааны гэрээний нэг тал нь захиргааны гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд негеэ талаас учирсан хохирлоо арилгуулахаар шаардах эрхтэй бөгөөд энэхүү шаардлагыг хэрэгжүүлэхэд Иргэний хуулийн 219 дүгээр зүйл хэрэглэдэнэ.³¹

Захиргааны гэрээний үүргийн зөрчлөөс үүдэлтэй учирсан хохирлыг шаардах тухай энэхүү шаардах эрхийг хэрэгжүүлэхдээ нийтийн эрх зүйн

³¹ Энэ тухай Германы адил төрлийн зохицуулалтыг тайлбарласан Maurer, Allgemeines Verwaltungsrecht, 16. Aufl, Verlag C.H.Beck, Muenchen, 2006, S.401 энэ хэсгээс үзж болно.

гэрээний (=захиргааны гэрээний) үүргийн харилцаа талуудын хооронд үүссэн байх, аль нэг тал нь үүргээ зөрчсөн байх, тухайн зөрчилдөө гэм буруутай байх, үүргээ зөрчсөний улмаас нөгөө талд хохирол учирсан байх гэсэн урьдчилсан нөхцөлийг нэгэн зэрэг хангасан байхыг шаардана.

§4. ДҮГНЭЛТ

Өгүүлэлд дурдсан зүйлсийг нэгтгэн дүгнэвэл:

1. Otto Майерын боловсруулсан захиргааны эрх зүйн сонгодог онол буюу захиргааны актын хажуураар 19 дүгээр зунаас захиргааны гэрээ бие даасан институт болж хүлээн зөвшөөрөгдөх эхэлсэн түүхтэй байх ба орчин үед захиргааны гэрээ гэж чухам байх боломжийт эсэх, захиргааны гэрээ захиргааны үйл ажиллагааны нэг хэлбэр мэн эсэх, захиргааны гэрээ ач холбогдолтой эсэх тэх мэт онолын маргаан нэгэнт утгаа алдсан бөгөөд ХБНГУ-ын хувь тогтоогчид 1976 оны 5 дугаар сарын 25-нд "Verwaltungsverfahrensgesetz" буюу Захиргааны үйл ажиллагааны тухай хууль (цаашид "ЗҮАтХ" гэх) ийг баталсаар нийтийн эрх зүйн гэрээ нь захиргааны үйл ажиллагааны нэг үндсэн хэлбэр болж хуульчлагдсан эрх зүйн институт болсон байна.

2. Харьцуулалтын хувьд ХБНГУ-ын ЗҮАтХ-д "нийтийн эрх зүйн гэрээ" хэмээн томьёолсон хэдий ч энд зөвхөн захиргааны гэрээг ойлгодог болох нь маргаангуй байна. Өөрөөр хэлбэл, энд Үндсэн хуулийн эрх зүйн гэрээ, олон улсын эрх зүйн гэрээ зэрэг хамааралгүй юм.

3. ЗЕХ нь нийтлэг зарчмын зохицуулалтыг агуулдаг бөгөөд ямар нэгэн тухайн тохиолдлын зохицуулалт дутагдах нь онолтаа тохиолддог. Иймд захиргааны гэрээний хувьд тухайн тохиолдлын зохицуулалт байхгүй бол иргэндийн эрх зүйн хэмжээнүүдийг, тодруулбал, Иргэний хуулийн зохицуулалтыг хэрэглэх боломжийт хэмээн үздэг байна.

4. ЗЕХ-ийн дурдсан зохицуулалт

болон аутентик тайлбараас үзвэл, захиргааны гэрээнд Иргэний хуулийг нөхөн тохиуулж хэрэглэх нь субсидиар (=хөөрдогч) шинжтэй байна.

5. "Хуульд үндэслэх зарчим" нь гэрээний чөлөөт байдлын зарчмыг хязгаарлана. Ийм ч ураас Иргэний эрх зүйн хувьд хулээн зөвшөөрөгдсөн "гэрээний чөлөөт байдал" нь иргэнтэй харьцуулбал захиргааны байгууллагын хувьд хязгарагддаг байна.

6. Захиргааны гэрээнд Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.5 дахь хэсэгт заасан нэрлэгдэхгүй гэрээний зохицуулалт хэрэглэгдэхгүй.

7. Захиргааны гэрээнд Иргэний хуулийн 220 дугаар зүйл буюу нөхцөл байдал өөрчлөгдсөнөөс үүрэг гүйцэтгэх боломжгүй болох тухай зохицуулалт хэрэглэгдэхгүй.

8. Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1-56.1.10 дахь хэсгүүдэд заасан хэцүэл хүчин төгөлдөр байх үндэслэлийг захиргааны гэрээнд хэрэглэгдэхгүй.

9. Захиргааны гэрээ байгуулах шатанд Иргэний хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2 дахь хэсгүүд болон 195 дугаар зүйлийн 195.1 дахь хэсэг тус тус шууд хэрэглэгдэнэ.

10. Захиргааны гэрээнд Иргэний хуулийн гэрээнээс татгалзахтай холбоотой 204, 205, 221, 227 дугаар зүйлүүдийг нөхөн тохиуулж хэрэглэж болно. Ингэж хэрэглэхдээ ЗЕХ-ийн 58 дугаар зүйлд заасан "... өөреөр зохицуулсан захиргааны хэм хэмжээ байхгүй тохиолддод" Иргэний хуулийн холбогдох заалтуудыг нөхөн тохиуулж хэрэглэх зарчмыг зайлшгүй баримтална.

11. Захиргааны байгууллагаас гаргаж буй цуцлах тухай шийдвэр нь албан бичгийн хэлбэрээр хэлбэржсэн нөгөө тал нь хүлээж авах шаардлагатай нийтийн эрх зүйн хүсэл зоригийн илэрхийлэл болохоос захиргааны акт биш юм.

12. Захиргааны гэрээ илт хууль бус байсны эрх зүйн үр дагавар буюу аливаа хохирлыг ариглахдаа Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.5, 56.6

дахь хэсгүүдийг мөн хуулийн 492 дугаар зүйл (Үндэслэлгүйгээр хөрөнгөжих)-тай хамтатган хэрэглэж болно.

13. Захиргааны гэрээний нэг тал нь захиргааны гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд негee талаас

учирсан хохирлоо арилгуулахаар шаардах эрхтэй бөгөөд энэхүү шаардлагыг хэрэгжүүлэхад Иргэний хуулийн 219 дүгээр зүйл хэрэглэгдэнэ.

---оо---



ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН АНХДУГААР ХУРАЛДААН БОЛЛОО

2017 оны 3 дугаар сарын 15-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захиралд зөвлөх чиг үүрэг бүхий Эрдмийн зөвлөлийн анхдугаар хуралдаан боллоо.

Эрдмийн зөвлөл нь хүрээлэнгийн судалгаа, мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлын чиглэлийг тогтоох, судалгааны ажлын явц, хэрэгжилтийг хэлэлцэж санал дүгнэлт гаргах, судалгааны ажлын сэдэв, сургалтын хөтөлбөр батлах, хууль зүйн их, дээд сургууль, судалгааны бусад байгууллагаас ирүүлсэн бүтээлүүдэд дүгнэлт өгөх, санал гаргах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэх юм.

Анхдугаар хуралдаанаар "Эрдмийн зөвлөлийн ажиллах журам"-ыг хэлэлцэж, "Судлаачийн гарын авлагы"-ын төслийг танилцуулсан юм. Мөн Хуульч эрдэмтдийн үндэсний анхдугаар чуулганы зохион байгуулалт, хэлэлцэх асуудлын талаар зөвлөлдлөө.

Хууль зүй үндэсний хүрээлэнгийн Эрдмийн зөвлөл нь нийт 15 хүний бүрэлдэхүүнтэй.

ХЭРЭГ, МАРГААНЫГ АНХАН ШАТНЫ ЖУРМААР ШИЙДВЭРЛЭХЭД ШҮҮХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ОРОЛЦООГ ТОДОРХОЙЛЖ БОЛОХ АСУУДАЛ



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм
шинжилгээний ажилтан, хууль зүйн
магистр М.Цэдээсүрэн

ТҮЛХҮҮР ҮГ:

Шүүх бүрэлдэхүүн, шүүгчдийн зөвлөгөөн, хэрэг хуваарилах журам, тусгай санал, шүүх бүрэлдэхүүний шийдвэрлэсэн хэргийн тоо.

ТОВЧЛОЛ:

Эрүү, иргэн, захиргааны хэрэг, маргааныг анхан шатны журмаар шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн, түүнийг оролцоог тодорхойлж болох зарим асуудлыг, мөн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарим онцлог зохицуулалтын талаар тус тус хөндсөн болно.

УДИРТГАЛ

Сүүлийн хэдэн жилийн дунджаас хараад шүүх бүрэлдэхүүний шийдвэрлэж буй хэрэг, маргааны тоо, тэр дундаа иргэн болон захиргааны хэрэг, маргааны тоо их хэмжээгээр¹ өсөж байгаа нь шүүн таслах ажлын тайлан мэдээнээс харагддаг.

Захиргааны хэрэг шүүхэд хянан

2016 онд шийдвэрлэсэн иргэний хэргийн тоог өмнөх омыгтой харьцуулакад 5500 орчим, захиргааны харгийн тоог өмнөх омыгтой харьцуулакад 350 орчим хэргээр тус тус измэгдэж байна.

шийдвэрлэх тухай хуулийг 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн ба энэ хуульд олон шинэлэг зохицуулалт тусгайдсан байна.

Энэхүү егүүлэлд хэрэг, маргааныг анхан шатны журмаар шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэх ажиллагаанд шүүгчийн оролцоо, түүнд хамаарах зарим асуудлыг "хэргийг шүүгч дангаар эсхул шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх" агуулгаар голчлон харуулах юм.

ШҮҮГЧ ДАНГААР ЭСХУЛ ШҮҮХ БҮРЭЛДЭХҮҮНТЭЙ ШИЙДВЭРЛЭХ ХЭРЭГ

Уламжлалаас хараад хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх хэрэгт шүүгч наг, ардын төлөөлөгч хоёр оролцож байсан бөгөөд дангаар эсхул бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх хэргийг хуульд тусгайллан заахаас гадна Улсын Дээд шүүхийн тогтоолд² дурдсанаар зааглан ялгаж байсан нь ажиглагддаг.

Хэрэг, маргааныг анхан шатны журмаар шийдвэрлэхдээ зруүгийн хэрэгт гэмт хэргийн ангилал³, иргэний

¹ Ж.Амарсаная нар. Монгол Улсын Дээд шүүхийн тогтолчин эмзэктэг (1959-2010). УБ., 2012 он. 84, 535. 610 дэх тал.

² ЭБШХ-ийн 32.1 дэх хэсэгт "Хөнгөн, хүндэтэр хэргийг шүүгч дангаар, хүнд, онц хүнд хэргийг З шүүгчийн бүрэлдэхүүнтэй эрх анхан шатны журмааг сум буюу сум дундым, дүүргийн шүүх хянан шинидэвэрлэн" гэж заасан бөгөөд ЭХ-ийн 16.1 дэх хэсэгт гэмт хэргийг ниймжин агуулын шиний чанар, хэр хэмжээ, оногдуулж болох яланы хүнд, хөнгөнний хяргалзан ангилласан байдал. Мөн хуулиин 32.2 дэх хэсэгт "Хөнгөн, хүндэтэр хэргээ эздрээ төвөгтэй улмаас шүүх бүрэлдэхүүнээр шинидэвэрлэх шаардлагатай гэж үзэл шүүгч энэ тухай саналыа гаргаж, тухайн шүүхийн Ерөнхий шүүгчний захиргааны шүүх бүрэлдэхүүн томил болно" гэсэн зохицуулалт нь гэмт хэргийн ангиллыг ул харгалзан шүүх бүрэлдэхүүнээр шийдвэрээр шаардлагатай" гэж үзэл шүүгч саналыа гаргаж Ерөнхий шүүгч уг асуудлыг шийдвэрлэхээс хуулийнж лген онцлог зохицуулалт юм.

хэрэгт ИХШХШТХ-ийн 82 дугаар зүйлд заасан ангилал⁴, захирагааны хэрэгт Захирагааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан ангилал⁵-ыг тус тус баримталж байна.

Эрүүгийн хэрэг дэх гэмт хэргийн ангилал нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан хөнгөнөөс хүнд рүү нь зааглан ялгасан байdag бол харин иргэн болон захирагааны хэргийн хувьд дээрх ангилал нь тухайн төрлийн маргааныг хуульд тусгайлан заасан бөгөөд мөн Захирагааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74.1.3 дахь хэсэгт “тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөр шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэхээр тогтоосон”⁶ гэсэн агуулгаар хуульчлагджээ.

Дээрхээс үзвэл хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхэд шүүч дангаар шийдвэрлэх үү эсхүл шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх үү гэдгийг хуульд тусгайлан заасан эсхүл тухайн тохиолдол нь “шүүх бүрэлдэхүүнээр шийдвэрлэх шаардлагатай”, “тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөр шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэхээр тогтоосон” гэх ангиллаар зааглан ялгахаар байна.

⁴ ИХШХШТХ-ийн 82 дугаар зүйлд хуульд тодорхойлон заасан харилцанаас үссэн маргааны шүүгч дангаар шийдвэрлэхээр хуульчилсан.

⁵ Захирагааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлд үндсэндээ “АШШ-ийн шийдвэрийг хүчингүй болгох, дахин хэлэлцүүлэхээр бууцасан”, “захирагааны хэм хэмжээний актвий холбоотой”, “тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөр шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэхээр тогтоосон” гэсан гасан 3 төрөлд хамаарах хэрэг, маргааны шүүх бүрэлдэхүүнээр буюу 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэхээр хуульчилсан.

⁶ Өмнө нь Захирагааны хэрэг хянан шийдвэрлэх тухайн хуулийн 52 дугаар зүйлээр хэрэг маргааны хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнээр талаар хуульчилж егшиг бөгөөд үнд “Шүүгчийн зөвлөгөөнөөр 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хэргийн хянан шийдвэрлэх” талаар хохицуулж байгаагүй. Этэл ИХШХШТХ-ийн 74 дүгээр зүйлийн 74.1.3 дахь хэсэгт энэ талаар хохицуулж шинээр орсон бөгөөд шүүгчийн зөвлөгөөнөөр тухайн хэргийг шүүх бүрэлдэхүүнээр шийдвэрлэх эсэхийн тоогоо болсон нь онцлог болижээ.

Үүнээс гадна эрүүгийн хэргийн хувьд гэмт хэргийн хүнд, хөнгөнөөс гадна хэргийн эздрээ төвөгтэй нэхцэл байдлаас шалтгаалан ЭБШХ-ийн 32.2 дахь хэсэгт зааснаар шүүгчийн гаргасан саналын дагуу Ерөнхий шүүгч хэргийг шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх эсэхийн тогтоож байгаа бол захирагааны хэргийн хувьд ЗХШХШТХ-ийн 74.3 дахь хэсэгт “тухайн шүүгчийн шүүгчдийн зөвлөгөөнөөр шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэхээр тогтоосон” гэж зааснаас хараад уг зохицуулалтын агуулга нь мөн л хэрэг, маргааны эздрээ төвөгтэй эсхүл шүүгч дангаар шийдвэрлэхэд хүндэтэй зайлшгүй нэхцэл байдал үүссэн тохиолдлыг хамрах болов уу гэж төсөөлж байна.

Харин дээр дурдсан нэхцэл байдал үүссэн тохиолдолд ЗХШХШТХ-ийн 74 дүгээр зүйлд шүүгчдийн зөвлөгөөн хэргийг шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэхээр тогтооходо түүнийг хэрхэн тогтоох нь тодорхойгүй байна.

ШҮҮХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ОРОЛЦООГ ТОДОРХОЙЛЖ БОЛОХ ЗАРИМ АСУУДАЛ

Шүүх бүрэлдэхүүний оролцоог “хэргийг шүүгч дангаар эсхүл шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх”, “шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх хэрэг дэх даргалагч шүүгч маргааны хуваар, тусгай санал, мэдээ, судалгааны үзүүлэлт эзрэг шүүгчдийн оролцоог харуулж болохуйц зарим асуудлын талаар тодруульяа.

Шүүгчдийн зөвлөгөөн: Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлд зааснаар Шүүгчдийн зөвлөгөөн нь тухайн шүүхийн нийт шүүгчээс бүрдэх бөгөөд тогтмол

хуралдаж Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт тусгайлан заасан хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой⁷, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоогүй⁸ асуудлыг тус тус шийдвэрлэдэг.

Шүүгчдийн зөвлөгөөн нь хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотойгоор "шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг тогтоох", "хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгчийг болон шүүх бүрэлдэхүүнээр шийдвэрлэх хэрэгт оролцох шүүгчийг томилох дарааллыг тогтоох", "хэрэг хуваарилах журмын батлах" асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг.

Хуваарь: Шүүхээр үйлчлүүлэгчид болон олон нийт нь хуваарийн талаар бараг ойлголтгүй байдаг болов уу. Хуваарь гэдэг нь дээр дурдсанчлан шүүгчдийн зөвлөгөөнөөс "даргалагчийн дараалал, мөн шүүгчийг болон бүрэлдэхүүнд оролцох шүүгчийг томилох дарааллыг тогтоох, хэрэг хуваарилах журмын батлах"⁹-аас гадна энэхүү журмын агуултыг шүүхийн мэдээллийн технологийн мэргэжилтэн "нэгдсэн систем"¹⁰-д бүртгэж, хуваарийн тохииргог тохируулах ўл явцыг хамарсан ойлголт болсон. Үний дараа хэрэг, нэхэмжлэл, бусад материал нь шүүгчдээ цахимаара хуваарилагдах¹¹ юм. Шүүх нь тухайн онд хэдэн нэхэмжлэл ирэх, хэдэн хэрэг дээд шатны шүүхээс

⁷Холбоотой гэдэг МУШТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.2.2, 25.2.3, 25.2.8-ыг ойлгох.

⁸Холбоогүй гадгат МУШТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.2.1, 25.2.4, 25.2.5, 25.2.6, 25.2.7 дахь хэсэгт тус тус хамааруулан ойлголт болгоор байна.

⁹МУШТХ-ийн 25 дугаар зүйл

¹⁰ Иргэн болон закиргааны хэргийн шүүх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэгдсэн системийндаа дээр дурдсан журмын агууллыг бүртэж, хуваарийн тохииргог тохируулах ажин 2015 оноос хэрэгжин эхалсан.

¹¹ ШЕЗ-ийн 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 08 дугаар тогтолцоогор "Иргэнжийн хөдөлгөөний нийтлаг аргачлал" батлагдсан бөгөөд аргачлалын 2.1.1 дахь хэсэгт "иргээлэл лавлагчдын мэргэжилтэн... нэхэмжилэх хүзүүн авсан тухай баримт №1-ийн системээс хэвлэж өгнө" гэж засээн. Энэ нь нэхэмжилэгийн нэхэмжилэх хувиралтадан шүүгчийн изирж харахас гадна хуваарийт холбоотой мэргэжилж баримтаар хүзүүн авах боломжийн бүрдүүлэсэн юм.

буцаж ирэхийг тааварлаж мэдэх боломжгүй тул нэхэмжлэл, хэрэг, бусад материалыг хүлээн авч, шийдвэрлэх буюу хариу өгөх шүүгчийн дарааллыг л дээр дурдсан журмаар урьдчилан тогтоож буй хэрэг бөгөөд журмаар оны эхэнд¹² баталдаг.

Ачаалал болон онцлогоос шалтгаалан шүүхүүдийн уг журмаар зохицуулах харилцаа харилцан адилгүй байгаа нь ШЕЗ-ын ажлын албанаас хийсэн судалгаа¹³-наас хараждаг байна. Мөн шүүгчдийн тооны өөрчлөлт болоод мэргэшүүлэх бодлого чиглэл, хуульд заасан тохиолдол¹⁴ зэрэгсэ хамааран шүүгчдийн зөвлөгөөн тухайн ондоо дахин хуралдах шаардлагат¹⁵ үүсч болно.

Шинээр батлагдсан ЗХШХШТХ-53.2 дахь хэсэгт уг журмыг батлаадаа хангах нэхцэлийн талаар "урьдчилан мэдэх боломжгүй, тохиолдоор хуваарилах" гэж хуульшилсан байна. Энэ нь хуваарытай холбоотойгоор хангах нэхцэлийг хуульшилсан анхны тохиолдол бөгөөд энэ нэхцэл нь өөрөө хэд хэдэн хүчин зүйлийг шалгуур болгож таарах байх. Тухайлбал, ачаалал,

¹² ЗХШХШТХ-ийн 72.1 дахь хэсэгт зааснаар "Хэрэг хянан шийдвэрлэх шүүч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийн жил, хэвэг жил эзрэг тодорхой хугацаагаар тухайн шүүгчийн зөвлөгөөнөөс хуваарь гарган томилж" гэж зассан.

¹³ Шүүхэд нэхэмжилэл, хэрэг, хүсслэл, томдол, хуваарилах ажиллагаанд хийсан дун шинжилгээ, зөвлөмж. Шүүх эрх мэдрэлээдэл, арга зүйн улсырал туслымж эмхэтгэл. УБ., 2015, №3, 113-118 дахь тал.

¹⁴ ЗХШХШТХ-ийн 72.2 дахь хэсэгт "Хуваарийн дагуу томилогдох шүүч, шүүх бүрэлдэхүүн тухайн шүүх хуралдаанд оролцож чадахгүй тохиолдолд түүнийг орлох шүүч, шүүх бүрэлдэхүүний энэ хуул: ийн 72.1 дахь хэсэгт зассан журмын томилж" гэж зассан.

¹⁵ МУШТХ-ийн 12.7 дахь "Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүч адил шатны фер шүүхэд томилотгоор ажиллас болно. Томилотгоор ажиллас нийтгэл журмын Шүүхийн ерөнхий зөвлөл беталын" гэж засвны дагуу ШЕЗ-ийн 2016 оны 06 дугаар сарын 09-ны өдөр 47 дугаар тогтолцоогор "шүүч томилотгоор ажиллах нийтгэл журмын" баталсан бөгөөд томилотгоор ажиллахийн холбогдуулсан тухайн томилотгоор ажиллах шүүгчийн шүүх аль нь ал шүүгчийн зөвлөгөөнийг хуралдуулж харж, нэхэмжилэх хувиралтаар журмыг дахин батлах шаардлагтаа үүссэн.

ажиллагааны хугацаа¹⁶ гэх мэт. Орон нутгийн ихэнх шүүхэд 3 шүүгч ажиллаж байгаа бөгөөд эдгээрийн хувьд урьдчилан мэдэх боломжийн магадлал Нийслэл дэх захирагааны хэргийн анхан шатны шүүхтэй харьцуулахад илүү байх нь ойлгомжтой.

ЗХШХШТХ-ийн 72.4 дэх хэсэгт зааснаар ерөнхий шүүгч бусад шүүгчтэй адил хуваарийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх болсон. Энэ нь ерөнхий шүүгч байх эсхүл шүүгч байхаас үл хамаараад хуваарийн хувьд бүх шүүгчийн оролцоо /ачаалал/ адил байх агуулга тусгагдсан зохицуулалт болжээ. Мөн ИХШХШТХ-ийн 78.4 дэх хэсэгт ерөнхий шүүгч бусад шүүгчтэй адил энэ хуульд заасан хуваарийн дагуу хэрэг хянан шийдвэрлэнэ гэж заасан бөгөөд энэ талаар Улсын Дээд шүүхийн тогтоолд¹⁷ "... тухайн шүүхэд хэрэг хуварилах, хянан шийдвэрлэх шүүгчийн зөвлөгөөнөөс тогтоосон журыг бусад шүүгчийн адил хэрэгжүүлэх бөгөөд ерөнхий шүүгчийн хувьд тусгайлсан хөнгөлөлт, давуу эрх здлэхгүй гэж ойлгоно" гэсэн агуулгаар тайлбарласан байдал.

Тусгай санал: Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31.5 дахь хэсэгт "Шүүх хамтын зарчмаар хэрэг, маргааныг хянан хэлэлцэхдээ олонхын саналаар шийдвэр гаргах ба цөөнх болсон шүүгч тусгай саналтай бол тэдгээрийг нэгтгэж шүүхийн шийдвэрт хавсаргана" гэж заасанд.

2002 онд батлагдсан ИХШХШТХ-д энэ талаар тусгайлсан зохицуулалт

¹⁶ Ажиллагааны хугацаа гэсэн нэршилээр "тогисалдоор хувверлил буй хирэн нэг шүүгчид нэг өдөр 3 нэхэмжил хувверлилгадлаа гэж үзье. Тухайн шүүгч ажиллагаанд мөн олон хэрэгтэй байсан бөгөөд шинээр кулзан авсан нэхэмжилгүүдэд хэрэг үүсгэх хугацаа нь гурвуулна нэг өдөр дүүсэхэвчийн байгаа нь хэрэв тоиргоор хувверлилгадсан бол магадгүй 1 шүүгч 1 өдөрт 1 нэхэмжилэг күлээн авах байсан гэсэн тойргийн зармын санагалзууллаа, аччалал тэнцвэрхийг бүй засжад, эргэлзээ төрүүлэх үү гэдээс үзээд хугацааг харгалзах нь зүйтэй гэсэн санааг илрүхийнсөн болно.

¹⁷ Ж.Амарсанова нар. Монгол Улсын Дээд шүүхийн тогтооны эмхэтгэл (1959-2010). УБ., 2012 он. 660 дахь тал.

байхгүй харин ЭБШХ-ийн түүхэн уламжлалаас хараад 1963 оны БНМАУ-ын ЭБШХ-ийн 299 болон 305 дугаар зүйлд тусгай саналын талаар зохицуулсан бөгөөд 2002 оны ЭБШХ-ийн 289 дүгээр зүйлд "... тусгай саналaa бичгээр гаргаж, ... шүүхийн шийдвэрт хавсаргах" гэсэн утгатай адил агуулгаар зохицуулж байсан нь харагддаг.

ЗХШХШТХ-д заасан тусгай саналын талаарх зохицуулалтыг харуулбал:

- ЗХШХШТХ-ийн 128.4, 128.5 дахь хэсэгт "Хяналтын шатны шүүхийн шийдвэр гаргахад оролцсон шүүх бүрэлдэхүүний хоёр шүүгч тусгай санал гаргасан, эсхүл Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч хуульд харшилсан гэж дүгнэн гаргасан бол хэргийг 30 хоногийн дотор Улсын дээд шүүхийн хяналтын шатны захирагааны хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Улсын дээд шүүхийн хяналтын шатны захирагааны хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаан явуулах тухай шийдвэр гаргаж, хуралдааны тов тогтооно" гэж;
- ЗХШХШТХ-ийн 88.1 дэх хэсэгт "Шүүх хуралдааны тэмдэглэлд хуралдааны хэзээ, хаяан хийсэн, эхэлсэн, дууссан цаг, шүүгч, шүүх бүрэлдэхүүн... шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэргийн талаар асуух тодруулсан байдал, тусгай саналын товч утга, шүүхийн шийдвэрийн агуулга, түүнд гомдол гаргах хугацаа, журыг тайлбарласан талаар бичнэ" гэж тус тус хуульчилсан байна.

Хэргийн хяналтын шатны шүүхэд хянан шийдвэрлэсэн 5 шүүгчийн 2 нь тусгай санал гаргасан тохиолдолд хэргийг УДШ-ийн хяналтын шатны захирагааны хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр болсон.

Өмнө нь БНМАУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын 1984 оны 36 дугаар тогтоолд¹⁸ зааснаар эсэргүүцлээс гадна шүүгчийн тусгай санал мөн зруүгийн хэргийг хянах үндэслэл болж байжээ.

Мэдээ, судалгааны үзүүлэлт:

Шүүн таслах ажлын тайлан мэдээнээс харахад шүүх бүрэлдэхүүний шийдвэрлэсэн хэргийн тоо жил ирэх тутам нэмэгдэж байна. Үнийг хүснэгтээр үзүүлбэл:

2013-2016 онд шүүх бүрэлдэхүүний шийдвэрлэсэн¹⁹ хэргийн тоо

Шүүгчийн хэргийн хөдөлгөөний чанарын судалгаа зэргийг нэрлэж болно.

ШЕЗ-ийн 2007 оны 64 дүгээр тогтооолоор²⁰ баталсан шүүх, шүүгчийн ажлыг дүгнэх тухай журам, аргачлал, маягтыг 2014 онд хүчингүй болгосон байдал. Шүүх, шүүгчийн ажлын гүйцэтгэлийг дүгнэх маягтын Шүүгчийн ажлын гүйцэтгэлийг дүгнэх тоон үзүүлэлтээр “шүүгчийн дангаар болон бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн хэргийн тоо, бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн хэрэгт даргалсан, оролцсон, илтгэсэн хэргийн тоог, харин чанарын үзүүлэлтээр дангаар болон

д/д	Он	Эрүүгийн хэрэг			Иргэний хэрэг		Захиргааны хэрэг				
		Шийдвэрлэсэн хэрэг	Үүнээс		Дангаар	Бүрэлдэхүүний	Шийдвэрлэсэн хэрэг	Үүнээс		Дангаар	Шийдвэрлэсэн хэрэг
			Дангаар	Бүрэлдэхүүний				Дангаар	Бүрэлдэхүүний		
1	2013	6169	4888	1281	35308	34713	601	1106	817	236	
2	2014	6375	5055	1320	33996 ²¹	33301	695	1187	1015	172	
3	2015	6756	5554	1202	40674	40034	640	1439	1293	146	
4	2016	5762 ²²	4618	1144	46173	45327	846	1780	1636 ²³	144	

Эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхийн шүүн таслах ажлын мэдээ хагас, бүтэн жилээр гардаг бөгөөд энэхүү мэдээнд шүүх бүрэлдэхүүний оролцоог харж болох дээрх утгууд үзүүлэлтээр тусгагдсан байдал.

Энэхүү үзүүлэлтээс гадна зарим нэг судалгаанд шүүх бүрэлдэхүүний оролцоог харж болох бусад үзүүлэлт мөн тусгагдсан байдал. Тухайлбал, Шүүгчийн ажил гүйцэтгэлийн үнэлгээ,

¹⁸ Мен адил. 296 дахь тал.

¹⁹ Шүүгчийн судалгаа, мэдээлэл, сургалтын курзэлэнгээс гаргасан. Шүүх таслах ажиллагааны 2013, 2014, 2015, 2016 оны тайлан мэдээ.

²⁰ 2014 онд шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо буурсан нь эвлэрүүлжин агуулч ажиллагатай холбоотой.

²¹ 2016 онд шийдвэрлэсэн эргүүгийн хээг буурсан нь Ерөнхийлийн тухай хууль батлагдсантай холбоотой.

²² 2016 онд дангаар шийдвэрлэсэн захиргааны хэрэг өссөн нь ЭХШХЛХ-ийн 71.2 дахь хэсэгт 74.1 дахь хэсэгт зааснаас бусад харгийн шүүгч дангаар шийдвэрлэнэ, гэсэн хошигуулгаттай холбоотой.

бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн хэрэгт даргалсан, илтгэсэн, оролцсон хэрэг, тэдгээрийг давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хүчингүй болсон, өөрчилсөн үндэслэлийн тоог тус тус гаргаж байсан.

Шүүгчийн хэргийн хөдөлгөөний чанарын судалгаа нь энэхүү нэршилзэрээ 2013 оноос эхлэн шүүгч тус бүрэр гардаг болсон.

Уг судалгааг дангаар болон бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн хэрэг, давж заалдах болон хяналтын курмаар шийдвэрлэсэн хэрэг, тэдгээрийн хэвээр үлдээсэн, өөрчлөлт оруулсан, хүчингүй болгосон мөн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн хэрэгтэй мен адил утга бүхий үзүүлэлтээр тус тус гардад.

Иймд энэхүү судалгаа нь шүүгчийн ажил гүйцэтгэлийн чанарын

²³ Шүүгчийн захиргааны удирдлага /Эрх зүйн баримт бичгийн эмжлэгт-2/ УБ., 2008 он 352 дахь тал

үзүүлэлттэй харьцуулахад дангаар шийдвэрлэсэн хэргийг давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хянаад хэвээр үлдээсэн, өөрчлөлт оруулсан, хүчингүй болгосон гэсэн үзүүлэлт мөн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн хэргийг давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хянаад хэвээр үлдээсэн, өөрчлөлт оруулсан, хүчингүй болгосон гэсэн үзүүлэлтээр тус тусдаа гардаг болсноороо давуу талтай болж, шүүгчийн дангаар шийдвэрлэсэн хэргийн болон бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн хэргийн чанарыг тус тусад нь харах боломжийг бүрдүүлсэн.

Мөн Шүүхийн шийдвэрийн чанар, тогтвортой байдалд²¹ дүн шинжилгээ хийхэд шүүгч тус бүрийн хэргийн хөдөлгөөний чанарын судалгаа нь өргөн хүрээнд ашиглагдах боломжтой.

ДҮГНЭЛТ

Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх "шүүх бүрэлдэхүүн"-ийг хуульд тусгайлан зааснаар эсхүл шүүгч дангаар шийдвэрлэхээр хуульд заасан хэдий ч хэргийн эздрээ төвөтгэй болон бусад зайлшгүй нөхцөл байдлаас шалтгаалан шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэхээр тоогоогдсон гэсэн өрөнхий агуулгаар зааглаж болохоор байна.

Эрүүгийн хэрэгт ЭБШХ-ийн 32.2 дахь хэсэгт зааснаар хэргийн эздрээ төвөтгэй байдлаас шалтгаалан шүүгчийн гаргасан саналын дагуу Ерөнхий шүүгч тухайн хэргийг бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх эсэхийг тогтоож байна.

Харин захирагааны хэргийн хувьд шүүгчийн зөвлөгөөнөөр шүүгч дангаар шийдвэрлэх хэргийг шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэхээр тогтоох ажиллагаа хэрхэн явагдах талаар тодорхойгүй байгаа нь энэхүү зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд мөн захирагаан хэргийн анхан шатны шүүхүүдэд уг зохицуулалтыг нэг мөр ойлгох хэрэглэхэд хүндэрэл учруулж болзошгүй юм.

²¹ Шүүн таслав ажлын тайлан мэдээнд ийм дун шинжилгээ заавсан хийдэг.

Шүүх нь шүүгчийн зөвлөгөөнөөр тогтоосон хэрэг нэхэмжлэлийг хуваарилах журам болон шүүх хуралдаан даргалагчийн дараалал, мөн шүүгчийг болон бүрэлдэхүүнд оролцох шүүгчийг дарваалыг мэдээлэл лавлагааны мэргэжилтэн эсхүл мэдээллийн самбаараа дамжуулан сурталчлан таниулбал шүүхээр үйлчлүүлгчдийн зугзэс хуваарийн талаар эргэлзээ төрөх, хардах, ойлгохгүй байх зэрэг хандлагыг өөрчлөхөд нелөө үзүүлэх боломжтой.

Харин хуваарийг тогтоождоо "урьдчилан мэдэх боломжгүй, тохиолдоор хуваарилах" нөхчлийг баримтлахын зэрэгцээ шүүгчийн ачаалал /энд зөвхөн ачааллыг тооны хувьд тооцоогоо хангатгуй/²², хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаа хугацаа зэргийг шалгур болгох нь хуваарь шударга байх, шүүх бүрэлдэхүүний оролцоо тэгш хангадах нөхцөлийг бүрдүүлнэ.

ЗХШХШТХ-ийн 72.4 дахь хэсэг, ИХШХШТХ-ийн 78.4 дахь хэсэгт тус тус зааснаар өрөнхий шүүгч²³ бусад шүүгчтэй адил хуваарийн дагуу хэрэг хянан шийдвэрлэхээр байгаа нь УДШ-ийн тогтоогд зааснаар тухайн шүүх дэх шүүх бүрэлдэхүүний оролцоог тэгш хангах талаар хуульчилсан шаардлага гэж ойлгох болохоор байна.

ЗХШХШТХ-ийн 88.1, 128.4 дахь хэсэгт тусгай саналын талаар онцлог зохицуулалт хуульчлагдсан байна.

—ооо—

²² Энэ нь А болон Б шүүгчид тус бүр 10 нэхэмжилэлт хуваарилагдсан байх гэсэн тоо ачааллаас гадна олон асуудал байгаагаас сэдэвтэй холбоотойтор тэдний хадий шүүгч дангаар, шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэхийг мөн харгалах боломжийн тухай ярыг байгаа юм. Гэтэл "систем"-ээс хуваарь хийцдээ тухайн нэхэмжилэлийн дагуу хэрэг үзүүлэх эсэх, эзргийг шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх эсэхийн тооцоогоо боломжтуй. Харин язгаар үзүүсний дараа тооцоогоо боломжтуй байж болох юм. Тагхадаа ЗХШХШТХ-ийн 74.1.3 дахь эсэгтэй засалт тохиолдол байвал хэрэг шүүгчийтэй зэрэгцэд энэ асуудлыг шийдвэрлэхийтэй бол ХХША-ийн хугацаа явагдах, бүрэлдэхүүн оролцогч шүүгчийн оролцоо тэгш хангагдахуй байх нөхцөл үүсэх таатай.

²³ Зарин шүүхийн өрөнхий шүүгчид хэрэг, нэхэмжилэлийг тойроог хуваарилж хуваарилж хувьшижсан ёноки /1 удаа ёноки гах мэдэх шүүгчийн зөвлөгөөнөөр баталсан журамд тусгасан бандай.

КАБИНЕТИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ



"Оюуны инноваци"-Эрх зүйн судалгааны
төвийн Тэргүүн, өмгөөлөгч П.Баттүлгэ

ТҮЛХҮҮР ҮГ:

Танхим (кабинет)-ын Засгийн газар, Сайд нарын Зөвлөл, Засгийн газар танхимын зарчмаар ажиллас

ТОВЧЛОЛ:

Монгол Улсын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг болон 43 дугаар зүйлийн 2 дахь хэсэгийн заалтад ямар үзэл санаа агуулагдаж талаар судлахаа 1993 оноос хойш Монгол Улсын Засгийн газрын онцлог, үндсэн шинжийг 1993 оноос өмнөх Сайд нарын Зөвлөлтэй харьцуулан авч үзсэн болно.

1. Оршил

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын ёмже хариуцаа.", Дөчин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно." гэж заасан нь манай улсын Засгийн газар хамтын хариуцлага хүлээдэг, танхимиын зарчмаар ажилладаг Засгийн газар

боловхыг тодорхойлсон. Чухамхуу Үндсэн хуулийн эдгээр заалтад ямар үзэл санаа агуулагдаж буй болохыг энэхүү өгүүлээр хөндөхийг зориллоо.

2. Сайд нарын Зөвлөл ба кабинет (танхим)-ын Засгийн газар

1990 оны 5 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан БНЧАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн хуулиар Ардын Их Хурлын зэрэгцээ Улсын Бага Хурлыг сонгох. Ерөнхийлөгчийн институутыг бий болгох, кабинетийн Засгийн газартай болох, Үндсэн хуулийн хяналттай болох, үүний тулд Үндсэн хуулийн зөвлөлийг байгуулах зэрэг Монгол Улсын төрийн дээд байгууллагуудын завсрлын чанартай тогтолцоог шинчлэн бий болгохээ. Тодруулбал, үүний дотор гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллагын тухайд социализмын үеийн Сайд нарын Зөвлөл хэмээх хамтын удирдлагатай байгууллага татгалзак танхимиын Засгийн газар гэсэн нэг хүний удирдлагатай байгууллагын хэлбэрт шилжүүлсэн байна.

Өөрөөр хэлбэл, 1990 оноос ёмже нь байсан Монгол Улсын төрийн гүйцэтгэх дээд байгууллага болох Сайд нарын Зөвлөл нь хамтын удирдлагатай буюу төрийн яамд болон хууль тогтоомжоор тодорхойлсон бусад байгууллагыг төлөөлсөн төлөөлгөч болох сайд, дарга нарыг нийлүүлж зөвлөл байгуулаад тэдгээр нь асуудлыг хамтын зарчмаар шийдэ:эрлэдэг байжээ. Харин одоогийн Засгийн газар нь нэг хүний удирдлагатай буюу гишүүд нь Ерөнхий сайдын бүрдүүлсэн сайд нарын бүрэлдэхүүн ба тэдгээр нь төрийн яамдыг төлөөлж цуглах биш, сайдууд нь хуулиар тодорхойлсон

¹Си-нэг МАХН-ын Төв корооны Улс төрийн төвчлийннос баталж оруулсан бурялжхүүнээр АИХ-ын чуулганыар 4 жилийн хугацаагаар томилын байгуулна. Б.Чимиджийн улс төр хуульчийн нудээр" УВ., 2006 он, 48 дахь тал

зохих чиг үргүйг хариуцан бодлогыг нь удирддаг байгууллага аж. Энэхүү зарчмыг ялгаат Б.Чимид багшийн "Сайд нарын Зөвлөлийн дарга, Ерөнхий сайд гэж яягаад хөөр өөр нэртэй байдаг юм ба ээзэл энэ хөөр өөр зарчмаар ажилладаг. Сайд нарын Зөвлөл бол зөвлөлөрөө хэлэлцэж байж асуудлыг шийдвэрлэдэг, Ерөнхий сайд бол сайд нараа удирдаж асуудлыг дангаараа (тухайн асуудлыг эрхэлсэн сайдтайгаа тохиолцон) шийдвэрлэдэг систем"² хэмээн тайлбарласнаас давхар харж болохоор байна. Өөрөөр хэлбэл Сайд нарын Зөвлөл болон одоогийн Засгийн газар нь удирдлагын хэлбэр, хариуцлага хүлээх, ажиллах зарчмын хувьд өөр, эсрэг чиглэлтэй байдаг аж.

Тодруулбал, Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх алжыг Улсын Их Хурлын өмнө хариуцна" гэж танхимын Засгийн газрын үзэл санааг тусгажээ. Засгийн газар танхимын зарчмаар ажиллах Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаа нь Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, түүний үйл ажиллагааг Улсын Их Хурлын өмнө дангаар хариуцах; сайд (Засгийн газрын гишүүн) нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийн зохих салбар, хүрээндийн бодлогын асуудлыг Ерөнхий сайдын өмнө шууд хариуцах зарчмаар тодорхойллогджээ.

3. Сайд нарын Зөвлөлийг босгон тавьж кабинетийн Засгийн газрыг угүй хийв

1993 оны 5 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн уг эхийн³ 30 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт Засгийн газар асуудлыг хуралдаанаараа хэлэлцэх боловч санал зөрвөл Ерөнхий сайд, уг асуудлыг эрхлан хариуцах сайд хоёр үеөөн болсон ч уг асуудлыг санал нэгтгээгээр шийдвэрлэх, харин Ерөнхий сайд эрхэлсэн сайдтай санал нэгдээгүй тохиолдолд Ерөнхий сайд бие даан шийдвэрлэхгүй байхаар, харин хуулийн

төсөл, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бусад асуудал, олон улсын гэрээ, нам, тусгай газрын олонхын эрхлэх ажилд холбогдсон болон хууль тогтоомжид тусгай заасан асуудлыг олонхын саналаар шийдвэрлэж байхаар зохицуулсан байжээ.

Харин 2005 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн "Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль"-ийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалтаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг "Засгийн газар асуудлыг олонхын саналаар шийдвэрлэнз. Ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол шийдвэр гарцаагүйд тбоюно" гэж өөрчлөн найруулж, мөн 6 дугаар зүйлээр 30 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг хүчингүй болгожээ. Үг хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2004 оны Улсын Их Хурлын сонгуулийн дараа хийсан нь улс төрийн зорилготой байсныг харуулж байгаа мэт. Учир нь 2004 оны Улсын Их Хурлын эзлжит сонгуулийн үр дүнгээр сонгуульд орцлсон нам, эвслээс аль нь ч парламентад олонхын судал авч чадаагүй тул Монгол Улсад анх удаа "эвслийн Засгийн газар" байгуулгасан байдал. Энэхүү эвслийн Засгийн газрыг "Эх орон-Ардчилал" эвсэл, МАН /тухайн үеийн "МАХН"/ тус бүр 9 хүний төлөөлөлтэйгээр, нийт 18 хүний бүрэлдэхүүн/Ерөнхий сайдыг оруулан-тэй⁴ бүрдүүлж байсан. Үүний дараа Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд уг нэмэлт, өөрчлөлт оруулан Засгийн газрыг хамтын зарчмаар шийдвэр гаргах зохицуулалтыг оруулсан нь Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлсэн бус харин "намууд харилцан зөвшилцэж Засгийн газрын шийдвэрийг гаргах" зорилтыг агуулсан болох нь харагдаж байна.

Ийнхүү Үндсэн хуульд Монгол Улсын Засгийн газар нь нэг хүний удирдлагатай байгууллага байхаар заасан байхад хамтын удирдлагатай байгууллагаын нэгэн адил асуудлыг

² Ардчиллын аман түүх – Б.Чимид, Эх сурвалж: <https://www.youtube.com/watch?v=ZbjpmWLO7M0> (7:12 – 7:40)

³ Төрийн мэдээлэл эмхэгтэлийн 1993 оны 3 (12) дугвартын нийтлэгдсэн.

⁴ Төрийн мэдээлэл эмхэгтэлийн 2004 оны 5 (370) дугвартын 2004 оны Засгийн газрын бүрэлдхүүнийн баталсан УИХ-ын тогтолцоогоы нийтлэгжээ.

хамтын зарчмаар шийдвэрлэдэг байхаар хуульд өөрчлөлт оруулсан нь Үндсэн хуульд нийцэхгүй байж болзошгүй. Үндсэн хуулийн зарчмаар тагцхүү Ерөнхий сайд л Улсын Их Хурлын эмне хариуцлага хүлээх ёстой ба энэ утгаараа Засгийн газар асуудлыг хамтран хэлэлцэх боловч Ерөнхий сайдын санал Засгийн газрын шийдвэрийг гаргахад шийдвэрлэх нелөөт байхаар байна.

Түүнчлэн дээрх нэмэлт, өөрчлөлтийн талаар Б.Чимид багш "... Засгийн газэр огцорч шинээр байгуулагдах тутам Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг ёс шиг өөрчилдөг болсноо гадна сүүлдээс танхимын зарчмаар ажиллах хууль зүйн цорын ганц үндсийн нь тасалсан өөрчлөлтийг 2004 онд хоёр намын зөвшүүлийн гэрээний дээгу оруулжээ. Энэ нь агуулжин хувьд Үндсэн хууль ноцтой харшилсныг хэн ч яруу тод ухаарсангүй. Харин "звслийн", "эв нэгдлийн" гэдэг яруу тооонгийн дор урьдын Сайд нарын Зөвлөлийг босгон тавьж, Ерөнхий сайдын үүрэг хариуцлагыг сурлуулж, сайд нарын "багийг" задлав. Юу гэвэл, уг хуулийн 1993 онд батлаадсан эхэд Засгийн газар асуудлыг хуралдаанаараа хэлэлцэх боловч санал зөрвэл Ерөнхий сайд, уг асуудлыг эрхлэн хариуцах сайд хоёр (цөөнх болсон ч) санаа нэгдэн шийдэж, үр дүнг хариуцах, эрхэлжн сайд зөрвэл Ерөнхий сайд дураар шийдвэгүй байх зарчмын тогтолцосон. Энэ бол төрийн хувь заяаг Ерөнхий сайд УИХ-ын өмнө ганцаараа, салбарыг нэг сайд дангаараа хариуцдааг зарчмыг баталгаж нэг сайдын шуурхай гүйцэтгэх үүрэгт бусад нь хөндлөнгөөс оролцож ажил хэргийг ацуулж эзэнгүйдүүлдэг "хамтын удирдлагын" зарчмаас татгалзсан шинээтгэл байсан юм.⁶ "Засгийн газар эрх хэмжээний асуудлыг Ерөнхий сайд салбар эрхэлжн сайдтайгаа тохиолцон (олонхтой санал зэрсэн ч) дангаар шийдэж байхаар Засгийн газрын тухай 1993 оны хуульд

заасан. Гэтэл үүнийг 2004 онд "хоёр намын гэрээ" гэгчээр хучингүй болгож "сүнсийг" нь аваад ЗГ-ыг өмнөх үеийн "Сн3" шиг, Ерөнхий сайдын УИХ-ын өмнө ганцаар хариуцах Үндсэн хуулийн зарчмыг хөсөр хаяж, "номжон тэмээз" болгожээ." хэмээн өөрийн номдоо бичжээ.

Үндсэн хуульд зааснаар танхимаа удирдаж төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх ёстой Ерөнхий сайд нь Засгийн газрын шийдвэрийг гаргахад танхимынхаа нэг гишүүнтэйгээ ижил статустай байхаар эрх зүйн зохицуулалтыг бий болгосон нь бодит байдал дээр Засгийн газар 18 хүний бүрэлдэхүүнтэй байлаа гэхэд Ерөнхий сайд салбар хариуцсан сайдтайгаа санал нэгдээд ч үлдсэн 16 сайд нь дэмжээгүй бол Засгийн газрын шийдвэр Ерөнхий сайдын эсрэг гарна гэсэн үг. Түүнчлэн Засгийн газрын шийдвэрийг олонхын саналаар гаргах тохиолдолд Ерөнхий сайдын оролцоогүйгээр бусад гишүүд хуралдан Засгийн газрын нэрийн өмнөс шийдвэр гаргах боломжийг олгоно.⁸ Негee талаас наад зах нь нэг агентлагийн дарыг томилох, чөлөөлөх асуудлыг шийдвэрлэхэд Ерөнхий сайд нь олонхын саналыг авахын тулд танхимиин гишүүдээ "царайчлах", тэдний ашиг сонирхлыг харгалzan үзэх нөхцөл байдал руу тулхэж байна.

Засгийн газар асуудлыг олонхын саналаар шийдвэрлэхээр зохицуулсан нь Засгийн газрыг буцаагаад социализмын үеийн Сайд нарын Зөвлөлийн систем руу шилжүүлж, улмаар парламентынхаа үүргийг нэхэн гүйцэтгэдэг жижиг парламент шиг болгосон нь⁹ Ерөнхий сайдын «Засгийн газраа удирдах», «Засгийн газрын нэгдмэл байдлыг хадгалах»

⁶ Б.Чимид "Өнөөгийн улс төр хуулийн нүдээр" УБ., 2006 он, 77 дахь тал.

⁷ Ерөнхий сайдын эзгүй хойгүүр Засгийн газрын бусад гишүүд хуралдан Цагдаагийн Ерөнхий газрын дарыг чөлөөлөх эсэх асуудлыг хэлэлцэх дэхсен саяхны жижээ үүний нотолж байна. Эх сурвалж: <http://www.news.mn/r/300865>, <http://today.mn/p/17877>, <http://www.newscom.mn/10009758>

⁸ Энэ талаар Б.Чимид "Өнөөгийн улс төр хуулийн нүдээр" УБ., 2006, 76 дахь тал болон мөн Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин "Парламентыг 76 хүнээр хэмжихгүй ээ" ярилцлагадаа дурдээж Эх сурвалж: <http://www.news.mn/r/22202>

⁹ Б.Чимид "Төр, нам, эрх түйн шинээтгэлийн эзлэлтэй асуудал" Хөөрдүгээр давтэр УБ., 2008 он, 31-32 дахь тал.

шинж чанарыг алдагдуулсан, Ерөнхий сайд эсрэг байр суурьтай байгаа асуудлынхаа ур дагаврыг Улсын Их Хурлын өмнө хариуцах, сайдын төрийн гүйцэтгэх эрх мэдлийн зохих салбар, хүрээний бодлогын асуудлыг Ерөнхий сайдын өмнө шууд хариуцан ажиллах үүрэгт нь бусад сайд хөндлөнгөөс оролцож, ажил хэргийг эзэнгүйдэх боломжтой болгосон нь манай улсын Засгийн газар танхимын зарчмаар ажиллах Үндсэн хуулийн үзэл санаатай нийцэхгүй мэт.

4. Дүгнэлт

Эцэст нь Засгийн газрын гол онцлог, үндсэн шинжийг өмнөх Сайд нарын Зөвлөлтийн харьцуулан авч үзсэний үндсэн дээр кабинетийн Засгийн газрын талаарх шинэ Үндсэн хуулийн үзэл санааг дараахаа байдаараа тодорхойлж болно гэж үзэж байна:

- 1) **Удирдлагын хэлбэр** – Сайд нарын Зөвлөл нь хамтын удирдлагатай бол одоогийн Засгийн газар нь нэг хүний удирдлагатай.
- 2) **Хариуцлага хүлээх** – Сайд нарын Зөвлөл нь хамтын бус хариуцлага хүлээдэг буюу дарга, гишүүд нь улс төрийн хариуцлагыг тус бүрдээ хүлээх бол Засгийн газар танхимын зарчмаар хариуцлага хүлээх буюу

Ерөнхий сайд, эсхүл гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бухэлдээс огцорч Улсын Их Хурлын өмнө хамтын (танхимаараа) хариуцлага хүлээнэ. Сайдын хувьд түүнд хариуцлага тооцуулах (огцруулах) талаар Ерөнхий сайд (Ерөнхийлгэчтэй зөвшилцэн) Улсын Их Хуралдан санаал оруулаагүй байхад Улсын Их Хурал дур мэдэн шийдвэрлэхгүй.¹⁰

- 3) **Ажиллах зарчим** (шийдвэр гаргах) – Сайд нарын Зөвлөл нь хамтын удирдлагатай байгууллага тул асуудлыг хамтын зарчмаар (олонхын санаалаар) шийдвэрлэн.¹¹ Өнөөгийн Засгийн газар нь нэг хүний удирдлагатай байгууллага тул Ерөнхий сайд нь танхимын гишүүдээс ног баg болгон удирдах, төрийн гүйцэтгэх эрх мэдлийг ажлыг (хууль билеүүлэх) шуурхай, тасралтгүй зохион байгуулж, үүнийхээ хариуцлагыг Улсын Их Хурлын өмнө дангаар хариуцах, сайд нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийн зохих салбар, хүрээний бодлогын асуудлыг Ерөнхий сайдын өмнө шууд хариуцна. Энэ утгаараа Засгийн газрын шийдвэрийг гаргахад Ерөнхий сайдын хүсэл зориг, санал шийдвэрлэх үүрэгтэй байна.

---000---

¹⁰ Засгийн газар танхимын зарчмаар (хамтын) хариуцлага хүзүүх талаар Б. Чимид багийн бутээлдээ: 'Ерөнхий сайд ямар сайдын ясны учир огцруулахыг өөрөө мэдэж, үндэслэлээс гаргаж парламентад оруулах ёстой. Фөөврөр хэмбэл, яж томилсон тагх огцруулахаа. Хэрээ Ерөнхий сайдын огцруулахар оруулсан сайдыг парламент огцруулах үндэслэлээг байна аа гэж үзэв УИХ эргээд Ерөнхий сайдтай хариуцлага тооцох үндэслэл гарч ирж болно. Энэ чинь хөөр тийшээ холбоо бүхий, танхимын зарчмыар хариуцлага хүлээдэгийн иргэлт байхгүй юу' гэж бичкээ. ('Тэр, нам, эдээ зүйн шинэцгээний эзгэлтэй асуудал' Нэдүүзэр дээгэр, УБ., 2008 он, 168 дахь тал.) Мен Үндсэн хуулийн цэц 2015 оны 11 дугаар дундгыл, 2015 оны 09 дугаар тогтоогоороо энэ зарчмыг баталгаажуулсан билээ.

¹¹ Б. Чимид 'Өнөөгийн улс төр хуульний нүдзэр' УБ., 2006 он, 48 дахь тал.

МОНГОЛ УЛС, ОХУ, БНХАУ-ЫН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



Шүүхийн судалгаа мэдээлэл, сургалтын хурзэлэнгийн судлаач **Л.Галбаатар**

ТҮЛХҮҮР ҮГ:

Хоёр хэрш, кибер аюулгүй байдал, хамтын ажиллагаа, олон улсын эрх зүй.

ТОВЧЛОЛ:

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзлэл баримтлалд, Монгол Улс нь ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн нийрэг харилцаа, өргөн хүрээлтийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, бүхэлдээ тэнцвэртэй харилцаахыг эрмэлзэх талаар тусгасан. Гэвч мэдээллийн үсрэнгүй хөгжлийн эрин үед БНХАУ, ОХУ-ын нутаг дэвсгэрээс Монгол Улс уруу чиглэсэн кибер халдлагаа ихээхэн нэмэгдэх болсон. Иймд энэ өгүүллээр, аюулгүй байдал, түүний дотор мэдээллийн аюулгүй байдлыг хангах салбарт Монгол Улс, хөрш хоёр оронтой хоёр болон турван талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд холбоотой эрх зүйн орчныг тодруулах, түүнийг шинжлэн судлах шаардлагаа нэгзэн үүсжээ.

Оршил

2016 оны 3 дугаар сарын байдлаар Монгол Улсын "интернетийн урсгал" дээр кибер халдлага үйлдсэн улс орнуудын дотроос манай хоёр хэрш буюу БНХАУ, ОХУ давамгайлах болсон нь ажиглагдлаа. Ер нь манайд ийм үйлдэл явуулж байгаа улс орны тоонд АНУ, Тайвань, БНСУ багтаж байгаа юм¹.

Кибер халдлага нь, кибер гэмт хэргийн төрөл төдийгүй кибер аюулгүй байдалд заналхийлэх голгох эх үүсвэр юм². НҮБ-ын мэдээллийн кибер халдлага нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгт хамаарах бөтөөд дэлхийн эдийн засагт жил бүр нэг тэрбум америк долларын хохирол учруулж байгаа ноцтой үр дагавартай юм³.

Ийм нөхцөлд Монгол Улсын зүгээс кибер аюулгүй байдлаа хангах, цахим орчинд бусад улс, этгээдтэй сергэлдэх аюулаас сэргийлэх зорилгоор хөрш хоёр оронтойгоо хоёр болон турван талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд холбоотой эрх зүйн орчныг тодруулах, түүнийг шинжлэн судлах шаардлагаа нэгзэн үүсжээ.

Ингээд энэ өгүүллээр, Монгол Улс, ОХУ, БНХАУ гэсэн турван орны

¹ Кибер аюулгүй байдлын газар. Монгол Улсын интернетийн 0.02% урсгал дээр хийдэж буй халдлагын шинж бүхий хандалт 2016 оны 2 дутвар гэр. 2016.03 http://nscs.gov.mn/?id=132

² Л.Галбаатар. Кибер гэмт хэргийн шүүжэд хянан шийдвэрлэх нь. МУИС Пресс хэвлэлийн газар. Улаанбаатар. 2015 он. 13 дахь тал.

³ United Nations Office on Drugs and Crime. Transnational organized crime: the globalized illegal economy <https://www.unodc.org/oc/crimes/organized-crime.html>

⁴ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзлэл баримтлал (2010)-ын 3.6.1.12 дахь хэсэгт Мэдээллийн аюулгүй байдлын хангах, мэдээллийн орчинд сергэлдэх аюулавс сэргийлэх, кибер орчин дахь гэмт явадлай тэмжэх чиглэдэг олон улсын хамтын ажиллагаагөргөжүүлэн хөгжүүлэх гэж заасан.

кибер аюулгүй байдлыг хангах хамтын ажиллагааны эрх зүйн орчин болон өнөөгийн нөхцөл байдлыг дүгнэж танилцуулах, цаашид Монгол Улсаас хөрш хоёр оронтой кибер аюулгүй байдлыг хангах асуудлаар яаж тэнцвэртэй харилцах болон кибер аюулгүй байдлыг хангахад цаашид анхаарах асуудлын талаар үндсан турван хэсэг бүхий бүтцийн хүрээнд барь сууриа танилцуулж байна. Үүнд,

1. Үндэсний аюулгүй байдал ба цахим орчны харилцан хамаарал;

2. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын цахим орчинд үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, эрх зүйн зохицуулалт;

3. Кибер аюулгүй байдлыг хангах асуудлаар Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын өнөөгийн байдал, чиг хандлага тус тус багтах байна.

Нэг. Үндэсний аюулгүй байдал ба цахим орчны харилцан хамаарал

1990-ээд оноос эхлж, АНУ-ын тухайн үеийн ерөнхийлгч Б.Клинтоны тамгын газраас, үндэсний аюулгүй байдал ба интернет хоорондын хамаарлыг дэвшүүлэн ярысан байдаг⁵.

Интернетийг зөвхөн нэг улс зээмшигхүй бөгөөд түүнийг нийт байгууллага, иргэн ашиглах боломжтой болгохын хувьд улс орууд интернетийг зөвхөн тухайн улсын нутаг дэвсгартай адил, дангаар зээгнэн засаглах боломжгүй юм.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлын үүднээс, цахим орчинд тухайн улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг, тухайн улсын кибер аюулгүй байдал гэж үзэж болох юм⁶.

⁵ Derek S. Reveron. "An Introduction to National Security and Cyberspace". p. 3-20. *Cyberspace and National Security: threats, opportunities, and power in a virtual world* / Derek S. Reveron, editor. Georgetown University Press. Washington DC. 2012. p. 6.

⁶ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010)-ын 1.1.1 дахь хэсэгт "Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ" гэснийг үндэслэн улс орны кибер аюулгүй байдлын тухай тохируулан тайлбарласан.

Цахим орчин (*CyberSpace*) гэдэгт, юуг ойлгох талаар бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт байхгүй хэдий боловч интернет, харилцаа холбооны сүлжээ, компьютерийн технологийн харилцан хамааралтай дэд бүтцийн сүлжээнээс бүрдэх дэлхий нийтийн мэдээллийн орчин дахь орон зай, гэж ойлгодог⁷. АНУ, БНХАУ, ОХУ, Израиль, Франц зэрэг олон улс орон, цахим орчин дахь зөрчил, мөргөлдөөнд бэлтгэж байна⁸. Тухайлбал, АНУ-ын хувьд "Цахим орчны олон улсын стратеги" хэмээх баримт бичгийг 2011 оны 5 дугаар сард хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд түүнд цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах ўйл ажиллагааны голлох дөрвөн шинжийг тодорхойлсон байна. Үүнд,

- инновацийд нээлттэй байх;
- хүмүүсийн итгэлийг олж авах буюу түүнийг алдахгүйн тулд аюулгүй байдлыг хангалттай хангах;
- дэлхий даяар харилцан хамтран ажиллах боломжтой байх;
- найдвартай байх⁹.

Энд дурдсан аюул заналын эсрэг, найдвартай байдлыг хангах нь өнөөдөр үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой яриа, хэлэлцүүлэгт давамгайлах болсон бөгөөд ирээдүйн аюул занал, дайны адил санаа зовоох зүйл болсон талаар судлаачид онцлох

⁷ "Cyber Space" буюу цахим орчин гэдэгт юуг ойлгох талаар улс орциуд язь бүрзэр тайлбарласан байгаа эндээс узэж болно Cyber Definitions. CCDOE. <https://ccdoe.org/cyber-definitions.html>:

Tim Maurer & Robert Morgus. Compilation of Existing Cybersecurity and Information Security Related Definitions. Report. 2014.10. p. 18 https://static.newamerica.org/attachments/175-compilation-of-existing-cybersecurity-and-information-security-related-definitions/OTI_Compilation_of_Existing_Cybersecurity_and_Information_Security_Related_Definitions_Updated122015.pdf

⁸ Derek S. Reveron. "An Introduction to National Security and Cyberspace". p. 3-20. *Cyberspace and National Security: threats, opportunities, and power in a virtual world* / Derek S. Reveron, editor. Georgetown University Press. Washington DC. 2012. p. 4.

⁹ U.S. International Strategy for Cyberspace. 2011.05. p.25 https://www.whitehouse.gov/sites/default/files/rss_viewer/international_strategy_for_cyberspace.pdf

болов¹⁰.

Умард Атлантын Гэрээний Байгууллага (NATO)-ын Кибер довтолгооноос хамгаалах хамтын ажиллагааны төв (CCDCOE)-өөс түүвэрлэн бэлтгэсэн, улс орнуудын кибер аюулгүй байдлын бодлого, эрх зүйн баримт бичгийн жагсаалтаас харахад, өнөөдөр кибер аюулгүй байдлыг хангахад ихэнх улс орон онцгой анхаарч байгаа нь тодорхой байна¹¹. Тодруулбал, дараахь улс орон кибер аюулгүй байдлын бодлого, эрх зүйн баримт бичиг боловсруулж, хэрэгжүүлж байна. Үүнд,

- НАТО-гийн гишүүн орнууд:

Албани, АНУ, Бельги, Болгар, Дани, ИБУИНВУ, Исланд, Испани, Итали, Канад, Латви, Литва, Люксембург, Нидерланд, Норвеги, Польш, Португали, Румын, Словак, Словени, Турк, Унгар, Франц, ХБНГУ, Хорват, Чех, Эстон.

- НАТО-гийн гишүүн бус орнууд:

Европын бус нутгаас: Австри, Босни-Герцеговин, Гурж, Европын холбоо, Ирланд, Кипр, Монтенегро, ОХУ, Серби, Украин, Швец, Швейцар, Финланд.

Ази, Номхон далайн бус нутгаас: Австрали, Азербайжан, Арабын нэгдсэн Эмирят, Афганистан, Бангладеш, БНСУ, БНХАУ, Катар, Малайз, Монгол, Пакистан, Саудын Араб, Сингапур, Шинь Зеланд, Энэтхэг, Япон,

Африкийн бус нутгаас: Африкийн холбоо, Ботсвана, Гамби, Гана, Египет, Зимбабве, Кени, Маврикий, Мавритани, Марокко, Нигер, ФАБНУ, Уганда.

Америк, Карибын тэнгисийн бус нутгаас: Бразил, Гренада, Колумб, Коста Рика, Панам, Тринидад-Тобаго, Ямайк.

¹⁰ Derek S Reveron. "An Introduction to National Security and Cyberspace" p 3-20. *Cyberspace and National Security: threats, opportunities, and power in a virtual world* / Derek S Reveron, editor. Georgetown University Press. Washington DC 2012. p 3

¹¹ Cyber Security Strategy Documents. NATO Cooperative Cyber Defence Centre of Excellence 2016.04 <https://ccdcoc.org/cyber-security-strategy-documents.html>

Дээр дурдсан 76 улсын жагсаалтад манай улсыг багтаасан байх бөгөөд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010) болон Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2010)-г оруулсан байгаа нь НАТО-гийн Кибер довтолгооноос хамгаалах хамтын ажиллагааны төв (CCDCOE)-өөс бэлтгэсэн улс орнуудын кибер аюулгүй байдлын бодлого, эрх зүйн баримт бичгийн жагсаалт үнэхээр шинэлэг бөгөөд бүрэн болохыг харуулж байна.

Улс орнуудын кибер аюулгүй байдлын бодлого, эрх зүйн баримт бичийг үнэлж цэгнэхэд, "CIA" гурвалжнингийн зарчмыг баримтлах шаардлагатай болохыг мэдээллийн аюулгүй байдлын судлаачид тэмдэглэсэн байдал¹².

Энэ нь мэдээллийн нууцлал (*confidentiality*), бүрэн бүтэн байдал (*integrity*), хүртээмжтэй байдал (*availability*) харилцан тэнцвэртэй, гурвалжнингийн тал мэт байх тухай үзэл санаа юм¹³.

¹² Anthony Henderson. The CIA Triad: Confidentiality, Integrity, Availability. Panmore Institute. 2015.07 <http://panmore.com/the-cia-triad-confidentiality-integrity-availability>

¹³ Энэ талаар Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6.2, 3.6.3, 3.6.4 дэх хэсэгт зассан Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтолцын хавсралт Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. http://legalinfo.mn/annex/details/3350?law_id=6163

1 дүгээр хүснэгт. Кибер аюулгүй байдлыг хангах зарчим

<p>Бүрэн бүтэн байдал</p> <p>Мэдээлэл, мэдээллийн орчин, түүний дэд бүтцэд хууль бусаар нөвлөвөлөх, өөрчлөх оролцлогогоос хамгаалж чадсанар мэдээллийн бүрэн бүтэн байдал хангагдана.</p>	
<p>Нууцлал</p> <p>Мэдээлэл, түүний бурдэл хасэгт хууль бусаар хандах, хандах, задруулахас хамгаалнаар нууцлал хангагдана.</p>	
<p>Хүртээмжтэй байдал</p> <p>Хуулиар хориглоогүй мэдээллийн чөлөөтэй хайх, олж авах, үүсгэх, дамжуулах, түгээх эрх, эрх чөлөөтэй хангах, мэдээллийн дад бүтц, түүний бурдэл хэсэг, үйлчилгээнд чөлөөтэй хандах боломж бурдуулсан эрх мэдээллийн хүртээмжтэй байдал хангагдана.</p>	

Хоёр. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын цахим орчинд үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, зохицуулалт

Энэ хэсэгт Монгол Улс болон хөрш хоёр орон болох ОХУ, БНХАУ-ын цахим орчинд үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон бодлого, эрх зүйн зохицуулалтаас тэдгээрийн онцлогийг тодорхойлох юм.

Монгол Улсын бодлого, эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын хувьд, кибер аюулгүй байдлыг хангах бодлогын үндсэн баримт бичиг нь, 2010 онд шинэчилж боловсруулсан, "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал" юм¹⁴.

Монгол Улс даяар дагаж мөрдөх цахим засаг, мэдээллийн аюулгүй байдлын нэгдсэн бодлыг "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-д тусгасан. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоофын хавсралт "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-д /3.6/ "Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мен" тэж зассан.

Энэ тухай 1994 оны "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын¹⁵ 7 дугаар зүйлд тусгагдсан боловч өнөөгийн шиг мэдээллийн дайны түвшинд асуудал дэгдээгүй байсан. Тиймээс мэдээлэл өөрөө үндэсний аюулгүй байдалд шууд нөвлөвөлөх үйлчлэл нь бага байсан юм. Дээрээс нь Монгол Улсад мэдээллийн хандлага, түрэмгийлэл ноцтой болчкоод байхад энэ талын ямар ч бичиг баримт байгаагүй учраас, ийм байдлаар мэдээллийн аюулгүй байдлын гол асуудлыг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тодруулан тусгасан байна¹⁶.

Үүнээс гадна манай Засгийн газрын 2010 оны 141 дүгээр тогтооолын 1 дүгээр хавсралтаар "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр", 2 дугаар хавсралтаар тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус тус баталсан¹⁷. Энэ хөтөлбөрийг 2010-2015 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2016 оноос эхлэн кибер аюулгүй байдлыг хангахтай холбоотой, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаас

¹⁴ Улсын Их Хурлын 1994 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 56 дугаар тогтооолын 1 дүгээр хавсралт. Энэ хавсралтын 2010 оны 7 дугаар сарын 15-нээдрийн 48 дугаар тогтооолоор хүчингүй болсонд тооцсон.

¹⁵ Монгол Улсын Ерөнхийлэгчийн Үндэсний аюулгүй байдлын бодлогын зөвлөх М.Батчимэг: Засгийн маргаанд үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал цаг тавиллаа. 2010.10.21 <http://www.president.mn/content/1229>

¹⁶ Монгол Улсын Засгийн газрын "Үндэсний хөтөлбөр батал тухай (мэдээллийн аюулгүй байдал)" 2010 оны 141 дүгээр тогтоо. <http://legalinfo.mn/law/details/4716>

өөр бие даасан бодлогын баримт бичигтүүлж байгаа юм.

Кибер аюулгүй байдлыг хангах нь нэг удаагийн шинжтэй үйлдэл биш бөгөөд кибер халдлага улам бүр балтгэгдсэн, хохирол ихтай болж байгаа тул орнууд кибер аюулгүй байдлыг хангах ажиллагааг цаг ямагт, тасралтгүй, идэвхтэй өрнүүлэх хэрэгтэй болдог, гэж судлаачид тэмдэглэсэн байдал¹⁸.

Гэхдээ, Монгол Улсын өрөнхийлөгчөөс, 2016.02.05-ны өдөр Улсын Их Хуралд “Мэдээллийн аюулгүй байдлын тухай” болон холбогдох бусад хуулийн төслийг өргөн мэдүүлсэн бөгөөд түүнийг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын кордоо 2016.04.05-ны өдрийн хуралдаанаар авч хэлэлцээд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй, гэсэн санал гарласан¹⁹. Энэхүү хуулийн төсөл нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо, мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдох бусад харилцааг зохицуулах зорилго тавсан байна. Энэ нь уг хуулийн төсөл батлагдаж хууль болсноор Монгол Улс кибер аюулгүй байдлаа хангахад, дотооддоо дагаж мөрдөх хэм хэмжээтэй болохыг харуулж байна.

ОХУ-ын бодлого, эрх зүйн зохицуулалт

ОХУ-ын хувьд дараах баримт бичигт кибер аюулгүй байдлыг хангах бодлогыг тодорхойлжээ. Үүнд:

- ОХУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратеги (2015)²⁰.

¹⁸ IT Expert underlines the need for firm cyber security measures and public awareness. The UB Post. 2016.03.14 <http://ubpost.mongolnews.mn/?p=18801>

¹⁹ Мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулини төсөл Монгол Улсын Их Хурлын цахим худас. 2016.04.05. <http://www.parliament.mn/laws/projects/814>

²⁰ Стратегия национальной безопасности Российской Федерации /утверждена Указом Президента Российской Федерации от 31 декабря 2015 г. №683 <http://static.kremlin.ru/media/events/files/ru/BiXKR6XLAtx-eiX7JK3XKybYUa#Hd5y.pdf>

- ОХУ-ын Цэргийн номлол (2014)²¹;
- ОХУ-ын Гадаад бодлогын үзэл баримтлал (2013)²²;
- Үндэсний аюулгүй байдлын стратеги 2009-2020 он (2008)²³;
- ОХУ-ын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2000)²⁴;
- ОХУ-ын Мэдээллийн аюулгүй байдлын номлол (2000)²⁵;
- Олон улсын мэдээллийн аюулгүй байдлын салбар дахь ОХУ-ын төрийн бодлогын үндсэн зарчмууд (2013)²⁶;
- Мэдээллийн орчин дахь ОХУ-ын зэвсэгт хүчиний үйл ажиллагааны баримтлал (2011)²⁷;
- ОХУ-ын кибер аюулгүй байдлын стратегийн үзэл баримтлын төсөл (2014.01)²⁸.

Эндээс харахад, ОХУ-ын хувьд

²¹ Военная доктрина Российской Федерации /Утверждено Президентом Российской Федерации В.Путиным <http://static.kremlin.ru/media/events/files/41d527556be8deb3530.pdf>

²² Концепция внешней политики Российской Федерации /Утверждена Президентом Российской Федерации В.В.Путиным 12 февраля 2013 г. http://archive.mid.ru/bipr_4_ns/0/6D84DDEDEDBF7DA64427B160051BF7F

²³ National Security Strategy of the Russian Federation to 2020 /Approved by Decree of the President Of the Russian Federation 12 May 2009 No. 537 / <http://w4trans.wikidot.com/russia-s-national-security-strategy--to-2020> Стратегия национальной безопасности Российской Федерации до 2020 года

²⁴ National Security Concept of the Russian Federation /Approved by Presidential Decree No. 24 of 10 January 2000 <http://archive.mid.ru/bdmp/nsosndoc.nsf/1e5f0de28fe77dc-32575d900298676/36aba64ac09f7c7fc32575d9002bb-310fOpenDocument>

²⁵ Information Security Doctrine of the Russian Federation /Approved by President of the Russian Federation Vladimir Putin on September 9, 2000/ <http://archive.mid.ru/bdmp/nsosndoc.nsf/1e5f0de28fe77dc-32575d900298676/2deaa9ee15ddd24hc32575d9002bc-442bfOpenDocument>

²⁶ Основы государственной политики Российской Федерации в области международной информационной безопасности на период до 2020 года /Утверждены Президентом Российской Федерации В.Путиным 24 июля 2013 г. № Пр-1753) <http://www.scrf.gov.ru/documents/6/114.html>

²⁷ Conceptual Views Regarding the Activities of the Armed Forces of the Russian Federation in the InformationSpace (Unofficial translation by NATO CCDCOE) https://ccdcoc.org/strategies/Russian_Federation_unofficial_translation.pdf

²⁸ Концепция Стратегии Кибербезопасности Российской Федерации (Проект), <http://council.gov.ru/media/files/41d4b3dfbd25cea{fa73}.pdf>

2000 оноос эхэлж цахим орчинд үндэсний аюулгүй байдлаа хангахтай холбоотой тусгайлсан бодлого баримталж ирсэн байх бөгөөд түүнийг цаг үеийн нехцэлд тааруулж тусгайлан тодруулах зорилгоор ОХУ-ын кибер аюулгүй байдлын стратегийн үзэл баримтлалтай болохын тулд 2014 оноос төлөвлөж, холбогдох төслийг боловсруулжээ. Тус үзэл баримтлалын төсөлд зааснаар дараах үйл ажиллагааг нэн тэргүүнд хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үссэн байдал. Үнд.

1) кибер халдлагын зэрэг үндэсний хамгаалалтын тогтолцоог хөгжүүлэх, кибер аюулыг сэргэмжлүүлэх аюулгүй байдлын хувийн тогтолцоог бүрдүүлж, боловсронгуй болгох;

2) онц чухал дэд бүтцийн найдвартай байдлыг хангах техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх шаардлагатай арга хэмжээ авч, тухай бүр боловсронгуй болгох;

3) цахим орчинд олон нийтийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн мэдээллийн нөөц бүрдүүлэх;

4) кибер аюулгүй байдлын салбарт тэр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түвшлэлийг бэхжүүлэх;

5) цахим орчинд аюулгүй байдлын зөв хэвлэлийг таниулах, иргэдэд цахим орчны боловсрол олгог ажиллагааг идэвхжүүлэх;

6) олон улсын түвшинд кибер аюулгүй байдлыг бэхжүүлэх арга зам, хөгжлийн төлөө гэрээ, хэлэлцээр байгуулах олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх.²⁹

БНХАУ-ын бодлого, эрх зүйн зохицуулалт

НАТО-гийн Кибер довтолгооноос хамгаалах хамтын ажиллагааны төв (CCDCOE)-ийн судалгаагаар БНХАУ-ын хувьд дараах баримт бичигт кибер аюулгүй байдлыг хангах бодлого, эрх зүйн зохицуулалтыг тусгасан, гэжээ.

²⁹ VI. Приоритеты Стратегии в обеспечении кибербезопасности. Концепция Стратегии Кибербезопасности Российской Федерации (Проект). <http://council.gov.ru/media/files/41d4b3dfbd25ce8a73.pdf>

Үнд.

- Үндэсний аюулгүй байдлын стратегийн чиглэл (2015);
- Үндэсний цэргийн стратеги (2014)³⁰.

Хятадын төрийн мэдлийн "Синхуа" агентлагийн мэдэлснээр, БНХАУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратегийн чиглэлийг, Хятадын коммунист намын Төв хорооны Улс төрийн төвөөн 2015.01.23-ны өдрийн хурлаар БНХАУ-ын Ардын их хурлын Байнгын хороо, Төрийн зөвлөл, БНХАУ-ын Ардын улс төрийн зөвлөлдөх бага хурал, Ардын Дээд прокурорын газраар хэлэлцүүлж баталсан байна³¹. Харин Синхуа агентлагийн хувьд Хятадын уламжлалт бус аюулгүй байдлын сорилтуу буюу Хятадын засгийн газрын хувьд онцгой аяхаарх болсон кибер халдлага, терроризм зэрэг шинэ аюул заналын талаар ямар нэг байдлаар тоймлоогүй байна. Кибер аюулгүй байдлыг хэрхэн хангах, эс хангах асуудал тус стратегийн чиглэлийн үндсэн хэсэг болсон эсэх нь олон нийтэд ил болоогүй байгаа юм³².

БНХАУ-ын Батлан хамгаалах яамнаас, БНХАУ-ын Үндэсний цэргийн стратегийг олон нийтэд 2015.05.26-ны өдөр танилцуулсан. Тус стратеги нь оршилоос гадна үндсэн зургаан хэсэгтэй³³. Үнд.

- 1. Үндсний аюулгүй байдлын нөхцөл байдал;
- 2. Хятадын Зэвсэгт хүчиний эрхэм зорилго, стратегийн зорилт;

³⁰ Document: China's Military Strategy. USNI News. May 26, 2015. <https://news.usni.org/2015/05/26/document-chinas-military-strategy>

³¹ 中央政治局审议通过“国家安全战略纲要”。2015年01月23日18:05 新华社 <http://news.sina.com.cn/c/2015-01-23/180531437149.shtml>

³² China's National Security Strategy - The Politburo, headed by Xi Jinping, emphasized the severity of threats facing China's national security. By Shannon Tiezzi. January 24, 2015 <http://thediplomat.com/2015/01/chinas-national-security-strategy/>

³³ Full text: China's Military Strategy (Xinhua). BEIJING - The Information Office of the State Council on Tuesday published a white paper on China's military strategy. 2015.05.26 http://www.chinadaily.com.cn/china/2015-05/26/content_20820628.htm

3. Батлан хамгаалах үйл ажиллагааны стратегийн чиглэл;
4. Хятадын Зэвсэгт хүчнийг бэжжүүлж, хөгжүүлэх нь;
5. Цэргийн тэмцэлд бэлтгэх нь;
6. Цэргийн болон аюулгүй байдлын хамтын ажиллагаа.

БНХАУ-ын Үндэсний цэргийн стратегийн 1 дүгээр хэсэгт, кибер аюулгүй байдлыг хангах нэхцэл шаардлагын талаар тодорхойлсон нь онцлог болижээ.

Энд "Гадаад болон цахим орчин нь стратегийн өрсөлдөөний хувьд бүх талын хооронд эрх мэдэл олж авах шинэ өндөрлөг болж байна. Мөн дайны хэлбэр нь мэдээлэлжсэн сергэлдэөн ируу илүү хурдтай хувьсан өөрчлөгдхөн болов³⁴. Дэлхийн томоохон хүчнүүд үндэсний аюулгүй байдлын стратеги, батлан хамгаалах бодлогоо тодруулж, цэргийн болон хүчний бүтцийн өөрчлөлтийг идэвхжүүлж байна. Дээр дурдсан цэргийн технологи, дайны хэлбэрийн хувьсан буй өөрчлөйт нь зөвхөн олон улсын улс төр, цэргийн байдалд нөлөөлөхгүй бөгөөд Хятадын цэргийн аюулгүй байдалд шинэ, хундкорилт болж байна" гэжээ.

Мөн стратегийн 4 дэх хэсэгт, цахим орчинд үндэсний аюулгүй байдлыг хангах нэхцэл, шаардлагыг авч үзсэн байна. Энд дурдсаараар, "цахим орчин нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн шинэ багана төдийгүй үндэсний аюулгүй байдлын шина орчин болсон. Цахим орчин дахь өрсөлдөөний, олон улсын стратеги нь улам харгис болж, нэлээд хэдэн улс кибер цэргийн хүчийг хөгжүүлэх болов. Хятад улс "хакерын халдлагын" гол хохирогчдын нэг байх болсон бөгөөд Хятад улсын кибер дэд бүтцийн аюулгүй байдалд ноцтой аюул тулгарсан. Цахим орчин нь цэргийн аюулгүй байдалд илүү жинтэй тусах болсон тул Хятад улс дараах үйл ажиллагаагаа идэвхийлж явуулна. Үнд:

- 1) кибер хүчний хөгжлийг хурдасгах;

³⁴ Кибер дайн тулван буюу Cyber war/ Cyber Warfare гэх ойлголтыг энд аяч үзсэн болголтой. Л.Г.

- 2) цахим орчны нөхцөл байдлын тухай ойлголтыг нэмэгдүүлэх;
- 3) кибер довтолгоонос хамгаалах чадавхыг сайжруулах;
- 4) олон улсын кибер аюулгүй байдлыг хангах хамтын ажиллагаанд оролцох;
- 5) цахим орчин дахь улс орны хичээл зүтгэлд дэмжилгээ үзүүлэх;
- 6) түүнчлэн томоохон кибер хямраалыг зоргоох;
- 7) үндэсний сүлжээг бэжжүүлж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах;
- 8) үндэсний аюулгүй байдал, нийгмийн тогтвортой байдлыг хангах³⁵.

Гурав. Кибер аюулгүй байдлыг хангах асуудлаарх Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын өнөөгийн байдал, чиг хандлага

ОХУ-ын хувьд бодлого, эрх зүйн зохицуулалт төдийгүй цахим орчин дахь өөрийн үйл ажиллагааны хувьд, цахим эринд бодитор эргэлт буцалтгүй хөл тавьсан, гэж судлаачид тэмдэглэсэн байдаг. Мөн, ОХУ-ын үндэсний аюулгүй байдал нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах, технологийн хөгжлийг хурдасгахаас ихээхэн хамааралтай болсон байна³⁶. ОХУ-ын цахим орчин дахь идэвхтэй ажиллагаа нь нэн түрүүнд кибер халдлага, кибер хүчний үйлдлээр илрэх болсон, гэж үзэх нь бий³⁷.

³⁵ IV. Building and Development of China's Armed Forces. Full text: China's Military Strategy (Xinhua: 2015.05.26 http://www.chinadaily.com.cn/china/2015-05/26/content_20820628_4.htm

³⁶ Nikolas K. Gvosdev. "The Bear goes Digital: Russia and Its Cyber Capabilities". pp. 173-190. Cyberspace and National Security: threats, opportunities, and power in a virtual world / Derek S. Reveron, editor. Georgetown University Press Washington DC. 2012. p.175. 177.

³⁷ Brandon Valeriano, Ryan Maness. "Persistent Enemies and Cyberwar: Rivalry Relations in an Age of Information Warfare". pp. 139-158. Cyberspace and National Security: threats, opportunities, and power in a virtual world / Derek S. Reveron, editor. Georgetown University Press. Washington DC. 2012. p.148.

БНХАУ-ЫН хувьд интернетийн хувьсгал нь, Хятадын эрх мэдэл, хүч чадлын хурдацтай ёсөлтийг тэтгэж, геополитик, эдийн засаг болон цэргийн хүчний төв болох аргаар дэлхийн томоохон "кибер хүч" болоход эргэлзэх зүйлгүй болов. Хятадын хувьд мэдээллийн технологийн салбаргаа дэлхийн хэмжээнд хүчтэй ерсэлдөхүйц болгож хөгжүүлэх замаар, АНУ болон барууны голлох оруудаас хамаарал баатай байх, дэлхийн интернетийн засаглалд илүү нөлөөтэй болохыг зорьж байгаа нь нууц биш болов³⁸.

Монгол Улсын хувьд сүүлийн 5 жилд кибер аюулгүй байдлыг хангах буюу цахим орчин дахь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах арга зам, туршлагын талаар дотооддоо төдийгүй олон улсын түвшинд хэлэлцэх, мэдээлэл солилцох үйл ажиллагаа эрчимжийг байна.

Цахим засгийн үзүүлэлтээр, Монгол Улс, олон улсын түвшинд тогтмол есч байгаа хэдий болочв үүнийг цахим орчин дахь хүний эрх, эрх чөлөөний бодит баталгаа, гэж үзэхэд зарим бэрхшээлтэй байгаа³⁹.

Ийм онцлог бүхий гурван улс буюу Монгол Улс, түүний хөрш хоёр орны хувьд, зарим талаар төвөгтэй байж болзошгүй. Гэхдээ энэ гурван улсын хувьд кибер аюулгүй байдлын түвшинг үнэлснээр, түүнд нийцсэн, харилцан уялддатай, тэнцвэртэй харилцаа тоогоо болох юм.

2 дугаар хүснэгт. Монгол Улсын, хөрш хоёр орны болон бусад зарим улсын кибер аюулгүй байдлын түвшин - 2010

Улсын нэр	Үзүүлэлт			Нийт очиг
	кибер зөрчил	кибер хамаарал	кибер хамгаалалт	
БНХАУ	5	4	6	15
ОХУ	7	5	4	16
АНУ	9	2	4	15
Иран	4	5	3	12
Израйл	8	3	4	15
БНАСАУ	2	9	7	18

2 дугаар хүснэгтэд харуулсан үзүүлэлт, оноог 2010 онд Richard A Clarke, Robert K. Knake нар "Кибер дайн: Үндэсний аюулгүй байдалд тутгачар буй дараагийн аюул заналхийлэл ба түүний эсрэг юу хийх вэ?" номондоо танилцуулсан байдаг. Энд "кибер зөрчил", "кибер хамаарал", "кибер хамгаалалт" гэсэн 3 үзүүлэлт тус бүриг 10 оноогоор үнэлж, түхайн улс орон компьютерын технологиос хамаарал баатай байх тутам "кибер хамаарал" гэсэн үзүүлэлтээр их оноо авах, цахим орчны технологиос илүү хамааралтай улсын хувьд кибер аюулгүй байдал нь илүү эмзэг, эрсдэлтэй байхаар тооцжээ.

Харин "кибер зөрчил" ба "кибер хамгаалалт" гэсэн үзүүлэлтийн хувьд "сайн хамгаалалт гэдэг нь сайн довтолгоо" гэх харьцуулалтад дүйцэхүйц байдлаар тооцсон байна. Энэдээс харахад, манай хөрш хоёр орны хувьд дээр дурдсан гурван үзүүлэлт харьцангуй ойролцоо оноо авсан байх бөгөөд нийлбэр онооны хувьд бараг ижил байна⁴⁰.

АНУ-ын, гурван ерөнхийлөнийн сонгуулт хугацаанд, тэдний ажлын албанад үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр ажилласан байдаг судлаач Richard A. Clarke-ийн зүгээс

³⁸ Nigel Inkster, China in Cyberspace, pp. 191-206. Cyber-space and National Security: threats, opportunities, and power in a virtual world / Derek S. Reveron, editor. Georgetown University Press. Washington DC. 2012. p.203.

³⁹ Л.Галбаатар. Монгол Улсын цахим орчны эрх зүйн зорилтуултын эмчийн байдал, чиг хандлага.2015.04.20 <https://lawschool.academia.edu/Galbaatar/ICT-Law> https://www.academia.edu/12012730/Mongolian_Law_Regulation_and_Enforcement_in_Digital_Environment

⁴⁰ Richard A Clarke, Robert Knake, Cyber War: The Next Threat to National Security and What to Do About It. HarperCollins Publishers. 2010. p 148. Тус номын танилцуулга, шумжийн эндээс унших боломжтой: *Georgetown Security Studies Review, Vol. 1 Issue 1, 2013.12.10.* "Richard A. Clarke and Robert K. Knake's "Cyber War: The Next Threat to National Security and What to Do About It" (Harper Collins, 2010) By David Vane. <http://georgetown-securitystudiesreview.org/2013/12/10/richard-a-clarke-and-robert-k-knakes-cyber-war-the-next-threat-to-national-security-and-what-to-do-about-it-harper-collins-2010/>

Монгол Улсын кибер аюулгүй байдлын түвшинд ямар оноо өгөхийг бид мэдэх боломжгүй боловч, тэрээр бичсэн номондоо “кибер аюулгүй байдлын хувьд голлох улс орны байдлыг үнэлсэн” гэж тэмдэглэсэн байгааг анхаарч үзээс Монгол Улсын кибер аюулгүй байдлын түвшин нь хөрш хоёр оронтой ойролцоо байна, гэж тооцох боломжгүйг харуулж байна.

Энэ нь Монгол Улсын зүгээс кибер аюулгүй байдлаа хангах арга хэмжээнд холбогдуулж ОХУ, БНХАУтай “кибер зөрчил”, “кибер хамаарал”, “кибер хамгаалалтын” хүрээнд хамтын ажиллагааг хөгжүүлэх, хоёр хөрштэйгээ харилцан ижил тэгш ажиллах нь зүйтэй иом, гэж ойлгогдж байна.

Үүнээс гадна Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас “Дэлхий нийтийн кибер аюулгүй байдлын индекс”-ийг санаачлан боловсруулсан байдаг.⁴¹ Энэ индекс нь тухайн улсын кибер аюулгүй байдлын хөгжлийн түвшинг эрх зүйн арга хэмжээ; техникийн арга хэмжээ; байгууллагын бүтэц; чадавх бэхжүүлэх; олон улсын хамтын ажиллагааг гэсэн таван хүрээнд тодорхойлдог. Тус индексийн 2014 оны үзүүлэлтээр Монгол Улс 0.412 гэсэн оноотойгоор зургаан улсын хамт 16-д эрэмбэлэгдсэн бол ОХУ 0.50 оноотойгоор 12-д, БНХАУ 0.441 гэсэн оноотойгоор 14-д тус эрэмбэлэгдсэн байна.⁴² Энэ нь Монгол Улс кибер аюулгүй байдлыг хангах, хөгжүүлэх чиглэлийг тодорхойлсон ач холбогдолтой үзүүлэлт байж болохор байна.

Харин, манай хөрш хоёр орон, Мянголтой кибер аюулгүй байдлын асуудлаар харилцах, энэ харилцааг өргөжүүлэх асуудал нь, манай улсын гуравдаг хөрш болох Япон, АНУ-тай тогтоосон харилцааг супруулж болзошгүй гэж зарим шинжээч үзсэн

байдаг⁴³. Мөн Монгол Улс хөрш орныхоо аль нэгэнтэй нь л илүү ойртох аваас Монголын хувьд аюултай байж болзошгүй гэжээ⁴⁴. Монгол Улсын хувьд хөрш хоёр орныхоо харилцаанд тэнцвэрээ байна хадгалж, гуравдагч хөрш болох Япон, Өмнөд Солонгос, Канад, АНУ зэрэг упсаас тусламж авах бодлогоо цаашид баримтлах хандлагатай байгаа. Энэ нь веर нэг улсыг хөрш хоёр орноосоо илүүд үзэн, гэсэн санаа биш, гэж ойлгогдох байна⁴⁵.

Нөгөө талаар хүний оршихуйд заналхийлж буй уламжлалт бус аюул занал буюу үндэстэн дамнасан гэмт хэрэг (кибер гэмт хэрэг) нь Азиин улс орнуудын аюулгүй байдалд шинэ сорилт болж байна⁴⁶. Иймд Монгол Улс, хөрш хоёр оронтойгоо кибер аюулгүй байдлыг хангах асуудлаар харилцах, хамтран ажиллахын өмнө Азиин бусад улсын кибер аюулгүй байдлыг хангах асуудлаар хоёр талт харилцаанаас туршлага судлах нь зүйтэй санагдана. Өнөөдрийн байдлаар Ази тивд дараахь улс орнууд кибер аюулгүй байдлыг хангах хоёр болон гурван талт харилцааг бусад улс оронтой хөгжүүлсээр байна.

З дугаар хүснэгтэд үзүүлснийг харахад, Азиин улс орнуудын кибер аюулгүй байдлыг хангах хоёр болон гурван талт харилцааны гол тоглогчид нь АНУ, Япон, БНСУ, ОХУ, БНХАУ, Австрали, Эстон байх бөгөөд 2009 оноос эхлэн улс орнууд кибер аюулгүй байдлаа хангах чиглэлээр хамтран

⁴¹ “Boringin-Future Хятад, Орос, Монгол Улстай харилцаагаа болжуулж байна. 2015.01.14. (Япон хэлээс точийн оруулж болжасэн Геополитикийн судалгааны хэрэлзэгийн гишүүн судлаач Л.Цагаансангаа). Геополитикийн судалгааны хүрээлэн, “Геополитик судалж”, №2, 2015 он. УБ. 2015. 19 дахь тал.

⁴² “Gabriel Dominguez. Орос, Хятадтай харилцах Монгол Улсын тэнцэвэрт бодлого 2014.10.05. Геополитикийн судалгааны хүрээлэн, “Геополитик судалж”, №2, 2015 он. УБ. 2015. 15-16 дахь тал.

⁴³ D Migrar. Гурван талт уулзарт болон гурван улсын харилцааны өнөөгийн байдал, ирээдүйн хандлага. 2014.10.31. Геополитикийн судалгааны хүрээлэн, “Геополитик судалж”, №1, 2015 он. УБ. 11 дахь тал.

⁴⁴ D Myagmar. New Geopolitical Situation and Defense Policy of Mongolia. 2012. pp. 15-20. The Institute for Geopolitical Studies. “The Mongolian Journal of Geopolitical Studies”, №1, 2015 Ulaanbaatar 2015 p.15,

ажиллах, харилцан үүрэг хүлээх болсон байна.

З дугаар хүснэгт. Азийн улс орнуудын, кибер аюулгүй байдлаа хангах хоёр болон гурван талт харилцааны байдал

Талууд	Зарласан огноо	Эхлэл	Зорилго, чиглэл
АНУ ОХУ	2013.6.17	2013	Мэдээлэл, харилцаа холбооны салбарт хамтран ажиллах асуудлаар хэвлэлээр хийж төвийн төвшний угзалт ¹⁶
БНХАУ БНСУ Япон	2014.10.21 ¹⁷ 2015.10.13 ¹⁸	2014	БНХАУ, БНСУ, Япон улсуудын кибер аюулгүй байдлын зөвлөлдөх механизмийн бий болгох, кибер гэмт хэрэг, тэргүүрхийтэй тэмцэх интернетийн онцгой байдлын уед хариу үзүүлэх асуудлаар хамтран ажиллах ¹⁹
АНУ Япон	2015.4.28 ²⁰	2013 ²¹	Японы хөрш этгээдийн кибер халдлагын хамгийн идавхатай ²² уял: орнууд болох БНХАУ, Хойт Солонгос, ОХУ, Ираны кибер халдлагаас урьдчилсан саргийлэх буюу түнд хариу үзүүлэх ²³
ОХУ БНХАУ	2015.5.08 ²⁴	2009 ²⁵	Кибер аюулгүй байдлыг хангах, цахим орчинд харилцан үл дөвтгөх ²⁶
ОХУ БНХАУ	2015.5.08 ²⁷	2009 ²⁸	Кибер аюулгүй байдлыг хангах, цахим орчинд харилцан үл дөвтгөх ²⁹

¹⁶ D.Magmar. New Geopolitical Situation and Defense Policy of Mongolia. 2012. p. 15-20. The Institute for Geopolitical Studies, "The Mongolian Journal of Geopolitical Studies". №1, 2015. Ulaanbaatar. 2015.p.15.

¹⁷ The New Norms: Global Cyber-Security Agreements Face Challenges By Tim Maurer, February 5, 2016 IHS Jane's Intelligence Review <http://carnegieendowment.org/2016/02/05/the-new-norms-global-cyber-security-protocols-face-challenges/>#ys3

¹⁸ China, Japan, ROK hold cyber security meeting in Beijing (Xinhua). 2014.10.22 http://www.chinadaily.com.cn/world/2014-10/22/content_18786642.htm

¹⁹ S. Korea, Japan, China to hold cyber policy talks, 2015.10.13 <http://english.yonhapnews.co.kr/news/2015/10/13/0200000000AEN20151013004800315.html?b1e0f30>

²⁰ Олон улсын цахилгааны холбооны байгууллага (ITU). Зүүн Өмнөд Азийн улсуудын холбооны бус нутгийн форум (ASEAN), БРИКС (Бразил, ОХУ, Энэтгэх, БНХАУ, Өмнөд Африкийн 5 улсын бүлэг). Шанхайн Хамтын ажиллагааны байгууллага зард олон улсын байгууллагудын уйн ажиллагааны хүрээнд кибер аюулгүй байдлын асуудлаар харилцан итгэлээд зарилогт. China, Japan, ROK hold cyber security meeting in Beijing (Xinhua). 2014.10.22 http://www.chinadaily.com.cn/world/2014-10/22/content_18786642.htm China, Japan, South Korea Talk Cyber Issues. By Emilio Iasiello. 2015.11.23. DarkMatters-Superior Attack Intelligence <http://darkmatters.norsecorp.com/2015/11/23/cyber-issues-china-japan-south-korea-talk/>

²¹ White House unveils cyber pact with Japan. By Cory Bennett April 28 2015, Th Hill <http://thehill.com/policy/cyber-security/240283-white-house-unveils-unprecedented-cyber-partnership-with-japan>

²² Joint Statement of the U.S.-Japan Cyber Defense Policy Working Group, May 30, 2015 http://www.mod.go.jp/press/news/2015/05/30a_1.pdf Japan and the United States to Deepen Cybersecurity Cooperation: The growing threat of digital attacks moves Washington and Tokyo closer together in trying to secure cyberspace By Franz-Stefan Gady, June 02, 2015 [pan-and-the-united-states-to-deepen-cybersecurity-cooperation/](http://thediplomat.com/2015/06/ja-</p>
</div>
<div data-bbox=)

²³ James Andrew Lewis. U.S.-Japan Cooperation in Cybersecurity (A Report of the CSIS Strategic Program). November 2015. p. 17 http://csis.org/files/publication/151105_Lewis-USJapanCyber_Web.pdf

²⁴ The Next Level for Russia-China Cyberspace Cooperation? By Elaine Korzak, August 20, 2015 <http://blogs.cfr.org/cyber/2015/08/20/the-next-level-for-russia-china-cyber-space-cooperation/>

²⁵ Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын пишүүн орнуудын олон улсын мэдээллийн аюулгүй байдлын салбарт хамтран ажиллас тухай хэлэлцэр – 2009.06.16 (2012.01.05-ны өдөр хүчин төгөлдөр болсон) <https://ccdcce.org/sites/default/files/documents/SCO-0906-6-IIS-AgreementRussian.pdf>

²⁶ Соглашение между Правительством Российской Федерации и Правительством Китайской Народной Республики о сотрудничестве в области обеспечения международной информационной безопасности, 2015.04.30 <http://government.ru/media/files/5AMAcs7mSIKgbff1Ua785WwMWcABDjw.pdf>

²⁷ The Next Level for Russia-China Cyberspace Cooperation? By Elaine Korzak, August 20, 2015 <http://blogs.cfr.org/cyber/2015/08/20/the-next-level-for-russia-china-cyber-space-cooperation/>

²⁸ Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын пишүүн орнуудын олон улсын мэдээллийн аюулгүй байдлын салбарт хамтран ажиллас тухай хэлэлцэр – 2009.06.16 (2012.01.05-ны өдөр хүчин төгөлдөр болсон) <https://ccdcce.org/sites/default/files/documents/SCO-0906-6-IIS-AgreementRussian.pdf>

²⁹ Соглашение между Правительством Российской Федерации и Правительством Китайской Народной Республики о сотрудничестве в области обеспечения международной информационной безопасности, 2015.04.30 <http://government.ru/media/files/5AMAcs7mSIKgbff1Ua785WwMWcABDjw.pdf>

Австралия БНХСУ	2015.9.11 ^{*14}	2013 ^{*15}	Кибер аюул заналтай холбогдуулж цахим орчин дахь хэмэхмижийн халалцаэр, хөбөр талт яриа хийх зэрэг цахим орчинд аюулгүй болон нээлтийн байдлыг хангах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулах, цахим орчинд үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар хамтран ажиллах ^{*16}
АНУ БНХАУ	2015.9.25 ^{*17}	2015	Хөбөр улсын застийн газрын аль нь ч тухайн улсын компаниудын хэвийн үйл ажиллагааг, ерсделдэвдэд ач холбогддог бүхий худалдааны болон бизнесийн нууц мэдрээлэл зэрэг иоуны эмчийн цахим хулгайг зохион байгуулахаа буюу мэдсээр байж дэмжихгүй дахь ^{*18} олон улсын хамтын нийгэмлэгийн хурзэнд цахим орчин дахь төрийн үйл ажиллагааны зохицтой хэмжээг дамжих ^{*19} ; Кибер гэмт хэрэгтэй тэмцэх болон кибер аюулгүй байдалд холбоотой бусад асуудлаар дээд төвшний яриа, хэлэлцээр хийх механизмыг бий болгох ^{*20}
АНУ БНХСУ	2015.10.16 ^{*21}	2013 ^{*22}	Хойд Солонгосын кибер халдлагын эсрэг хамтран тэмцэх
Эстония Япон	2016.04.08 ^{*23}	2015	Төр, иргэн, хувийн хэвшлийн өдөр тутмын ажиллагаанд тоон сүлжээг үүсгэж, хэвийн ажиллах нөхцөлийг дэмжих; Токиогийн 2020 оны олимпийн наадамас өмнө кибер аюулгүй байдлыг бэхжүүлэх.

^{*14} Australia-Republic of Korea Foreign and Defence Ministers' 2+2 Meeting, Joint Statement, 11 September 2015 http://foreignminister.gov.au/releases/Pages/2015/jb_mr_150911.aspx?w=lb_1CaGpkPX%2FIS0K%2Bg9ZKEg%3D%3D

^{*15} Australia and South Korea to Deepen Defense Ties: The defense and foreign ministers of both countries agreed to a new defense and security cooperation blueprint. By Franz-Stefan Gady, September 17, 2015 <http://thediplomat.com/2015/09/australia-and-south-korea-to-deepen-defense-ties/>

^{*16} Энэ хүрээнд кибер халдлагыг бүргэн судлах, харин Үзүүлэх, мэргэжлийн багуудын хооронд мэдээлэл солицох, хамтран ажиллах (KxCERT/CC, CERT Australia), хөөр талын цахим гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн цагдаалжийн албад хооронд хамтын ажиллагааг хөгжүүлэхээр тохиорлоцсон.

^{*17} Fact Sheet: President Xi Jinping's State Visit to the United States, September 25, 2015 <https://www.whitehouse.gov/the-press-office/2015/09/25/fact-sheet-president-xi-jinping-s-state-visit-united-states>

^{*18} Хөөр тал хор хөнөөн бүхий кибер үйл ажиллагаатай холбоотой туслахад үзүүлэх, мэдээлэл хүснэгээд таг тухайд хариу үүч байх, түүнчлийн холбогдох үндэсний хууль тогтоомж, олон улсын эрх зүйгээр хүлээсэн үүргийн хүрээнд кибер гэмт хэрэгийг мэдрэн шалгах, цахим нотог баримт цуглуулах, хөөр талын тухайн нутаг дэвсгэрээс үүрэлжсан хортой кибер үйл ажиллагаагаар бууруулах асуудалд хамтран ажиллах, кибер гэмт хэрэгийн мэдрэн шалгальтадаас яваа, үр дүнг негеэ талд зохих ёссоор мэдэлжэээр тохиорлоцсон.

^{*19} АНУ болон БНХАУ нь олон улсын аюулгүй нөхцөл байдал дахь мэдрээлэл, гарилцаваа хобоноса салбарын асуудлаарх НҮБ-ын засгийн газрын шинжээчийн багийн 2015 оны 7 дугаар сарын тайландаа тусгасан цахим орчинд олон улсын аюулгүй байдлын хангахад холбоотой зан байдлын хам хамжээ болон бусад чухал ач холбогдолтой

асуудлыг найрсаар хүлээн авах, цаашид тус асуудлаарх яриа, хэлэлцүүлэгт хийх зорилгоор алхам шинжээчийн баа байгуулахаар хүзүүн зөвшөөрөн.

^{*20} Ийм яриа, хэлэлцүүлэгт БНХАУ-ын талаас сайд нарын түвшний албан тушаалтнуудыг томилж оролцуулах баөөд Нийтийн аюулгүй байдлын сайд, Төрийн интернет, мэдээллийн газар хэлэлцүүлгийн даргалган оролцно. АНУ-ын талаас Дотоод аюулгүй байдлын нарийн бичгийн дарга, Ерөнхий прокурор болон Хөлбөнчны мөрдхөв төвч, АНУ-ын тагнуулын байгууллагуудын төвлөөлөл хэлэлцүүлгийн хамтран даргалж оролцно.

Энэ яриа, хэлэлцүүлэгт талуудын зүгээс хортой кибер үйл ажиллагаагаар бууруулах асуудалд хамтран ажиллах, кибер гэмт хэрэгийн мэдрэн шалгальтадаас яваа, үр дүнг негеэ талд зохих ёссоор мэдрэхээр тохиорлоцсон. Чакарыг хаянаа. Мен хөөр тал дурдсан асуудлаар талуудын мэдрээлэх үйл ажиллагааны цаг хугацаа, чакарыг хаянаа. Мен хөөр тал дурдсан асуудлаар зориулсан шууд утас ажиллуулна. Мен хөөр тал анхын уулзалтын 2015 оны сүүлээр зохион байгуулахаар тохиорлоцсон.

^{*21} Remarks by President Obama and President Park of the Republic of Korea in Joint Press Conference. The White House, Oct 16, 2015 <https://www.whitehouse.gov/the-press-office/2015/10/16/remarks-president-obama-and-president-park-republic-korea-joint-press>

^{*22} US, South Korea join forces to prevent cyberattacks by North Korea By Jennifer Chang, IDG News Service, Apr 3, 2013 1:25 PM <http://www.pcworld.com/article/2032918/us-south-korea-join-forces-to-prevent-cyberattacks-by-north-korea.html>

^{*23} Japan, Estonia vow to strengthen cybersecurity cooperation. The Japan Times, April 8, 2016 <http://www.japantimes.co.jp/news/2016/04/08/national/politics-diplomacy/japan-estonia-vow-strengthen-cybersecurity-cooperation/#.Uyg0lgQrlNN>

Кибер аюулгүй байдлын асуудал дээр АНУ ба Японы эвслийн талаар бичсэн бүтээлдээ улс төр цэргийн нэрт судлаач, доктор James Andrew Lewis кибер аюулгүй байдлыг хангахад улс орнуудын хоёр талт харилцаанд дараах гол турван чиглэлээр онцгой анхаарах хэрэгтэй, гэж тэмдэглэсэн байдал⁴⁷. Үүнд,

1) Цэргийн хамтын ажиллагааг өргөхүүлэх;

2) Онцгой ач холбогдолтой дэд бүтцийг хамгаалахад үндэсний хэмжээнд төдийгүй негee талтайгаа хамтарч илүү хүчин чармайлт гаргах;

3) Кибер аюулгүй байдлын хангахад, хүний нөөц ихтэй болох.

Монгол Улсын хувьд дээр дурдсан турван чиглэлээсгэдна Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнууд болох ОХУ, БНХАУ, Казахстан, Киргиз, Тажикстан, Узбекистан гэсэн зураган улс хамтран НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад 2011; 2015 онд өргөн барьсан “Мэдээллийн аюулгүй байдлын асуудлаар баримтлах зан үйлийн олон улсын код”ыг зайлшгүй харгалзан үзэх нь чухал юм⁴⁸.

Гэвч, тухайн үед 2011 оны “Мэдээллийн аюулгүй байдлын асуудлаар баримтлах зан үйлийн олон улсын код”ын төслийг АНУ тэргүүтэй барууны изэнх орны зүгээс, “...энэхүү баримт бичгийг санаачлагч дөрвөн улс (БНХАУ, ОХУ, Тажикстан, Узбекистан) нийлж, интернетийн засаглалын бүтэц, онлайны контентод төрийн хяналт

⁴⁷ James Andrew Lewis. U.S.-Japan Cooperation in Cybersecurity (A Report of the CSIS Strategic Program). November 2015. p.3 http://csis.org/files/publication/151105_Lewis_US-JapanCyber_Web.pdf

⁴⁸ International code of conduct for information security (Annex to the letter dated 9 January 2015 from the Permanent Representatives of China, Kazakhstan, Kyrgyzstan, the Russian Federation, Tajikistan and Uzbekistan to the United Nations addressed to the Secretary-General [Original: Chinese and Russian]) https://cccdce.org/sites/default/files/documents/UN-110912-CodeOfConduct_0.pdf <https://documents-dds-pv.un.org/doc/UNDOC/GEN/N15/014/02/PDF/N1501402.pdf?OpenElement> International code of conduct for information security (Annex to the letter dated 12 September 2011 from the Permanent Representatives of China, the Russian Federation, Tajikistan and Uzbekistan to the United Nations addressed to the Secretary-General [Original: Chinese, English and Russian])

тавих гэж байна”, хэмээн шүүмжилж эсэргүүцсэнээр НҮБ-ын дэмжлэг авч чадаагүй юм⁴⁹.

Мен 2011 оны төслийг шүүмжлэгчид “...олон талт оролцоог угүйсгэсэн” гэж үзсэн учраас 2015 оны тесөлд “мэдээллийн аюулгүй байдлын олон улсын хэм хэмжээтэй холбоотой олон улсын мэтгэлцээний эрчимжүүлж, энэ асуудлаар урьдчилан зөвшилцэхэд туслах” нэхцэлийг хангасан, гэж боловсруулагчид нь тайлбарлажээ⁵⁰. Одоогоор 2015 оны төслийг НҮБ-аас батлаагүй байгаа бөгөөд боловсруулагчид нь төслийн Үндсэн санааг дэмжихийг бусад улс орнуудад уриалсан байна⁵¹.

Кибер аюулгүй байдлын асуудал нь зөвхөн Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнууд боловсруулсан “Мэдээллийн аюулгүй байдлын асуудлаар баримтлах зан үйлийн олон улсын код”ыг тойрсон хэлэлцүүлгээр хязгаарлагдахгүй, харин ч дэлхийн улс төр, эдийн засаг, мэдээллийн салбарт өдөр ирэх тусам ач холбогдолтой болсоор байна. Тухайлбал, 2016 оны 5 дугаар сард болох Мэдээллийн нийгмийн асуудлаар хийх дэлхийн хэмжээнд дээд уулзапт (WSIS)-д оролцогчид, тогтвортой хөгжлийн төлөө кибер аюулгүй байдлын үндэсний стратегийн талаар хэлэлцэх, гэж байна⁵². Мөн Олон улсын цахилгааны холбооны байгууллага

https://cccdce.org/sites/default/files/documents/UN-110912-CodeOfConduct_0.pdf http://www.un.org/ga/search/view_doc.asp?symbol=EA%2F66%2F2359&Submit=Search&Lang=E

⁴⁹ Will China and Russia's Updated Code of Conduct Get More Traction in a Post-Snowden Era? By Alex Grintsby. January 28, 2015 <http://blogs.cfr.org/cyber/2015/01/28/will-china-and-russias-updated-code-of-conduct-get-more-traction-in-a-post-snowden-era/>

⁵⁰ An Analysis of the International Code of Conduct for Information Security. By Sarah McKune September 28, 2015 <https://citizenlab.org/2015/09/international-code-of-conduct/>

⁵¹ Dmitry Medvedev attends the opening ceremony of the 2nd World Internet Conference. From Dmitry Medvedev's address, 16 Dec 2015, Wuzhen, People's Republic of China <http://government.ru/en/news/21075/>

⁵² WSIS Forum 2016, Draft Agenda (As of 7 April 2016) https://www.itu.int/neid4/wsis/forum/2016/Content/documents/agenda/WSISForum_2016_DraftAgenda_2016-04-07.pdf

(ITU)-аас "Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийн гарын авлага" боловсруулж нийтэд танилцуулсан ажээ⁵³.

Дүгнэлт

Өнөөдөр цахим орчин нь дэлхийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн шинэ тулгуур төдийгүй үндэсний аюулгүй байдлын шинэ орчин болсон учраас ихэнх улс орон, цахим орчин дахь үл ойлголц, зөрчилдөөнд блэн байхыг зорих болов. Энэ нь юуны өмнө цахим орчинд, үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын баримт бичиг боловсруулж батлах, энэ асуудлаар хоёр болон олон талт яриа хэлэлцээ хийх, хамтарсан кибер сургуулит зохион байгуулах зэрэгээр илрэх болов.

Үндэсний аюулгүй байдлыг, цахим орчинд хангахтай холбогдуулсан, олон улсын хүчин чармайлтын үр дүнд, улс орнууд кибер аюулгүй байдлаа хангахын тулд мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан байдлыг бэхжүүлэх нь зүйтэй, гэдэг дээр санал нэдэж байгаа хэдий боловч мэдээллийн хүртээмжтэй байдлыг яаж хэрэгжүүлэх талаар санал зөрлөх, нээлттэй интернетийг хягаарлах аливаа санаачилгаас болгоомжилдог байна. Үүний тод жишээ нь, Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнууд боловсруулсан "Мэдээллийн аюулгүй байдлын асуудлаар баримтлах зан үлийн олон улсын код"-ыг тойрсон асуудлаар улс орнууд хоёр талт байр суурь баримталж байна.

Улс орнуудын кибер аюулгүй байдлыг хангах хоёр болон гурван талт харилцааны гол тогтолгид нь АНУ, Япон, БНСУ, Эстон, Австрали улсаас гадна Монгол Улсын хөрш хоёр орон ОХУ, БНХАУ болжээ.

Ийм харилцаа нь ОХУ ба БНХАУ-ын хувьд, кибер халдлагаас сэргийлэх буюу түүний эсрэг хамтран тэмцэх чиглэлээр хөгжиж байгаа нь ажиглагдаж байна. Энэ нь Монгол Улс кибер аюулгүй байдлыг хангах асуудлаар хөрш хоёр оронтой харилцаадаа тэнцвэрэйг хадгалж, цаашид гуравдагч хэрх буюу Япон, Өмнөд Солонгос, АНУ зэрэг улсаас дэмжлэг авах бодлого баримтлах нь зүйтэй гэдгийг харуулж байна.

Энэхүү нарийн төвөгтэй байдал нь, Монгол Улсын хувьд бусад улс орон, олон улсын байгууллагаас боловсруулсан кибер аюулгүй байдлын бодлого, үйл ажиллагааны баримт бичигт уялдуулсан бөгөөд өөрийн орны "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-д нийцүүлсэн "Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги"-ийг гаргаж ирэх хэрэгцээг бий болгож байгааг анхаарч үзэх хэрэгтэй байна.

Цаашид Монгол Улс "Дэлхийний тийтийн кибер аюулгүй байдлын индекс" дэх байраа ахиулах, үүний тулд кибер аюулгүй хангах чиглэлээр эрх зүй, техникийн арга хэмжээ авах, энэ чиглэлийн байгууллагудын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах төдийгүй олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай байна.

---00---

⁵³ The ITU National Cybersecurity Strategy Guide. Dr. Fred-erick Wamala (Ph.D.), CISSP® Geneva, 2012
<http://www.itu.int/ITU-D/cyb/cybersecurity/docs/ITUNationalCybersecurityStrategyGuide.pdf>

ОЮУТНЫ ИЛТГЭХ УР ЧАДВАР ХӨГЖИХӨД СЕМИНАРЫН НӨЛӨӨ



**МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн давдлагажигч
багш, хууль зүйн магистр Э.Мөнхдаваа**

ТҮЛХҮҮР ҮГ:

Оюутан, багш, семинар, хэлэлцүүлэг, мэтгэлцээн, харилцан ярилцах, мэдлэг, арга зүй.

ТОВЧЛЛОЛ:

Хүмүүс англи хэл хэрэгтэй гэж ярьдаг. Тэгвэл түүнээс чухал хэргэцээ байна. Энэ бол эх хэлээрэй зөв цэгтэй ярьж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж сурна гэдэг нь англи хэлтэй байхаас чухал зүйл юм. Ярих чадварыг хөгжүүлэх асуудал нь сэтгэх чадварыг хөгжүүлэхтэй шууд холбоотой тул их дээд сургуулийн семинарын хичээлийн хөтөлбэр нь оюутны бүтээгчээр чөлөөтэй сэтгэх, харилцан ярилцах, илтгэх чадварыг хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Үдиртгал

Оюутан сургуулиас авсан онолын мэдлэгээ практикт ашиглах, бусадтай харилцах, олон нийтийн өмнө үг хэлэх, аливаа хурал зөвлөгөөнд илтгэл тавих, хуулийн чиглэлээр суралцаж

төгссөн оюутнуудын хувьд практикт гараад иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлэн хамгаалах, яллах, өмгөөлөх талыг төлөөлж шүүхэд мэтгэлцэх зэрэг олон бэрхшээлтэй тулгардаг. Иймд ямар ч мэргэжлээр суралцаж буй оюутаны эзэнхүү чадвараа оюутан ахуй цагтаа хөгжүүлэх нь ирээдүйд амжилт гаргах сурь нөхцөл бүрдэх тул их дээд сургуулийн семинарын хичээлд оюутны илтгэх ур чадварыг хэрхэн хөгжүүлэх тухай болон их дээд сургуулийн семинарын хичээлд илтгэл, хэлэлцүүлэг, мэтгэлцэх, асуудал дэвшиүүлэх, тодорхой үр дүнд хүрэх, шинэ мэдлэг бүтээх замаар оюутны илтгэх чадварыг хөгжүүлэх арга замыг эрэлхийлэхээс гадна дэлхийд нэр хүндтэй АНУ-ын Стэнфордын их сургуулийн семинарын хичээлийн заах арга зүйн хөтөлбөрөөс туршлага судлах нь энхэүү өгүүлийн зорилго оршино.

Нэг. Семинарын хичээлд оюутны илтгэх ур чадварыг сайжруулах талаарх онол, арга зүйн асуудал

Шавь төвтэй технологийг хэрэгжүүлэх аргачлалыг боловсруулах хүрээнд семинарын хичээлийн үр нөлөөг дээшлүүлэх, бодгаль хүний үзэл бодол, түүний авьяас чадварыг нээн илрүүлэх, диалогийн буюу аливаа үзэгдэл юмыг хоёр талаас нь авч үзэх, цаашлаад олон талт хандлагаар асуудалд хандах сөйл, арга зүйн хандлага, ярих чадварыг эзэмшиүүлэх, сургалтын шинэлэг арга зүйг боловсруулах зайлшгүй шаардлагатай.¹

Лекц өрөнхий мэдлэгийн шинжлэх ухааны үндсийг нэгтгэсэн

¹ Ц.Батбаяр "Ярих чадварыг хөгжүүлэхдээ анхаарах зарим асуудал" <http://tsbatbayar.blogspot.ne/102593/main.php>

байдлаар хүргэдэг бол семинарын хичээл нь энэхүү мэдлэгийг тэлэх, илүү нарийвчлах, мэргэжлийн ўл ажиллагааны дадлагыг үүсгэж бэхжүүлэхэд чиглэгддэг.

Семинар бол дээд сургуулийн практик хичээлийн нэг ба эдгээр хичээл нь зорилго, зохион байгуулалтасаа хамааран хэд хэдэн төрөлд хуваагддаг бөгөөд оюутнууд бүлэг, хамт олондоор багшийн удирдлагын дор зохион байгуулдаараа онцлог.²

Ялангуяа философи, социологи, эрх зүй, түүх, улс төр, эдийн засгийн чиглэлийн хичээлийн хувьд асуудлыг ганц өнгөөс харах, өрөөсгөл байр сууринлас хандах, монист сэтгэлгээг халж, үзэгдэл үйл явцын талаарх олон хувилбар дүгнэлт, шийдвэрлэлт, хүрэх, улмаар плюарлист, арга зүйг эзэмших, зөв хандлагаар хандах, зөв чөлөөтэй сэтгэх сёйлэгийг эзэмшүүлэх нь чухал бөгөөд хэн зөв чөлөөтэй сэтгэж байна тэр зөв дүгнэлт шийдвэр гаргаж, зөв илэрхийлэх учиртайд хэл сэтгэхүйн нэгдэл оршино. Гэвч зөв сэтгээд буруу илэрхийлэх алдаа байдгийг анхаарж ярих урлагийн хөгжүүлэх тал дээр анхаарах шаардлагатай байна.³

Харилцан ярилцах нь өөрөө урлаг бөгөөд энэ нь уран илтгэхүйн ухаан болон хөгжжик /риторика/ ярих чадвартай холбогдож ирсэн нь нэг талаас сэтгэл ухаан, негеө талаас мэргэн ухаанд хуваагдан үнэмшүүлэх чадвараар илрэх болсон байна.

Аристотель "Илтгэгч гэдэг зүтгэлийнх, найрагч гэдэг занаянх" гэсэн нь сайн илтгэгч байх боломж хүн бүрт байгааг олон зууны тэртээ олж харсан хэрэг байна.⁴

² "Дээд сургуулийн сургалтын технологи" МУИС-ийн НШУС. УБ 2013 он. 71 дахь тал.

³ Монгол Улсад илтгэх урлагийн тухай гадаадын болон дотоодын ном, уран зохиолууд, судалгааны ажил, илтгэлүүд, гарын авлагад зохих ёсоор судалсан бүтээгдэх байж бөгөөд сүндаа МУИС-ийн доктор, багш нарын бүтээгдэх болих "Илтгэх урлагийн онол, арга зүй" сэдээгт ерөнхий сурье боловсрол эзэмшижээд зориуласан их сургуулийн анхны сурхын бичиг хэвлэгдэн гарчээ.

⁴ "Ярих урлагийн үндэс" (Хувь хүний хөгжил цуврал №1, Ц баатархуу УБ, 2006 он. 13 дахь тал

Эртний грекийн гүн ухаантан Сократ хүнтэй харилцан ярилцах явцдаа өөрийг нь хэн болохыг өөрт нь ойлгуулдаг байсан⁵ шиг бид өнөөдөр шинжлэх ухааны контекстийг тайлбарлах процесст оюутнууд асуудлын мөн чанарыг нээх арга зүйг боловсруулах шаардлага тулгарч байна.

Энэ нь оюутантай харилцан ярилцах үйл явцад хэрэгжжик, тэндээс илүү олон талтай бодгалг санаа бий болох, шинэ мэдлэгийг бүтээх, нөхцөл байдлыг бусдын байр сууринлас харах чадвартай болох зэрэг чадваруудыг эзэмшиж, сонсож, асуух, ярьж сурх зэрэг нь сургалтын шинэ технологийн үндэс болж байна.

Ярих урлагийн асуудал нь хүнээс олон талын онолын мэдлэг, мэдээлэл, чадвар, философи сэтгэлгээ, логик танин мэдэхүйн арга зүйн үндсүүд, ашиг сонирхлын олон призмүүд дунд түүний албан дунджийг олох, эмх цэц, дэс дараа, зохион байгуулалтын сасиглаа батыг шаардаж, өөрийн гэсэн технологиудыг хүн бүрт бүрдүүлж өгч байдаг.

Хоёр. АНУ: Стэнфордын их сургуулиудын семинарын хичээл, заах аргын тухай⁶

Семинар гэж юу вэ? "Семинар" бол жижиг хэмжээний хэлэлцүүлэлт / антиг, бүлэг г.м./ сууринлас хичээл бөгөөд семинарын хичээлийн үеэр оюутнууд даалгаварт өгсөн материалиг уншиж, багшийн заавар, чиглэлийн дагуу санаа бодлоо хуваалцдаг. Мөн оюутнууд үндэслэл гаргах, түүнийгээ баримтаар нотлох, санал зөрж байгаа талтай ч боловсноор харьцаахад суралцдаг.

Семинарын хичээлийг хөгжүүлэх нь:

1. Хичээлээ төлөвлөх.
Стэнфордын их сургуулийн хичээлийн

⁵ Мен тэнд 26 дахь тал.

⁶ <https://teachingcommons.stanford.edu/gallery/seminar>

бэлтгэлийн гарын авлага (course preparation handbook), хичээл төлөвлөхөд зориулсан тусламж (course design aids)-ийн дагуу хичээлээ маш бодож төлөвлөх хэрэгтэй. Тухайлбал, та хичээлийнхээ төлөвлөгөөг боловсруулахдаа дараах асуултуудыг өөрөөсөө асуух хэрэгтэй⁷:

- Энэ хичээлээс оюутнуудын олж авах хамгийн чухал мэдээлэл юу вэ?
- Энэ хичээлийн дараа оюутнуудын ойлгож авах хамгийн чухал санаа (онол, хандлага) юу вэ?
- Хичээлийн үеэр оюутнуудын хөгжүүлэл зохиц ур чадварууд юу вэ? (лабораторт ажиллах, асуудал шийдвэрлэх, бүтээлчээр ажиллах, бичих г.м)

2. Хичээлийн хөтөлбөрөө боловсруулах. Энэ нь зөвхөн унших материалын жагсаалт бус хичээлийн зорилго, үр дүнг агуулсан байна. Хөтөлбөр нь дараах зүйлсээс / элемент/ бүрдэнэ:

- Багшийн тухай мэдээлэл, холбоо барих хаяг, ажлын цаг;
- Хичээлийн тодорхойлолт, зорилго, хичээлээр хөндөгдхөн асуултууд;
- Сургалтын зорилго, үр дүн;
- Унших материал, эх сурвалж;
- Хичээл дээр баримтлах бодлого, хүлээнт;
- Стэнфордын их сургуулийн бодлого;
- Хөтөлбөрийн төлөвлөгөө.

3. Анги ба хэлэлцүүлэг.

Хэлэлцүүлгийг хөтөх нь⁸:

-Бэлтгэлтэй байх. Хэлэлцүүлгийн зорилгоо маш сайн ухамсарлах хэрэгтэй. Та оюутнуудад шинэ

ур чадвар эзэмшиүүлэх, эсхүл шинэ зүйлийн талаар эргэцүүлэх, шүүмжлэлтэй хандахад сургахыг хүсч байна уу гэдгээ тодорхойлох хэрэгтэй. Үзэл санааг оюутнуудын амьдралтай холбож тайлбарлахад туслах, унших материалыд шүүмжтэйгээр (*critically*/ хандахыг дэмжих, илуу чөлөөтэй, тодорхой шийдэлгүй бөгөөд олон талын хандлагыг гаргаж болох сэдвийг хэлэлцүүлэх. Мен оюутнуудад тухайн сэдвийн талаар 1-5 минут товч тэмдэглэл бичүүлэх, эсхүл 3-5 хүнтэй баг болгон хоорондоо ярилцах, хичээлийн ёмне гарийн даалгавар өгч бэлдүүлэх эзэрг “бие халаах” боломжийг олгох. Төгсгөлд нь тэдэнд шалтгаануу дагаврын, урьдчилан таамагласан, эрэлхийсэн, оношилсон г.м яңз бүрийн асуултуудыг тавьж болно.

-Хэлэлцэх асуудлыг танилцуулах⁹. Оролцооны талаар удирдамжаар хангах. Хэлэлцүүлгийн ёмне тэдэнтэй ярилцах, хэлэлцүүлэгт идэвхтэй оропцуулах. Асуудлын шийдлийн талаар оюутнуудтагаа саналаа хувалцах. Юунд төвлөрч байгаа, яагаад энэ чухал болохыг оюутнууддаа мэдэх боломжийг олгох. Мен хэлэлцүүлгийн сэдэв, хэлбэрийн талаар оюутнууддаа саналаа хэлэх боломжкоор хангах. Даалгаварт өгсөн асуудлыг хэлэлцсэн эсэхийг нягтлах. Хэрэв оюутнууд асуулт, хариултад бэлтгэгүй бол хэлэлцүүлгийн сэдвээс хазайж болохгүй.

-Дэмж, буу эзэрх. Нээлттэй асуулт ашигла. Тодорхойлолт, жишээ, лавлагаа зэргийг асуу. Оюутнууддаа бусдын сэтгэгдэл, өөрийн хураангуйд саналаа хэлэх цаг өгхө. Оюутнуудын хариултыг хураангуйл. Хэлэлцүүлгийн үеэр гарсан гол санааг самбарт тэмдэглэ. Боломжтой бол, хүн бурийн санааг тэмдэглэ. Хэлэлцүүлгийн төгсгөл гол санаануудыг нягтлах, хэлэлцүүлгээ дүгнэж дуусгах.

⁷ Brookfield, Stephen D. and Stephen Preskill. Discussion as a Way of Teaching: Tools and Techniques for Democratic Classrooms. San Francisco: Jossey-Bass, 2005.

⁸ <https://teachingcommons.stanford.edu/resources/course-preparation-resources/course-preparation-handbook>

⁹ Barkley, Elizabeth F. Student Engagement Techniques: A Handbook for College Faculty. San Francisco: Jossey-Bass, 2010.

-Хэлэлцүүлгийн таатай уур амьсгал бий болгох¹⁰. Та урам зориг төрүүлсэн хэлэлцүүлгийн орчныг бий болго замаар оролцогчдын тоо, чанарыг дээшлүүлэх боломжтой. Үүний тулд: оюутан бүрийн нэрийг мэддэг байх. Мен оюутнууд бусдынхаа нэрийг мэддэг эсэхийг нягтлэл. Оюутан бүр бие биенээз харах боломжтой байдлаар өвөөг зохион байгуулах. Жишээ нь: сандлыг дугуй байдлаар засах. Багшийн хувьд сүдлаа өөрчилж явж болно. Оюутан асуулт асуухад, тэдэнд хариултыг бусдаасаа хайхад нь туслах. Мэтгэлцэх үед маргааныг "албан тушаал"-ын байр сууринаас илүүтэйгэр объектив баримтад үндэслэн шийдвэрлэхийг оролд.

-Үнэлгээ. Хэлэлцүүлэгт хичнээн оюутан оролцсон талаар мэдэгд. Мен хэн оролцсон, оролцогчийг мэдэгд. Ингэхдээ хүйс, арсын өнгийг харах хэрэгтэй. Хэлэлцүүлгийн уур амьсгалт хэр болсныг дүгнэх. Оюутнуудаас хэр хүлээж авсан талаар асуу.

Бүлгийн хэлэлцүүлгийг хөтөлбөх нь:

-Хэлэлцүүлгийн өмнө: Зорилго, дүрмээ тодорхойлох. Үнших материалуудаа шалгах. Төрөл бүрийн асуулттаа боловсруулах. Заах стратегиа төлөвлөх. Жишээ нь: бие халаалт, жижиг бүлгийн хэлэлцүүлэг

-Хэлэлцүүлгийн дундуур: Хэлэлцүүлгийг асуулт асуух, оюутнууд асуулт асуух, оюутнууд даалгаварт өгсөн материалаа танилцуулах, хосоор нь эсхүлжижиг бүлэг болгон хуваах зэрэг замаар эхлүүлэх. Сорилтын, шалтгааны дагаврын, тааварласан, харилцааны, оношилсон зэрэг шинжтэй асуулт асуух. Оролцогчдыг анхааралтай сонсох. Түлкүүр асуудлуудад хэлэлцүүлгийг төвлөрүүлэх. Оюутнуудын оролцоог хангах, сэдэлжүүлэх. Давамгайж байгаа оюутнуудыг барих /хянах/. Оюутнуудад эргэцүүлэх хугацаа өгөх.

¹⁰ Christine M David M. Donahue, and Associates. Democratic Dilemmas of Teaching Service-Learning. Curricular Strategies for Success. Sterling, VA: Stylus, 2011.

Багш өөрөө бага ярих. Гүйцэтгэлийг оюутнуудаар өөрсдөөр нь үнэлүүлэх. Хураангуй хийх замаар хэлэлцүүлэгт дусгах. Дараагийн хэлэлцүүлэгт оюутнуудаа бэлдэх.

*Ангид оюутнуудыг хэрхэн яриулах вэ?*¹¹

-Төвлөрлийг сааруулах. Тэднийг өөртэйгээ бус өөр хооронд нь яриулах. Оюутнуудад тайлбарaa өөр хоорондоо танилцуулна гэдгийг шууд хэл. Тэдний асуулт болгонд хариулахгүй байх. Үүний оронд тэдний бодлыг асуух. Мес хагалах буюу зөв хариултуүг асуулт асуух. Хэрэв хэлэлцүүлгийг групп том байвал, түүнийг жижиг хэсгүүдэд хуваах. Хэсгээс хэсгийн хооронд явж шаардлагатай бол оюутнуудын асуултад хариулж, заавар, чиглэл өгөх. Хэлэлцүүлгийн хугацаа дөхөх үед, хэсгүүд хоорондоо ярилцаад зориулж 20 минутыг үлдээ.

-Асуулттаа бодох. Уран яруу асуулт буюу "тийм, үгүй", эсхүл "зөвшөөрөх, зөвшөөрхгүй" гэсэн асуулттуудыг хэрэглэхгүй байх. Харин "Америкчудын талаарх ойлголтод аж үйлдвэрийн хувьсгал, хил хязгаар хоёрын аль нь илүү чухал вэ? гэсэн "аль нь вэ?" гэсэн асуултыг давих. Ингэснээр ангийг нэг талыг дэмжих байгаа болон тодорхой шийдвэрт хүрээгүй байгаа гэсэн хоёр хэсэгт хуваах боломжтой. Асуудлын давуу болон сүл талыг хэлэлцүүлэх. Мен хэлэлцүүлгийн үеэр үзэл бодлоо өөрчилсөн тохиолдолд негөө хэсэгт шилжих боломжтой талаар зааварлах. Энэ терлийн хэлэлцүүлэг нь оюутнуудад үндэслэл, байр сууриа тайлбарлахад тусалж, оюуны үйл ажиллагааг уян хатан байлгах боломжийг олгодог.

-Эргэцүүлэх хугацаа өгөх. Оюутнуудад хэлэлцүүлэгтэй холбоотой сэдвийн талаар 5-10 минут бичих хугацаа өгөх замаар хичээлийг

¹¹ Millis, B. J., and Cottell, P. G., Jr (1998). "Cooperative Learning for Higher Education Faculty." American Council on Education, Series on Higher Education. The Oryx Press, Phoenix, AZ.

хэлүүлэх. Энэ нь оюутнуудыг бодол санаагаа төвлөрүүлэхдэд тустай. Хэрэв дахин хугацаа шаардлагатай гэж үзвэл, 2-3 минутад тэдний асуултад хариулах.

-“Байгаа олоогүй” тайлбарт хариулах нь. Тайлбар нь бүхэлдээ буруу буюу байгаа олоогүй ч гэсэн, оюутнуудад санаа бодлоо хуваалцанд нь таларах хэрэгтэй. Хичээлийн дараа буруу тайлбар хэлсэн оюутнуудтай ярилцах цаг гарга. Энэ нь дараагийн хичээлд оюутнуудыг буруу тайлбар гаргах эрдэлээс сэргийлнэ. Мөн оюутнууд унших материалыг зөвөөр ойлгоход дэмжлэг болно. График мэдээлэл нь оюутнуудыг системтэйгээр сэтгэх, үндэслэлээ тэмдэглэхэд тусалдаг.

-*Биеийн хэлний стратегийг хэрэглэх нь.* Хэлзүүлгийн үеэр сандлаа ширээнээс шууд хол байлгаа. Энэ нь хэлзүүлэгт бол оюутнуудынх юм гэсэн дохио. Толгойгоо дэмжих байдлаар хөдөлгөх, оюутнуудыг ярж байх үед гаралаа амаа хаах. Энэ нь тэдний яриаг таслахгүй гэсэн дохио юм. Мөн тэднийг ярж байх үед хөмгөө зангидах эсхүл хоёр гаралт чагтлахгүй байх.

-*Оюутнуудыг ярж байх үед тэмдэглэх хөтлөх.* Энэ бол оюутнуудын ярж байгаа эүйл багшид чухал байна гэдгийг тэдэнд харуулахад ач холбогдолтой. Мөн энэ нь оюутнуудын хэлсэн зүйлийг санаадаа чухал билээ.

Оюутан-багшийн харилцаа¹²

-*Үр нэлөөтэй асуулт асуулт нь.* Сайн асуулт гэдэг бол сонирхол татсан, хариулж болохуйц байдаг. Сайн асуулт шүүмжлэлтэй хандах, тайлбарлах, дүн шинжилгээ хийх сэдлийг төрүүлдэг. Туршлагатай багш нар холимог асуулт асуулт бэлтгэдэг. Энэ нь хариулахад хялбар, үл ялиг сонирхолтой, цогц

байдаг. Унших материал оюутнуудад танил байх хэрэгтай. Мөн тухайн судлаждахуунаас хариулж болохор асуулт байж болно. Оюутнуудыг халаасны дараа мэдээлэл хооронд ямар уялдаа холбоо байгаа болон өрөнхий үзэл санааг бий болгох талаар өөрсдөөс нь асуух. Тэгээд оюутнуудын өөрсдөө хөгжүүлсэн үзэл санаа, зарчмуудаа хэрэглэхийг шаардсан асуултыг асуух замаар хэлэлцүүлгийг өрнүүлэх.

Үр нэлөөтэй асуулттын төрлүүд:

-Дүн шинжилгээний: “Яагаад?”, “Та үүнийг хэрхэн тайлбарлах вэ?”, “Ач холбогдол нь юу вэ?”, “Үүний утга нь юу вэ?” г.м.

-Харьцуулсан ба эсрэг тэсрэг: “Эдгээрийн ялгаа нь юу вэ?”, “Эдгээрийн ижил төстэй тал нь юу вэ?” г.м.

-Шалтгаан ба үр дагавар: “Үүний шалтгаан юу вэ?”, “Эдгээрийн хооронд ямар холбоо байна вэ?” г.м.

-Тодорхойлсон: “Үүнийг ямар утгаар вэ”.

Үр ашиггүй асуултууд. Хэлзүүлгийг унтрааж болох асуултуудаас зайлсхийх хэрэгтэй.

Бөөрөнхий: Энэ төрлийн асуултууд нь юу асуугаад байгаа нь тодорхой биш буюу бүрхэг байдаг.

Чиглүүлсэн: Энэ төрлийн асуултад хариулт нь харагдаж байдаг.

Нэг талыг барьсан: Энэ төрлийн асуулт нь тухайн асуудалд санал зөрхөн оюутнуудыг үндсэндээ зогсоодог.

Гурав. Семинарын хичээлд оюутны илтгэх үр чадварыг хөгжүүлэх арга зүйг боловсронгуй болгох нь:

1. Нэгдмэл сургалтын онол арга зүйг хэрэглэх: Сургалт нь хоёр талтай үйл ажиллагаа тул түүний мөн чанар нь багшийн дидактик арга барил, мэдлэг туршлагаас шалтгаалахаас гадна, оюутнуудын хичээлд хандах хандлага, тэдний танин мэдэх идэвхийн түвшнээс

¹² William H. Bergquist and Steven R. Phillips, A Handbook for Faculty Development, Volume 2. Washington, D.C.: Council for the Advancement of Small Colleges, 1977, p. 207.

их хамаарна.¹³

Сургалтыг ямар нэгэн бүтээлч, практик үйл ажиллагаагаар баяжуулаагүй тохиолдолд нэгдмэл сургалтыг хэрэгжүүлэхэд бэрхшээл тулгарч сургалтын үйл ажиллагаа зорилгодоо нийцэхгүй.

Иймээс оюутны илтгэх ур чадварыг хөгжүүлэхэд "нэгдмэл сургалтын онол" болох лекцээс олгосон онолын ерөнхий мэдлэгийг семинарын хичээлээр илүү боловсронгуй болгох, практик үйл ажиллагаандашиглах, хэрэглэж, онол талаас нь шүүн ярилцах бүтээлчээр сэтгэж идэвхтэй оролцоог бүрдүүлж сургаснаар оюутны илтгэх ур чадвар хөгжихэд түлхэц өгөх юм. Багш сургалтандаа "тухайн сэдвээр эзэмшсэн шинэ мэдлэгээс бүтээлчээр ашиглах чадвар эзэмшүүлэх" зорилго давшүүлсэн бол түүнийг хангах сургалтын үйл ажиллагаа, арга зүй нь оновчтой байж, суралцагчдын үр дунгийн үнэлгээгээр батлагдаж байх ёстой.¹⁴ Хэрэв дээрх арга зүйн дагуу семинарын сургалтыг явуулж эс чадвал сургалт ач холбогдоо алдаж, лекц, семинар хоорондоо уялдаагүй болж, хичээл тэр чигээрээ үр дүнгүй болох, оюутны сэтгэл ханамжийг хангасан үр дүнг олж авах ямар ч боломжгүй юм.

2. Идэвхтэй сургалтын арга: Идэвхгүй сургалт нь мэдээлэл хүлээж авах, давтах, агуулгыг тэр чигээр нь хуулах байдаг бол семинарын сургалтыг идэвхтэй болгохын тулд түршилт, дадлагыг их хэмжээгээр оруулахаас гадна тунгааж ярих, хэлэлцэх боломжийг өргөнөөр олгох хэрэгтэй байна. Идэвхтэй сургалтын арга нь зөвхөн мэдээлэл авах биш, харин туршлагажих, мэтгэлцэх, хэлэлцэх үйлийг мөн агуулдаараа оюутны илтгэх ур чадварыг хөгжүүлэхэд зөрэг сайнаар нелөөлөхөөр байна.

¹³ "Дээд сургуулийн сургалтын технологи" МУИС-ийн НШҮС. №. 2013.05. 342 дахь тал.

¹⁴ "Үйтгэл урлагийн онол, арга зүй" Ерөнхий суурин болсовсрыг эзэмшихэд зориулсан их сургуулийн сурх бичиг. УБ, 2015 он, 7 дахь тал.

3. Багшийн үүрэг: Их дээд сургуулийн сургалт, семинар нь мэргэжил эзэмшихэд багш бус, харин оюутан өөрөө шийдвэрлэх. Үүрэг гүйцэтгэхээр зохион байгуулагдсан байдаг.¹⁵ Багш семинарын хичээлээр мэдлэг шууд олгох бус, харин оюутны бие дааж мэдлэгийн цар хүрээг хэрхэн тэлэх, ямар арга хэрэглэн юуг сургах талаар санаа оч чиглүүлэх шаардлагатай. Тухайлбал семинарын хичээл дээр эх зохиол, сурх бичигт байхгүй зүйлийг нэмж тодруулах, онол хоорондын холбоо уялдааг гаргах, харьцуулах, санаа дэвшүүлэх зэрэгээр оюутны бие дааж сэтгэн бодох, таамаглах, логик дүгнэлт гаргахад нь туслах чиг үүрэгтэй байна. Харин багш нь хий хоосон тоо баримт, үйл явдалт тулгуурлах бус харин сургалтын онолын үндэснээ дээр зохион байгуулах, бөгөөд багш өөрөө зохион байгуулагч, манлайлагч, илтгэгч, сайн лектор байх шаардлагатай анхаарах хэрэгтэй.

4. Харилцан ярилцах: Энэ нь оюутантай харилцан ярилцах үйл явцад хэрэгжиж, тэндээс илүү олон талтай бодгалт санаа бий болох, шинэ мэдлэгийг бүтээх, нөхцөл байдлыг бусдын байр сууринласаас харах чадвартай болох зэрэг чадваруудыг эзэмшиж, сонсож, асууж, ярж сурх зэрэг нь сургалтын шинэ технологийн үндэс болж байна.

Сургалтын технологийн хамгийн гол амин сунс нь оролцоо бөгөөд оюутан семинарын хичээлд зөв байх нь албагүй, харин буруулаас зөвд шилжих үйл явцын дагуу идэвхтэй байр сууринласаас оролцох шаардлагатай бөгөөд семинарын хичээлд харилцан ярилцах процессыг хөгжүүлснээр оюутны унших чадварыг сайжруулах ой тогтоолтыг дээшлүүлэх, логик сэтгэлгээг хөгжүүлэх, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх, анхаарал, төвлөрөлт нэмэгдэх бусдын үзэл болод үнэлэмжийг хүндэтгэн тэднээс

¹⁵ Мен тэнд 17 дахь тал.

суралцах, асуудалд уян хатан хандах, зөв чөлөөтэй сэтгэх, өөрийгөө болон нийгмийг танин мэдэх арга зүй, өөртөө итгэх соёлыг төлөвшүүлэх зэрэг ач холбогдолтой байна.

Дөрөв. Дүгнэлт, санал

Өнөөдөр их дээд сургуулийн сургалт шинжлэх ухааны судлагдахуунд хэт их анхаарч, хүний бодгаль шинж чанарт бага анхаарч байгаа нь чанартай боловсон хүчин бэлтгэхэд төвөгтэй байдлыг үүсгэж байна. Иймээс судлагдахуун, суралцагч хөёрын тэнцвэртэй байдлыг хадгалсан оюутныг чөлөөтэй сэтгэх, харилцан ярилцсан сургалтын арга зүйтгээ боловсруулах шаардлагатай байна.

Үг арга зүйн давуу тал нь оюутны ертөнцд байгаа олон талт нөөцүүдийг буюу төрөлхийн авяасыг илрүүлэх хүрээнд тэдний оюун санаанаас өөрөөс нь урган гарсан мэдлэгийг бүтээхэд чиглэгдэх юм.

Бидний өнгөрсөн хугацааны туршлагаас үзэхэд оюутнуудаас бие даалтыг бичгийн хэлбэрээр хураан авах, шалгалтыг тест, бичгэн хэлбэрээр авах нь тэднийг ярих, илтгэх чадварын хомдолд хүргэж байна.

Иймээс нийгэм хүмүүнлэгийн гэгдэх үнэлээмж дээр сууринсан хичээлүүдийн хүрээнд аливаа асуудалд дорматгийн байр сууринласан хандах хандлагыг арилгах, уян хатан харилцан ярианы арга зүйтгээ боловсруулах хүрээнд зөв, чөлөөтэй, эмх цэгцтэй сэтгэх соёлыг семинарын хичээлийн явц дунд хөгжүүлэхэд чиглэгдэх шаардлагатай байна.

Үүний тулд оюутны илтгэх ур чадварыг хөгжүүлэхэд семинарыг дараах хэлбэрээр явуулах нь үр дүнтэй, ач холбогдолтой байна. Үүнд:

1. Мэтгэлцээний төрлүүдийг их дээд сургуулийн мэргэжлийн багш нар заадаг хичээлийнхээ сэдвийн дагуу

сургалтад үр бүтээлтэй хэрэглэснээр тухайн сургалтын чанар сайжирна.

2. Семинарын хичээлд багш бага ярих, зөвхөн хөтлих, удирдан чиглүүлэх үүрэгтэй оролцож оюутнуудын дунд хичээлийн аливаа сэдвийн дагуу хэлэлцүүлэг өрнүүлах, оюутнуудыг идэвхтэй байр сууринласан оролцоог илүүд үзэх нь оюутны бүтээлч, хамтын зөв боловсон харилцава, хэвшил болон тогтоно.

3. Оюутан бүр бие биенээс харах боломжтой байдлаар өрөөг зохион байгуулах. Сандал ширээг дугуй байдлаар засах. Өнөөгийн их дээд сургуулийн анги, танхимын зохион байгуулалт оюутныг ар араас нь харх суулгах нь үндсэндээ хоцгродж оюутнуудын харилцан ярилцах, хэгжих чадварт сергээр нөлөөлж байна. Оюутны илтгэх, мэтгэлцэх чадварыг тасралтгүй хөгжүүлэх, мэдлэгээ ашиглан аливаа асуудалд шүүмжлэлтэй хандаж, шийдвэр гаргажад идэвхтэй ухамсартай, хариуцлагатай байр сууринласан ханддаг чадварыг суулгана.

4. Явцын шалгалаат болон бие даалтыг бичгийн хэлбэрээр авахаас аль болох татгалзаж, оюутан бүртэй нэг бурчлэн тулж ажиллах, илтгэл тавьж амаар хамгаалуулж үнэлж дүгнэх нь оюутны илтгэх урлагт суралцах, өөрийгөө бусдад таниулах, илтгэл бичих арга зүйтгээ зэмших анхан шатны чадвэр төлөвшине.

Ийнхүү их дээд сургуулийн семинарын хичээлд мэтгэлцээн зохион байгуулах, илтгэл тавих, харилцан ярилцах зэрэг арга хэлбэрээр явуулах нь лекцийн хүрээнд авсан онолын мэдлэгийг бататгах, онол практикийн холбоог тогтоох, онолын мэдлэгийг шинэ нэхцэлд шилжүүлэн хэрэглэх, оюутнуудад шинжлэх ухааны мэдлэгийг ирээдүйн мэргэжилтэй холбоход тус дэмжлэг болно.

ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ТОДОРХОЙГҮЙ НЭР ТОМЬЁО БАШҮҮГЧИЙН ЭРХ ХЭМЖЭЭ

МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш, (Ass. Jur) Б.Буянхишиг

ТҮЛХҮҮР ҮГ:

Хуулийн тодорхойгүй нэр томьёо, Иргэний хууль, эрх зүйн онол, кодификаци, шүүгч

ТОВЧЛЛОЛ:

Энэхүү өгүүллийн хүрээнд, хуулийн тодорхойгүй нэр томьёо, түүний ерөнхий ангилал хэлбэрийг авч үзүүхийн сацуу, тэдгээрийн эрх зүйн ач холбогдлыг хувийн эрх зүйн салбарын суурь хууль болон Монгол Улсын Иргэний хууль болон ХБНГУ-ын Иргэний хууль буюу кодификацийн тодорхойгүй хэм хэмжээтэй харьцуулах замаар судлахыг зорьлоо.

Үдиртгал

МУИС-ийн ХЗС-иас хэрэгжүүлж буй гадаад орны хууль тогтоомжийг эх хэлнээ хөрвүүлэх, харьцуулсан судалгааны хэрэглэгдэхүүн бэлтгэх ажлын хүрээнд саяхан "ХБНГУ-ын Иргэний Хууль"-ийг бүрэн эхээр нь орчуулан та бүхэнд хүргүүлсэн билээ. Улмаар орчууллын явцад ХБНГУ-ын Иргэний хууль нь бүтэц, агуулга, эрх зүйн харилцааг хир өнгөт эсвэл гүн гүнзгийг, тал бүрээс цогц байдаар зохицуулсан зэрээрээ ялгадаж байлаа. Ялангуяа хамгийн их бэрхшээл дагуулж байсан ухагдахуун нь манай хуултай харьцуулахад тодорхойгүй нэр томьёо, хувьсэн хэллэг зэргийг германы хуульд их тулхүү хэрэглэсэн явдал байв.

Монгол Улсын Иргэний хууль (Цаашид "ИХ" гэх)-д тодорхойгүй нэр томьёог аль болох ашиглахаас зайлсхийсэн, шүүгчид эрх хэмжээ олгох зохицуулалт харьцангуй бага байгаа нь бичмэл хуулийг ягштал мэдүүлэх (заримдаа ч бүр шударга ёсны эсрэг), авлига хээл хахуулиас урьдчилан сэргийлэх, шүүгчийн нелөөлэлд авталаас аль болох зайлсхийлгэх хэд хэдэн практик зорилго агуулдаг. Гэсэн ч бид шинэ ИХ-тай золгоод чамгүй хэдэн жил өнгөрсөн, мөн 1994 оны ИХ маань ОХУ-ын хуулинд тулгуурласан байсан (ОХУ-ын хууль ч мөн оригинал биш) гэх мэт хучин зүйлсийг бодож үзэхийн сацуу энэ салбарт өнөөг хүртэл сэтгэл хангалин бус байдал гарсаар байгаа нь шүүхэд эрх хэмжээ олгох зохицуулалт байхгүйтэй холбоотой мэт. Мэдээж уг асуудал хууль тогтоогчийн чадвх, хуулийн чанартай зарим талаар холбогдох нь гарцаагүй ч, шүүхийн казуистик өнөөг хүртэл хүчтэй хөгжихгүй байгаа нь шүүгчийн үүргэл роль, тодорхой хуулийн хүрээнд сонголтгүй силлогизм хийж буй нөхцөл байдалд судалгаа хийхийг шаардаж байна.

Хууль хэрэглэх, мөн энэ зорилгоор хууль тайлбарлах үйл явц нь хүмүүнлэгийн шинжлэх ухааны өөрийн гэсэн бүтэц тогтолцоог ашигласан танин мэдэхүүн акт юм. Эрх зүйн силлогизм буюу субсумци хийх явцад гарч ирдэг эргэлзээ, хууль тайлбарлах аль ч түвшинд тохиох хоёрдмөл утга санаа, хууль тайлбарлах аргуудын харилцаан адилгүй байдал, тайлбар хийж болсон зорилго зорилтын түвшин дэх үзэл баримтлалын зөрүү, эцэст нь тайлбарыг " явцуу" эсвэл "өргөн" хүрээнд байлагах уу гэдгээ шийдэх нь заримдаа төөрөгдөлд хүргэх, айдас

төрүүлэх талтай. Ямар ч шинжлэх ухааны салбарт хүндэрэл тохиох нь ойлгомжтой ч, үнэндийг хайх нь төдийлен чухал эсэх, мөн үр дүн өгөх эсэх нь гол байдал. Эрх зүйн шинжлэх ухаан болон түүний танин мэдсэн үзэгдлүүд дотор үнэндийг хайх зарчим нь цэвэр эрх зүйн танин мэдэхүйн үр дүн ба түүний сүүдэр хэсгийг зааглах боломжгүй зээрээтэй асуудал гэдгийг харуулсан олон жишээний¹.

Энэхүү өгүүллийн хүрээнд хуулийн тодорхойгүй нэр томьёо, түүний ерөнхий ангилал хэлбэрийг авч үзэхийн сацуу, тэдгээрийн эрх зүйн ач холбогдлыг хувийн эрх зүйн салбарын суурь хууль болох ИХ болон ХБНГУ-ын Иргэний Хууль буюу кодификацийг тодорхойгүй хэм хэмжээтэй харьцуулах замаар судаллаа.

I. Тодорхойгүй хэм хэмжээ ба түүний төрөл ангилал

1. Тодорхойгүй нэр томьёо:

Тодорхойгүй нэр томьёо гэдэгт агуулга, хүрээг хэрхэн тогтоох нь тодорхой бус хэм хэмжээг ойлгоно. Аливаа эрх зүйн тогтолцоонд түйлн тодорхой ухагдахуун тун цөөн бий. Үүнд хэмжээ заасан нэр томьёо хамаарах бол бусад эрх зүйн ухагдахуун нь дор хаяж зарим хэсгээрээ тодорхойгүй гэж үзэхэд хүргэдэг. Жишигэлбэл шөнийн цаг, орчны нөлөө, эд юмс, аюул гэх мэт.

2. Норматив хэм хэмжээ:

Дээрх ангилалд багтаж нэр томьёог хуульд хэрэглэснээр здгээрийг нэгэн зэрэг норматив ухагдахуун хэмээн үзэхэд хүргэнэ. Норматив гэсэн ойлголтыг дескриптив буюу бодитоор танин мэдэж болох объектыг тайлбарлах замаар тогтоохын эсрэг утгыг илэрхийлнэ. Ийнхүү хуульд олон утга бүхий тодорхойгүй нэр томьёо тусгаж, шүүгчид сонгох эрх олгох нь хууль тогтоогч өөрөө санаатайгаар үүсгэсэн төлөвлөгөөт хийдэл юм.

¹ Ханс Кельзен: Хэм хэмжээний тухай ерөнхий, (М.Хатанбаатарын герман хэлнээс орчуулсан хувилбар), 2013 он, 171 дэх тал.

3. Шүүгчид эрх хэмжээ олгосон хэм хэмжээ:

Эрх зүйн оноплын хувьд хамгийн их бэрхшээл дагуулдаг бүлэг хэсэг. Ялангуяа материаллаг эрх зүйн асуудлыг шийдвэрэд олгосон шүүгчийн эрх хэмжээний асуудал нь процессын хууль тогтоомжтой холбогдох асар өргөн хүрээтэй боялдоороо онцлогтой. Жишигэлбэл захиргааны эрх зайд төрийн байгууллага өөрийн үзэмжээр шийдвэр гаргах эрх хэмжээтэй нөхцөлд шүүх болон доод шатны шүүхийн шийдвэрийг дараачийн шатны шүүх ямар шалгуураар хянаж үзэх асуудал нэлээд явrigтай болдот. Гэсэн ч сонгох боломжкоо хэрхэн хэрэгжүүлснийг хянах хэд хэдэн шалгур үзүүлэлтийг тогтоосон. Тухайлбал өөрийн үзэмжээр хийх сонголтоо ашигласан эсэх, хуульд заасан хүрээ хэмжээнээс хэтрүүлсэн эсэх, буруу хэрэглэсэн эсэх² гэх мэт.

4. Ерөнхий зохицуулалт:

Хувийн эрх зүйн салбар дахь зорилготой хийдлийн томоохон жишээ бол хэт өргөн утга бүхий эрх зүйн тодорхойгүй нэр томьёо, ерөнхий агуулга бүхий хэм хэмжээ байдал. Хатуу тогтсон, хийсвэр ухагдахууныг хуульд тусгаснаар эрх зүйн тогтвортой байдал, баталгаа буй болдог ч эдгэр нь зарим адилтгах тохиолдлыг хамардаггүй сүл талтад. Энэ үднээс хууль тогтоогч ИХ-ийн хэдэн ерөнхий агуулга бүхий хэм хэмжээг тусгасан ба агуулгыг хууль хэрэглэх байгууллагууд, ялангуяа шүүх эрх мэдэл тодорхойлох эрхтэй³. Ерөнхий агуулга бүхий хэм хэмжээ гэдэгт тодорхой бус, хууль хэрэглэгчийн үзлэлт дүгнэлтээс хамаарах ухагдахуун бүхий зүйл заалтыг ойлгоно. Үүнд жишигэлбэд “нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээ” тогтоохыг шаарддаг ИХ-ийн §56.1.1, “шударга ёс” хэмээх тодорхойгүй ухагдахууныг агуулсан ИХ-ийн §§206, 193 зэрэг багтана.

² Ганзоригчл Д.Дэлгэрзаяа: Захиргааны эрх зүйн бодлогын хуваамж, 2011 он, 149 (154) дах тал.

³ Б.Буяниши: Иргэний эрх зүйн удирдтал, 2014 он, 2 дэх хэлэл, 36 дах тал.

II. Санаандгүй болон санаатай хийдэл

Хийдлийн тухай ойлголт эрх зүйн шинжлэх ухаанд нэг мөр болоогүй ч мөн чанарынх нь хувьд үүний санаандгүй ба зорилготой хийдэл хэмээн ангилж болно. Хийдэл хэмээх ухагдахууныг сонгодог утгаар нь эрх зүйн тогтолцоон дахь хэм хэмжээ урьдчилантелөвлөөгүй байхад дутагдах буюу бүрэн бус байхыг ойлгодог⁴. Гэхдээ төлөвлөөгүй хийдлийг тогтооход анхны төсөөллийн концепцын хожим батлагдсан хуультай харьцуулах болдог. Энд харин хэний концепцийг уг хуультай харьцуулах нь тодорхойгүй бөгөөд нийт эрх зүйн тогтолцоонд системийн тайлбар хийх замаар хийдлийг тогтоо ба ингэхдээ холбогдох хууль тогтоогийн бодлогыг анхаарч үзэх зэрэг икэхэн бархшээл тулгарна. Зарим тохиолдолд хууль тогтоогүй зохицуулбал зохиц ашиг сонирхлын тогтолцоогоо таңсан хэдий ч өөрөө зохицуулах хүсэлгүй байх нь злбэг. Тэрбээр янз бүрийн шалтгаанаар ийнхүү хуулынхад явдлыг асуудалтай гэж үзэж, энэ талаара шуүхээс хэм хэмжээ тогтоох “эрх олгох” нь элбэг.

Жишээлхэд ХБНГУ-ын 1871 оны Эрүүгийн Хуулийн оршил хэсэгт “гэмт хэрэг хийхээр завдсан нэхцэлд ямар эрх зүйн үр дагавар гарахыг эрх зүйн шинжлэх ухаан ба практикт найдаж үлдээлээ” гэсэн байдаг. Энэ жишээнээс эрх зүйн онолын түүхэн дэх зорилготой хийдэл байж болохыг тод харж болно. Өнөө уед жишээлбэл хөдөлмөрийн эрх зүйн салбар дахь тэмцлийн хурц хэлбэрүүдийг хуульчлахаас зайлсхийдэг нь дээрх хийдлийн нэг илрэл юм.

Хууль тогтоогийн төлөвлөсөн буюу санаатай хийдлийн нэг хэлбэр бол дээр дурдсан хуулийн тодорхойгүй нэр томъёо болон ерөнхий агуулга бүхий зохицуулалтууд юм. Жишээлбэл МУ-ын ИХ-ийн §§56.1.1, 206, 193 гэх

мэт. Харин ХБНГУ-ын Иргэний Хуулийг⁵ узвэл гэрээний нэг тал гүйцэтгэлийг зохих ёсоор, шударгаар тодорхойлох (§315), талууд хүлээсэн үүрэгтээз үнэнч байх, харилцан итгэлцлийн зарчимд нийцүүлэн гүйцэтгэх (§242), зан суртахуунд харш хэлцэл ба үйлдэл (§§138, 826), хүндэтгэх шалтгаанаар гэрээг цуцлах (§314) гэх мэт.

Эдгээр тодорхойгүй нэр томъёо, хэт ерөнхий агуулга бүхий хэм хэмжээг хууль тогтоогүй хэрэглэх болсон шалтгаан нь зохицуулбал зохих амьдралын үйл явцыг бүхэлд нь хуульчлах боломжгүйтэй холбогтой. Тийм учраас ерөнхий хийсвэр бүрэлдэхүүн бүхий хэм хэмжээ, ергэн хэрэглээз шаардлага гардаг. Эдгээр нь хэрэглээний хувьд туйлын тодорхойгүй олон утгатай тул тэднийг ашиглан шийдвэр гаргасан шүүгчид эрх зүйн бодлогын хувьд эсрэг тэсрэг зорилыг мөрдлөг болгох эрсдэл бий. Тиймээс ч эдгээрийг “хууль тогтоох боломжийг нээлттэй үлдээсэн хэм хэмжээ” хэмээн нэрлэдэг⁶. Өөрөөр хэлбэл эдгээр нь хууль тогтоогүй зохицуулалтыг үлдээсэн хуулийн хийдэл бөгөөд шүүгчид хэм хэмжээ тогтоох эрх хэмжээ олгох зорилготой. Тодорхой тохиолдолд ийнхүү шүүгч уян хатан шийдвэр гаргах боломж олгох нь техник-эдийн засгийн, нийгэм-улс төрийн хөгжлийг шударгаар дүгнэх боломж олгоно.

III. Хийдэл шүүгчийн “хууль тогтоох” арга хэрэгсэл болох нь

Хэрэв бид хууль тогтоомжид төлөвлөөгүй хийдэл бий болохыг тогтоомжгүй хэний шийдэл чухал вэ? гэсэн асуултад зөв хариулбал хийдлийн тухай ойлголт, түүний чи үүрэг өөрчлөгдөнө. Хууль тогтоогийн шийдэл чухал болох нь тогтоогдол хийдлийг тогтоох, нөхөх ажиллагаа нь өмнөх хуулийг өөрчлөх, нөхөх сайжруулахад чиглэнэ. Харин үүнийг тодорхойлох

⁴ Ч Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол. 2010 он. 350 дахь тал.

⁵ МУИСI ХСС: ХБНГУ-ын Иргэний хууль (Кодификации буряк он, французыг настгасан анхны хэвлэл, 2017 он

⁶ J.W.Hedemann: Die Flucht in die Generalklausein, Tübingen 1929, §4, S.1.

ажлыг шүүгчид оноож өгөхөөр бол хуулийг нөхөн батлахыг оронд “засаж” хэрэглэх боломжийг эрэлхийлэх шаардлагатай. Ийнхүү хийдлийг тогтоо явдал нь улмаар шүүхийн чиг үүргийг хууль тогтоо ажиллагаагаар өргөжүүлж өгдөй. Шүүгч энэ тохиолдолд хууль тогтоогчид туслан хэм хэмжээ тогтоо шаардлага гарна.

Өнөөгийн кодификацийн эрин үед хийдлийг олж тогтоосон шүүхэд ямар ямар боломж бий талаар эрх зүйн бодлогын түвшинд налзээд анхаарал татсаар иржээ. Жишээлбэл Францын хувьсгалчдын зөвлөлөөс 1790 онд шүүх хууль тайлбарлах, мөн хуулийн цоорхой буюу хийдлийг илрүүлэх явцаадаа заавал хууль тогтоогчид хандан хэрхэг талаар асуулга явуулах тухай хуулийг баталж байжээ. Өөрөөр хэлбэл кодификацийн эхэн үед хууль тогтоогч л хэм хэмжээг тогтоох эрхтэй бөгөөд ганцхан хууль тогтоох байгууллага л иргэдийн оролцоотой энэ асуудлыг шийдвэр эрхтэй гэж үзэж байв. Улмаар абсолютизмын төлөөлөл болсон Прусс, Бавари, Австри зэрэг улсуудад туйлын хэлбэрээр нöörхж монархийн эрхийг хамгаалах зорилгоор шүүхээс хууль тайлбарлахыг хоригложээ. Тиймээс энд хууль тайлбарлах арга нь ч гэсэн үг зүйн утга, хуулийн шүтлэцэнд хатуу сууринсан байжээ.

Германы Иргэний Хуулийг орчуулах явцад тодорхойгүй нэр томьёо их байгааг анхааруулж, цаг хугацааны болон агуулгын хувьд шүүгчид эрх хэмжээ олгосон зохицуулалтуудыг өөрчлөхийг зөвлөж байв. Гэвч эдгээр хоёрдмол утга бүхий хуулийн нэр томьёог тус улсын хууль тогтоогч өөрөө санаатай, санаандгүй аль нэгзэр хөтлөгднөхуульдаа авч хэрэглэсэн байх тул орчуулахаа хийж буй этгээд үүнийг “өөрчлөх” буюу бутээлчээр ажиллах ямар ч эрхгүй билээ. Харин манай улсад эдгээр тодорхойгүй нэр томьёог ашиглах явдал тун хомс байгаа нь ихэд анхаарал татах байна. Нийтээр хүлээн зөвшөөрсөн, тодорхойгүй боловч

ашиглахад нэр цэвэр ухагдахуун нь “шударга ёс”; үүнээс бусад харилцан итгэлцэл, шударга ёсны зарчим зэрэг хувийн эрх зүйн үндсэн категорийг авч хэргэлэх ёсгүй гэнэ. Логикийн үндэснээс шударга ёсны тогтоо гэсэн хуулийн зорилгыг эргээд энэ нэр томьёогоороо тодорхойлох нь эцэс тэгсгэлгүй логик гинжин урвал үүсгэх⁷ ба салбар эрх зүйн онцлогийг туслаагүй хэт өрөнхий зарчмыг салбар бүрт оновчтой хэрэгжүүлэх асуудал тулгамдана. Мэдээж эдийн засгийн хямрал, шүүхийн шударга ёсны индекс зэрэг нь ингэхийн зэрэг байгаа. Гэсэн ч энэ нь эргээд шүүгч хууль хэрэглэх машин уу эсвэл хараат бус шударга ёсны элч үү гэсэн асуултыг сехөхөд хүргэж байна. Тиймээс хууль тогтоогч санаатай буюу төлөвлөгөөт хийдэл гаргаж, түүнийгээ онлын үндэстэй хянах, хянуулах нь тэртэй тэргүүлэхэд үзэлдээс баригдаж, санаандгүй баахан хийдэл үлдээхээс хавьгүй ач холбогдолтой юм.

IV. Тодорхойгүй хэм хэмжээ ба түүний үр нөлөө

Эрх зүйн түүхэнд хууль тогтоомж туйлын тодорхой байх нь эрх зүйн тодорхой ба баталгаат байдлыг бий болгох хүчин чадалтай хэмээн үзэж, шүүхийн бүх шийдвэр туйлын зөв нэг утгатай гэдэгт найдаж байсан эрин цаг бий. Тухайлбал Европ дахь соён гэгээрлийн үе үүнд хамаарна. Энэ үзлийн үндсэн концепцыг “шүүгчийн хууль хэрэглээ нь автомажсан шинжтэй байх бөгөөд шүүхийн аппарат нь механик бус, харин логик автоматизмын илрэл” хэмээн тайлбарласан байдаг⁸. Өмнө нь “шүүгч бол хуулийн боол” гэсэн төсөөлөл байсан бол 19 дүгээр зуунаас эхлэн хууль тогтоомж ба шүүгчийн харилцаа аажмын өөрчлөгджэх, хуулийн агуулга, албан ёсны тайлбар нь хэрэглээний түвшинд үргэлж эргэлзээ үл төрүүлэхүйц нарийн, тодорхой байх боломжгүй гэдгийг хүлээн зөвшөөрч, шүүгчээс хуулийг хатуу чанд ёсчлон

⁷ Эрх зүйн философид үүнийг “Münchhausen-Trième” буюу Мянгуужинин гацалт (үлгэр) хэмээдэг. Kurt Seelmann, Rechtsphilosophie, 2.Aufl., S. 161-164.

⁸ Bockelmann: Festchrift für Smend (1952). S.26.

биелүүлэхийг шаардах нь үл гүйцэлдэх үзэл гэдгийг тогтоожээ. Тиймээс шүүгч хүн амьдралын олон талт чанар, урьдчилан харах боломжгүй байдлыг даван туулахад шаардагдах шийдвэр гаргах эрх чөлөөг здлэх ёстой гэсэн үзэл үүсэн бий болж⁹, энэхүү чөлөөт эрх зүйн урсгал өнөөгийн төрийн шүүх болон төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц ба хууль тогтоомжийн харилцан хамаарлыг бүрнээ илтгэх хэлбэр болтлоо хөгжих чадаагүй ч, эрх зүйн методологийг шинш шатанд гаргаж ирсэн байна.

Европын эрх зүйн түүхэнд анх I дайны дараа шүүгч нар инфляцийн хэмжээг тооцож, хэрэг маргааныг шийдсэн явдал нь шүүгч ба хуулийн харилцан хамаарлыг тодорхойлох практик ач холбогдолтой болжээ. Тухайн үед дийлэнх шүүгчид хуулийн позитивизмыг ягштал дээдэлж байхад зарим нь шүүгч жам ёсны буюу байгалиас занясан эрх зүй, нийтээр хүлээн зөвшөөрөөд байгаа эрх зүйн ухамсар зэргийг анхаарах ёстой гэж үзэж байв. Харин цөөн хэсэг нь инфляцийн улмаас үнийн дүнг өсгэн тооцох болсон үзэгдлийг ердийн хуулийн үйлчлэх хүрээнд буюу Германы ИХ-ийн §242-т заасан “харилцан итгэлцэл, үнэнч байдлын зарчим” нийцсэн тайлбар хэмээж байв. Ямартай ч энэхүү бүтээлч ажиллагаа нь шүүгчийг хуулийг автоматаар хэрэглэгч машин гэсэн төсөөллөөс ангижуулж, бие даан хуулийн хүрээнд шударга шийдэл гаргадаг хараат бус институт болохыг баталж өгсөн байна.

Харин тодорхойгүй нэр томъёог хуульд тусгахын сөрөг талыг харуулсан нэг жишээ бол II дайны үеэс эхлэн ерөнхий агуулга бүхий зохицуулалт нь нам, үзэл бодол, үндэс угсаа зэргээр ялгаварлан гадуурхах националсоциализмын арга хэрэгсэл болж, маш олон тооны үзэл сурталжсан шударга бус шийдэл гаргах гол гогцоо болсон явдал юм. Энэ гашуун түүхээс Густав

Радбрухын¹⁰ алдарт томьёолол ургаж гарсан бөгөөд үүнд тэрээр “шударга ёсны зарчимд харшилсан хэм хэмжээг мөрдхөд ч гэсэн хууль дээдлэх зарчим үйлчлэх нь гарцаагүй (позитивизм), гэхдээ шударга ёссыг бүрэн уландаа гишгэсэн, хүлцэн тэвчихийн аргагүй хэмжээнд шударга ёсны зарчимд харшилсан хэм хэмжээ нь өөрөө хууль биш болох тул үүнийг заавал мөрдхөөс чөлөөлөгдхөк ёстой (жам ёсны үзэл)” гэжээ. Энэ загвараар Германы шүүгчид нацизмын үеийн гэмт хөргүүд болон хуучин ардчилсан германнд хүнийг үзэл бодлоор нь мешгэж, хэлмэгдүүлж байсан хөргүүдийг авч хэлэлцсэн байдаг¹¹.

Шүүх, захирагааны байгууллагын аль аль нь хууль дээдлэх ёсонд захирагдаж, гүйцэтгэх засаглал ба шүүх эрх мэдэл нь хууль, шударга ёссыг баримтална. Гэхдээ өнөө үеийн салбарлан хөлжсөн хууль тогтоомжийн бүтцийг авч үзвэл шүүгч тодорхой эрх зүйн ухагдахуун ба үйл баримтыг харьцуулан дүгнэх буюу субсумци хийхээс гадна тэдгээрийн агуулгыг тайлбарлахаас эхлээд бие даан хууль тогтоогчийн адилаар шийдвэр гаргах эрхтэй болж байгаа нь дэлхий нийтийн өнөө ба ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг илтгэж байна¹². Гагцүү энэ хамаарал нь их байх уу, бага байх уу гэдгийг шийдэх л үлдэх юм. Өөрөөр хэлбэл үүнийг тогтоохын тулд судалгаа маань хууль тогтоогчийн аргачлалаас эхэлнэ гэсэн үг юм.

Тухайлбал аль ч хуульд уг хуулийг хэрэглэгч хууль тогтоогчоос хараат бус, бие даан шийдвэрлэх эрх хэмжээ олгосон зүйл заалт цөөнгүй бий. Эдгээрийг дээр дурдсанчлан тодорхойгүй нэр томъёо, норматив ухагдахуун, шүүгчид эрх хэмжээ олгосон

¹⁰ Радбрухын хийсэн дүгнэлтийн тухай - Х.Сэлэнгэ: Эрх зүйн философи: онол-арга зүйн асуудал, 2016 он, 28 дахь тал.

¹¹ Энэ загвар үгий бол “nulla poena sine lege” зарчим дамгаар үйлчлэх тул тухайн уедээ гэмт хэрэг гэж тооцогдох баигаагүй хэргийг сөхөх боломжгүй.

¹² Karl Engisch: “Einführung in das juristische Denken” herausgegeben von Wurtenberger, Thomasl. Otto, Dirk, 11. Aufl., 2010, S.191.

* Чөлөөт эрх зүйн сургуулийн үндсэн үзэл баримтлал.

хэм хэмжээ, ерөнхий зохицуулалт гэж ангилж болох боловч нэгдсэн ангилал болж хараахан хэвшээгүй. Энэ төрлийн зохицуулалтаас бид аль болох зайлсхийсэн ч санаандгүй, төсөөлөөгүй хийдэл гарсаар байх нь тодорхой. Тухайлбал амьдралд тохиох үзэгдлүүдийг туйлын тодорхой хуульчлахтусамдорхаяжхэмхэмжээний зөрчилдэвнөөс¹³ болж хийдэл үссэн чухал хэргүүд шийдвэргүй улдэх нь ч бий. Тиймээс хийдлийг арилгах гол арга зам бол хууль тогтоогч санаатай буюу төлөвлөгөөтэй шүүгчийн эрх хэмжээг олгосон ерөнхий агуулга бүхий хэм хэмжээ тусгаж, энэ талаар шүүхийн казуистик хөгжихийг хулээх нь хамгийн үр өгөөжтэй ажээ.

V. Хувийн эрх зүйн салбарт шүүгчид эрх хэмжээ олгохын ач холбогдол

Дээр дурдсан ХБНГУ-ын Иргэний Хуульд тусгалаа олсон тодорхойгүй хэм хэмжээ нь гагцхүү үүргиний ерөнхий ангийн хүрээнд өөрөөр хэлбэл тусгай ангийн дийлэнх хэсэгт хамаарах нийтлэг хэм хэмжээ бөгөөд эдгээр зохицуулалт нь манай ИХ-ийн §56.1.1 шиг өргөн утгатай тул гэрээний төрөл зүйл бүрт, мен хуулиас үүдэх үүргийн онцлогийг тусгасан шүүхийн казуистикийг тодорхойлж, хөгжсен байдал. Жишээлэхэд зах зээлийн дундаж хүүгээс хавьгүй их хүү санал болгох, зээлийн баталгаа болон шаардлагын хэмжээ харилцан тэнцвэргүй байх зэрэг нь германы ИХ-ийн §242-т харш гэж үздэг.

Эрх зүйн онолын үүднээс позитив хэм хэмжээ туйлын тодорхой байх боломжгүйн улмаас шүүгчид эрх хэмжээ олгох зохицуулалтыг дэмжих гэсэн ихээхэн төвөгтэй жимээр та бүхнүүдийг хөтлөхийн оронд дээрх асуудлаас урган гардаг нэлээд ач холбогдол бүхий практик жишээг авч үзье. Тухайлбал практикт "Бие махбод, амь насанд хохирол учруулснаар үүдэх

эдийн бус хохирлыг нөхөн төлүүлдэг болох" нь зүйтэй гэсэн саналыг хууль хэрэглэгчдийн дийлэнх олонх нь гаргасаар байгаа¹⁴. Шалтгаан нь эдгээр унэт зүйлсэд халдсаны улмаас хохирогчид маш их сэтгэл санааны хохирол учирдаг бөгөөд энэ салбарт бид дэлхий нийтийн жишгээс нэлзээд хазаж буй нь хараагддаг. Жишээ нь англо-саксоны эрх зүйн *punitive damage* олгох хандлагад ойртох зорилгоор ХБНГУ-ын Иргэний Хуулийн §253-т "амь бие, эрүүл мэнд, эрч чөлөө зэрэгт учирсан эдийн бус хохирлыг эдийн хохирлоос гадуур мөнгөөр үзлэн нөхөн төлүүлэхээр тогтоосон. Энэ зохицуулалтыг **шүүхээс хэрэгжүүлэхдээ** тэгш байдлыг буй болгох зорилгоор эдийн бус хохирлыг хэрхэн үнэлэх тухай нийтлэг жишиг гаргаж, хуулиа тайлбарлах эрх хэмжээг олгодог. Мэдээж "эдийн бус хохирол" хэмээн ухадахаун нь хуульд тусгасан туйлын тодорхойгүй ойлголт мөн. Гэхдээ хууль тогтоогч ийнхүү шүүгчид итгэж, эрх хэмжээ олгосон нь "Düsseldorfer Tabelle" зэрэг анагаахын шинжлэх ухааны судалгаанд үндэслэн эдийн хохирлыг эрх зүйн үүднээс мөнгөөр үзлэх жишиг тогтоож, энэ шүүхийн жишигийг бусад шүүхүүд хулээн авч, өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргадаг сайн туршлага бий болсон. Энэ жишээ нь хууль тогтоогч эрх хэрэгжүүлэх хуулийн нийтлэг шалгтуураас гадуур амьдралын бүх тохиолдлыг өөрөө зохицуулах боломжгүйн нэг илрэл бөгөөд шүүх тодорхой тохиолдолд сэтгэл хангалиун шийдлийг сонгох чадалтайн илрэл юм.

Харин манай ИХ-ийн §230 нь эдийн бус хохирол зөвхөн хуульд заасан нөхцөлд л арилгах боломжтойг дурдсан бөгөөд энэ нь ИХ-ийн §511-ээс өөр эдийн бус хохирол нөхөн төлүүлэх арга хэрэгслэл байхгүйг сануулдаг. Нэгэнт энэ асуудлыг хуулиар зохицуулна хэмээн энд заасан тул шүүгч эдийн бус хохирлыг

¹³ Б.Буянишиг: Хэм хэмжээний хийдлийг арилгахад эх сурвалжийн онолын гүйцэтгэх үүрэг. Эрх зүй сэтгүүл 2011 оны №1, 24 дахь тал.

¹⁴ Ш Сүхбаатар: Хүний нэр тэр, алдар хүндийн эрх зүйн хамгаалалт. 2012 он. 135-136 дахь тал; Э.Огтонзүйл: Эдийн бус хохирол, түүнийн арилгах эрх зүйн зохицуулалтыг боломжонгуй болгох нь сэдэвт бакалаврын дипломын ажил, МУИС-ийн ХЭС, 2011 он. 25 дахь тал.

шударга гэж үзсэн хэлбэрээрээ арилгах шийдэлд хүрч чадахгүй. Мөн ИХ-ийн §230 нь зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд л эдийн бус хохирлыг мөнгөөр нехэн төлөх хязгаарлалт хийсэн нь гагцхүү нэр териин болон дурсийн эрхэнд халдсанаас учирсан эдийн бус хохирлыг авч үзэхэд хүргэж байна. Ийнхүү дээрхэс бусад үнэт зүйлд халдсанаас учирсан эдийн бус хохирлыг арилгуулах боломжгүй байгаа нь иргэний эрх зүйн хохирол арилгахас өмнөх байдалд эрхийг сэргээх үндсэн зарчим, цаашлаад Үндсэн Хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхолд үл нийцэж, тэгш ёс, шударга ёс хангадахгүйд хүргэдэг¹⁵.

VI. Дүгнэлт

Дээрхээс үзвэл шүүх хэд хэдэн шийдэлээс илүү тохирохыг сонгох эрх хэмжээтэй байх тусам шүүхийн казуистик илүү хөлждэг, шударга ёс тогтох үйл явц илүү үр нөлөөтэй байх

¹⁵ Б.Буяновшиг: Иргэний эрх зүйн тусгай анги, 2013 он, 3 дахь хавсралт, 520 дахь тал.

талтай; харин хуульд ийм эрх хэмжээ олгогдоогүй бол хууль хэрэглэгчид нэг талаар амар хялбар байх ч нөгөө талаар шүүхийн шийдвэр хэлбэр тедий, амин судал буюу казуистик багатай, эмпирик талаас нь авч үзвэл нийгэмд нөлөөлөх хүч нь бага байх юм; Тиймээс хууль тогтоогч ерөнхий агуулга бүхий хэм хэмжээг санаатайгаар нэмэгдүүлж, тодорхойгүй нэр томьёог тайлбарлах хүрээ хязгаарыг шүүхээр өөрөөр нь тогтооптон хянах нь үй түмэн асуудлыг хуульчлагыг оролдож, улмаар хэм хэмжээний зайлшгүй зөрчилдээн газар авч, хийдэл үүссэнээс хавьгүй дээр сонголт болохны харгадаж байна. Үнийг эрх мэдэл хуваарилах зарчмын үүднээс авч үзвэл хүлээн зөвшөөрч болохуйц бөгөөд хууль тогтоогч нийгэмд тулгарч буй асуудлын цөм хэсгийг шударгаар зохицуулахад хангалттай бөгөөд шүүх эрх мэдэл нэгдсэн шалгуурын үндсэн дээр тоо томшгүй олон хэв шинж бүхий үзэгдлийг тухай бүр нь хэрхэн шударгаар шийдэхээ сонгох эрх хэмжээтэй байх нь дээрх зарчимд үл харшлах арга зам билээ.

---оо---



Нийслэлийн шүүх байгуулагданы 90 жилийн ойд зориулсан "Иргэний эрх зүйн онол, практикийн уялдаа" эрдэм шинжилгээний бага хурлыг Хууль зүйн үндэсний хүрээлэн, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхтэй хамтран 2017 оны 03 дугаар 30-ны өдөр зохион байгууллаа. Хуралд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, гишүүд, Улсын Дээд шүүх, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, анхан шатны шүүхийн шүүгчид болоин Хууль зүй дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, өмгөөлөгчид оролцов.

КОМПАНИЙН ЭРХ ЗҮЙН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ



Өмгөөлөгч, хууль зүйн магистр
Б.Буянтогос

ТҮЛХҮҮР ҮГ:

Компанийн эрх зүй, сонирхлын зөрчилтэй хэлцэл, зонхилох хувьцаа эзэмшигч, жижиг хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захираал, нэгдмэл сонирхлойтэй этгээд, эрх бүхий этгээдийн үүргээ, вэртэйгээ хийх хэлцэл, таннелинг, дотоод мэдээллийг ашиглаж арилжаанд орох.

ТОВЧЛОЛ:

Компанийн эрх зүйн сонирхлын зөрчил бүхий хэлцэл гэдэг нь компанийн дотоод мэдээлэл бүхий этгээд буюу түүнтэй хамаарал бүхий болон нэгдмэл сонирхолтой этгээдүүд нь тухайн хэлцлийн хувьд компанийн ашиг сонирхлоос гадуур санхүүгийн шууд болоод шууд бус сонирхлойт байхыг хэлнэ.¹ Гэж тодорхойлох нь зүйтэй юм.

Хэн нэгэн ашиг сонирхлын зөрчлийг үүсгэх ийм харилцаанд оролцох нь ямар нэг хохирол үүсгэж болно. Иймээс учирч болзошгүй болон учирсан сонирхлын зөрчлийг урьдчилан таньж түүний учруулах эрсдэлийг тооцож, ямар хэмжээний эрсдэлийг хүлээн зөвшөөрч болох

эсэхийг тогтоож, сонирхлын зөрчлийг хүлээн зөвшөөрч болох хэмжээнд удирддаг. Зарим тохиолдолд сонирхлын зөрчлийг зохицуулах нь хангалттай биш байх тохиолдолд түүнийг хүлээн зөвшөөрөхгүй байх нь гол шийдэл болж болно.

Орчин үеийн хандлагаар сайн нөхцөлөөр хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хүлээн зөвшөөрөх буюу хувьцаа эзэмшигчдийн болон ТҮЗ-н зөвшөөрөл авсан эсхүл шудараа ёсны стандартыг хангасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хүлээн зөвшөөрч болохыг зохицуулсан байна.

Удиртгал

Хамгийн энгийн утгаар хувь хүний хувийн сонирхол (заавал мөнгөн хэлбэртэй байх албагүй), өөрийнх албаны үүрэг хоёр хоорондоо харшилж байгаа нөхцөл байдлыг ашиг сонирхлын зөрчил гэж ойлгож болно. Хүн бүрт өөрийн гэсэн хувийн амьдрал, хувийн үзэл бодол байдаг тул үүнтэй уялдан өөрийн гэсэн хувийн сонирхол ч бас байдаг. Аливаа хувийн сонирхол нь эдийн болон эдийн бус, ашигийн сонирхлыг хамтад нь багтаадаг өргөн ойлголт. Иймд тухайн хүний хувийн сонирхол нь эрхэлж буй албан тушаал, гүйцэтгэж буй ажил, үүрэгтэй нь зөрчилдэх болзошгүй нөхцөлд ашиг сонирхлын зөрчил үүснэ гэж үздэг.

Ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголтын үндсэн гол агуулга, зарчим нь "Эрх бүхий этгээд шуд болон шууд бус хувийн болон санхүүгийн сонирхол нь үнэн зөв, бие даасан шийдвэр гаргахад нь нелөөлөхөөр байвал тухайн асуудлаар албаны байр суурин илэрхийлж болохгүй" байх явдал юм.

¹ Коннелл Финнин, Цогт.Н., Компанийн эрх зүй Сургалтын гарын авлагага.У.Б., 2008 он, 94 дэх тал.

Нэг. Компанийн эрх зүй дэх сонирхлын зөрчилтэй хэлцлийн ойлголт, илрэх хэлбэр, эрх бүхий этгээдийн үүрэг

1.1 Ойлголт

Ашиг сонирхлын зөрчлийг хуулиар зохицуулах нь компанийн хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг захирал болон бусад компанийн ажиллагсдын үйл ажиллагаанаас, жижиг хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг онолын хувийн хувьцаа эзэмшигчээс мөн эзлэл олгогчийг компанийн дотоод мэдээлэл бүхий ажиллагсаас² хамгаалах ёндер ач холбогдолтой бөгөөд компанийн хөрөнгө оруулагчадаа ч ихээхэн нелвэ үзүүлэх асуудал байдаг.

Зарим тодорхой сонирхлын зөрчил нь сайн ч муу ч үр дунд хүргэж болох хэдий ч энэ нь тухайн хүний хараат бус байдалд саад болж байдаг. Хэн нэгэн ашиг сонирхлын зөрчлийг үүсгэх ийм харилцаанд оролцлох нь ямар нэг хохирол үүсгэх болно. Иймээс учирч болзошгүй болон учирсан сонирхлын зөрчлийг урьдчилан таньж түүний учруулах эрдээлийг тооцож, ямар хэмжээний эрдээлийг хүлээн зөвшөөрч болох эсэхийг тогтоож, сонирхлын зөрчлийг хүлээн зөвшөөрч болох хэмжээнд удирддаг. Зарим тохиолдолд сонирхлын зөрчлийг зохицуулах нь хангалттай биш байх тохиолдолд түүнийг хүлээн зөвшөөрхгүй байх нь гол шийдвэр болж болно. Сонирхлын зөрчлийг шийдвэрлэх гол тулхүүр нь тухайн нөхцөл байдалд дүгнэлт хийх явдал юм.³

Гадаадын ихэнх компаниуд ашиг сонирхлын тодорхой зөрчил шийдвэрлэх

дүрмийг мөрдөн ажилладаг.⁴ Иймэрхүү дүрэм, журамд ихэвчлэн сонирхлын зөрчил гэж юуг хэлэх талаар энгийн тодорхой болтыг өгсөн байдаг бөгөөд үүнд ажилчид өөрийн ажил үүрэгтэй харшлах, хохирол учруулах, зөрчилдэх аливаа үйл ажиллагаанд оролцгуйг байх болон компанийн хөрөнгө, бүтээгдэхүүн, дотоод мэдээлэл болон бусад мэдээллийг хувийн болон өөр бусдын ашиг сонирхлын төлөө ашиглажгүй байхыг тусгагдаа. Мөн болзошгүй сонирхлын зөрчлийг мэдээлэх хугацаа мөн адил тогтсон нэг ойлгоптой байдаг. Ийм дүрэм журамдаа сонирхлын зөрчил үүссэн үед хэрхэн ажиллах талаар заавар, процедурыг тусгаж өгсөн байдаг.⁵

1989 онд АНУ-д Бизнесийн корпорацийн загвар акт шинчлэгдсэн байдаг бөгөөд уг актаар захирлуудын ашиг сонирхлын зөрчилтэй хэлцлийг тодорхойлохын тулд асуулга тест оруулж болохыг заасан.

Их Британид компанийн тухай хуулийн дагуу компанийн захирлуудын сонирхлын зөрчлийг шалгадаг гарын авлага 2008 онд гаргасан байдаг.⁶ Энэхүү гарын авлагад компанийн нарийн бичгүүдэд хяналтын асуулгын жагсаалтыг гаргаж өгсөн бөгөөд уг асуулгын дагуу захирлуудын ашиг сонирхлын зөрчилтэй эсэхийг шалгадаг ба ихэнхдээ компанийн захирлууд эрх бүхий этгээдүүд нь сонирхлын зөрчилд орж байгаа гэдгээ мэдэж тодорхойлж чаддагчай. Энэ гарын авлагыг ашиглан Их Британийн компанийд дүрмээс 2006 оны компанийн хуулийн дагуу өөрчлөх зөвлөмж өгснөөр олон компани дүрмэндээ өөрчлөлт оруулсан. Уг дүрэмд “компани дүрмэндээ сонирхлын зөрчилтэй холбогдуулан хариуцлага

² Коннелл Фиона, Цогт.Н., Компанийн Эрх зүй Сургалтын гарын авлага, УБ, 2008 он, 94 дэх тал.

³ James D.Cox Managing and Monitoring Conflict of Interest: Empowering the Outside Directors with Independent Counsel, https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=473284

⁴ <http://www.referenceforbusiness.com/encyclopedia/Clo/Con/Conflict-of-Interest>

⁵ Тухайлбал Sumitomo Mitsui Financial Group “Сонирхлын зөрчилтэй холбоотой удирдлагын бодлого” гэсэн бодлоготой бөгөөд уг бодлогын дагуу сонирхлын зөрчил, сонирхлын зөрчилтэй холцлийг зохицуулж бөгөөд өөрийн цахим худсвараа давхижуулж энэ талбарын мэдээлэл хийдэг байна. <http://smth.jp/en/col/index.html>

⁶ <http://www.referenceforbusiness.com/encyclopedia/Clo/Con/Conflict-of-Interest>

⁷ GC100: Companies act 2006- Directors conflict of Interest <http://uk.practicallaw.com/8-380-1895>

хүлээлгэх эрх хэмжээг ТҮЗ-д олгож өгсөн байх ёстой" гэж зохицуулсан байна.

Манай улс нь АНУ болон Их Британи улсын сонирхлын зэрчлийн талаарх гарын авлага болон сонирхлын зэрчлийг шалгах сорилт зэрэгтэй адил бичиг баримт, үлгэрчилсэн журмыг боловсруулж хэрэгжүүлбэл компанийн хуулийн сонирхлын зерчилтэй хэлцлийн хэрэгжилтэд хувь нэмэр оруулах зүйтэй алхам болно гэж үзжэй байна.

Нийтлэг сонирхлын зерчилтэй хэлцлийн субъектийг дараах хурээнд авч үздэг:

Хувьцаа эзэмшигчид	Нийтийн сонирхлыгийн эзээд	Эрх бүхий эзээд	Дотоод мэдээллийн эзэмшигчид

Монгол Улсын компанийн тухай хуульд дурдсан этгээдүүд дээр нэмэгдээд компанийн дотоод мэдээллийг эзэмшигч⁷ компанийн ажилтан болон гадны зөвлөхүүд буюу албан үүргээ хэрэгжүүлэх, гэрээ, хэлцлийн бэлтгэл болон түүнийг байгуулах, гүйцэтгэх үе шатанд дотоод мэдээллийг олж авсан этгээд болон тэдгээрийн холбогдох этгээд нь энэхүү сонирхлын зерчилтэй хэлцлийн субъект болдог нийтлэг ойлголт байгааг анхааран үзжэй компанийн хуульд тусгаж өгснөөр компани болон хувьцаа эзэмшигчид зэргийн эрх ашиг илүү хамгаалагдах боломжтой болох юм.

1.2 Сонирхлын зерчилтэй хэлцлийн илрэх хэлбэр⁸

- Өөртэйгээ хийх хэлцэл: компанийн захирагал, эрх бүхий этгээдүүд нь хариуцсан ажлынхаяа дагуу ямар

⁷ Үзүүлэлтэй цасын зам эзэлийн тухай хууль, (2014) 77 дугаар зүйл.

⁸<http://www.legalmatch.com/law-library/article/business-conflict-of-interest>.

нэг гэрээ хэлэлцээр байгуулахад өөрөө оролцож, шийдвэр гаргаж ямар нэг байдлаар ашиг олох явдлыг хэлдэг. Энэ мэт зерчил гаргагчийг «компанийн боломжийг хууль бусаар ашиглагч» гэж нэрлэдэг.

- Таннелинг: компанийн зонхилох хувьцаа эзэмшигч болон өндөр түвшний удирдлагууд компанийг ашиглан хувьдаа ашиг олох зорилготой хэлцэл
- Дотоод мэдээллийг ашиглаж арилжаанд орох замаар хийгдсэн хэлцэл: компанийн дотоод мэдээллийг өөртөө ашигтайгаар ашиглаж болохгүй, ялангуяа худалдааны нууцлалтай холбоотой мэдээлэл болон дотоод мэдээллийн үндсэн дээр хийх арилжаа зарим төрлийн зерчил үүсч нэхцэлийг бий болгодог,
- Бэлэг авсны дагуу хийх хэлцэл¹⁰: олон бизнесийн хуулиудад албан тушаалтан компанийт ямар нэг бизнесийн харилцаанд орж байгаа гуравдагч этгээдээс бэлэг авч түүнд ашигтай хэлцэл байгуулахыг хориглодог. Бэлэг нь биет болон биет бус зүйл байж болно. Биет бус зүйлд тухайлбал унааны болон буудлын зардал гэх мэт орж болно.
- Өөр байгууллагад давхар ажил эрхэлснээс үүсчээ зерчил¹¹: хэрэв компанийн ажилтан, албан хаагч нь нэгээс илүү компанийд ажилладаг бол тухайн ажилтны ажиллах буй компанийн ашиг сонирхол нь хоорондоо зерчилдэж болохгүй.
- Гэр бүлийн сонирхлоос үүсчээ зерчил: компанийн захирын хүүхэд, эхнэр нэхэр болон бусад ойрлын төрлийн хамаатан саднаа ажилд авах явдлыг ойлгоно. Гэр бүлийн харилцаанаас үүсчээ

⁹ Usurping corporate opportunities. Орчуулав.

¹⁰ Issue with gift. Орчуулав.

¹¹ Outside employment conflict. Орчуулав.

сонирхлын зөрчлийг непотизм гэдэг бөгөөд энэ нь шударга бусаар буюу үндэслэлгүйгээр цалин нэмэх болон бусад тэтгэмж олгох зэрэгтэй тухайн этгээдэд ашигтай байдлыг үүсгэдэг серег талтай.

Өөртэйгээ хийх хэлцэл¹²

Өөртэйгээ хийх хэлцэл нь компанийн хөрөнгө болон боломжийг хууль бусаар ашиглах, завших байдлаар илрэдэг бөгөөд энэ нь ашиг сонирхлын зөрчилтэй хэлцлийн нэг томоохон илрэх хэлбэр юм.

1. Өөртэйгээ хийх хэлцэл гэдгийг компанийн эрх бүхий албан тушаалтан болон зонхилох хувьцаа эзэмшигч нь компанийн ашиг багатай нөхцөлөөр хэлцэл хийхийг хэлдэг. Өөртэйгээ хийх хэлцэл нь ихэндээс нэгдмэл сонирхолтой этгээдээс хөрөнгийг худалдах, худалдан авах тухайлбал гүйцэтгэх захирал нь өөрийн компанийсаас газар худалдан авах гэх мэт байдлаар илрэдэг. Гэхдээ өөр байдлаар буюу тухайн компанийг эзэмшидэг, зонхилох хувьцаа эзэмшигч болон компанийн гүйцэтгэх удирдлага тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдэд гэрээ хэлэлцээр хийхэд нь баталгаа гаргаж өгөх байдлаар илрэх болно. Энэ төрлийн сонирхлын зөрчил нь их ноцトイд тооцогддог.

2. Компани дээр цалин урамшууллын гэрээ хийхэд өөртэйгээ хийх хэлцлийн асуудал элбэг тохиолддог бөгөөд үүнээс зайлсхийх боломж бас бага байдаг. Гэсэн хэдий ч удирдлагын түвшний албан тушаалтан, ТУЗ-н гишүүдийн цалин урамшууллын асуудлыг шийдвэрлэхэд бас эрсдэл байгааг угүйсгэхгүй учир нь захирлууд өөрсдийн цалин урамшууллыг өндөрөөр тогтоох явдал элбэг тохиолддог.

3. Компанийн эрх бүхий этгээд тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд

нь компанийд санал болгосон бизнесийн боломжуудыг ашиглах явдлыг хэлдэг.

Нийтийн эрх зүйн тогтолцоотой улс оронд өөртэйгээ хийх хэлцлийг ерөнхийдөө хүчин төгөлдөр бус гэж үздэг. АНУ-н олон муужуд "айтуулгүй эрэг"¹³ гэж нэрлэгдэх журмыг баримталж өөртэйгээ хийх хэлцлийг хүлээн зөвшөөрдөг. Үүнд: (I) ямар нэг ашиг сонирхолгүй захирлууд болон хувьцаа эзэмшигчид өөртэйгээ хийх хэлцлийн талаар мэдэх байсан (II) хэлцэл нь компанийд ашигтай шударга болсон гэсэн нөхцөлүүд байгаа тохиолдолд л хүчин төгөлдөр байж болно гэж үздэг.¹⁴

Өөртэйгээ хийх хэлцэл нь компанийд хохирол учруулах үр дүн хүргэхгүй байж болох хэдий ч хэрэв шударга бус байдлыг бий болгосон бол хохирлын үндэс болдог. Өөртэйгээ хийх хэлцэл нь хэрэв тухайн хэлцлийг хийж эрх мэдээл бүхий этгээд нь ямар нэг сонирхлын зөрчилгүй, бие даасан, хараат бус байх үед гарах үр дүнтэй харьцуулахад компанийд ашиг багатай байхыг шударга бус гэж тодорхойлдог. Ийм учраас сонирхлын зөрчилтэй хэлцлийн зохицуулалт нь шударга бус өөртэйгээ хийх хэлцэл хийгдэх явдлаас хамгаалахад оршдог.¹⁵

Нийтлэг эрх зүйн тогтолцоотой орнуудад өөртэйгээ хийх хэлцлийг зохицуулсан бодит хууль тогтоомж, дүрэм журам дээр тулгуурладаг энэ талаар хуульд бичмэл байдлаар тусгасан байдаг. Нийтийн эрх зүйн тогтолцоотой улс оронд шударга ёсны байглолтын дагуу буюу хамгийн үнэнч байх үүргээ биелүүлсэн эсэхийг шүүхээс шалгаж тогтоож шүүхийн прецедентээр зохицуулдаг.

Таннелинг¹⁶ буюу компанийн зонхилох хувьцаа эзэмшигч, өндөр түвшний удирдлага компанийг ашиглан

¹² Self dealing. Орчуулсан Өөртэйгээ хийх хэлцэл гадзг нь эрх бүхий этгээд хууль, компанийн ажилтан нь ямар нэг төрлийн хэлцэлд орохдоо өөрийн албан тушаалаа ашиглан (байр суурь) өөрийн ашиг сонирхло тухайн итгэмшил өгсөн этгээд үйлчлүүлгүүтэй болоул ажил олготчинийн ашиг сонирхлоос дээгүүр тавьж хэлцэлд орохыг хална.

¹³ Safe harbor, Орчуулсан.

¹⁴ Gregory V Varallo, Daniel A. Dreisbach, Black Rohrbacher Fundamentals of Corporate Governance, p.30.

¹⁵ Luca Inrikes, The Law on Company Director' Self Dealing: A Comparative Analysis https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=135674

¹⁶ Tunneling, галиглэв.

Хувьдаа ашиг олох зорилготой хэлцэл

Ашиг сонирхлын зөрчилтэй хэлцлийн нэг төрөл болох таннелинг нь бизнест ихэвчлэн зонхилох хувьцаа эзэмшиг болон компанийн өндөр түвшний албан тушаалтан буюу дотоод мэдээлэл эзэмшиг нь компанийн хөрөнгөөр өөрийн хувийн бизнесийн боломжийг есгэж ашиг олохыг хэлдэг бөгөөд уг хэлцлээс компани хохирол амсаж байдаг онцлогтой. Үүнд: гүйцэтгэх удирдлагын өндөр цалин, урамшуулалт, үнэт цаасны хувийг бууруулах, хөрөнгө худалдах, хувийн зээлийн баталгаа зэрэг нь таннелинг гэж тооцогддог. Үүнээс жижиг хувьцаа эзэмшигчид хохирол амсах байдал нийтийг тохиолддог буюу тэдгээрийн хувьцааны хэмжээ багасах болон компанийн бизнесийн үнэ цэнэ буурдаг.¹⁷ Таннелинг хийсэн бол уг хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж үздэг.

1990-ээд оны эхийн хагаст Бүгд Найрамдах Чех улсын хэд хэдэн дэнгэж хувьчлагдсан томоохон банкууд болон үйлдвэрүүд гэнэт дампуурсан бөгөөд тухайн компанийн удирдлагууд компанийн хөрөнгө болон үл хөдлөх хөрөнгийг өөрсдийн хувийн бизнес болон оффшор бүсэд шилжүүлснийг тогтоосноор таннелинг үүссэн гэж үздэг. Таннелингийн хамгийн нийтлэг жишээ бол Төв Европын орнуудын хувьчлалын дараах үеийн их хэмжээний бэлэн мөнгтэй байсан компанийн удирдлагуудаас хөрөнгө мөнгийг өөрсдийн хувийн компани руугаа шилжүүлсэн тохиолдлуудыг нэрлэж болно. Тухайлбал: буцааж төлөх ямарч баталгаа байхгүй маш өндөр хэмжээний зээл гаргах, гаднаас авсан үйлчилгээний үнэд хэтэрсэн өндөр хөлс төлөх,¹⁸ компанийн үл хөдлөх хөрөнгийг зах зээлийн үнээс хэт бага очуухэн хэмжээний үнээр худалдах үйлдлээр таннелинг илрэдэг.

¹⁷ <http://www.investopedia.com/terms/t/tunneling.asp#ixzz4QEUV7xehN>

¹⁸ Энэ нюхцэл байдал гэсэн Монгол Улсын хувьд төрийн өмчтэй хувьцаат компанийнад тохиолддог жишээ юм. Тухайлбал: төрийн өмчтэй хувьцаат компаний маш өндөр үнэтийн хувьчллын зөвлөл үйлчилгээ авсан жишээ олон нийтийн харгаслээр цацгаджак байсан.

Таннелинг хийсэн хүмүүс бүх үйл ажиллагаа, процедурыг хуулийн дагуу хийж тухайн таннелингийг хүсэж хийдэг онцлогтой.

Бэлэн мөнгөний таннелинг нь Тухайлбал: гүйцэтгэх захирад өөртөө хэт өндөр цалин урамшуулалт олгох, бага хэмжээний бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээс доогур худалдах, дэзгүүр худалдан авах хэлцэл байгуулдаг. Ийм төрлийн хэлцэл нь компанийн бэлэн мөнгөний чадавхид тиймч их нөлөө үзүүлэхгүй байх талтай болбеч урт хугацаанд байнга давтадах байдалтай бол хэсэг хугацааны дараа компанийн бэлэн мөнгөний ургслад сергээр нөлөөлж компанийд хохирол учруулдаг.

Хөрөнгийн таннелинг гэдэг нь өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдэд компанийн хөрөнгийг худалдах, зээл олгоходоо бага хүүтэй байх зэрэг ордог. Эсрэгээр өндөр үнэр үл хөдлөх хөрөнгө худалдан авах, өндөр хүүтэй зээл авах зэрэг багтана. Хөрөнгийн таннелинг компанийн бэлэн мөнгөний чадавхид шууд нөлөөлдөг, компанийн ашиг орлого нь энэхүү таннелинг хийсэн хөрөнгө дээр нь үндэслэдэг учир бэлэн мөнгөний таннелингээс ялгагддаг.

Үнэт цаасны таннелинг гэдэг нь хувьцааны үнийг бууруулсан оффер санаал тавих, жижиг хувьцаа эзэмшигчдийн ногдол ашигийг өгөхгүй байх, дотооддоо зээл олгох буюу энэхүү зээл нь буцаан төлөгдхүгий байх, хувьцаанд тулгуурласан өндөр урамшуулалт олгох болон дотоод мэдээллийг ашиглаж арилжаа хийх зэрэг багтана.

Монгол Улсын дампуурлын тухай хуульд¹⁹ таннелинг хэлбэрээр илрэх хэлцлийг хүчин төгөлдөр бус байх зохицуулалт орсон байх бөгөөд энэхүү зохицуулалтыг компанийн хуультай холбож өгвэл таннелинг төрлийн сонирхлын зөрчилтэй хэлцлийг зохицуулах зохицуулалтад чухал хувь нэмэр болох юм.

¹⁹ Дампуурлын тухай хууль. (1997) 19 дүгээр зүйл

Дотоод мэдээллийг ашиглаж арилжаанд орох замаар хийгдэх хэлцэл²⁰

Компанийн эрх бүхий албан тушаалтан компанийн нууц, дотоод мэдээллийг²¹ хадгалах үүрэг бүх л улс орны компанийн хуульд тусгалаа олон байdag бөгөөд эс бөгөөс компаний бизнесийн ўйл ажиллагаагаа явуулж чадахгүй. Энэхүү нууц буюу дотоод мэдээлэл гэдэгт зөвхөн компанийн нууц орохгүй бөгөөд компанийн холбоотой олж авсан мэдээллүүд ч хамрах боломжтой. Энэхүү мэдээлэл нь заавал нууц гэж ангилагдсан байх дотоодос л гарсан байхыг хэлэхгүй бөгөөд компанийн гаднаас авсан мэдээлэл ч нууцад буюу дотоод мэдээлэлд орж болно. Тухайлбал хяналтын хувьцааг худалдан авах мэдээлэл байж болно.

Дотоод мэдээллийг ашиглаж хийх арилжаа гэдэг нь хувьцаат компанийн хувьцаа болон бусад үнэт цаасыг (бонд, опцион) хувь хүн нийтэд ил болоогүй мэдээллийг ашиглан арилжаа хийхгүй хэлдэг. Олон оронд зарим нэг төрлийн дотоод мэдээллийг ашиглаж хийх арилжааг хууль бус гэж үздэг. Учир нь бусад хөрөнгө оруулагчид шударга бус бөгөөд дотоод мэдээллийг мэдэж байгаа хөрөнгө оруулагч нь бусад хөрөнгө оруулагчаа илүү ашиг олох давуу боломжтой байдаг юм.

Хэрэв компанийн дотоод мэдээлэлтэй этгээд эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээд хэлэлцэд нэг тал болж оролцсон гэж үзэвл уг хэлцэл нь тухайн компанийн дотоод мэдээлэл бүхий этгээдийн хувьд сонирхлын зерчилтэй хэлцэл болно.²² Энэхүү этгээд нь компани болон ТУЗ-д энэ арилжааны талаар урьдчилж мэдэгдэх үүрэгтэй.²³

²⁰ Insider trading. Орчуулав

²¹ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, (2014) 76 дугаар зүйл "Тодорхой үнэт цаасны үнэт ханшид нөхөнхөн нийтийн хуртгэл бологууч мэдээллийг дотоод мэдээлэл үзэх" гэж тодорхийлон байдал.

²² Коннелл Фиона. Цогт Н. Компанийн эрх зүй сургалтын гарин авлагыа. 2008 он. 97 дахь тал.

²³ Компанийн тухай хууль, (2011) 91 дутгээр зүйл.

Дотоод мэдээллийг ашиглаж хийх арилжааны сонгодог онолоор эрх бүхий этгээд болон нууцлал хадгалах харилцаатай этгээдүүд нь компанийн нийтэд ил болоогүй материаллаг буюу компанийн үнэт цаасанд нөхөнхөн мэдээллийг ашиглан арилжаа хийхгүй байх үүрэг хулээнэ. Энэхүү дотоод мэдээллийг мэддэг этгээдүүдийг албаны байр сууринькаа хүчээр нууц мэдээллийг олж авсан этгээд буюу нууц, дотоод мэдээлэл эзэмшиг²⁴ гэж нэрлэдэг бөгөөд үүнд: компанийн ажилчид, захицууд мян хуульцид, нягтлан бодогчид, зөвлөхүүд бусад түр хугацаагаар итгэмжлэгдсэн этгээдүүд багтаг.

Монгол Улсад үнэт цаасны арилжаанд оролцогч мэргэжлийн оролцогчид нь компанийн дотоод мэдээлэл эзэмшигч болж болох боловч өөр бусад компанийн гаднаас зөвлөгөө өдөг зөвлөхүүд энэхүү категориид багтахгүй байгаа тул энэ талаар зохицуулалтыг хуульд тусгаж өгснөөр хуулийн гадуур байсан здээр этгээдүүдийг үүрэгжүүлэх мян хамгаалалтын зохицуулалт болох юм. Манай улсын компанийн захидал, өндөр албан тушаалтууд, хувьцаа эзэмшигчид ч гэсэн энэ талаар хуулийн мэдлэг дутуу дулимаг байгаагасаа болж хохирох явдал байгаа боловч ямар хуулийн ямар зохицуулалт ашиглах ёстойгоо мэддэггүй.

Жишиж нь АНУ-н Дээд шүүхээр компанийн үнэт цаасны арилжаанд үнэт хаялцагч компанийг төлөвлөж оролцсон хуульчийн хамтрагч хуульч нь тухайн компанийн хувьцааг худалдан авсан маргааныг шийдвэрлэсэн байдал. Энэ асуудал дээр үнэт цаасыг худалдах худалдан авахтай холбоотой ямар нэг хууль бус үйлдэл үүссэгүй боловч үнэт хаялцагчийн мэдээллийг хууль бусаар ашигласан, хуульчийн үйлчлүүлэгчдээ хулаасан үүргээ зэрчсэн нь ямарч зарилготой байсан гэсэн энэ нь луйвар, заплан болно.²⁵ Гэж үзсэн байдал.

²⁴ Insider, Орчуулав

²⁵ William J. Carney, *Essentials Mergers and Acquisitions* Aspen Publishers, (2009) p.247.

1.3 Сонирхлын зөрчилтэй хэлцэлтэй холбоотойгоор эрх бүхий албан тушаалтны хүлээх үүрэг

Сонирхлын зөрчилтэй хэлцлийн зохицуулалт түүний хэрэгжилтийн чухал хөшүүрэг бол сонирхлын зөрчил бүхий этгээдийн хүлээсэн үүрэг байдаг. Компанийн эрх бүхий этгээдийн компанид хүлээсэн үүргээс үндэслэн сонирхлын зөрчилтэй холбогдох үүргийн асуудал урган гардаг. Тиймч уураас сонирхлын зөрчилтэй хэлцлийн асуудлыг эрх бүхий этгээдийн үндсэн үүрэгтэй холбон авч үзэх нь чухал бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцлээс үүдэн маргаан гарвал шүүх компанийн эрх бүхий этгээдүүд үүргээ хэрхэн биелүүлсний гол шалгур болгол маргааныг шийдвэрлэдэг онцлогтой.

Эрх бүхий буюу итгэмжлэгдсэн этгээдийн үүрэг

Үнэнчээр ажиллах үүрэг Хариуцлагатай хандах үүрэг

26

Нийтийн эрх зүйд "үнэнчээр ажиллах үүрэг"-г шүүхээс шударга ёсны үндсэн дээр тогтоодог, итгэмжлэгдсэн этгээдийн гол үүрэг болох "хариуцлагатай хандах үүрэг"-г хайнга, болгоомжгүй хандах талаар хуулийн зохицуулалтад үндэслэгдэж тодорхойлдогддог. Итгэл хүлээх буюу үнэнч байх үүрэг нь компанийн хуульд тодорхой тусгагдаж хэрэв зөрчвэл хариуцлага хүлээх зохицуулалт үйлчилдэг. Үнэнч байх үүрэг нь журам биш стандарт ба нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлээс "хамгаалах шүхэр"²⁷ нь буюу хувьцаа эзэмшигч болон компанийг хамгаалах хамгаалалт болдог. Мөн үүний хажуугаар үнэнч байх зарчим нь зах зээлийн өрсөлдөөнийг хамгаалах зорилготой.²⁸

Үнэнчээр ажиллах үүрэг -

²⁶ Энэхүү судалгааны хүрээнд Duty of care, Duty of loyalty гэх томъёолуудыг Амарсангаа Б., Компанийн засаглан, компанийн эрх зүйн тulgamsan асуудал, УБ., 2012 оны бутгалд харгассан "хариуцлагатай хандах үүрэг болон үнэнчээр ажиллах үүрэг" хэмжээ нэршилээр авч улзва.

²⁷ Umbrella phrase, Орчуулав.

²⁸ Klaus J.Hopt., Conflict of Interest, Secrecy and Insider Information of Directors G Comparative Analysis, European Corporate Governance Institute https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=2313697

Компанийн захирал, ТУЗ-н гишүүн болон компанийн өндөр албан тушаалтан нь ямар нэг шийдвэрийг гаргахдаа өөрийн хувийн ашиг сонирхлоос ангид байж компанийн ашиг сонирхлыг дээдэлж, түүний ашиг сонирхолд нийцсэн шийдвэр гаргах нь хамгийн чухал үүрэг юм. Үнэнч байдлын үүрэг нь захирлуудыг өөртэйгээ хэлцэл хийхийг хориглодог. Захирлууд болон түүнтэй хамааралтай хуулийн этгээдийн худалдах худалдан авах гэрээ хийх, толгой компани охин компанийг хэлцэлд орох, дотоод мэдээлэл дээр үндэслэн арилжаанд орох болон компанийн дотоод мэдээллийг буруугаар ашиглах, захирлуудаас эргэлтийн хөрөнгөгүй болсон компанийг санхүүжүүлсэн, компанийн боломжийг хууль бусаар ашиглах тохиолдуудад дээрх үүргээ биелүүлсэн эсэх талаар асуулт урган гарч ирдэг.²⁹

Үнэнчээр ажиллах энэхүү үүргийн хувьд ямар эрх зүйн тогтолцоонд, хэрхэн тусгагдсанас ул хамааран зайлшгүй хоёр шинжийг агуулах ба үнд нэгдүгээр: шударга бус буюу үнэнчээр ажиллаагүй хэлцлийг хууль бус хэлцэлд тооцох, хоёрдугаарт: шударга бус эсэхийг тухайлсан фактад үндэслэн шүүхээс тогтоосон байх гэсэн хоёр зарчмыг зайлшгүй хангасан байна.

Хариуцлагатай хандах үүрэг – энэ үүрэг тухайн субъект аливаа үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргахдаа хариуцлагатай сонор сэргээжтэй болгоомжтой хандах, хийх ёстойгоо хийн мэдлэг чадвартай байх зэрэг үзэр илэрхийлгэдэх боломжтой.³⁰ Бизнесийн маргааныг шийдвэрлэх дүрэмд заасны дагуу шүүх тухайн субъект бизнесийн шийдвэр гаргахдаа компанийн ашиг сонирхлыг өндөрт тавьж үнэнч шударгаар хандсан эсэхийг шалгадаг. Дэлаверийн Хууль, 102 (b) (7) дугаар хэсэгт компани нь хэрэв компанийн захирлууд хариуцлагатай хандах үүргээ

²⁹ Gregory V.Varallo, Daniel A.Dreisbach, Black Rohrbach-er, Fundamentals of Corporate Governance.. American Bar Association; 2 edition (2011) p.30

³⁰ Амарсангаа Б., Компанийн засаглан, компанийн эрх зүйн тulgamsan асуудал, УБ., 2012 он, 28 дахь тал.

биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх болон хариуцлагаас чөлөөлөх зохицуулалтаа компанийн дүрэмдээ нарийн тусгаж өгөх ёстой гэсэн байдал.³¹ АНУ-н бараг ихэнх муйжийн компанийн хуульд энхүү журам тусгагдсан. Японы компанийн хуульд захирлуудын унэнчээр ажиллах үргийг бас тусгасан.³²

Хоёр. Компанийн эрх зүй дэх сонирхлын зөрчилтэй хэлцлийг шийдвэрлэх арга зам

2.1 Компанийн эрх зүйн сонирхлын зөрчилтэй хэлцлийг зохицуулах арга

Компани дээр гарч болох ямар нэг маргаанаас урьдчилан сэргийлж сонирхлын зөрчлийн асуудлыг журамласан байх нь чухал.

Хэрэв дараах байдлаар сонирхлын зөрчлийн асуудлыг компани дээрээ зохицуулсан зохицуулалтыг хийсэн бол хуулийн ямар нэг үр дагавар эрсдэл үүсгэхгүй, маргаан гаргахгүй байх боломжтой буюу энэ талаар сонирхлын зөрчилтэй хэлцлийн субъектүүдийн үргийн талаар дурдсаныг дэлгэрүүль:

Урьдчилж мэдэгдэх

Зөвшөөрөл авах

Таталзах, зайлсхийх

Хориглолт хийх

Урьдчилж мэдэгдэх - энэ үргийн зайлшгүй мэдэгдэх үүрэг ч гэж нэрлэдэг.

Компанийн эрх бүхий этгээд нь ажил үргийнхээ хувьд ямар нэг шийдвэр гаргах, хэлцэл хийхэд түүнд хувийн сонирхолт үүсч байгаа бол энэ талаараа тухайн шийдвэрийг гаргахаасаа өмнө Төлөөлөн удирдах зөвлөлдөө заавал мэдэгдэх үүрэгтэй. Энэ зохицуулалт нь зөвхөн компанийн захиралд төдийгүй урьд тодорхойлсон сонирхлын зөрчилтэй хэлцлийн субъектүүддэд ч хамааралтай юм.

Дээр дурдсан үнзч байх үүргээс урган гардаг чухал үргийн нэг бол мэдэгдэх үүрэг юм. Энэхүү үргийг хэрэгжсэн эсэхийг шалгахдаа мэдэгдэл хийсэн гэдэг нь баримтжсан болон ямар мэдээллийг мэдэгдсэн, мэдэгдэл нь журмын дагуу хийдсэн зэрэг байдал. Зарим улс оронд бичгэн мэдэгдэл хийх шалгур тавьдаг. Манай компанийн хуульд бичгэн мэдэгдэл хийх шалгуурыг оруулж өгвэл мэдэгдэх үүргийн биелэлтийг хянах боломжтой болох юм.

Монгол Улсын компанийн тухай хуульд компанийн эрх бүхий албан тушаалтан нь шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ талаар тухай бүр мэдэгдэх үүрэгтэй гэж зохицуулсан байна.³³

Дотоод мэдээллийг ашиглаж хийх арилжааны зохицуулалтын гол асуудал нь урьдчилж мэдэгдэх журмыг буюу цаг тухайд нь мэдэгдэх байх шаардлага тавьдаг ба үүний зорилго нь компанийн нууц мэдээлэл алдагдах эрсдэлийг бууруулах, дотоод мэдээллийг ашиглаж хийх арилжаанд орохос урьдчилан сэргийлэх явдал байдал.³⁴ Монгол Улсын компанийн хуульд дотоод мэдээллийг ашиглаж арилжаа хийхийг сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж тодорхойлоогүй, үнэт цаасны зах зээлийн хуульд дотоод мэдээллийг ашиглаж арилжаа хийхэд урьдчилж мэдэгдэх үүргийг тусгаагүй байгаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг супруулах сүл тал болж байна.

³¹ Dana M Muir Cindy A Schipani, The Challenge of Company Stock Transactions for Directors' Duties of Loyalty

³² Klaus J.Hopt, Eddy Wymeersch Capital Market and Company Law pp.530-544.

Үрьдчилж мэдэгдэх үүргээс гадна хуулийн дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн бол тайлант жилийн эцэст цахим хуудсандаа тавьж нийтэд мэдээлэл болон компанийн санхүүгийн тайландаа тусгах, хувьцаат компани болон өөр бусад зохицуулалттай компани нь давхар төрийн эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүргийг компани хуулиар хүлээсэн байдал.

Монгол Улсын хувьд хувьцаат компанийд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн талаар мэдээлж байх үүрэг болгосон байдал нь сонирхлын зөрчлөөс үүдэн эрсдэл үүссэхэс хамгаалах, хувьцаат компанийг нээлттэй байлгаж хөрөнгө оруулагчдийг хамгаалах, татах зорилго давхар агуулагдаж байдаг гэж ойлгогджэй байна.³⁵ Энэхүү үүргийг ТУЗ-н нарийн бичгийн дарга хүлээндэг.³⁶ Энэ мэдээлэл харин дутмаг байгаа нь СЗХ дээр байгаа мэдээлэлээс харгадах ба СЗХ-ны 2014 оны судалгааны харахад нийт 22 компанийн мэдээлэл орсон байх ба үүнээс 3 сонирхлын зөрчилтэй хэлцэл хувьцаат компанийнад хийгдсэн байна. СЗХ-оос 2015 болон 2016 оны энэ мэдээлэл гаралаагүй байна.

Цалин урамшууллын гэрээ, өөртгэйгээ хийх хэлцэл эсхүлхувьцаагаа худалдах зэрэгээр зайлшгүй мэдэгдэх үүрэг хязгаарлгахдагүй бөгөөд АНУ-н хуульд эдгээрийг мэдэгдэх ёстойг хуульчилсан байдал. Тухайлбал АНУ-н Үзт цаасны тухай хуульд тус улсын болон тус улсын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй гадаад улсын компанийн захирилууд, ТУЗ-н гишүүд,

³⁵ Үзт цаасны зах эзэллийн тухай хууль (2014) 56 дугаар зүйлийн 1 дахь хэсэг болон 56 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Үзт цаасны хөөрдөг зах эзэлд үзт цаасын арилжих байвал үзт цаас гаргагч нь дор үзт цаас гаргагчийн байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл хийнээс хошиж алжны нэг адарт багтааваа энэ талбар Хороо, хөрөнгийн бирж болон өврийн цахим худалдаан дамжуулан нийтэд мэдээлэх үүрэгтэй:

³⁶ Санхүүгийн Зохицуулалт хоороны тогтоо, 2015.12.17, №443, Үзт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам, 4.1 дахь хэсэг Сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар мэдээллийг өврийн болон Хөрөнгийн биржийн цахим худалдаан байршиулах үүргийг ТУЗ-н нарийн бичгийн дарга гүйцэтгэж бөгөөд үзт цаасны зах эзэллийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу мэдээллийн үзт цаасыг компанийн хариуцна.

5%-аас дээш хувь эзэмшидэг хувьцаа эзэмшигчид ямар нэг материаллаг ашиг сонирхолтой 120,000 ам.доллараас дээш үүний дүнтэй хэлцлийн жилд нэг удаа мэдэгдэх үүргэгт байдал.³⁷ Европын холбооны улс суулийн үед нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн хэлцлийг мэдэгдэх талаар дорвitoят алхам хийсан бөгөөд Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг нэвтрүүлснээр хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн захириал, ТУЗ-н гишүүд болон зонхилох хувьцаа эзэмшигчтэй байгуулсан гэрээний талаар жилдээ нэгдэвээ заавал мэдэгдэх үүргэгтэй, ХБНГУ-н Компанийн засаглалын кодекст хувьцаат компани нь хяналтын зөвлөлдөө сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар жилийн эцсийн Тайландцаа тайлагнахыг зөвлөсөн байдал боловч ХБНГУ-н компанийн хуульд (Aktiengesellschaft) энэ талаар зохицуулалт ороогүй хэдий ч компанийн хувьцаа эзэмшигчид хэдий ч асуулга тавих, мэдээлэл авах өргөн эрх олгосон байдал бөгөөд компанийн албан хаагчид үүнд хариулах үүргийг тогтоож өгсөн байдал. Япон улсын хувьд компанийн шийдвэр гаргах эрх мэдэлтэй захириал, албан хаагчийн сонирхлын зөрчилтэй хэлцэлд орсон талаараа мэдэгдэх үүргэгтэй байдал.³⁸

Татгалзах үүрэг – хэрэв тухайн эрх бүхий этгээдэд тодорхой шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцоход ямар нэг байдлаар сонирхлын зөрчил үүссэн бол тухайн шийдвэр гаргах болон үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс татгалзах нь эдгээр этгээдүүдийн гол Үүрэг байдал. Эрх бүхий этгээд нь ашиг сонирхлын зөрчилтэй бол түүний уг үйл ажиллагаа, хэлцэл хийх шийдвэр гаргахад санаал өгөх ёсгүй гэж үздэг ба бүр тухайн үйл ажиллагаа, хэлцэлд ямар нэг байдлаар оролцуулахгүй байх чанга журам үйлчилдэг.

Зайлсхийх үүрэг – хэрэв эрх бүхий этгээдэд сонирхлын зөрчил үүсч болох

³⁷ Anatomy of Corporate Law, A comparative and Functional Approach (second edition) p.156.

³⁸ Anatomy of Corporate Law, A comparative and Functional Approach (second edition) p.156 - 158.

нөхцөл байдал бий болбол түүнээс зайлсхийг үүрэгтэй. Компанийн хуулийн 84 дүгээр зүйлд энэ үргүйг тусгасан байдаг. Их Британийн компанийн хуулийн 175 дугаар зүйлд энэхүү санааг оруулсан байдаг бөгөөд сонирхлын зөрчил үүсэж болох нөхцөл байдлаас захирлууд нь зайлсхийг ёстой байдаг.

Зөвшөөрөл өгөх - мэдэгдэх үүргээс урган гардаг бөгөөд тухайн этгээд нь тодорхой журмын дагуу өөрийн ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэж энэхүү хэлцлийг хийх эсэх талаар зөвшөөрлийг ТУЗ-өөс авдаг. Зөвшөөрөл өгөх журам, шалгуурыг хууль тогтоомжоор зохицуулсан байдаг бөгөөд зөвшөөрлийг зөвхөн ТУЗ-н дарга өгөх эсхүл ТУЗ-өөс өгөх, хоёр шатлалт ТУЗ-тай бол хянантын зөвлөл өгдөг. Зарим хатуу зохицуулалтад зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаас зөвшөөрөл олгох заалт байдаг ч компанийн хувьд энэхүү шийдвэрийг хурдан гаргах нь үр ашигтай байх тохиолдолд энэ зохицуулалт үр дун мутай байдаг. Гэхдээ зөвхөн ТУЗ-өөс зөвшөөрөл өгөх нь хангалийн хамгаалалт болж чадахгүй. Монгол улсын хувьд ТУЗ-н сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхын саналын үндсэн дээр зөвшөөрөл өгдөг бөгөөд зарим тохиолдолд ТУЗ нь энэ асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас зөвшөөрөл авахаар оруулдаг, хурлаас мөн сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн олонхын шийдвэрээр зөвшөөрөл өгдөг. Үүнээс гадна зөвшөөрөл өгөхдөө хөндлөнгийн мэргэжлийн этгээдээр үнэ тогтолгосны дагуу зөвшөөрөл өгөх зохицуулалт байгаа³⁹ нь олон улсын жишигт нийцсэн сайн зохицуулалт болж чадсан.

Компанийн тухай хуулийн зөвшөөрөл өгөх зохицуулалтаас гадна иргэний хуульд зөвшөөрлийн үндсэн дээр хийгдэх хэлцлийн талаар зохицуулсан байдаг.⁴⁰ Иргэний хуулийн зохицуулалтын дагуу зөвшөөрөл

олгосон эсэх талаараа хэлцлийн талуудад мэдэгдэх ёстойг хуульчилсан нь процессын хувьд ашиглаж болох чухал зохицуулалт юм.

ТУЗ-н хараат бус эсхүл сонирхлын зөрчилгүй гишүүд нь хураалдаж хурлын тэмдэглэл үйлдэж, хурлаас тогтоол гаргаж зөвшөөрлийг баталгаажуулдаг. Сүүлийн үеийн хандлагар бие даасан хараат бус захирлууда, аудиторын гаргасан тусгай тайланг үндэслэж, бие даасан хараат бус зөвлөхийн шударга зөвлөгөөний дагуу зөвшөөрөл өгдөг жишиг бас байна. Гэхдээ Их Британийн хуулиар хувьцаа эзэмшигчээс зөвшөөрөл авах явдал одоо хүртэл шаардлагатай хөвөөрээ л байна.

Делаверийн шүүх нь хэрэв сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдэх нөхцөл бүрдэвэл хараат бус ТУЗ болон хараат бус захирлуудын шийдвэрийг авсан байх нь зүйтэй гэж тэмдэглэсэн байраг.⁴¹

Компанийн нэгдлийн хувьд хараат болон охин компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ихэвчлэн толгой компаниас томилогддог, мөн ерөнхий ассамблей нь өөрөө толгой компаниас хараат тохиолдолд энэхүү зөвшөөрлийн шаардлага нь харьцангуй үр дунгуй бөгөөд харин энэ тохиолдолд Австралийн жишгээр төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн шийдвэр болон жижиг хувьцаа эзэмшигчдээс зөвшөөрөл авах нь илүү үр дүнтэй. Итали улсын хувьд энэхүү асуудлыг жижиг хувьцаа эзэмшигчийн төлөөлөл Төлөөлөн удирдах зөвлөлд ч мөн цөөнхийг бүрдүүлэх ёстой гэсэн шаардлагаар дамжуулсан шийдвэрлэдэг ба энэ нь хараат бус төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд шийдвэр гаргахаас ч илүү үр нөлөөтэй байдаг гэж үзсэн байна.⁴²

³⁹ Gregory V.Varallo, Daniel A.Dreisbach, Black Rohrbacher Fundamentals of Corporate Governance., American Bar Association, 2 edition (2011).

⁴⁰ Дам ишлэв, Bianchi 2014, supra note 3, at 24, 25. See also Corrado Malberti/Emiliano Sironi, The Mandatory Representation of Minority Shareholders on the Board of Directors of Italian Listed Corporations: An Empirical Analysis, available at <http://www.ssn.com/abstract=965398, 2007>

³⁹ Компанийн тухай хууль (2011) 92 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

⁴⁰ Иргэний хууль (2002) 50 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

Сонирхлын зөрчлийн эсрэг дараах арга хэмжээ авч болдог.⁴³

Урьдчилсан мэдэгдэл хийх журмаас гадна үнэнч байх үргийг амьдрал дээр хэрэгжүүлэхэд хэцүү байдаг. Тиймээс заримдаа хориглолт хийх аргыг ашиглаж болдог тухайлбал зээлийг хориглох, дотоод мэдээлэлтэй этгээдийн гэр булийн гишүүдийн компанийтай хийх хэлцэл болон үнэт цаасны арилжааг хориглох, ашиг сонирхлын зөрчилтэй хамтрагчийг хориглох эзрэг байж болдог.

Сонирхлын зөрчилтэй хэлцлийг хориглох – хэрэв сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн бол түүнийг хүчин төгөлдөр бусад тооцож болох механизмыг заавал байх ёстой. Сонирхлын зөрчилтэй хэлцэл нь аюултай бол түүний шүүд хориглох энгийн арга хэрэглэх нь зүйтэй байдаг.

Олонх болон цөөнхийн санал авах – энэ аргаар зөвхөн тухайн хэлцэлд ашиг сонирхолтой гишүүдийн санаалаар шийдвэрлэдэг. Энэ арга нь хоёр үндсэн ач холбогдолтой. Нэгт: **өөртэйгээ хэлцэл хийх этгээдийг хэлцэлд оролцохос хамгаалдаг**. Хоёрт: нэгэнт тухайн хэлцэл нь зөвшөөрлийн үндсэн дээр хийгдсэн учир шуухэд маргаан үүсэхээс хамгаалдаг.

Шударга байдлын сорил⁴⁴ – шударга ёсны стандарт нь цөөнхийг буюу хараат бус этгээдийг хэлцэл хийх боломжийг олгодог. Гэхдээ шударга байдлын сорил нь цөөнх үнэхээр сайн хэлцэл хийж чадна гэдэг баталгаа өгч чадахгүй юм.

Хөндлөнгөөс оролцохгүй байх – сонирхлын зөрчилтэй хэлцлийг хориглох аргын эзрэг энэ арга нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд ямарч хориг тавихгүй нээлттэй үлдээж зах зээл өөрөө тухайн асуудлыг шийдвэрлэнэ гэж үлдээдэг. Сонирхлын зөрчилтэй хэлцэл байнга хийдгээ компанийг хөрөнгө оруулагч нар сонирхдоггүй тэдний зах

зээлийн үнэлгээ нь өөрөө буурч байдаг, эсхүл хууль бус байдлаасаа болж өөрсдийнх үйл ажиллагаа нь хундрэлд ордог.

Дотоод мэдээллийг ашиглаж хийх арилжааны эзрэг үндсэн хоёр төрлийн журам үйлчилж байна.

- **Богино хугацааны арилжааны хязгаарлалт⁴⁵.**

- Дотоод мэдээлэл дээр үндэслэсэн бол шууд хориглолт⁴⁶ тавих.

Богино хугацааны арилжааны хязгаарлалтын журам нь компанийн захидал, ажилчид, компанийн хувьцааны 10%-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчийг тодорхой заасан хугацаанд компанийн үнэт цаасны арилжаа хийлгэхгүй байж зохицуулалт байдаг.⁴⁷ Энэхүү журмаар богино хугацааны арилжааг хязгаарласнаар компанийн баялгийг ашиглаж өөртөө ашиг олох явдлаас урьдчилан сэргийлдэг юм. Америк, Англи, Япон улсууд энэхүү журмыг үнэт цаасны хуулийн зохицуулалтдаа оруулж өгсөн байдаг.

Бүхий л гол эрх зүйн системүүдэд нийтэд дэлгэгдээгүй үнэт цаасны үндэл нелеөөлөх дотоод мэдээллийг ашиглаж хийх арилжааг шууд хориглолтын журмыг хэрэглэдэг.

2.2 Сонирхлын зөрчилтэй хэлцлийг хулээн зөвшөөрөх болон хүчин төгөлдөр бусад тооцох

Сонирхлын зөрчил байсан ч гэсэн хэлцэл хийх нь тухайн компанийд ашигтай байж болох тохиолдолд асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ? гэсэн асуулт урган гардаг. Энэ сэдвийг онцлон судлахдаа судлаач сонирхлын зөрчилтэй хэлцлийг байгуулж болохыг угүйсгээгүй юм. Харин сонирхлын зөрчилтэй хэлцлийн субъектуудийн гаргасан шийдвэр хийсэн хэлцэл эрх

⁴³ Restriction on short term trading, Орчуулав.

⁴⁴ Direct ban, Орчуулав.

⁴⁵ Reinier Kraakman/John Armour/Paul Davies/Luca Enrico/Henry Hansmann/Gerard Hertig/Klaus Hopf/Hideki Kanda/Edward Rock, *The Anatomy Of Corporate Law*, Oxford 2d ed. 2009, p. 170-172.

⁴⁶ Zohar Goshent, *The efficiency of controlling corporate self dealing: Theory meets reality*, https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=2318668

⁴⁷ Fairness test, Орчуулав.

зүйд нийцэж байгааг хянах ёстой байдаг.

Тухайн хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэл мөн ч гэсэн энэ нь компанийн эрх ашигт нийцсэн, шударга зүй ёсны хэлцэл байж чадсан, энэхүү хэлцлийн үр дүнгээс компани, хувьцаа зэмшигч, зээлдүүлэгч зэрэг ямар нэг хохирол уураагүй, хэлцэлтэй холбогдон ямар нэг маргаан гарахгүй байх нөхцөлийг харгалзан узэх хуулиар заасан шаардлагыг биелүүлж байвал тэр хэлцлийг хүчин төгөлдөрт тооцох хоёр ялгаатай аргачлал байна.

Нэгдүгээрт: тухайн сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах эсэх талаар тодорхой процессын буюу журмын шалгуурыг бий болгодог бөгөөд энэ журмыг ягштал биелүүлсэн бол тухайн хэлцэл дэх сонирхлын зөрчлийг даван тулсан гэх үзэх хэлцэл нь хүчин төгөлдөрт тооцогддог.

Хоёрдугаарт: тухайн хэлцлийн хувьд агууллын шаардлага хангаж байгаа эсэхийг шалгадаг. Энэ нь тухайн хэлцлийн үр дүнд компани юу авсан, мөн юуг алдсаныг шалгах үздэг. Энэ нь зөвхөн процессын шаардлагыг хангаж байвал болох мэт үздэг ёмнөх шалгуураас хэдийгээр илүүтэй мөн чанар руу хандсанаараа давуу мэт харагдаж байж болох ч түүнийг хэн хэрэглэж байгаагас ихээхэн шалтгаалдаг, алдаа гарах магадлалтай, бизнесийн шийдвэр хэт удаан гарахад хүргэх хүндрэлтэй аргачлал юм. Нёгөө талаас зарим тохиолдолд хувьцаа зэмшигчид, ТУЗ-ийн аливаа сонирхолгүй гишүүдийн зөвшөөрөл авсан байсанч хэлцэл нь хүчин төгөлдөр бус байх магадлалтай. Компанийн хөрөнгийг үр ашиггүй ашигласан, захиран зарцуулсан, запилан мэхэлсэн, эрх мэдлээ хэтрүүлсэн байвал ямарваа нэг агаар зөвшөөрөл авсан байж нь хамааралгүй гэж үзэх хэлцлийг нь хүчингүй болгох орон зай шүүхэд байх нь зүйтгэй юм. Гэхдээ энэ эрх зүйн боломжийг шүүх зайлшгүй тохиолдолд авч үздэг хандлага зонхиилдог.⁴⁹

⁴⁹ Амарсанаа Б. Компанийн засаглал, компанийн эрх зүйн тulgamsan асуудал. УБ., 2012 он. 33 - 34 дахь тал

1880 онд АНУ-д захидал нь өөрийн ажиллаж буй компанитайгаа гэрээ байгуулсан тохиолдолд тухайн гэрээ шударга эсэхээс үл шалтгаалан гэрээг хувьцаа зэмшигч болон компани цуцлах журам үйлчилж байсан. Харин 1910 оноос хэрэв энэхүү сонирхлын зөрчилтэй хэлцэл нь ашиг сонирхол байжгүй бусад захирилдуулж хүлээн зөвшөөрсөн бол хүчин төгөлдөр гэж үзэх болсон бөгөөд энэ нь шуухээс запилан гэж толгоогдохгүй тохиолдолд үйлчилдэг. Энэхүү туххээс харахад маш богино хугацаанд ашиг сонирхлын зөрчилтэй хэлцлийг хориглодог байснаа сонирхлын зөрчлийг удирдах арга руу шилжсэн харагдаж байна.⁵⁰ Үүнээс дутгээд ашиг сонирхлын зөрчилтэй хэлцлийг хориглох биш түүнийг зөв удирдах нь чухал гэдэг нь харагдаж байна.

Сонирхлын зөрчилтэй хэлцлийг хүпээн зөвшөөрөх орчин үеийн хандлагад дараахаа гурван шаардлагыг хангаж байгаа тохиолдолд сонирхлын зөрчил байсан ч хэлцлийг хүчин төгөлдөрт тооцдог.⁵¹ Үүнд:

- тухайн хэлцэлд ямар нэг хувийн санхүүгийн сонирхол байжгүй ТУЗ-н гишүүдийн олонхын саналаар хэлцлийг зөвшөөрсөн байх бөгөөд уг зөвшөөрөл нь шударга ёсонд нийцсэн байх,

- сонирхлын зөрчил байжгүй хувьцаа зэмшигчдийн олонхын саналаар зөвшөөрсөн байх,

- хэлцэл нь компанийн хувьд зүй ёсны буюу шударга байсан гэсэн ерөнхий шаардлага орж буй юм.

Эдгээр гурван шаардлагыг гурвуулсан хангахыг шаардах эрх зүйн боломж байхад зөвхөн нэгийг нь хангахад сонирхлын зөрчилтэй хэлцлийг хүчин төгөлдөрт тооцох боломж бий.⁵²

⁴⁹ James D.Cox Managing and Monitoring Conflict of Interest: Empowering the Outside Directors with Independent Counsel. https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=473264

⁵⁰ Депаварийн корпорацийн ерөнхий хууль, 144 дүгээр зүйл.

⁵¹ Амарсанаа Б.. Компанийн засаглал, компанийн эрх зүйн тulgamsan асуудал, УБ., 2012 он. 33 дахь тал.

Дөлөвөрийн хуулийн дагуу шударга эсэх байдлыг үнэлэхдээ тухайн хэлцлийг гуравдагч этгээдтэй хийсэн бол түүнд тавигдах нэхцэлтэй ижил, адилтгахайц нэхцэлөр хийсэн эсэх гэсэн шалгурлыг тавьдаг бол Итали улсын хувьд тус хэлцэл нь компанийг хохиросон эсэхийг л шалгур болгодог байх жишиэтэй. Процедурын хувьд Дөлөвөрөө мүжийн хуулийн дагуу хариуцагч тал тухайн хэлцэл, эсхүл шийдвэрээ шударга ёсонд нийцсэн эсэхийг нотлох үүрэгтэй байдаг бол харин бусад орнуудад нэхэмжлэгч этгээд тухайн хэлцэл, шийдвэр нь ягаад хууль бус буюу шударга ёсны зарчимд нийцэгүй болохыг нотлох үүрэг тус тус хүлээдэг.⁵²

Орчин үед нийтлэгээр өөртэйгээ хийх хэлцлийг хүлээн зөвшөөрөх тохиолдол дээр дурдсан шаардлагаас гадна тухайн хэлцлийг хийхэд бие даасан хараат бус зөвлөх, хуульчийг оролцуулах нь шударга шийдвэр гаргахын үндэс болдог гэж үздэг байна.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хүчин төгөлдөр бус байх, хүчин төгөлдөр бусад тооцох

Дээрх хэсэгт дурдсан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хүчин төгөлдөр байгладаг нэхцэлүүдийг зөрчсөн тохиолдоос гадна иргэний эрх зүйн дараах өрөнхий үндэслэлийн дагуу сонирхлын зөрчилтэй хэлцлийг хүчин төгөлдөр бус байх хоёр үндсэн нэхцел байдаг. Үүнд:

- Хууль зөрчсөн - Хуульд заасан шаардлагыг зөрчиж байгуулсан.

- Хуулиас гадуур хийсэн-Хуулийн заалтыг шууд зөрчөөгүй боловч хуулийн өрөнхий агуулга, зарчим, нийтийн дунд хэвшилсэн ёс суртахууны хэм хэмжээнд харшилсан.

Сонирхлын зөрчилтэй хэлцлийн хувьд хүчин төгөлдөр бус байх хэлцэлд иргэний хуулийн 56.1.1 болон 56.1.8 дагаар зүйлүүд заасан хэлцэл хамаарч

⁵² Reinier Kraakman/John Armour/Paul Davies/Luca Enriques/Henry Hansmann/Gerard Hertig/Klaus Hopf/Hideki Kanda/Edward Rock, *The Anatomy Of Corporate Law*, Oxford 2d ed. 2009, p.173-174.

болно. Иргэний хуулийн 56 дугаар зүйлд тусгасан нэхцэл байдал илэрвэл уг хэлцлийг хууль тогтоогч хүчингүй байхаар зохицуулжээ. Тэгэхээр тухайн хэлцэл нь анхаасаа ямар нэг эрх зүйн үр дагавар үүсгэхгүй гэсэн уг.⁵³

Хэрэв эрх бүхий этгээд нь өөрийн үнэнч байх үүргээ зөрчж, урьдчилж мэдэгдээгүй, зөвшөөрөл авалгүйгээр сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн байвал уг хэлцэл нь хуульд заасан шаардлагыг зөрчиж хийсэн учир хүчин төгөлдөр бус хэлцэл болдог буюу компанийн хуулийн зохих зохицуултаас гадна иргэний хуулийн 56.1.8 дугаар зүйлийг хэрэглэх нэхцэл бүрдэх юм.

Хэрэв сонирхлын зөрчилтэй хэлцэл нь хууль болон дүрэм журмынхаяа процедурын (сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдсэн, эрх бүхий этгээдээс уг хэлцлийг үргэлжлүүлэн хийж болох зөвшөөрлөө авсан гэх мэт) дагуу хийгдсэн ч гэсэн хариуцлагатай хандах болон үнэнчээр ажиллах үүргээ биелүүлээгүй, хэлцэл нь шударга зүй ёсны байх нэхцэлийн хангаагүй бол компанийн хууль болон иргэний хуулийн 57.1 дүгээр зүйлийн дагуу шүүхээс энэхүү хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцож болно.

Компанийн эрх зүйн сонирхлын зөрчилтэй хэлцэл хүчин төгөлдөр бус байх болон хүчин төгөлдөр бус тооцсоны дараа компани уг хэлцлийн үр дагаврыг хэрхэн арилгах вэ ? гэсэн асуудал хамгийн чухал юм.

Нэг удаагийн шинжтэй сонирхлын зөрчилтэй хэлцлийн хувьд иргэний хуулийн дагуу өгсөн авснаа буцаах зарчмыг баримталыг асуудлыг шийдэж болох (тухайлбал: үл хедлэх хөрөнгө худалдах худалдан авах гэрээ) бөгөөд Иргэний хуулийн 57.2 дугаар зүйлийн дагуу хийсэн цагаасаа хүчин төгөлдөр бус байж болох хэдий ч урт хугацааны, олон удаагийн давтамжтай хийдгэж байгаа (тухайлбал: түрээсийн гэрээ, зээлийн гэрээ гэх мэт) сонирхлын

⁵³ Тэмүүлэн.Б нар, Иргэний эрх зүйн өрөнхий англи.УБ., 2010 он, 118 дахь тал.

зөрчилтэй хэлцлийн хувьд шүүхээс хүчин төгөлдөр бус гэж тооцсон нь өгсөн авсны буцаах боломжгүй бол энэхүү хуулийн зохицуулалтыг хэрэглэхэд хүндэрэл учирна. Хүчин төгөлдөр бус хэмээн тооцуулж болох хэлцлийн тухайд гэвэл төвөргдсөн тал хэлцлээ шүүхээр хүчингүй тооцуулахаас өмнө энэ нь хүчинтэй хэвээр байна.⁵⁴ Тиймээс иргэний хуулийн 57.2 дугаар зүйлд урт хугацааны гэрээг зөвхөн хүчингүйд тооцуулсан уээс буюу "ex pips" хүчингүй болгох тухай нэмэлт зохицуулалт оруулалт нь зүйтэй⁵⁵. Үүний дагуу сонирхлын зөрчилтэй хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцоходо бизнесийн хэлцлийн онцлог шинжид тохирсон арга хэрэгслийг ашиглаж тухайлбал: шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон ерөөр тасалбар болгож уг сонирхлын зөрчилтэй хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцох нь компанийн сонирхлын зөрчилтэй хэлцлийн хувь тохирхой шийдэл болох талтай. Учир нь шүүхийн шийдвэр зөвхөн хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцоод хэрэгжүүлэх арга замыг шийдвэртээ тусгаж өгөхгүй байх нь эргээд талуудыг мухардмал байдалд оруулдаг талтай учир асуудлыг урагшлуулахын тулд компанийн хуульд хүчин төгөлдөр бус тооцсоны үр дагавар түүний хэрэгжүүлэх арга замыг заах өгвөл хуулийн сайн зохицуулалт болно. Тухайлбал тухайн сонирхлын зөрчилтэй хэлцлийн шүүхийн шийдвэр гарснаар хүчин төгөлдөр бусад тооцож учирсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэх шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй. (Буруутай этгээд хохирол төлөх хуулийн зохицуулалт байдаг).⁵⁶ Шүүхийн шийдвэрээр хүчин төгөлдөр бусад тооцсоны дараа компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд эрх мэдлийг олгох зохицуулалт ч оруулж болно. Олон улсад шүүхээс

⁵⁴ Тэмүүлэн Б. нар.. Иргэний эрх зүйн өрөнхий англ.УБ. 2010 он. 117 дахь тал.

⁵⁵ Тэмүүлэн Б. нар.. Иргэний эрх зүйн өрөнхий англ.УБ. 2010 он. 131 дахь тал

⁵⁶ Компанийн тухай хууль.(2011) 90 дүгээр зүйлийн 1 дахь эзэсэг

сонирхлын зөрчилтэй хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцоход уг хэлцэл нь компанийн эрх ашигт хэрхэн нийцсэн бэ? Компанийн эрх ашиг дээд зэргээр хамгаалагдж чадсан уу? гэдэг щалтуур тавьж шийдвэр гаргадаг.

2.3 Сонирхлын зөрчилтэй хэлцэлд холбогдох маргааныг шийдвэрлэх, зөрчилд хүлээлгэх хариуцлагын төрөл

Нэгэнт сонирхлын зөрчилтэй хэлцлийн нөхцөл байдал үүсэхэд дээр дурдсан аргуудыг ашиглаж эрсдэл үүсэх, маргаан гарахаас урьдчилан сэргийлж, хамгаалдаг бол хэрэв энэхүү журмыг баримтлахгүйгээр ямар нэг зөрчил гаргасан тохиолдолд маргааны шийдвэрлэх, тухайн зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэх механизмыг үйлчлэх ёстой.

Хэрэв ашиг сонирхлын зөрчил нь ямар нэг төрлийн маргааныг үүсгэж байвал дараахаар байдлаар шийдвэрлэх боломжтой:

- Маргааншийдвэрлэх компанийн дотоод дүрэм, журмаар (тухайлбал маргааныг компанийн дотоод хянантай зөвлөлөөр албаар шийдвэрлүүлэх)

- Гуравдагч этгээдийг оропцуулах: төвийг сахисан гуравдагч этгээдийг зөрчил болон маргаанд оропцуулж асуудлыг шийдвэрлүүлэх. Энэхүү гуравдагч этгээдэд ихэвчлэн Үнэт цаасны зах зээлийн хороо газ эзрэг ЗГ-н хэрэгжүүлэгч агентлагийг оропцуулдаг.

- Иргэний эрх зүйн маргаан үүсгэх: ашиг сонирхлын зөрчилгүй захирап нь иргэний шүүхэд маргаан үүсгэх байдлаар тухайн сонирхлын зөрчилтэй хэлцэл нь компаниид эшигтай байсан эсэх талаар тодорхойллуулдаг.⁵⁷

Компанийн эрх бүхий этгээдийн компанийд хүлээсэн үүргэгэй холбон үзэж сонирхлын зөрчилтэй хэлцлээс үүссэн маргааныг бизнесийн маргаан шийдвэрлэх дүрмийг ашиглан шийдвэрлэдэг туршлага АНУ, Их Британия, Австрали, ХБНГУ зэргэл улсад

⁵⁷ <http://www.legalmatch.com/law-library/article/business-conflict-of-interest>

хэрэгждэг туршлага байна.

Шүүхээс хариуцлага хүлээнгэх стандарт болгож бизнесийн маргаан шийдвэрлэх дүрмийг ашигладаг, энэ дүрэм нь шүүхэд эрх бүхий этгээдийг үргээ билүүлж байсан эсэхийг шалгах шалгуур нь болдог. Энэ шалгуураар нэхэмжлэгчийг нотлох баримтад үндэслэж тухайн нөхцөл байдлыг тодорхойлохыг шаардаг. Тухайлбал: залилан, хууль бус үйлдлэл, өөртэйгээ хэлцэл хийх, ТУЗ-н зөвшөөрөл аваагүй гэх мэт нөхцөл байдлыг нотлох баримтад үндэслэн тогтоох ёстай гэж үздэг. Нотлох баримтыг үндэслэх журмын дагуу бизнесийн шийдвэр гаргахдаа компанийн эрх бүхий этгээд нь тухайн асуудлын талаар сайн мэдэж байсан эсэх, шударга үнэнчээр хандсан эсэх, тухайн үйлдэл нь компанийн хамгийн дээд ашиг сонирхолд нийцэж хийгдсэн гэдгийг нотлох ёстай юм.⁵⁸

ДҮГНЭЛТ

- Компанийн эрх зүйд сонирхлын зөрчилтэй хэлцэл огт байж болохгүй зүйл биш багаад сонирхлын зөрчилтэй хэлцлээс үүдэн эрсдэл үүсэхгүй, хохирол учрахгүй, шударга бус байдал үүсэхгүй байх тэр нөхцлийг бүрдүүлж өгөх буюу зөв удирдах, хянах, зөрчил үүссэн тохиолдолд хариуцлага хүлээнгэдэг байх нь компанийг өөрийг нь болон жижиг хувьцаа эзэмшигчид, зээлдүүлэгч, хөрөнгө оруулагч нарыг болон зах зээлээ хамгаалах хамгийн чухал учир дэлхийн улс орон бур сонирхлын зөрчилтэй хэлцлээс үүсэх эрсдэлээс үрдчилан сэргийлэх, зарим сонирхлын зөрчилтэй хэлцлийг хулзэн зөвшөөрөх, эс зөвшөөрөх шалгуурыг тогтоох нийтлгээр компанийн хууль, үнэт цаасны зохицуулалтын хууль, худалдааны хууль зэрэгтэй зохицуулсантай нэгэн адил манай улс ч компанийн болон үнэт цаасны зах зээлийн тухай хуульдаа хангалттай хэмжээгээр зохицуулж өгсөн хадий ч хэрэгжилт хангалтгүй байна,
- Манай улсын Компанийн тухай хуульд заасан эрх бүхий этгээдийн итгэл хүлээх, үнэнчээр ажиллах үүргээ буюу КтХ-ийн 84 дүгээр зүйлийн 84.4.2, 84.4.3 дахь хэсэгт заасан компанийн эрх ашигийг дээдлэх буюу үнэнчээр ажиллах зарчим, компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах буюу хариуцлагатай ажиллах зарчмуудын хувьд эдгээр үргээ билүүлээгүйгээ сонирхлын зөрчилтэй хэлцлийн маргаан үүссэн бол компанийн хувьцаа эзэмшигч компанид учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй тухай зохицуулсан ч шүүхийн зүгээс эрх бүхий этгээдийг уг үргээ билүүлээгүйг хэрхэн тогтоох талаар тодорхойгүй байдлыг үүсгэж байна,
- Сонирхлын зөрчилтэй хэлцлийг хүчин төгөлдөр байлгах гол шалгуурууд болох үрдчилж мэдэгдэх, хараат бус ТУЗ-н гишүүд, сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигч нарын зөвшөөрлийг авсны үндсэн дээр хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар маргаан үүсэх, хэлцлээс үүдэн хохирол учирсан тохиолдолд хэлцэл хийхэд шударга ёсны буюу тэгш байдлын зарчмыг баримталсан, компанийд ашигтай байсан эсэхийг шалгаж үзсэнээр маргааныг шийдвэрлэдэг олон улсын сайн туршлагыг манай улсын шүүх хэрэг маргаан шийдвэрлэхээс хэрэглэх нь зүйтэй.
- Манай улсын компанийн хуульд сонирхлыг зөрчилтэй хэлцэл хийх журмыг зөрчсөн тохиолдолд уг хэлцлийг шүүхээс хүчин төгөлдөр бус тооцож болохыг зохицуулсан боловч үүнийг цаашид хэрэгжүүлэх арга замыг

⁵⁸ Andrew Lumsden., The business judgment defence – insights from ASIC v Rich, file:///C:/Users/HOME/Downloads/SSRN-id1584652%20(1).pdf

тодорхойлж өгөгүй. Нэг удаагийн шинжтэй сонирхлын зөрчилтэй хэлцлийн хувьд иргэний хуулийн дагуу өгсөн авснаа буцаах зарчмыг баримталж асуудлыг шийдэж болох боловч урт хугацааны, олон удаагийн давтамжтай хийдэж байгаа (тухайлбал: түрээсийн гэрээ, зээлийн гэрээ гэх мэт) сонирхлын зөрчилтэй хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцохдоо бизнесийн хэлцлийн онцлог шинжид тохирсон арга хэрэгслийг ашиглах нь зүйтэй.

5. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг

---00---

байгуулах журам зөрчсөн, хууль бусаар сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсан, эрх бүхий этгээд нь компанийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд тэдгээр этгээдүүдэд тохирсон хариуцлагын хүлээлгэдэг хуулийн зохицуулалт зайлшгүй хэрэгтэй бөгөөд энэ нь сонирхлын зөрчилтэй хэлцлийн зохицуулалт түүний хэрэгжилтийг хангах хөшүүрэг болж өгөх ёстой. Манай улсын хувьд ийм хариуцлагын сайн тогтолцоо хангалттай хуульд тусаагүй байна.

Хуульчдын номын сангийн журмаас

ДӨРӨВ. НОМЫН САНГИЙН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЭРХ НЭЭЛГЭХ, СУНГАХ, ЦУЦЛАХ

- 4.1. Үйлчлүүлэгч номын сангийн гишүүнчлэлийн эрхийг нэг жилийн хугацаатай нээлгэж болно. Номын сангийн гишүүнчлэлийн эрхийг шинээр авах, хугацааг сунгуулахад хавсралтад заасан хураамж төлнө.
- 4.2. Үншигчийн эрх нээлгэхийн өмнө номын сангийн ажиллах журамтай танилцан зөвшөөрсөний үндсэн дээр номын сангийн гишүүнчлэлийн эрх нээлгэнэ.
- 4.3. Номын сангийн гишүүнчлэлийн эрх нээхэд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үнд:
 - a) 1 хувь цээж зураг (3x4 хэмжээтэй, суулийн 3 сарын дотор авахуулсан)
 - b) Иргэний үнэмлэх (Жич: Улаанбаатар хотод түр оршин сүгч бол тухайн оршин суугаа газрын хорооны Засаг даргын тодорхойлолт)
 - c) Ажлын газрын үнэмлэх, оюутны үнэмлэх: /оюутны үнэмлэхгүй тохиолдолд сургуулийн тодорхойлолт, ажил эрхлээгүй бол оршин суугаа хорооны тодорхойлолт/ хүчинтэй байх
 - d) Үйлчилгээний хураамжийг банкинд тушааж, баримтыг авчирч өгнө. /Төрийн банк 100900001009, Хууль зүйн үндэсний хүрээлэн, номын сангийн гишүүнчлэлийн үнз/
- 4.4. Үншигчийн эрхийн хүчинтэй хугацаа дууссанаас хойш нэг сарын дотор дахин сунгуулах ба үншигч энхүү дүрмийн 4.3-ын b, c, d-д заасан баримтыг бүрдүүлнэ.
- 4.5. Энэ дүрмийн 4.4- д заасан хугацаа өнгөрсөн бол 4.3-т заасан баримтуудыг шинээр бүрдүүлэн дахин үншигчийн эрх нээлгэнэ.
- 4.6. Үншигчийн эрхийн үнэмлэхээ үрэгдүүлсэн, үнэмлэхний баркодыг гэмтээсэн тохиолдолд шаардлагатай хураамжийг төлж үнэмлэхийг сэргээлнэ.
- 4.7. Үншигчийн эрх нээлгээгүй тохиолдолд хавсралтаар баталсан тарифын дагуу номын сангийн үйлчилгээ авч болно. Үншигчийн эрхгүй тохиолдолд иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичигийг номын сангийн ажилтанд түр хадгалуулан үйлчилгээг авна. Бүртгэлийн хураамж, төлбөрт үйлчилгээний жижигийг тухайн үеийн бараа, үйлчилгээний үнийн өсөлттэй уялдуулан хүрээлэнгийн захирын тушаалаар өөрчлөн тогтооно.

ШИНЭ БҮТЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА



**БҮТЭЭЛ: ХБНГУ-ЫН ИРГЭНИЙ
ХУУЛЬ (КОДИФИКАЦИИЙН БҮРЭН
ЭХ), ОРЧУУЛГЫГ НЭГТГЭСЭН
АНХНЫ ХЭВЛЭЛ, УЛААНБААТАР ХОТ,
2017 ОН**

Эрхлэн гаргасан: "ХБНГУ-Ын Иргэний хууль (Хувийн эрх зүйн суурь кодификац)" хэмээх энэхүү орчуулгыг МУИС-ын Хууль зүйн сургуулийн 2016 оны санхүүгийн жилийн "Гадаад орны хууль тогтоомжийг хөрвүүлэх нь" дотоод төслийн хүрээнд санхүүжүүлж хэвлүүлжээ.

Орчуулагч: Энэхүү нарийн төвөгтэй, агуулга, цар хүрээ ихтэй хуулийг тус сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш Б.Буянишиг орчуулсан байна.

Агуулга: Өнөөгийн ХБНГУ-Ын Иргэний хууль нь 1900 онд батлагдсан анхны хувилбарынхаа гол агуулгыг хадгалсаар иржээ. Энэхүү хууль нь хувь этгээд хоорондын харилцаанд эдлэх эрх чөлөө, эрх үүргийг мэн хүлээх эрсдэлийг нарийчлан зохицуулсан байдгаараа хувийн эрх зүйн салбарын суурь кодификац болдог. Хувь этгээдийн чөлөөт байдал, ялангуяа иргэд ба аж ахуй эрхлэгчдийн бусадтай харилцах эрх зүйн харилцаагаа бие даан, өөрөө хариуцан тодорхойлох эрх чөлөөг тусгасан энэ хууль нь нийт эх газрын эрх зүйн тогтолцоо (civil law system) бүхий улс орнуудын хууль тогтоомж, тэр дундаа зүүн Европын хуучин социалист орнуудын хууль тогтоомж, тэр дундаа зүүн Европын хуучин социалист орнуудын хувийн эрх зүйн шинэчлэлд томоохон жишиг болсон хэмээн судлаачид үздэг. Энэ утгаараа бид дотоодын болон хөрш залгаа ОХУ, Украян зэрэг улс орнуудын иргэний хуулиудыг судлахдаа харьцангуй ёмне батлагдсан ХБНГУ-Ын Иргэний хуулийг харьцуулсан эрх зүйн онолын үүднээс зайлшгүй авч узэх шаардлага гардаг. Тиймээс хувийн эрх зүйн салбар дахь судалгааны ажлыг хөнгөвчлөх, харьцуулалтын зорилго, үр дүнд зөргөр нөлөөхөд чухал ач холбогдол бүхий бүтээл болсон байна.

ШИНЭ БҮТЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2017 ОНД ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГЭЭС
ШИНЭЭР ХЭВЛҮҮЛСЭН БҮТЭЭЛ



Монгол Улсын Хууль
“ИРГЭНИЙ ХУУЛЬ”

Монгол Улсын Хууль
“ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ”,
“ДОТООДЫН ЦЭРГИЙН ТУХАЙ ХУУЛЬ”



“ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГЫН
БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХАД
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ НЬ”
Судалгааны үндсэн тайлан

“ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГЫН
БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХАД
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ НЬ”
Судалгааны хавсралт тайлан



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН “ХУУЛЬЧДЫН НОМЫН САН”-ИЙН ТАНИЛЦУУЛГА



Тус номын сан 2002 онд Хуульчдын давтан сургах төвийн дэргэд байгуулагдсан бөгөөд фонд нь хууль, эрх зүйн чиглэлийн монгол, гадаад ном, сэтгүүл, бусад бүтээлзэс бүрдэж байна. Монгол, англи, орос гэх мэт хэл дээр хэвлэгдсэн нийт 3605 төрлийн 11028 номтой. 2004-2006 онд Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэлгэл” төслийн хүрээнд үйлчилгээний тоног төхөөрөмжийн хувьд иж бүрэн тоноглогдсон ба уншлагын танхимдаа Checkpoint хамгаалалтын систем болон камер суурилуулан ашиглаж байна.

Номын сан – үйлчлүүлэгчийн хоорондын эргэх холбоог идэвхжүүлэх зорилгоор үйлчилгээндээ хэрэглэгчийн үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэх, facebook.com, twitter.com зэрэг social media, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглах замаар тус хүрээлэнгийн судалгааны ажлууд, шинээр хийсэн номын баяжилт, шинэ үйлчилгээ зэргийг сурталчлан судлаач, олон нийтийг татах ажлуудыг эхлүүллээ.

Номын сан www.library.legalinstitute.mn цахим хаягийг электрон каталогит байршуулан танд өрөөнөөсөө болон хаанаас ч интернетээр ном, гарын авлага, товхимлоо хайлт хийх боломж олгож байна.



АНДЕРСОН & АНДЕРСОН ХХН
ANDERSON & ANDERSON LLP

Website: www.anallp.com

“Андерсон энд Андерсон” ХХН нь санхүүгийн гэрээ хэлцэл, оюуны өмчийн хамгаалалт, бургтэл, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, гадаадын хөрөнгө оруулалт болон уул уурхай, үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдаан авах ажиллагаа зэрэг өргөн хүрээнд хууль зүйн үйлчилгээ үзүүлсээр ирсэн зуу гаруй жилийн туршилгатай олон улсын хуулийн фирм юм. Одоогийн байдлаар Монгол Улс, АНУ, БНХАУ, Хонг-Конг, Макао, Энэтхэг Улс болон Израйл улсад өөрийн болон хамтын ажиллагааны салбаруудтай болоод байна.

“Андерсон энд Андерсон” ХХН-ийн Улаанбаатар хотын салбар нь Удирдаж гицүүн Дэвид С. Баксбамын удирдлагад дор үйл ажиллагаагаа явуулад нийт 25 жил болж байна. Энэ хутсаанд бүх төрлийн салбарт хөрөнгө оруулж буй лотодын болон гадаадын компанийн зөвлөгөө өгөх, тэдгээрийг төлөөлөх болон хамтран ажиллас хэлбэрээр хууль зүйн үйлчилгээ үзүүлж байсан арвив туршилгатай билээ.

Улаанбаатар хотын салбарын хаяг:

Монгол Улс, Улаанбаатар 210628, Баянгол дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө-46, Гранд Плаза, 10-р давхар, 1008 тоот

Утас: (976) 70119339

Факс: (976) 70119669

Вэбсайт: www.anallp.com

И-мэйл хаяг: anderson.mongolia@anallp.com



NEW YORK
 30 Wall Street
 8th Floor
 New York, NY 10005-2205
 U.S.A.
 Tel: (1)(212) 709-8278
 Fax: (1)(212) 943-2300
 Email: anderson.newyork@anallp.com

HONG KONG
 Suite 2207, 22nd Floor, Tower 2
 Lipps Centre, 89 Queenway
 Admiralty, Central
 Hong Kong
 Tel: (852) 2537-9768
 Fax: (852) 2537-4028
 Email: anderson.hongkong@anallp.com

MACAU
 20th Floor
 AIA Tower, No 251A-301
 Avenida Comercial De Macau
 Tel: (853) 2871-5995
 Fax: (853) 2871-5181
 Email: anderson.macau@anallp.com

ULAANBAATAR
 Suite 1005, 10th Floor
 Grand Plaza, Enkhzavhan Ave-46
 Bayangol District
 Ulaanbaatar 106-28
 Mongolia
 Tel: (976) 70119339
 Fax: (976) 70119669
 Email: anderson.mongolia@anallp.com

BEIJING
 Suite 601, 6th Floor
 Chongming Sino-Tower
 1 Zhangjia Lane
 South Chao Nci Avenue
 Dongcheng District, Beijing 100010
 China
 Tel: (86)(10) 5711-40720
 Email: anderson.beijing@anallp.com

GUANGZHOU
 Suite 3901, 39th Floor, Profit Plaza
 76 Huangpu Avenue West, Tianhe District
 Guangzhou 510623
 China
 Tel: (86)(20) 3839-2008
 Fax: (86)(20) 3839-2009
 Email: anderson.guangzhou@anallp.com

SHANGHAI
 Suite 1621, 16th Floor, Tower 1
 Zhongshan Binjiang
 2742 Pudong Avenue
 Pudong New District
 Shanghai 200136
 China
 Tel: (86)(21) 5846-0290
 Fax: (86)(21) 5846-0329
 Email: anderson.shanghai@anallp.com

Associated Offices

MUMBAI
 Shah & Sanghavi
 Advocates Solicitors & Notary
 114-A Mittal Court
 Nariman Point
 Mumbai 400 021
 India
 Tel: (91)(22) 285-3592
 Fax: 91(22) 284-5040
 Email: anderson.india@anallp.com

TEL AVIV
 Dr. Yael Shachar & Co
 14 Weizmann Street
 Weizmann Centre
 Tel Aviv 64219
 Israel
 Tel: (972)3 718-1111
 Fax: 972(3) 718-1112
 Email: anderson.telaviv@anallp.com